



Coloring Our Lives

Амьдралаа солонгоруулъя

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн оюун санааны
сургаал айлдвар, эшлэлүүдийн эмхтгэл

Амьдралаа солонгоргуулья

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн компани**

Өөрийн дотоод сэтгэлдээ бүрэн
дүүрэн байхын тулд бид хоёр зүйл
хийх ёстой. Нэгт, бид энэ дэлхийн
ажил үүрэгтээ санаа тавих. Хоёрт,
гэгээрэх, энэ нөхцөлд бид эхний үүргээ
бүр илүү сайн биелүүлэх болно.
~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай



Баяр хөөртэй, идэвхтэй, өнгө жавхаатай дотоод оюун санаа биднээс
гарах ёстой. Бид ажиллаж байхдаа энэ дэлхийд эрч хүч, амьдрал, аз
жаргалын хүчийг авчрах хэрэгтэй.

~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Оршил

Энэхүү ном нь төрөх, амьдрах, үхэх, сүнслэг хөгжил болон Үнэн Ёсны талаар Үнэнийг эрэгчдээс ямагт тавьдаг асуултуудад Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн өгсөн хариултуудын эмхтгэл юм.

Гэвч эдгээр бүх аман хариулт бол зөвхөн чихээр сонссон дам мэдээлэл билээ. Их Багш биднийг өөрийнхөө дотоод дахь Хамгийн Дээд Хүчийг олж авах, улмаар тэр Хүч бидний амьдралд санаа тавьж, бүхнийг зохицуулахыг нь зөвшөөрөх замаар анхдагч мэдээллийг олж авахыг урамшуулан дэмждэг.

Бяцхан илгээлт

Оройн Дээд Бурхан болон Дээд Сүнсний тухай ярихдаа Бурхан эр, эсвэл эм хүйстэй аль нь болох тухай гарч болзошгүй маргаанаас зайлсхийж, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүйсийн ялгаа заадаггүй нэр томъёог хэрэглэдэг.

She + He = Hes (Bless гэдэгтэй адил дуудна.)

Her + Him = Hirm (Firm гэдэгтэй адил дуудна.)

Hers + His = Hiers (Dears гэдэгтэй адил дуудна.)

Жишээлбэл: Бурхан хүсвэл Тэрбээр (Hes) юмсыг Өөрийн (Hirmself) таалалд нийцүүлж, Түүний (Hiers) хүсэл зоригийн дагуу зохицуулдаг.

Уран бүтээлч, бурханлаг багш Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай дотоод гоо сайхны аливаа илэрхийлэлд дуртай. Тиймээс ч Тэрбээр Вьетнамыг “Ау Лак”, Тайванийг “Формоса” хэмээн нэрлэдэг. Ау Лак гэдэг нь “Аз жаргал” гэсэн утгатай Вьетнам орны эртний нэр. “Үзэсгэлэнтэй” гэсэн утгатай Формоса хэмээх нэр энэ арлын орон болон хүн ардынх нь гоо сайхныг илүү төгс төгөлдөр илэрхийлдэг. Төгс Гэгээрсэн Их Багш энэ нэрсийг хэрэглэх нь нутаг орон хийгээд оршин суугчдад нь бурханлаг хөгжил дэвшил, аз хийморь авчирна гэж үздэг юм.



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Хайр энэрлийн замнал

Эдүгээ цагийн Төгс Гэгээрсэн Их Багшийн
амьдралын зам мөр

Хорвоогийн өнцөг булан бүхний
Хамаг амьтанд зориулах гэж
Дэндүү жаахан хайрыг
Дэндүү жаахан хайрыг
Дээгүүр доогуур, хаа сайгүй
Эрэн хайнам, бид.

Уулзан учирч ухаарч, хамтран ажиллах хувь тохиосон хүн бүхэнд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хэмээн хүндлүүлэн өргөмжлөгдсөн Тэрбээр хайр энэрлийн замаар хэрхэн замнахын үлгэр дуурайл юм.

Дэлхийд нэрд гарсан оюун санааны хөтөч, хүмүүнлэг үзэлтэн, уран бүтээлч Тэрбээр гачигдаж дутагдсан болон орон гэргүй хүмүүс, ДОХ болон хорт хавдрын салбар дахь анагаах ухааны судалгааны хүрээлэнгүүд, АНУ-ын дайны ахмад дайчид, гачигдалтай ахмад настан, бие махбодын болон сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, дүрвэгсэд, ядуурал, газар хөдлөлт, үер, хар салхи, гал түймэр зэрэг байгалийн гамшигт нэрвэгдсэн хүмүүс гэхчлэн дэлхийн өнцөг булан бүрд сая сая хүмүүст аливаа арьс өнгө, соёл суртлын ялгааг үл харгалзан хайр халамж, тусламжийн гараа сунгаж байдаг билээ. Түүний нинжин сэтгэлд хүмүүс төдийгүй мөн хамаг амьтан адислагдаж, цаглашгүй ивээл хайрыг хүртдэг юм.

Энэхүү халамжит хатагтайн хайр нигүүлсэл, түүний хайрын үлгэр дуурайллаас үүссэн олон улсын буяны сангийн нэн олон сайн үйлсийг хүмүүс бид дурсаж байдаг билээ.

«Бид юуг хуваалцаж болохоор байна, тэр бүхнээ хуваалцахаас эхэлдэг. Ингэснээр бид дотооддоо нарийн өөрчлөлтийг мэдэрнэ - бидний ухамсарт илүү их хайр урсан ороход бид ямар нэг зүйлийг ухаарч сэхээрнэ. Энэ бол ердөө л эхлэл. Бид энд суралцах гэж, өсч хөгжихийн тулд суралцах, түүнчлэн бид хаана байлаа ч гэсэн эх дэлхийгээ улам сайхан болгохын төлөө өөрсдийн хязгааргүй хүч чадал, хайр, бүтээх чадвараа ашиглаж сурахаар энд ирсэн билээ.»

Амьдралын эхэн үе

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Ау Лак (Вьетнам)-ын төв нутагт мэндэлжээ. Бага насандаа эмнэлгийн өвчтөн, зовж зүдэрсэн хүмүүс, мөн шархадсан амьтдад чадлын хэрээр тусалж байхыг нь хүмүүс олонтоо анзаардаг байжээ. Хожим нь Европт суралцахаар ирж, улмаар тэндээ Улаан Загалмайн нийгэмлэгт орчуулагчаар ажиллажээ.

Удалгүй Тэрбээр зовлон зүдгүүр дэлхийн аль ч өнцөг буланд, аль ч ард түмний дунд нэгэн адил оршиж байгааг ухаарч, үүнээс гэтлэн гарах арга замыг эрж олохыг амьдралынхаа эрхэм зорилго болгожээ. Тухайн үед Герман эмчтэй гэрлээд аз жаргалтай амьдарч байсан хэдий ч тус тусын зам мөрийг хөөх амаргүй шийдвэрийг гаргажээ. Ийнхүү Тэрбээр сүнслэг ойлголтыг эрэлхийлэх хоёр жилийн аянд мөрдсөн билээ.

Хималайн уулнаа даяанчилсан нь

Эцэст нь, Энэтхэгийн Хималай уулын хамгийн гүнд хүрч очин, нэгэн Төгс Гэгээрсэн Их Багшаас дотоодын Гэрэл, Аялгууг ажиг Арьяабалын Бясалгалын Аргыг (Гуан Инь бясалгал) уламжлан авчээ. Хималайн уулнаас буцаж ирснийхээ дараа эргэн тойрны хүмүүсийн хичээнгүй гуйлт хүсэлтээр Их Багш Чин Хай Арьяабалын бясалгалын аргыг бусадтай хуваалцаж, тэднийг дотоод руугаа хандан аугаа мөн чанараа нээж олохыг дэмжин урамшуулсан юм.

Нийгмийн бүхий л давхаргын хүмүүс Арьяабалын аргаар бясалгаснаар өдөр тутмын амьдралдаа амар амгалан, аз жаргал, асар их сэтгэл ханамжийг олсон байдаг. Төд удалгүй АНУ, Ази, Европ, Австрали, Африк болон Өмнөд Америк, мөн түүнчлэн дэлхийн хэмжээний томоохон байгууллагууд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайг ном сургаал айлдахыг хүсэж урилга ирүүлдэг болсон ажээ.

Амьдарч буй Дэлхийгээ үзэсгэлэн төгөлдөр болгоё

Их Багш Чин Хай хүмүүнлэгийн үйлсийн эрхэм үлгэр жишээг үзүүлдэг төдийгүй бас хүмүүсийг амьдарч байгаа дэлхийгээ улам сайхан болгохыг урамшуулан дэмждэг билээ. Их Багш Чин Хай Арьяабалын бясалгалын аргыг дадуулснаар олон авъяас чадвараа аяндаа олж нээсэн ба уран зураг, чамин тансаг гэрэлтүүлэг дэнлүү, хөгжим, яруу найраг, хувцасны загвар, гоёмсог сайхан үнэт эдлэл гэх мэт бүтээлүүдээ туурвин, уулзан учирсан улс үндэстэн, ард түмэн болон тэдний соёлын дотоод болон гаднах гоо сайхныг тусган илэрхийлжээ. 1995 онд олон нийтийн хүсэлтээр Түүний хувцас загварын бүтээлүүд нь Лондон, Парис, Милан, Нью-Йорк зэрэг хотуудад олон улсын хувцас загварын төвүүдээр аялан толилуулагджээ. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн уран бүтээлийн орлого нь гачигдал зовлон амсаж буй Бурханы хүүхдүүдэд туслах эрхэм зорилгыг нь дэмжих хүмүүнлэгийн үйлсийг санхүүжүүлэх бие даасан эх үүсвэрийг бий болгох боломж олгодог.

Их Багшийн мөрөөдөл

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүмүүнлэг ажил үйлсийнхээ хариуд ямарваа гавьяа шагнал горьддоггүй ч дэлхийн улс орнуудын төр засаг, хувийн байгууллагууд Түүнд хүндэт шагналуудаа олгодог билээ.

Үүнд, Дэлхийн Энхтайвны Шагнал, Дэлхийн Оюун санааны Удирдагч шагнал, Хүний эрхийг хөхиүлэн дэмжсэний төлөө шагнал, Дэлхийн Иргэн Хүмүүнлэгийн үйлсийн төлөөх шагнал, Хүн төрөлхтний Гарамгай зүтгэлтний шагнал, 2006 оны Гүси Энхтайвны шагнал, Лос Анжелесийн Хөгжмийн Долоо Хоногийн Сайшаалын гэрчилгээ, 2006 оны 27 дахь Телли шагналын Тэргүүн байрын Мөнгөн цом зэргийг дурдууштай. Үүнээс гадна АНУ-д жил бүрийн 10 дугаар сарын 25 болон 2 дугаар сарын 22-ны өдрүүдийг “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Өдөр” хэмээн зарлан тунхаглажээ. Хонолулу хотын дарга асан Фрэнк Фази “Тэр бол аугаа хүний гэрэл гэгээ, бид бүгдийн энэрэл нигүүслийн сахиулсан тэнгэр” хэмээжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол ирээдүйгээ үзэсгэлэнтэй сайхнаар төсөөлөн бүтээхэд бид бүхэнд тусалж буй манай эрин үеийн жинхэнэ үнэнч, гарамгай хүмүүсийн нэг билээ. Түүхэнд үе үеийн олон аугаа хүн мөрөөдөлтэй байсан лугаа Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай мөрөөдлөө ийнхүү өгүүлсэн байдаг:

“Бүх дэлхий даяараа энх амгалан болоосой гэж би мөрөөддөг.

*Аливаа аллага хядлага зогсоосой гэж би мөрөөддөг.
Хүүхэд бүхэн амар амгалан, эв найртай амьдраасай гэж би мөрөөддөг.*

Бүх үндэстэн гар гараа барилцан мэндчилж, бие биенээ хамгаалж, харилцан тусалж байгаасай гэж би мөрөөддөг.

Үзэсгэлэнт гараг дэлхий маань бүү сүйрээсэй гэж би мөрөөддөг.

Энэ гараг маань бүрэлдэн тогтоход асар олон тэрбум жил шаардагдсан билээ.

Дэлхий маань машид үзэсгэлэнтэй, гайхамшигтай шүү дээ.

Түүнийг энэ л чигээрээ, гэхдээ энх амгалан, гоо үзэсгэлэн, энэрэл хайр дээр үргэлжлэн оршоосой гэж би мөрөөддөг.”

Агуулга

Хайр энэрлийн замнал.....7

Бүлэг 1 Бурханыг таних нь хүний амьдралын зорилго юм

Хүний амьдралын зорилго 19

Бид яагаад энд байгаа вэ?.....21

Бид Арьяабалын Аргаар бясалгахын төлөө л төрсөн.....24

Гэрэл ба Аялгуу бол бидний охь чанар юм..... 26

Аялгуу бясалгахын хүч 28

Залуужих арга зам..... 29

Биеийн галбир нэн сайжрахуй..... 30

Сүнслэг бясалгал дадуулахад Гэгээрсэн Их Багшийн удирдамж зайлшгүй хэрэгтэй31

Гагцхүү Гэгээрсэн Их Багшийг олсон цагт л

Үнэнийг олно 35

Аугаа Багш таны дотоодод бий37

Эзотерик ба экзотерик зам мөр38

Амьсгалын бясалгал нь эцсийн дээд арга биш 40

Мессиа ирчихсэн байна 44

Их Багш бүр Христийн хүчтэй байх ёстой.....46

Христ гэж юу вэ?48

Есүс Христ хоёр дахиа эргэн ирэх нь 49

Исламын сургаал номлол дахь үнэн (1).....50

Исламын сургаал номлол дахь үнэн (2).....52

Исламын сургаал номлол дахь үнэн (3).....54

Арьяабалын бясалгалын Арга нь бүх сайн шашинтай

нийцдэг57

Бусад сүнслэг бүлгийн талаарх сэтгэгдэл58

Бүлэг 2 Авшиг бол орчлон дахь хамгийн үнэт эрдэнэ	
Авшиг бол хамгийн үнэт эрдэнэ	65
Авшгийн үнэ цэнийг эрхэмлэхүй	68
Сүнслэг бясалгалын нууц – Их Багшид бүрэн итгэх	72
Их Багш Үнэнд хүрсэн нууц	75
Бүх гайхамшгийн эх нь итгэл бишрэл юм	83
Гэгээнтэн болохын тулд нэг арга дээрээ төвлөр	85
Жинхэнэ Их Багшийг болон зөв Зам Мөрийг олох нь	88
Үр жимсээрээ тэд танигдана	89
Жинхэнэ Авшиг	92
Зүрх сэтгэлийн тэмүүлэл бол Бурханы Хаант улсын түлхүүр юм	94
Кали Эринд бясалгах боломжоо нандигна	98
Бид бол хамгийн азтай йогч	100
Та нар өөрсдөө Их Багш	103
Толин тусгал	105
Бүлэг 3 Сэтгэлд таатай эрдэнэ - Бясалгалаар өөрийгөө адисал	
Өөрийгөө бясалгалаар адисал	111
Бясалгалын ач тус	116
Сэтгэл оюуныг сургах нь	117
Бясалгалын зорилго - Өөрийгөө ухаарах ба дотоодын аз жаргалдаа хүрэх	120
Зориулал үнэн зүрхнээс төрдөг	124
Хамгийн сайн бодол бол Бурханы тухай юм	125
Өглөө эрт босож бясалгах дадлыг хэрхэн бий болгох вэ?	129
Бясалгах хамгийн сайн цаг нь өглөө	132
Цаг хугацаагаа бясалгахад зориул	133
Удаан сууж бясалгах нууц	134
Бид зөвхөн хичээнгүй бясалгалаар Дэлхийдээ тусалж чадна	135

Арьяабалын Арга бол хамгийн дээд эрдэнэ	136
Залбирал ба бясалгалын хоорондын ялгаа	137
Бүлэг 4 Билгийн мэлмий – Хамгийн ер бусын хүрд	
Хамгийн ер бусын хүрд	141
Билиг ухааны үл үзэгдэх эх сурвалж	143
Гуравдагч мэлмийг хөгжүүлэх нь	144
Төгс Дээд Мэлмий	145
Мөнхийн аз жаргалын эх булаг	146
Билгийн мэлмийдээ үргэлж төвлөр	148
“Адамыг бүтээсэн нь” уран зургийн нууц	149
Нууцлаг Боргоцой булчирхай	151
Бүлэг 5 Шинжлэх ухаан ба сүнслэг хөгжил, тэдгээрийн нийцэл	
Хувьсал хөгжил	157
Шинжлэх ухаан ба сүнслэг хөгжил, тэдгээрийн нийцэл	161
Адислах хүчний гайхамшиг	166
Бодол ба сэтгэл хөдлөлийн хүчийг нүдэнд үзүүлэх нь	169
Бүлэг 6 Аугаа өөрчлөлт нь өсөж дэвших туршлага болж чадна	
Өсөж дэвших туршлага	177
Гэрэл ба Аялгуу бясалгах нь бидний цор ганц өмөг түшиг	178
Халдварт өвчний эсрэг хамгийн сайн ерөндөг – Арьяабалын бясалгалын Арга	181
Бүхнийг чадагч Арьяабалын даатгал	183
Бясалгалаар үйлийн үрээ цэвэрлэ	185
Амь аврах эцсийн дээд арга	185
Өвчин бас л дохио сануулга юм	186
Галзуу дэлхий дээрх Бүхнийг чадагч хамгаалалт	187
Зөвхөн сүнслэг бясалгал бүх өвчин зовлонг арилгаж чадна	188

14. Амьдралаа солонгоруулъя	Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай
Дотоодын анагаах энергийг хөгжүүл.....	189
Төрөлх хамгаалалтын тогтолцоогоо ашигла.....	190
Эерэг чанараа хөгжүүлэхүй.....	191
Бурхан эсвэл чөтгөр байх эсэхээ бид бодлоороо бүтээдэг	192
Гамшгийг зайлуулж, бие сэтгэлийг гэрэлтүүлэхийн тулд Ургамал хоолтон болоорой	194
Веганизм таныг илүү эрүүл болгодог	196
Дархлааны дотоод хүчээ идэвхжүүл.....	197
Бид үнэндээ бүр ч сайн сайхан амьдарч чадна	198
Чанагуух - Ертөнцийн эмчилгээ.....	200
Бүлэг 7 Амьтай бүх бүтээл эн тэнцүү	
Ахимса-Анд найз амьтдадаа хайр энэрлээ тэлье	207
Амьтай бүхэн эн тэнцүү	208
Дэлхийгээ бүх амьтантай хуваалцъя.....	210
Амьтад бидний анд нөхөр.....	212
Гэрийн тэжээвэр амьтнаа өөр шигээ хайрла	213
Бүлэг 8 Сүнсний хос	
Сүнсний хос гэж юу вэ?	221
Сүнсний хосын сүнслэг ач холбогдол юу вэ?	222
Сүнсний хостойгоо холбогдох шаардлагатай юу?	223
Сүнсний хостойгоо хэрхэн учрах нь.....	224
Хаа сайгүй оршигч болох нь сүнсний хос олох шаардлагагүй гэсэн үг	225
Сүнсний хамт олон	226
Бид цөмөөрөө Орчлонгийн аугаа үйлсийн хэсэг	228
Бүлэг 9 Гэрлэлт ба Сүнслэг хөгжил	
Гэрлэсэн ч бай үгүй ч бай, өөрөөрөө л байгаарай	233
Гэрлэлтийн мөн чанар	235
Амьдралын хамгийн сайн замыг сонгох.....	236

	Агуулга. 15
Зүрх сэтгэлийн асуудлаа зохицуулах нь	237
Гэрлэлтийн зөрчлийг шийдэх арга	240
Гэрлэлт бүтэмжтэй байх нь	242
Гэрлэлтээ хадгалахыг хамгийн сайнаар хичээ	243
Гэрлэлт ба сүнслэг хөгжил.....	245
Сайн хань ижил бай	247
Аз жаргалтай гэр бүлийг төлөвшүүлэх нь	249
Хань ижлийн үүргээ биелүүлээрэй.....	255
Бүлэг 10 Залуу үеийг Алтан эринд дагуулахуй	
Залуу бясалгагчдыг хэрхэн төлөвшүүлэх вэ?.....	259
Залуу үеийг Алтан эринд дагуулахуй	261
Залуу насны сатаарлыг даван туулах нь	263
Сурч боловсрох соёлыг дээшлүүлэх	264
Өсвөр үеийг сүнслэг хөгжилд чиглүүлэх	266
Бясалгал бол нэг төрлийн боловсрол юм.....	268
Боловсрол гэр бүлээс эхэлдэг	269
Гэр бүл бүхэн сүнслэг бясалгал дадуулж, хүн бүр гэгээнтэн шиг байх.....	271
Ёс зүйн ойлголт ухамсрыг бага наснаас нь төлөвшүүлэх	274
Оройн дээдийн их сургууль	280
Чанагуух сургууль.....	280
Хөгжим залуучуудад нөлөөлөх нь	281
Авшиг хүртэхүй: Арьяабалын Бясалгалын Арга.....	282
Ном хэвлэлийн танилцуулга.....	284
Бидэнтэй холбоо барих	288

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бидний сүнсийг хамгийн гүн хөндөж, хязгааргүй хайраар дүүргэн, өргөн дэвшүүлдэг аялгуут дуу хөгжим, шүлэг найраг олныг туурвисан билээ.



Бүлэг 1

*Бурханыг таних нь
хүний амьдралын зорилго юм*

Хүний амьдралын зорилго

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Брисбэйн хот, Австрали улс, 1993 оны 3-р сарын 22 (Дүрс бичлэг №338)
(Эх нь Англи хэлээр)

***Асуулт:** Бид зорилгоо хэрхэн мэдэж, үүнийгээ бидний зорилго гэдэгт лавтай итгэлтэй байх вэ? Хүмүүс асуувал тэдэнд амьдралын зорилгоо мэдэхэд нь бид тусалж чадах уу? Энд бид хувь хүнийхээ хувьд юу хийх ёстой вэ?*

Их Багш: Бид энэ дэлхийг адисалж, мөн өөрийн аугаа чанарыг таньж мэдэхийн төлөө энд байгаа юм гэж Би нэгэнтээ дурдсан. Бид өөрийн аугаа чанарыг мэдсэнээр бүх орчлонгийн сансар эрхэсийн хүчтэй нэгдмэл болдог. Тэгээд бидэнтэй холбоо харилцаа үүсгэсэн хэн ч энэхүү орчлонгийн сансар эрхэсийн хүчнээс мөн л адислагдана. Бидэн шиг өшөө олон хүн бясалгаж, сүнслэг буян ба билиг ухаанаараа дэлхийг чимээгүйхэн адислах тусам манай Дэлхий улам илүү хөгжих болно. Энэ бол бидний зорилго юм. Эс бөгөөс өөр юу байна гэж та бодож байна? Бид энд өдөрт хоёроос гурван удаа хооллож, хэдэн хүүхэдтэй болоод л дуусах гэж үү? Юутай ч байсан энэ жинхэнэ зорилго биш юм! Бурхан нэн их бэрхшээл туулан байж биднийг бүтээчихээд энд хэдэн арван жил байлгаж байгаад л зовж зүдэн үхэх, заримдаа хорт хавдар, тарчлаан тамлалт, гамшиг, газар хөдлөлт гэх мэтээр зовж үхэхийг болгоодог гэвэл утга авцалдахгүй байна. Энэ бол учир зүйгүй хэрэг.

Иймээс, хүний амьдралын зорилго нь Бурханыг танихад оршино. Бурханыг таних гэдэг нь бид өөрсдийн аугаа чанараа танин мэдэх, бид өөрсдөө нэг хэсэг нь болдог сансрын хүчийг бүхэлд нь мэдэхийг хэлнэ. Хэсэг гэж хэлэхэд ч бүхэл бүтэн болно, харж байна уу? Жишээ нь, хэрэв миний хурууг тайрчихвал энэ нь зөвхөн нэг хуруу л юм. Харин энэ хуруу биенд маань залгаатай байх үед биеийн минь нэг хэсэг болж, миний биед хамаарч байна. Хэдийгээр би үүнийг миний биеийн нэг хэсэг гэж хэлсэн ч үнэндээ бүхэл бие маань юм.

Тиймээс бид сансар огторгуйн хүчний нэг хэсэг боловч дахин холбогдчихвол бид мөн бүхэл бүтэн юм. Тэдний хоорондох багахан завсар зай нь авшиг хүртэх үед эргээд холбогдчихдог. Бид өөрийн дотоод руугаа ханддаг, бид дотоод руугаа нэгддэг, бид залгагддаг, ингэснээр бид орчлонтой нэгдэж бүхэл бүтэн болдог. Тиймээс бид эргэн тойронд ирсэн хэнийг ч гараа хүргэлгүй, тэдэнд юу ч хийхгүйгээр адисалдаг. Бидний энэрэн өрөвддөг, эсвэл цусан төрлийн холбоотой хэн бүхэн аврагддаг, эсвэл ямар нэг хэлбэрээр адислагддаг. Энэ нь тэдний үйлийн үрээс хамаарна, тэднийг хайрлах бидний хайраас хамаарна.

Бид яагаад энд байгаа вэ?

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Окленд, Шинэ Зеланд, 2000 оны 4-р сарын 27 (Дүрс бичлэг №686)
(Эх нь Англи хэлээр)

Буддын шашны ном сударт та бол Бурхан, Бурхан чанар таны дотор байдаг хэмээжээ. Библи сударт Бурхан энэ сүм дотор чинь л амьдардаг юм гэж хэлдэг. Тэнд Бурханаас өөр хэн байна вэ? Хэрвээ бид сүм бөгөөд тэнд гагцхүү Бурхан л амьдардаг юм бол бид Бурханаас өөр хэн байж таарах вэ? Бид үүнийгээ санахгүй байсан ч яахав, гэсэн ч бид мөн л Бурхан хэвээр шүү дээ.

Тиймээс бид бүх бурхдын Бурханы хувьд юу хийхээр сонгосон бай үүнийгээ хүндэтгэх ёстой. Бид эдгээр бүх оршихуйн Эцэг/Эхийн хувьд бид хүссэн арга замаараа амьдарч, бурханлаг Би-гээ илэрхийлэх өөрийн хүсэл эрмэлзэл, сонголтоо хүндэтгэх ёстой.

Тийм учраас Есүс бидэнд хүмүүсийг шүүх ёсгүй гэж хэлсэн. Учир нь өөр оршихуйн явахаар сонгосон зам мөрийг бид мэдэхгүй. Тэр эрэгтэй/эмэгтэй Бурханыг өөр замаар таньж мэдэж магад тул өөрийнхөөрөө үүнийг хийдэг. Тэр эрэгтэй/эмэгтэй харваас муу хүн юмуу тун дорд хүн эсвэл ёс жудаггүй гэгддэг нэгэн байх сонголт хийж магад юм. Гэхдээ энэ бол түүний Тэнгэрлэгийг таних арга зам юм. Тэр хүн бурханлаг бус байхаар сонгосноороо хэзээ нэг өдөр өөрийгөө тэр хүн биш гэдгийг мэдэх болно. Гэхдээ тэд дахиж буцаж явах ба бүхэл оршихуйг эргэн сурч мэдэх ёстой болно. Учир нь хэрэв бид Диваажиндаа үргэлж Бурхан чигээрээ байгаад байх юм бол өөрсдийгөө Бурхан гэж ухаарч танихгүй.

Тиймээс бид өөрийн аугаа байдлаа дахин нэг удаа таньж мэдэхийн тулд өөрсдийгөө доошлуулж, энэ биет түвшинд бууж ирэх хэрэгтэй. Энэ бол бидний сонголт, ийм учраас бид энд ирсэн.

Тиймээс бид яагаад энд байгаа тухай асуултын хариу нь: Яагаад гэвэл бид Бурханыг мэдэхийг хүсдэг. Цаг нь болжээ гэж мэдрэх үе бол бид өөрсдийгөө эргэн санахаар сонгосон цаг нь юм. Энэ бол бид хурдан эргэж санахын тулд сүнслэг найз нөхөд, сүнслэг бүлгийг эсвэл магадгүй сүнслэг багшийг хайж олоход бэлэн болсон цаг нь юм; учир нь бид хэрхэн эргэж санах, хаанаас эрж хайхаа мартсан байдаг. Тиймээс Жинхэнэ Өөрийгөө аль хэдийн эргэн санасан найз маань бидэнд тусалж магадгүй юм. Мөн бид өөрийгөө Хамгийн Дээд Оршихуй, Бурханаас өөр юу ч биш гэдгээ таньдаг. Бид энэ биед оршдог Дээд Оршихуйг ухаарч ойлгодог.

Гэвч Тэр үнэндээ энэ бодгаль биед оршдог ч юм биш. Тэр бидний биеийг өөртөө оршоодог. Гэхдээ дахин хэлэхэд, сүнслэг нэр томъёо хэзээ ч нарийн тодорхой шинжлэх ухаан байдаггүй. Тиймээс нэгэн багш бидэнд Бурханы тухай хэчнээн их ярьсан ч, аль нэгэн сүнслэг найз өөрийн тань доторх бурханлаг оршихуйн талаар хичнээн уран яруу ярьж магад ч, бид зөвхөн чихээр сонссоноор ойлгож чадахгүй. Тиймээс тэрхүү сүнслэг багш, хөтөч эсвэл найз бидэнд ердөө онолын хувьд төдийгүй бодит байдлаар харуулах ёстой.

Жишээ нь, Есүс манай дэлхий дээр ирээд шавь нартаа онолын ба бодит арга замын аль алинаар нь заасан. Тийм ч учраас хожим Түүний ойрын шавь нар бас гайхамшгийг бүтээж, Диваажинг үзэж, Бүтээгчийн Үг хэмээх Бурханы Дуу хоолойг сонсож, мөн Диваажингийн Гэрлийг харж, Диваажин руу дэвшин нэвтэрч, тэр ч байтугай тэнгэр элчсийг эсвэл Эцэгийг харж чадсан аж. Эцэг Моисейд хэлсэн шиг, Эцэг нь тэдэнтэй ярьсан. Тэнгэр элчис ч мөн тэдэнтэй ярилцсан байдаг.

Үүний нэгэн адил бид ингэж чадна. Учир нь Есүсийн шавь нар аугаа байсан шиг бид ч бас аугаа юм. Есүс биднийг бүгдээрээ Бурханы хүүхэд гэж хэлсэн учраас бид болон

Есүсийн шавь нар адилхан. Гэтэл бид мартчихсан байгаа тул заримдаа нэг юм уу хоёр найз бидэнд эргэн сануулахаар ирдэг, гэхдээ биднийг бэлэн болсон үед л. Учир нь бид бэлэн биш бол хэн ч бидний төлөө ихийг хийж чадахгүй.

Бид Арьяабалын Аргаар бясалгахын төлөө л төрсөн

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Тайбэй хот, Формоса, 1988 оны 3-р сарын 6 (Дуу бичлэг №CG10/17)
(Эх нь Хятад хэлээр)

Асуулт: Буддизмд 84,000 арга байдаг. Очироор огтлогч сударт энэ бүх арга бүгд эн тэнцүү бөгөөд энэрэл буяны дадал бясалгал болно гэж бичжээ. Гэвч Баатар явагч Их хөлгөн сударт, Бурхан Багш “Дээдийн ном төгсөх цаг үе” (Dharma Ending Period) -ийн мэдрэхүйт төрөлтнүүд Арьяабалын Аргаар бясалгах хэрэгтэй гэж айлджээ. Энэ нь Арьяабалын Арга мэдрэхүйт төрөлтөнд илүү тохиромжтой учраас тэр үү?

Их Багш: Зөвхөн илүү тохиромжтой төдийгүй, харин мэдрэхүйт төрөлтөн нэн тэргүүнд Арьяабалын Аргаар бясалгаж байвал зохино. Энэ санааг тодруулж өгүүлье. Бид Арьяабалын Аргаар бясалгахын тулд л хүн болж төрсөн, хэрвээ бид үүнийгээ эс хийвээс хүний амьдралд хийвэл зохих зүйлээ таньж ухаарч чадахгүй. Бид энэ амин чухал санааг эс оновчоос энэхүү үнэ цэнтэй завшаан боломжоо алдана, тэгвээс 84,000 аргыг бүгдийг ахин эхнээс нь дадуулахаар хаа нэг тийш явна. Харин эцэстээ энэ аугаа дээд аргын хаалганд хүрч, дахин хүн болж төрчихөөд бид ангижрах дур сонирхолгүй байдаг. Бид бүр гэгээрсэн Их Багштай учирсан ч бясалгахаас татгалзан, улмаар сансрын хүрдэнд дахин төрөл авахад хүрдэг. Хүн төрөлтөн бол Арьяабалын Аргаар бясалгахын тулд л төрсөн; ингэх нь бидний заавал биелүүлэх ёстой үүрэг юм.


Бид гэгээнтэн хутагт хүрэх, аугаа Билиг ухаанд хүрэх зорилгоор л хүн болж төрсөн юм. Бидний эцсийн, хамгийн эрхэм, цорын ганц боломж бол аугаа Билиг ухаанд хүрэх, мэдрэхүйт төрөлтнийг хүлсэн бусад 84,000 аргаас чөлөөлөгдөх зорилгоор хүн болж төрөх явдал юм. Гэтэл бид энэ үнэнийг ойлгодоггүй, хүн болж төрсний хувьд юу хийх ёстойгоо мэддэггүй. Арьяабалын Аргаар бясалгаснаар бид яагаад хүн болж төрсөн, бидний зорилго юу болохыг аажим ойлгодог. Яг одоо та нар эргэлзэж байна, гэхдээ надад ямар ч сонголт өгсөнгүй. Та нар асуусан учраас би үүнийг хэлэх хэрэгтэй болов. Бусад 84,000 арга тус нэмэргүй; тэд биднийг Гурван Ертөнцийн дотор хүлж байдаг. Тэд бидэнд адис ивээл, хүч, ид шидийн хүчийг авчирдаг ч биднийг Гурван Ертөнцийн дотор л хүлсээр байх болно. Арьяабалын Арга бол биднийг Гурван Ертөнцөөс чөлөөлөх цорын ганц арга юм. Энэ итгэмээргүй, бид үүний тухай тун ховорхон сонсдог нь ийм учиртай юм.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай
Шихү, Формоса, 1989 оны 9-р сарын 3
(Дуу бичлэг #CE1A)
(Эх нь Хятад хэлээр)

Өнгө Үг

Бид яагаад Арьяабалын
Аргаар бясалгаж байгаа юм
бэ? Яагаад гэвэл бид орчлон
дахь юм бүхнийг ойлгохыг
хүсдэг.

Энэ бодит нарны гэрлээс чанагш илүү
аугаа, бүр тод бөгөөд улам гоё Гэрэл бий.
Манай дэлхийн хэлнүүдээс чанагш илүү
аугаа, нэн сайхан Хэл байна. Энэ Хэлийг,
энэ Аялгууг сурмагц бид бүх хэлийг,
хүмүүсийн, тэрчлэн хамаг төрөлтөн
бүхний хэл яриаг ойлгох болно.



Гэрэл ба Аялгуу бол бидний охь чанар юм

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Лос Анжелест болсон Олон Улсын гурван өдрийн даяан, Калифорни, АНУ
1998 оны 12-р сарын 16-18 (Дүрс бичлэг №639)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: Надад хэлж өгнө үү, яагаад Гэрэл ба Аялгууг бясалгах нь гэгээрэлд хүрэх хамгийн зөв зам юм бэ?

Их Багш: Яагаад гэвэл хамгийн шилдэг нь учраас. Тайлбар хэрэггүй.

Асуулт: Энэ тухай Та жаахан нэмж тайлбарлаж өгнө үү?


Их Багш: Би их тайлбарлах тусам л энэ надад хог шиг сонсогддог. Ер нь та нар тэгвэл нарыг яаж тайлбарлах вэ? Энэ яг түүнтэй адил. Яагаад гэвэл энэ нь бид өөрсдөө юм; Гэрэл ба Аялгуу нь бидний охь чанар юм. Та буцаад өөр лүүгээ орно гэсэн үг. Өөрөөс чинь өөр юу танд илүү сайхан санагдах гэж? Загас усандаа байхаас өөр юу загасанд сайхан байх вэ? Түүнд яагаад усанд л байх нь сайхан байдаг вэ? Яагаад гэвэл тэр загас учраас. Надаас тайлбар хүслээ: Би мэдэхгүй байна.

Хэрэв та сайн байгаа бол үүнийг хэдийн мэдэж байдаг. Хэрвээ танд таатай сайхан биш байвал явж өөр ямар нэгэн юмыг эрж ол, тэгээд буцаад гүй. Энэ хамгийн сайн нь; миний мэдэх зүйл энэ л байна. Та хэрэв лавлагаа хайж байвал, бид Библи сударт бичигдсэн байгааг харж болно, жишээ нь Гэгээнтэн Жонн бүрээ дуугарахыг сонсож, аянгын дуутай хамт Бурхан ирж байв гэхчлэн. **“Хамгийн анхлан Үг байсан; Үгнээс бидний оршихуй үүссэн.”** гэж бичсэн байдаг. Энэ нь Аялгууг хэлж буй юм.

Тиймээс хэрэв бид өөрсдийнхөө элементэд байгаа бол энэ хамгийн шилдэг нь байж таарна, ийм л байна. Буддын сударт ч мөн ижил зүйл бичсэн байдаг. Коран сударт Гэрэл ба Аялгууны тухай үргэлж дурдсан байдаг; энэ бол бидний оршихуйн охь чанар юм гэж. Шинжлэх ухааны үүднээс авч үзвэл бид бол Гэрэл ба Аялгуу гэдгийг одоо та мэдлээ; бид бол энерги юм. Тэгвэл өөрсдөөс маань өөр юу бидэнд хамгийн сайхан мэдрэмж төрүүлж чадах вэ? Өөрийнхөө элемент рүү буцаж орж, өөрийгөө таньж ухаарах - энэ бол хамгийн шилдэг нь, чухам энэ л юм шүү дээ.

Асуулт: Бид өөрийн гэрлийг үзэж, өөрийн аялгууг сонсох уу?

Их Багш: Өөрийнхөө гэрлийг харж байгаа ч юм биш; та бол Гэрэл юм. Өөрийнхөө аялгууг сонсож байгаа ч биш; та бол Аялгуу юм. Та бол бүхэл орчлонг бүтээдэг тэр хэлбэлзэл юм. Та бол тийм л юм шүү дээ. Та бол энэ сансар огторгуйн Ерөнхий командлагч. Та өөрийгөө ийм гэдгээ илүү их таньж ухаарах тусам Та илүү их хүчтэй, улам эрх чөлөөтэй болно. Та өөрийгөө энэ махан бие, энэ хурууны хумс, энэ эсвэл тэр гэж ойлгохынхоо оронд, “Үгүй шүү, үгүй, тийм биш, би бол Бүтээгч. Би бол Гэрэл; Би бол Аялгуу; Би бол үнэмлэхүй зүйл” хэмээн ойлгож ухаар.



Аялгуу бясалгахын хүч

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Хонолууд болсон 4 өдрийн даяан, Хавай, АНУ
1993 оны 10-р сарын 22
(Дүрс бичлэг №383)
(Эх нь Англи хэлээр)



Зөвхөн Арьяабалын бясалгалаар л бид ухамсрын бүх түвшнийг нэвтрэн туулж чадна. Тийм ч учраас олон хүн Гэрэл бясалгадаг боловч Аялгуутай холбогдох түвшинд хараахан хүрч амжаагүй байгаа харагддаг бөгөөд тэдний амьдрал тийм ч их өөрчлөгддөггүй.

Коанууд (Зэн буддизмын шашны оньсого таавар)-ын утгыг асуух эсвэл чийдэн ширтэн гэрэл харах зэрэг оюун ухааны түвшний олон төрлийн бясалгал хийдэг хүмүүс бас л Гэрэл үздэг ч тэдний амьдрал тийм ч их өөрчлөгддөггүй. Учир нь Гэрлийн зарим түвшин нь өргөн дэвшүүлэгч Аялгууны түвшнээс доогуур байдаг. Зарим хүн Гэрэлд төвлөрөн бясалгах, мөн Самадид орох, эсвэл гүн төвлөрсөн мөчид Аялгуутай аяндаа холбогддог. Энэ үед тэд мөн Гуан Инь хийж байдаг. Тиймээс тэдэнд Аялгуу, Гэрэл хоёр хамтдаа байна. Гэвч тэд чадварлаг найз, чадварлаг хөтчийн тусламжтайгаар Аялгуутай холбогдоогүй байгаа тул хэрхэн зүдрэлгүйгээр Аялгуунд хүрэх вэ? гэдгийг мэддэггүй. Тэгэхээр бид хэрхэн үүнийг хийхийг мэддэг учраас энэ бидэнд илүү хялбар байдаг. Орчин үед “яаж хийхийг мэдэх” бол амжилтын түлхүүр юм. Тэгэхлээр, бясалгал дадуулахад бас ноу-хау хэрэглэгддэг. Тиймээс бид жинхэнэ Самадид ороогүй байлаа ч Аялгууны Урсгалын ач тусыг бага сага амсан мэдэрдэг, энэ нь бидэнд бие болон сүнсээ сэхээн сэргээхэд тусалдаг.

Онч Үг



Залуужих арга зам

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Шихү, Формоса, 1989 оны 8-р сарын 13
(Дуу бичлэг №CG15)
(Эх нь Хятад хэлээр)

Арьяабалын Аргаар бясалгаснаар бидний энергийн чичирхийлэл илүү хурдан болж, залуу хүн шиг эрч хүч ордог. Бид илүү сэргэлэн гавшгай, асуудлыг амархан тодорхойлох чадвартай, залуу хүн шиг ухаалаг болдог. Тиймээс бид өөрсдийгөө залууждаг гэж хэлж болно.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Шихүд болсон 7 өдрийн даяан, Формоса, 1991 оны 5-р сарын 5-12
(Дүрс бичлэг №163)
(Эх нь Хятад хэлээр)

Арьяабалын Аргаар бясалгахад бид өөрсдийн сүнслэг нөхцөл байдал, ойлголт ухагдахуун, билиг ухаанаа өөрчилдөг, мөн бие махбодын эрхтэн, эд эсээ дахин шинэчилж, хорноос цэвэрлэдэг. Бид бясалгах цаг завгүй бол ийм өөрчлөлтүүд гарахгүй. Бид олны төлөө зүтгээд завгүй буюу дэндүү ядарч туйлдсан үед энэ өөрчлөлт ажиглагдахгүй. Эс бөгөөс бясалгах бүрд эд эс сэргэн шинэчлэгдэнэ; тэгээд л бид “хүүхэд насандаа эргэж ирлээ” гэж хэлдэг. Бид сэтгэц оюун төдийгүй бие махбодын хувьд ч залууждаг. Бид илүү эрүүл, уян налархай биетэй, булбарай зөөлөн арьстай болсноо мэдэрдэг. Биеэс бүх хорт бодис зайлснаар бид өдрөөс өдөрт улам сайхан харагдаж, дээрддэг.

Арьяабалын Аргаас өөр ийм түргэн бөгөөд гайхамшигтай өөрчлөлт авчирч чаддаг өөр ямар ч арга би олж мэдэж байсангүй. Хүмүүсийг залуужуулна гэх маш олон янзын дасгал, бэлдмэл нийгэмд байдаг даа. Гэвч тэд сэтгэл хөдлөм үр дүн өгч байгаагүй; бэлдмэл зардаг хүмүүс нь өөрсдөө хөгшрөөд л байдаг. (Их багш болон бүгд инээлдэв) Тэд бас хөөрхөн ч харагддаггүй. Үнэн үү? (Сонсогчид:Тийм)



Онч Үг

Биеийн галбир нэн сайжрахуй

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Шиху, Формоса, 1995 оны 7-р сарын 11 (Дүрс бичлэг №488)
(Эх нь Англи хэлээр)

Хөгжилтэй шүү. Бид Арьяабалын Аргаар бясалгахад заримдаа биеийн галбир өөрчлөгддөг. Зарим махлаг хүмүүс гоолиг болдог; зарим туранхай хүмүүс бөөрөнхий болдог - тарган биш, харин илүү мяраалаг, илүү дүүрэн болдог.

Иймэрхүү зүйл олон тохиолдоно. Заримдаа авшиг хүртээд төд удалгүй тохиолдоно. Тэгэхлээр орж ирсэн, гарч явсан хүн үнэхээр танихад амаргүй. Би өөрөө ч таньдаггүй! Авшиг хүртсэний дараа тэр тэс ондоо, өөр хүн шиг харагддаг: илүү хайр татам, ойр дотно, удаан нөхөрлөсөн найз юм шиг л. Энэ их хөгжилтэй; Би үүнийг олон удаа анзаарсан.

Заримдаа хүмүүс “Яагаад Их Багш намайг танихгүй байна вэ? Би хэдхэн өдрийн өмнө очиж Түүнтэй мэндэлсэн юмсан, одоо Тэр санахгүй байх шиг байна.” гэж боддог. Би санадаг, гэхдээ зүгээр л өөр хүнийг! Та өөрчлөгддөг; бие дэх химийн бодисууд ч бас. Бид биеийнхээ зөөлөн эд, эсүүдээ өөрчилдөг. Мөн бидний сэтгэлгээний бүтэц өөр болдог, гэхдээ энд үүнийгээ ашиглах боломж гараагүй байгаа тул та үүнийг анзаарахгүй байж магадгүй юм. Харин та гэртээ харихад, эсвэл ижил асуудлыг шийдэх нөхцөл боломж үүсвэл нэг шөнийн дотор маш олон шинэ санаа бий болсныг та харах болно. Тэгээд та өөрт чинь юу тохиолдсоныг мэднэ.

Сүнслэг бясалгал дадуулахад Гэгээрсэн Их Багшийн удирдамж зайлшгүй хэрэгтэй

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Флорида, АНУ, 2001 оны 6-р сарын 8 (Дүрс бичлэг №716)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: Их Багш аа, эмнэлзүйн салбарт хүмүүс ухаарч сэрж байгааг Танд дуулгая. Саяхан Ньюсвийк болон Тайм сонинд “Йогийн хүч” мэдээ нийтлэгдсэн байгааг Та харсан болов уу. Тэд мөн сүнслэг бясалгалын туршилага, мөн экстаз буюу улангассан хөөрлийн физиологийг судалж байгаа юм.

Их Багш: Цаг нь болсон!

Асуулт: Энэ их том нийтлэл юм; Та харсан байж магад.

Их Багш: Тэдэнд бэрхшээлтэй байсан, гэвч энэ нь тэд Бурхан оршдог гэдгийг тойруугаар хүлээн зөвшөөрч буй хэрэг.

Асуулт: Энэ өгүүлэлд тэд кундалини йог хамгийн хялбар, харин хатха йог хамгийн хэцүү нь гэж хэлсэн нь инээдтэй юм.

Их Багш: Эд бүхэн бол бүгд л дасгал юм; бид үүнээс давж бүр цаашаа явах хэрэгтэй. Үнэн хэрэгтээ та Арьяабалын Аргаар бясалгаж байхдаа заримдаа кундалини сэрж байгааг мэдэрдэг. Энэ нь бүх зүйлийн ёроолоос эхлэхээс илүү жамын дагуу байдаг. Бид оройгоос эхэлдэг бөгөөд юм бүхэн дээшээ өгсөж очих ёстой. Энэ нь доороос эхэлж, авирч мацахаас илүү дээр юм. Хэрэв таны доод хэсэг илүү том бол энэ удаан үргэлжлэх болно! (Инээлдэв)

Асуулт: Гэвч маш олон хүн үүнд сохроор хандаж улмаар хүндрэлд ордог нь асуудал болж байна. Тэд янз бүрийн шинж тэмдэг, асуудлаар эмчид ханддаг. Тиймээс хүмүүсийн дасгалаас ямар нэгэн сөрөг үр дагавар гаргахгүйн тулд бүхэл бүтэн зохион

байгуулалт хэрэгтэй болдог. Тэд энэ бүхний талаар сонсож мэддэг учраас бие даан дасгал хийдэг, хүссэн бүхнээ хийдэг.

Их Багш: Би мэднэ. Та нар бол азтай нөхдүүд юм. Оюун санааны буруу дасгалын улмаас хичнээн хүмүүс “солиорсон” бэ? Би, та нарт, хүн бүрд олон удаа хэлсэн: Нэг бол юу ч бүү хий, эсвэл таныг эндээс Диваажинд хүргэх бүх замын турш дэмжин тусалж, ард тань түшиж чадах хэн нэгэн жинхэнэ Багшийг явж ол гэж. Үгүй бол та ямар нэгэн “нигилизм” (үгүйсгэх үзэл)-д, эсвэл хоосонд хаа нэгтээ төөрөх болно. Хоосон зай маш том бөгөөд сансар орчлон асар өргөн уудам; нэгэн Хөтөчгүйгээр та хаашаа явах вэ?

Тэгээд мэдээж, та зарим асури биетүүд эсвэл хар нүх рүү санаандгүй түлхэгдчихнэ. Та үүрд төөрч магадгүй, энэ аймшигтай байх болно! Энэ орчлонгоор, ялангуяа сүнслэг хүчээр тоглож наадахгүй байсан чинь дээр. Та цөмийн бөмбөгөөр наадахад л энэ чинь аль хэдийн хангалттай аюул шүү дээ. Гэхдээ энэ бол биет зүйл учраас та үүнийг зохицуулж чадна. Харин та зарим үл үзэгдэх эсвэл үл мэдэх юмсыг бол, хэрвээ та үүгээр оролдвол: Ээ, Бурхан минь, би бүр бодож эхлэх ч юм биш!

Асуулт: *Экстаз хөөрөл гэх зүйлийн тухай нийтлэлд өгүүлснээр бол хүмүүс зарим оч гялбаа хальт үзчихдэг ба дараа нь замчлаад өгөх зүйл байхгүй учраас сэтгэлээр унадаг гэдэг.*

Их Багш: Тийм ээ, үнэн. Яахав дээ, тэд эрж хайх хэрэгтэй шүү дээ. Орчин үед тэд Их Багш олохгүй байгаа бол өөрсдийнх нь буруу. Хаа сайгүй, энд тэнд юм бүхэн байна; цахим шуудан, вэб хуудас байна. Төгс Гэгээрсэн Их Багш энд тэндгүй, хаа сайгүй байна. Би компьютерээ асаах болгондоо шууд л өөрийгөө ширтдэг. “Энэ хэн бэ? Бурхан минь!” (Их Багш болон бүгд инээлдэв).

Өнөөдөр асууж байцаах тун амархан байна. Харин би мэдэхгүй юм. Энгийн хүмүүст хэн нь хэн бэ гэдгийг ойлгох тийм амаргүй байх. Тэгээд хэнд итгэхээ мэдэхгүй, тэгээд л урсгалаараа явж байдаг. Гэвч энэ харамсалтай.

Та нөхдүүд ийм учраас л энд байцгааж байна. Та нар хаа сайгүй байдаг; та нар юмнаас хаа сайгүй оршигч чанартай. Та нар хүн бүхэнд юу нь юу вэ, хэн нь хэн бэ гэдгийг хэлж чадна. Та нар Арьяабал Бодьсадва (Өршөөл Ивээлийн Дара Эх Бурхан)-гийн мянган мутар нь юм, Арьяабал Бодьсадвагийн мянган мэлмий нь юм. Та нар энд тэндгүй байдаг. Та нар аливааг хийж, ярьж, явж байдаг.

Тийм учраас би та нарыг Будда мэт биеэ авч яв гэж хэлдэг. Та нар хором бүрд үүнийг чадахгүй бол ядахдаа Бясалгалын Төв дээрээ Будда шиг яв. Энд бидэнд өөр хэн ч биш зөвхөн Будда нар л байна. Тэгэхлээр, нэг л бай. Тэгэхгүй бол та эндэх Бурханы хутгийн ой модонд өргөс шиг л ялгарч харагдана.

Асуулт: *Тэгэхлээр бид өөрсдийгөө Будда биш гэж итгэдэг нь биднийг Будда Чанараараа байхад саад болдог цорын ганц зүйл нь үү?*

Их Багш: Тийм ээ, зөвхөн энэ л юм!

Асуулт: *Энэ тэгээд тийм хялбар юм уу?*

Их Багш: Тийм ээ, хялбар. Харин таны бодол санаа үүнийг тун ярвигтай болгодог учраас энэ хялбар биш байгаа юм. Та Будда юмуу Бурханыг их хол байдаг, хүрч боломгүй, ойртож боломгүй ямар нэгэн зүйл болгочихдог. Тэгээд та юу бодсон түүн шигээ л болдог. Хэрвээ загас дотор нь сэлж буй далайгаа хаана байгааг мэддэггүй бол хэн ч түүнд тусалж чадахгүй. Хэрвээ тэр одоо сэлж байгаа далайгаа хаана байгааг мэдэхгүй байгаа бол хичнээн хол сэлж явлаа ч үүнийгээ хаана ч хэзээ ч олж мэдэхгүй. Энэ миний та нарт хэлсэнтэй адил юм: Хималайд очоод ч хэрэг байхгүй. Та эндээ байгаад, өөрийнхөө Хималайтай ажилласан нь дээр. (Их Багш билгийн нүдээ заав.)

Та хаана байна тэндээ л бай; та яг тэнд Бурханыг мэдэх хэрэгтэй. Яагаад гэвэл Тэр хаа сайгүй байдаг. Бурхан бол хаа сайгүй оршигч, бүхнийг чадагч гэж би та нарт хэлсээр байгаа. Энэ зүгээр л тоглоом шоглоом уу? “Бурханы Эзэнт улс таны дотоодод байдаг.” Энэ хошигнол уу эсвэл Есүс худлаа хэлсэн юм уу? Эсвэл “Будда дотоодод тань бий” гэдэг.

Хүний итгэл сэтгэлээр Будда даажигнана гэж үү? Үгүй ээ! Тэд бүгд Үнэнийг л хэлсэн. Тэгэхлээр та зүгээр л өдөр бүр өөртөө “Би бол Будда” гэж сануулах хэрэгтэй. Хэрвээ та Будда гэдгээ мэдэхгүй байгаа бол Будда-мэт ямар нэг үйлдэл хий. Жишээ нь, бусад хүмүүст гэгээрэхэд нь туслаарай. Та ямарваа байдлаар хүмүүст туслахын хэрээр улам илүү гэгээрч, “Тийм ээ, надад ийм хүч байна” гэж сайтар ухаарах болно.

Нэг удаа та хүмүүстэй яриад үзгэл, таны Будда Чанар гарч ирээд тэдэнтэй ярих болно. Тэгээд та ухаарах болно, “Бурхан минь, би ингэж ярьж чадлаа гэж үү? Хэн ярьж байгааг хар даа! (Инээлдэв) Би хэрхэн ингэж ярихыг өмнө нь огт мэдсэнгүй” гэдэг. Та дотоод дахь Буддагийн хүчээ илүү их ашиглах тусам бусад хүмүүсийг жамаараа гэгээрэхийг нь чин сэтгэлээсээ хүснэ. Та тэднийг албадах буюу хүчлэх биш, сүрдүүлэх биш харин жам ёсоор нь. Энэ хүчээ их гаргах тусам, та улам сайн ухаарна. “Надад ийм хүч байдаг юм байна! Өөрөөр энэ хаанаас ирэх гэж? Яаж би ингэж ярьж чадаж байна вэ?” Та нэгэнт өөрийн уран цэцэн үг, итгүүлэх хүчээ таньчихвал өөрийгөө ч бас үнэмшүүлэх болно. За, таны ачаар Би Будда болчихлоо. Энэ ийм л утгатай юм. Хэрвээ та нарт миний хэрэг байхгүй байсан бол би магадгүй Бурханы хутгийг хажуу тийш тавьчихаад л явж хөл бөмбөг тоглох байх даа. (Инээлдэв.)

Гагцхүү Гэгээрсэн Их Багшийг олсон цагт л Үнэнийг олно

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Хонконг, 1989 оны 7-р сарын 8 (Дуу бичлэг №CL 16B)
(Эх нь Хятад хэлээр)

Асуулт: Өнөөдөр дэлхий дээр олон шашны бүлэглэл байдаг. Аль нь биднийг Үнэнд хүргэхийг бид яаж мэдэх вэ?

Их Багш: Та зөвхөн Гэгээрсэн Их Багшийг эрж олбол сая Үнэнийг олох болно. Асуудал нь шашны бүлэгт байгаа юм биш. Тэд бүгдээрээ сайн, гэвч гэгээрсэн Их Багшийг эрж олох нь хамгийн сайн. (Алга ташив) Эртний Энэтхэгт нэлээд олон шашны урсгал байсан ч хүмүүс яагаад Шагжамуни Буддаг дагасан бэ? Яагаад гэвэл Тэр гэгээрсэн Их Багш байсан учраас юм. Сүнслэг бясалгал дадалдаа миний зааврыг дагаснаар та өөрийн итгэдэг шашнаа өөрчлөх шаардлагагүй. Католикчууд Есүс Христ ба Бурханд итгэх итгэлээ үргэлжлүүлж болно; Буддистууд хамгийн дээд Буддад итгэх итгэлээ үргэлжлүүлж болно, тэр бас л Бурхан юм. Хамгийн дээд Бурхан гэдэг нь хамгийн дээд Будда юм; цорын ганц ялгаа нь тэдний танигдсан нэр юм. Дотооддоо буй Хамгийн Дээд Хүчинд л итгэх нь бидний хийх хэрэгтэй зүйл нь; түүнээс биш ер нь юуг ч өөрчлөх шаардлага байхгүй.

Будда, Бодьсадва нар, Энэрэл Өршөөлийн
Дарь эхүүд, Мария, Есүс гээд Бурхадын янз бүрийн
трасценденталь хэлбэрүүд бүгд нэг л

Хүчнээс ирдэг. Тэд нар мэдрэхүйт
төрөлтний дур сонирхолд таарч
нийцэхийн тулд үргэлж өөрчлөгдөж
байдаг. Тэд Газар дэлхийн янз бүрийн
өнцөг буланд мэдрэхүйт төрөлтнийг
гэтэлгэн чөлөөлөхийн тулд
өөр өөр хэлээр ярьдаг.

~Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Онч Үг



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Коста Рика, 1990 оны 12-р сарын 16
(Дүрс бичлэг №141) (Эх нь Англи хэлээр)

*Хэрэв хүн бүр Библи эсвэл Буддын
ном сударт юу сургасныг үнэнчээр дадуулах
юм бол тэд хэзээ ч өөр хоорондоо эв
эвдрэлцэхгүй, бүх шашин нэг сүмд хамтдаа
баярлаж, нэг нэгэнтэйгээ жаргалтай байх
болно. Пап хийдэд ирж, лам сүмд очиж, ямар
ч асуудалгүй байх болно.*



*Ганц л шашин байдаг – тэр нь Оройн Дээд
Бурханы, хайр энэрлийн, ойлголцлын шашин л юм.
Зөвхөн ганц л сүм, ганц л хийд байдаг нь -
гэгээрлийн хийд юм. Энэ хийдэд очоорой, тэгвэл
бид дэлхийн бүх шашныг мэдчихнэ.*

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Тайнан, Формоса, 1989 оны 8-р сарын 31
(Дүрс бичлэг №CG 10/17) (Эх нь Хятад хэлээр)

*Бидний өөрийн дотоодын Их Багш аугаа их билиг
ухаантай. Энэ хорвоогийн хууль ёсыг үймүүлэх, бусдын хэрэгт
хөндөлсөх, өөртөө гэм хор учруулахаас зайлсхийхийн тулд бид
юу хийх, юу ашиглах хэрэгтэйг Тэр мэддэг. Энэ нь бидний ой
тойнд бүртгэгдсэн нэн хязгаарлагдмал ид шидийн хүчнээс өөр
юм. Хэрвээ бид зарим ид шидийн хүчээ таньж мэдэх юм бол
бидэнд байгаа бүх зүйл ердөө л энэ болчихно. Хэрвээ бид ид
шидийн хүчүүдийг Арьяабалын Аргаар бясалгаснаар үүсгэн
гаргана гэвэл тэдгээр нь сэтгэшгүй бөгөөд бид янз бүрийн
нөхцөлд өөр өөр хүчийг ашиглаж чадна.*

*Ийм аугаа билиг ухаан байхгүй бол бид сүнслэг бясалгал
дадалдаа амархан төөрч будилах болно. Сайн багшгүйгээр бид
амархан мэхлэгдэнэ. Үр дагаварт нь бид бүхэл бөгөөд бүрэн
төгс зүйлийг нь сурахын оронд тодорхой хэсгийг л сурч мэдээд,
түүнээгээ л дагана. Олон шашин биднийг энэ тэрийн элдэв
зүйлс, ид шид, янз бүрийн арга техник сургахад ач холбогдол
өгдөг; тэд бидний анхдагч Чанарыг олж нээхийг чухалчлан
хэлээгүй байдаг.*



Аугаа Багш таны дотоодод бий.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Харвардын Их Сургууль, АНУ, 1989 оны 10-р сарын 27
(Дүрс бичлэг №101F) (Эх нь Англи хэлээр)

*Үнэндээ би та нарт өөрийгөө-сургах аргыг л үзүүлнэ.
Таны өөрийн Будда сэрж босоод, танд зааж сургах болно. Таны
өөрийн Бурхан сэрж босоод, таныг сургах болно. Харин эхлээд би
таны доторх аугаа багш тэрхүү Бурханыг буюу Буддаг яаж
сэрээхийг танд үзүүлэх ёстой. Таны дотоодын Бурханы Хаант
улс буюу таны доторх Будда л аугаа багш чинь болохоос би биш
юм. Харин би бол хэрхэн Түүнийг сэрээгээд, таныг Түүнд
танилцуулж, босож зөв ажлаа хий гэж Түүнд хэлэхийг мэднэ. Энэ
бүгд бол миний хийх ажил юм.*

Эзотерик ба экзотерик зам мөр

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Хонконг, 1989 оны 7-р сарын 8 (Дуу бичлэг №87)
(Эх нь Хятад хэлээр)

Асуулт: *Сүнслэг бясалгал дадалд эзотерик ба экзотерик зам мөр ямар ялгаатай вэ?*

Их Багш: Нэгдүгээрт, сүнслэг хөгжил "эзотерик" болон "экзотерик" талуудыг хоёуланг нь багтаасан тохиолдолд л төгс болно. Гэтэл ихэнх хүн эзотерик аргаар бясалгаж чаддаггүй, учир нь уг аргыг зааж уламжлах гэгээрсэн Их Багштай уулзаагүй эсвэл тэрхүү жүд дамжлагыг эрж олоогүй байдаг. Иймээс тэд зан байдал буюу ёс суртахууны хэм хэмжээндээ өөрчлөлт гаргахгүйгээр дагаж болдог, нийтэд нээлттэй заагддаг экзотерик зам мөрийг сонгодог. Буддагийн хөшөө барималд мөргөдөг, сүм хийдэд хандив өргөдөг хүмүүс бүр заримдаа гахай нядалдаг хэрнээ л экзотерик бясалгагч гэж тооцогддог. Эзотерик бясалгалын сүсэгтнүүд өндөр ёс суртахуунтай, сахилаа хатуу сахьдаг байх ёстой бөгөөд үе дамжин уламжлуулсан олон нууц аргыг мэддэг. Гэсэн ч, эгэл хорвоо дэлхийн хэлийг хэтийдэн давсан эзотерик аргыг эзэмшсэн гэгээрсэн Их Багшийг олох хамгийн хэцүү. Тэр л энэ биет бус номын цогцыг сурч дүүргээд, “дүрслэх ч боломжгүй, нэрлэх ч боломжгүй” үнэн аргыг эзэмшсэнийхээ дараа энэ аргыг бидэнд дамжуулж чадах юм.

Экзотерик зам мөрд орсон бясалгагч нар Буддизмын маш олон нэр томъёог сурч, олон ном судрыг судалж байж энэ сургуулиа дүүргэх ёстой. Тэд нар Будда, Махаяна эсвэл Махапражнапарамита гэж юу болохыг мэдэх хэрэгтэй байдаг. Тэд хүмүүсийн асуултад хариулж чаддаг байхын тулд энэ бүх зүйлийг сурч мэдэх хэрэгтэй болдог. Зөвхөн тэгж байж л тэд экзотерик аргыг номлох боломжтой болдог. Эзотерик аргыг сургах ном судар байдаггүй учир дадал бясалгалыг нь хийх илүү бэрхшээлтэй. Бид маш олон насандаа бясалгал дадуулах, Үнэнийг олохын төлөөх хүчтэй хүсэл тэмүүлэлтэй байх, түүнчлэн чин сэтгэл, сахил, хичээл шамдалдаа найдах хэрэгтэй

болдог. Бид өөрийн гэгээрсэн Их Багшаа олох хүртэл өөртөө л итгэж найддаг. Тийм учраас эзотерик зам мөрийг суралцаж төгсөх нэн хэцүү. Шагжамуни Будда экзотерик болон эзотерик замуудыг хоёуланг нь гүйцэлдүүлжээ. Тэр ямар ч зүйлийг зааж, дөрвөн Вед зэрэг аль ч судрыг сайтар ухуулан тайлж чаддаг. Энэ сэдвээр Брахманд итгэгчидтэй эсвэл хэн нэгэнтэй ямар ч бэрхшээлгүй мэтгэлцэж чадаж байв. Тэр мөн үг хэлээр эсвэл бичгээр илэрхийлэн дамжуулан уламжлах боломжгүй эзотерик онол сургаалуудыг нэвтэрхий эзэмшжээ. Тэрбээр энэхүү биет бус ном сургаалын сургуулийг дүүргэсэн байсан тул үүнийг Өөрийнхөө сүсэгтнүүдэд дамжуулж чадсан юм.

Энэ хоёр зам мөрийн ялгаа гэвэл эзотерик аргыг тун цөөн хүн бүрэн сурч дүүргэсэн байхад экзотерик аргаар маш олон хүн бэлтгэгдэж төгсжээ. Буддист сургуульд нэлээд хэдэн жил суралцаж төгссөн жирийн хүмүүсийг мөн экзотерик сургуулийг төгсөж дүүргэсэн гэж үздэг. Тэгэхлээр, эгэл бясалгагч хүмүүс ч Махапражнапарамита-гийн тодорхойлолт; Аугаа Өршөөлийн Мантра; эсвэл жинхэнэ Аминдаваа Бурханы уг гарал, Түүний нэрийн утга болон яагаад бид Түүний нэрийг дурьдан унших хэрэгтэй талаар олон түмэнд тайлбарлаж, номлож болно.

Эсрэгээрээ, эзотерик сургууль тун бэрх. Үүнд түшиглэж тулгуурлах ямар ч ном судар байхгүй. Бид зөвхөн өөрийн Бурхан Чанар ба уг замыг нээх билиг ухаанаасаа хамаарна. Бид түүнд бүрэн нэвтрэх хүртлээ өдөр бүр хичээнгүйлэн бясалгаж, хүсэн тэмүүлнэ. Зөвхөн тэгж байж л уг аргыг бид бусад хүмүүст дамжуулж чадна. Энэ бол үнэхээр хэцүү, яагаад гэвэл үнэн бөгөөд биет бус сургаал, бид зөвхөн биет бусаар бөгөөд анир чимээгүй олж авч болдог, бидний биет бус хөрөнгө, Муни-Сувд юм. Тэр байтугай Их Багш ч бидэнд тусалж чадахгүй; Тэр биднийг зөвхөн замд газарчилж чадна. Бид Билиг ухаанаа ашиглахын тулд өөрийнхөө хүчин чармайлт, хэрхэх-мэдлэг ухаан (ноу-хау)-аа зориулах ёстой.

Амьсгалын бясалгал нь эцсийн дээд арга биш

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Харвардын Их Сургууль, АНУ, 1991 оны 2-р сарын 24
(Дүрс бичлэг №155) (Эх нь Англи хэлээр)

Зарим хүн надаас амьсгалыг, зүрхний цохилтыг зогсоодог бясалгал зааж чадах уу гэж асуудаг. Би “Тэгтлээ яарах хэрэггүй. Азнаад хүлээ; таныг үхэхэд энэ бүх зүйл бүгд тохиолдоно.” гэж хэлдэг. Энэ тийм хиймээр чухал зүйл биш. Бидэнд байгалийн жам ёсонд хөндлөнгөөс оролцох хэрэг байхгүй. Энэ бол гэгээрэх зам биш. Тэгтэл тэд дулаанаар дамжин самадийн гал мэт - самадийн хүчийг бий болгох биеийн дулааныг ихэсгэх бясалгалын аргыг зааж өгөх үү гэж надаас асуусан. “Шаардлагагүй, зүгээр л зуух руу үсэрч ор.” гэж би хэлсэн!”

Энэ утгагүй зүйл! Гэгээрэлтэй ямар ч хамааралгүй. Магадгүй Хималайн ууланд байгаа Их Багш эсвэл бясалгагч нар хангалттай дулаан биш байдаг байх, тэгээд тэд Хималайн хүйтэн цаг агаартай үед биеэ дулаацуулахын тулд наран сүлжээнээсээ бидний хэлдгээр “түмэ” дулааныг бий болгох аргыг дадуулах хэрэгтэй болдог байж магадгүй. Харин энд бидэнд төвлөрсөн халаалт дулаан бас халаагуур ч байна, бидэнд бүх юм байна, түүний хэрэг энд алга. Тэгээд би Буддагаас нэгэн жишээ татсан. Нэгэн хүн Будда дээр ирээд би голын усан дээгүүр нөгөө эрэг хүртэл алхаж чадна гэж сайрхжээ. Будда “Ийм болохын тулд хэр удаан дадуулав даа?” гэж асуув. Тэр “Хорин таван жил” гэжээ. Будда: “Тэгж цаг, мөнгө үрэх гэж? Би тавхан зоос төлөөд л завиар гол гаталчихна.” гэж хэлжээ.

Эдгээр нь буруу үзэл санаа юм. Бид хүн төрөлхтний төлөө өөр юу хийж чадах вэ гэдгийг мэдэх, орчлонтой бид ямар хамааралтай юм, бидэнд маш ихийг зориулдаг орчлонд бид хэрхэн ямар нэг зүйлийг өгч чадах вэ гэдгийг мэдэх; эсвэл өөрсдөө зовлонгоос ангижрах, төрөх үхэх ба дахин төрөхийн боолчлолоос өөрсдийгөө чөлөөлөхийн төлөө л өөрсдийгөө

гэгээрүүлэхээр бясалгадаг. Гэхдээ бид гайхуулах гэж бясалгадаггүй. Энд дулааныг өсгөх эсвэл хүйтэн болгох, амьсгал ба зүрхний цохилтоо зогсоох гэх ямар ч хэрэг байхгүй. Эдгээр нь мөнх бусын үзэгдэл, байгалийн ажил үүрэг. Бид ийм зүйлээр яршиг удахгүй.

Бурхан Чанар амьсгалд байхгүй; зүрхний цохилтод эсвэл ходоодны халуунд байхгүй. Бурхан Чанар тэдэнд бас л бий, гэхдээ тэд Бурхан Чанарын зөвхөн өчүүхэн жижиг ганц тал нь юм. Харин бид бүхэл бүтнээр нь олох хэрэгтэй, тэгвэл бид жижиг хэсэг бүрийг ойлгох болно. Бид бүхэл бүтнийг нь мартчихаад л жижиг зүйлсэд нь санаа зовох гэх хэрэггүй юм. Бид түвшингээ дээшлүүлэх, улам цааш ойлгодог болохын тулд, ядаж оюун ухааны түвшингээ дээшлүүлэхийн тулд ийм буруу үзэл санааг өөрчлөх хэрэгтэй. Хэрвээ бид иймэрхүү үзэл санаа буюу үеэ өнгөрөөсөн мухар сүжигт хүлэгдсээр байвал илүү иргэншсэн, улам ухаалаг байх итгэл найдваргүй болно.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Панам, 1991 оны 1-р сарын 28 (Дүрс бичлэг №146)
(Эх нь Англи хэлээр)

Пранаямагаар хичээллэснээр танд олон ач тустай байх нь дамжиггүй. Эрүүл болж магадгүй, арай урт наслах биз, зарим нэг ид шидийн хүчтэй ч юм уу, эсвэл та илүү тайван болж магадгүй. Иймэрхүү өгөөжөөс өөр юу ч байхгүй. Гэхдээ пранаяма дангаараа таныг юунд ч хүргэхгүй, учир нь амьсгалгүйгээр бид мөнхөд амьдарна. Бидний амьдрал гэж нэрлэдэг зүйл нь махан бие гэсэн утгаар байх ёсгүй. Хэрэв та амьдралыг бие махбод гэж үзэж байвал тэр дасгалыг хий л дээ, зөвхөн жирийн хүмүүсийн хувьд л амьсгал бие махбодод чухал юм. Олон хүнд үүний хэрэг байдаггүй. Та Йогонандагийн “Йогчийн намтар” номыг уншсан уу? Түүний Их Багш нь самадид байхдаа амьсгал ч авдаггүй.

Амьсгалахгүй байсан үедээ тэр билиг ухаангүй байсан гэж та бодож байна уу? Түүний билиг ухаан хаачсан байх вэ? Тэр амьсгалахгүйгээр Пранаяма хийж байхдаа хэрхэн билиг ухаан олж авсан байх вэ?

Олон хүн Пранаяма биш, амьсгалын аргаар хичээллэж байхдаа амьсгалаа тоолж байдгийг би мэднэ. Амьсгалтай холбоотой, амьсгалыг төвлөрөх аргаа болгодог олон дасгал байдаг. Анхаарлаа төвлөрүүлэх тухайд бол энэ тусалдаг. Энэ нь зарим хүнд тус болдог, гэхдээ би үүнийг ашиглахыг хэнд ч зөвлөхгүй. Түр зуурын амьсгалд найдахаас дээр олон арга бий. Та гадны тусламжид найдахгүйгээр оюун ухаанаа өөрөө, сүнсний хүчээр төвлөрч сургах ёстой. Тэгэхгүй бол осолд орох, ухаан алдах, үхэх, өвдөх үедээ, унтаж байхдаа бас амьсгалаа мэдрэхгүй байхдаа та яаж дасгал хийх гэж? Бид зөвхөн сэрүүн байхдаа эсвэл амьсгалаа мэдэрч байхдаа дасгал хийдэг байж болохгүй. Бид 24 цагийн турш үргэлж дасгал хийж сурах ёстой бөгөөд үүнийг гагцхүү сүнс л хийж чадна.

Амьсгалгүйгээр үргэлжлүүлж чадах хэмжээнд хүртэл амьсгалын дасгал хийдэг олон хүнийг би мэднэ, энэ нь эдгээр аргуудын хамгийн дээд амжилт юм. Хэрэв хэн нэгэн амьсгалахаа зогсож чадвал тэд түүнд баяр хүргэнэ, учир нь энэ бол тэдний хүрч чадах хамгийн дээд цэг юм. Гэвч тэд амьсгалаа зогсоох үед, амьсгалах нь тэгээд ч тийм их чухал биш гэсэн үг юм. Та үүнгүйгээр амьдарч чадна.

Үнэндээ, хэрвээ намайг та нарт үнэнийг хэлэхийг болгоовол, амьсгалаар оролдох хэрэггүй. Бие махбод дотор хоёр гүйдэл байдаг: нэгийг бидний амьдралын хүч буюу "шабд" (shabd) гүйдэл гэж нэрлэдэг, нөгөөг нь "мотор" гүйдэл буюу амин гүйдэл гэж нэрлэдэг. Шабд гүйдэл бол амьсгалтай амьсгалгүй, амьд амьгүй, амьдралын бүхий л төрөлд чичирхийлж байдаг Бурханаас ирсэн гүйдэл юм. Шабд бол бидний сонсдог гүйдэл юм. Нөгөө нь дулаан, хүйтэн, хоол боловсруулах ба амьсгалын замын тогтолцоо, амьсгал зэрэг бүх зүйлийг хариуцдаг мотор гүйдэл юм. Үүнийг хэдийн зохицуулсан, бид үүнд санаа зовох хэрэг байхгүй. Дээд Оюун Ухаантан үүнийг зохицуулдаг учраас бид үүнийг ямар нэг аргаар урт богино болгох, зогсоох, хянах гэх ёсгүй. Хэрэв бид энэ машинтай хутгалдвал тэр буруудаж мэднэ.

Асуудалтай байгаа үед нь бид түүнийг засах эсвэл анхаарал тавих ёстой; тийм биш бол бид санаа зовох хэрэггүй, эсвэл бид буруу товчлуурт гар хүрчихвэл тэр бүхэлдээ буруудах болно.

Мессиа ирчихсэн байна

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Калифорни, АНУ, 1991 оны 5-р сарын 19 (Дүрс бичлэг №170В)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Хуучин Гэрээ болон Жүүд шашины талаар Та ямар санал бодолтой байдаг вэ*

Их Багш: Сайн л зүйл, гэхдээ Мессиаг хүлээх хэрэггүй, гуйя, учир нь Тэр бүх цаг үед ирдэг. Та өөрөө орчин цагийн Мессиаг таниасай гэж залбираарай; өөрсдийнхөө хүлээж байгаа Мессиаг ирээсэй гэж залбираад хүлээгээд байх хэрэггүй. Та нар одоогийнхоо аргаар Түүнийг хүлээх юм бол Тэр хэзээ ч ирэхгүй. Есүсийг ирэхэд тэд мөн л Мессиаг хүлээж байсан мөртлөө гартаа байгаа нэгнийг алчихсан шиг. Бид үргэлж л тэнэглэлээ давтаж байдаг.

Хэргийн учир нь Жүүд шашин муу байгаа юм биш; бидний мунхагт байгаа юм. Тэр байтугай Есүс ч бидэнд тайтгаруулагч илгээхээ амласан; энэ нь Түүнийг явсны дараа өөр хэн нэгэн ирнэ гэсэн үг. Биднийг тайтгаруулж чадах хэн нэгэн нь Түүнтэй эн чацуу нэгэн гэсэн үг, гэтэл бид хоёр мянган жилийн хойно хүлээсээр л байна. Олон Мессиа ирээд буцсан байдаг, бид одоо ч тэнгэрээс ирэх нэгнийг хүлээсээр л байна. Бид ийм маягаар хүлээх юм бол Тэр хэзээ ч ирэхгүй.

Бид Есүс дахин үзэгдэнэ гэж сонссон; Түүнийг ямаршуу ирнэ гэж та бодож байна? - бидэнд танигдахын тулд Тэр далавчтай, сахалтай эсвэл загалмайтай байх уу? Хэрэв Тэр ирдэг юм гэхэд бид Түүнийг хэрхэн таних вэ? Бид тэр байтугай Есүс ямар дүр төрхтэй байсныг ч мэдэхгүй шүү дээ. Бид тэр үед байгаагүй, байсан байлаа ч хоёр мянган жилийн өмнө шүү дээ, тийм сайн ой санамжтай хүн хэн байх юм бэ? (Инээлдэв.)

Есүс дүрээрээ биш, харин сүнсээрээ ирдэг. Есүс хангалттай ухаж ойлгосон нэгэнд, Түүнийг оруулах зөв хаалгаа нээсэн хэнд ч ирнэ. Тэгж бид Есүстэй, эсвэл Эцэгтэй адил болно. Тэр мөчид Есүс дахин ирнэ. Тэр үргэлж буцаж ирдэг; бид бэлэн болох цагт Тэр ирдэг.

Түүнийг өөртөө багтаах, Түүний бүхнийг чадагч хүчийг агуулах чадвартай аливаа Их Багшаар дамжин Тэр ирнэ. Тэр хүн мөн л Есүс - өөр үс зүстэй, эсвэл өндөр өсгийт өмссөн байж ч мэднэ, гэвч Тэр бас л Есүс юм. (Инээлдэж, алга ташив)

Их Багш бүр Христийн Хүчтэй байх ёстой

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Сидней, Австрали улс, 1993 оны 3-р сарын 17 (Дүрс бичлэг №334)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Бурханы цорын ганц төрсөн Хүү бөгөөд орчлонгийн Хамгийн Дээд Мессиа – Есүс хэлэхдээ “Би бол зам, Үнэн ба амьдрал. Хэн ч надгүйгээр Эцэгт маань хүрч очихгүй.” гэж хэлсэн; Есүсээс өөр хэн ч Диваажин, Бурханы оронд нэвтэрч чадахгүй гэдэгт Та итгэдэг үү?*

Их Багш: Тийм ээ, энэ үнэн; Их Багш бүр тийн айлдсан. “Есүс” бол Түүний лагшингийн нэр; “Христ” бол Түүний алдар. Их Багш бүрд энэхүү Христийн хүч байх ёстой; тиймээс энэ утгаар бол Есүс хэзээ ч үхээгүй. Есүс бүхий л цаг үе, олон зууны туршид, бүхий л Их Багш нараар дамжуулан биднийг гэтэлгэх ба гэгээрүүлэх ажлаа хийсээр л байгаа, мунхаг харанхуй нь бас л ард хоцорч үлддэг. Хэрвээ Тэр явчихвал Есүс ганцаараа биднийг гэгээрүүлж чадахгүй. Тэр чадна л даа, гэхдээ тодорхой хэмжээгээр, харин бид хүн шүү дээ. Тэр өндөр дээд ертөнцөд байх үед Бид Түүнд хүрч чадахгүй. Тийм учраас л амьд биеэр заларсан Их Багш зайлшгүй чухал. Харин Христийн хүч нь тухайн цаг үедээ заяагдсан буюу амьд заларсан Их Багшаар дамжин ажилладаг. Тийм учраас Есүс Өөрийгөө цор ганцхан зам, зөвхөн ганц гэж хэлж байхдаа туйлын үнэнийг ярьсан. Харин аль ч Их Багш амьд сэрүүн байхдаа мөн л тийм байдаг.

Библи сударт дулдуйдахын бэрхшээлийг би мэднэ. Олон Буддист хүн бас л ийм байдаг. Библи болон олон ном судар нь эрт урьдын Их Багш нарын гайхамшигтай нотолгоо юм, гэхдээ бас бидний оюун ухаан шунан хүлэгдэх томоохон саад тээг болдог. Энэ үнэхээр хэцүү гэдгийг би мэднэ. Би та нарт зөвхөн хамгийн сайныг хүсэж чадах байна, мөн таны ойлгох тэр цаг ирэх хүртэл би ердөө тэвчээртэй хүлээх л байна.

Манай Газар Дэлхийг ивээсэн нэгэн гарамгай дээд Их Багшийн цорын ганц баримт бичиг нь Библи юм, тэгвэл Есүсээс өмнө бас дараа ирсэн тэдний тухайд юу болсон бэ? Есүсийн дараа ирсэн нь магадгүй ингэж хэлэх байх: “За, бид Түүний нэрийг сонсоод гэтэлгэгдэх болно.” Харин Есүсийн өмнөх тэрбум, их наяд жилд тэднийг аврахаар хэн ч ирээгүй гэж үү? Эцэг маань зөвхөн ганц Хүүгээ бас ганцхан удаа л явуулдаг тийм өршөөлгүй гэж үү? Тэр тийм нарийн харамч байх уу?

Хэрэв Есүс үнэхээр биднийг бүгдийг нь аварч чөлөөлсөн юм бол яагаад бид мунхаг харанхуй хэвээр байж байгааг та нар надад үнэнээр нь хариулж өгөх үү? Энд бидний мэдэхгүй зөндөө юм байна; бид Диваажинтай холбогдож чадахгүй байна. Зарим хүн чаддаг; тэднийг нэн гүнзгий, чин сэтгэлээр Есүст залбирахад магадгүй Тэр тэдэнд үзэгдээд заримыг нь сургана, гэхдээ маш цөөхнийг. Тэр бидэнд бүгдэд нь үзэгдэх нь үгүй. Харин манай шавь нарт Тэр үзэгддэг, яагаад гэвэл бид яаж түүнтэй холбогдохыг мэднэ. Бид түүний түвшинд хүртэл дээш өгсөж, Түүний сургаалыг шууд хүлээн авч чаддаг. Би ямар нэг өөр зүйл сургадаггүй. Хэрэв та Есүсийг болон Бурханыг харахыг хүсвэл Би танд зүгээр л туслах болно. Хэрэв та Буддаг харахыг хүсвэл танд би тусална, ингээд л боллоо-гэхдээ та тэртээ тэргүй бид ихэнхийг нь ойлгодоггүй нэгэн аугаа Их Багшийн эрт урьд цагийн баримт бичвэртэй зууралдаж байхынхаа оронд үүнд итгэх л юм бол шүү дээ.

Христ гэж юу вэ?

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Грекийн Атен хот, 1999 оны 5-р сарын 20 (Дүрс бичлэг №653)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Христ гэж юу вэ?*

Их Багш: Энэ Христийн улс орон биш үү? (Инээлдэв) За яахав, та “үл-мэдэхийн” дүр эсгэснээс хойш би бас ямар нэг юм мэддэг дүр эсгэн, яриагаа үргэлжлүүлэхийн төлөө танд үүнийг тайлбарлая. (Инээлдэв)

Христ гэдэг бол Тэнгэрлэг Ухамсрын нэр. Тэнгэрлэг Ухамсрын олон янзын нэр байдаг. Хэн нэгэн сэрж сэхээрэхэд тэр “Христэд итгэгч” гэж нэрлэгддэг. Энэ бол Христийн нэр томъёо. Бусад өөр улс оронд, өөр зан заншилд, мөнхүү л ижил Хүчийг янз янзаар нэрлэдэг, энэ олон янзын нэр томъёоноос болж бид маш олон янзаар нэрлэгдсэн “шашин”, тэр байтугай шашин хоорондын дайнтай байдаг. “Эж” гэхийг Грекээр юу гэж хэлэх вэ? (Хариулт: МНТЕРА) Англиар энэ нь “mother”, Францаар “la mere”, германаар “mutter” гэдэг. Эдгээр нь ялгаатай юу эсвэл бүгдээрээ биднийг төрүүлсэн нөгөө л хатагтайг хэлж байна уу? Энэ ердөө хэлний л асуудал юм.

Бидний бүгдийнх нь дотоодод Христ байдаг. Бид түүнийгээ одоо санах хэрэгтэй, харин яаж гэдгийг нь би үзүүлье. Та хэрвээ Есүс бол надаас ондоо хүн, би биш гэж бодсоор байж магад бол өөрийн Бурхан хүчээ сэрээсний дараа бясалгал хийхдээ та Түүнийг харж, ярилцаж чадна.

Есүс Христ хоёр дахиа эргэн ирэх нь

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Грекийн Атен хот, 1999 оны 5-р сарын 20 (Дүрс бичлэг №653)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Та эцсийн шүүлт ба Есүс хоёр дахь удаагаа эргэж ирнэ гэдэгт итгэдэг үү?*

Их Багш: Эцсийн шүүлт биднийг энэ физик ертөнцийг орхих үед ирнэ. Тэр мөчид бүх юмс, сайн муу, энэ амьдралдаа хийсэн бүхэн бидний нүдний өмнүүр хоромхон зуур үзэгдээд өнгөрнө. Бид өөрсдийгөө өөрөө өөрийнхөө шүүгч болон зогсож буйгаар харах болно, яагаад гэвэл бид бүгд л анхнаасаа бол Бурхан юм, бид өөрийн оршин байх хугацаандаа өөрийн хийсэн ба хийгээгүй байгаа ямар ч сонголтын төлөө хариуцлагатай байх хэрэгтэй. Есүс дахин ирэх тухайд бол Тэр бүх цагт ирдэг. Тэр бид бүгдийн дотоодод байдаг, мөн бид энэхүү Христийн хүчээ сэрээх цаг мөч бол Есүс Христийн хоёр дахиа эргэн ирэх гэдэг нь юм.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай албан ёсоор урлагийн ямар нэг сургалтад суугаагүй хэдий ч бүрэн гэгээрснийхээ дараа олж нээсэн төрөлх авьяас билгээрээ тосон будаг болон харандаагаар даавуу, чулуу, мөн дэвүүр, вааран эдлэл дээр уран зураг зуржээ.



Исламын сургаал номлол дахь Үнэн (1)

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Тайбэй хот, Формоса, 1988 оны 3-р сарын 6 (Дуу бичлэг №CE1A)
(Эх нь Хятад хэлээр)

Би Коран судрын нэгэн гүн утгатай өгүүлбэр уншлаа. Тэнд: **“Газар Дэлхий дээр сайн зочин байгаарай. Мөн баян тансаг амьдраарай”** гэж бичжээ. Исламын Кораны энэ мэдэгдэл миний сэтгэлийг үнэхээр хөдөлгөсөн юм. Түр зуур амьдраад буцдаг энэ хорвоогийн мөнх бус талаар зөвхөн Буддизм л онцлон тэмдэглэдэг гэж бид боддог байсан. Коран судар яг ийм ижилхэн санааг бас агуулдаг гэж бид мэддэггүй. Тэгэхлээр, бид яагаад одоо болтол ямар шашин илүү дээр талаар ширүүхэн мэтгэлцсээр байдаг юм бэ? Бид энэ ганц өгүүлбэрийг уншаад үнэхээр гүн утгатайг нь олж мэдсэн. Богино атлаа төгс! Бид энд байх хугацаандаа эрх чөлөөтэй агаад баялаг тун утга учиртай амьдарвал зохих ажээ.

Коран сударт ч бас Аялгууны тухай өгүүлдэг. Тэдний Их Багш Мухаммед Үүнийг дурьдсан бөгөөд Түүний шавь нар ч мөн адил. Тэд лимбэний аялгууг сонсмогцоо билиг ухаан нь нээгдэж, бүх зүйлсийг мэдсэн. Тэд үнэхээр амарч тайвширч, аз жаргалтай, эрх чөлөөтэй болж гэтлэгдсэн! Тэд гаднах дэлхийн лимбэний дуу чимээг хэлээгүй аж. Арьяабалын бясалгагч бид үүнийг илүү дээд ертөнцийн түвшнийг хэлж буйг мэддэг. Хэдий тийм ч, жишээ нь бид мусульманчууд бөгөөд дотоодын лимбэний Аялгуу сонсоогүй байлаа гэхэд Коран судар чухам юуг хэлээд байгааг ойлгож чадахгүй байсан.

Библид Есүс Христ: **Та салхины чимээг сонс. Та салхи хаанаас ирж, хаашаа явж буйг мэдэхгүй!** гэж хэлсэн.

Энэ Аялгуу нь хаа сайгүй орших чанарыг илэрхийлдэг. Бид хаа сайгүй оршдог Тэнгэрийн Аялгууг сонсох үедээ, Хаа сайгүй Оршигч (Татагата)-ийн нэг хэсгийг мэдэрдэг. Нөгөө нэг хэсэг нь Түүний Гэрэл юм; энэ нь хаанаас ирж, хаашаа явж байгааг бид мэдэхгүй. Энэ Гэрэл бас хаа сайгүй оршигч чанар юм. Хаа сайгүй орших гэдэг нь бид түүний хаанаас ирсэн, хаашаа явж байгааг мэдэхгүй гэсэн үг.

Хаа сайгүй оршигч (Татагата)-ийг харна гэдэг нь бид Аминдаваа Бурхан эсвэл Шагжамүни Будда гэсэн хэн нэгнийг үнэндээ харах ёстой гэсэн үг биш юм. Шагжамүни Будда Өөрийгөө “Татагата” гэж нэрлэсэн нь үнэн боловч Тэр Үнэн рүү ердөө л хурууныхаа үзүүрийг чиглүүлэн заасан төдий гэж тайлбарласан. Татагата бол дотоод зөн билиг, хаа сайгүй орших чанар юм. Бид Хаа сайгүй Орших Чанарыг харснаар бидний билиг ухаан нээгдэж, үйлийн үр маань алга болж, бид туйлын эрх чөлөөтэй болж, Орчлонгийн Системийг болон Бүтээлийн нууцыг бүхэлд нь ойлгож чадна. Эцэст нь бид Бүтээлтэй нэгдмэл нэг байх нь үнэхээр ямар байдгийг ойлгоно. Бид Лууз (Lao Tzu)-ын сүнслэг дэс түвшинг мэдэж, Түүнийг үнэхээр магтах болно. Учир нь тэгвэл бид яг ижил туршлагыг амссан байх ба улмаар “Бүх Бүтээл нэг юм!” гэж Түүний хэлсэн мэдэгдлийн цаад үнэнийг гэрчлэн нотолж чадна.

Исламын сургаал номлол дахь Үнэн (2)

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Сурабая, Индонези улс, 1993 оны 3-р сарын 1
(Дүрс бичлэг №321) (Эх нь Англи хэлээр)

Асуулт: Хэрвээ Мусульман хүн цагаан хоолтон болбол яах билээ, гэтэл тэдний шашинд жил бүр амь золиослох тухай ойлголт байдаг.

Их Багш: Тахил өргөх үү. Тахил өргөх гэдэг бол амь золиослох гэсэн утгагүй. Үнэндээ зарим тохиолдолд буруу орчуулсан байдаг. Жишээ нь, Их Багшийн сургаалыг зарим нь эндүү ташаа ойлгодог. Аль ч Их Багш хэзээ ч ямар ч цус гаргахыг огт хүсдэггүй. Юуны төлөө тэгэх гэж? Ямар Их Багш гэхээрээ амьд амьтны цус үзэхийн төлөө үйлчлэх вэ? Та үүнд итгэх гэж үү? Та өөрөө их багш биш байлаа ч гэсэн ийм юм хийх үү?

Өөр хэн нэгэн аль хэдийн юуг ч юм алсан байгааг магадгүй та иддэг; харин танаас тахиа ч юмуу ямааг өөрөө алахыг хүсэхэд үүнийг хийж чадаагүй. Нэгэн Их Багш юу боллоо гэж шавиа иймэрхүү цустай зүйл хийнэ гэж санах билээ? Энэ үнэхээр буруу ойлголт юм. Учрыг нь та нарт хэлье. Жишээ нь, Их Багш бүр өөрт байгаа бүхнээ түүнд өргө гэж хэлдэг. Бхагавад-Гита сударт, *“Бүх юмаа надад өг; ганцхан намайг сана; зөвхөн намайг л санан дурс; зөвхөн надад бууж өг, надаас өөр хэн ч биш; байгаа бүхнээ надад өг; өөрийн амьдрал, өөрийн гэр бүл, өөрийн эзэмшил гээд бүгдийг надад өг.”* гэж хэлсэн. Гэвч Кришна тэгээд өөрт нь хэрэгтэй байсан ч үгүй ч Аржунаагаас сохор зоос ч авсан бил үү? Үгүй, тэр хэзээ ч аваагүй! Энэ бол зүгээр л Их Багшийн яриа юм. “Үхрээ, машинаа, ямаагаа, алтаа, эхнэрээ, хүүхдүүдээ, юм бүхнээ надад өг. Би бүгдийг нь харж хандъя.” Харин тэр өөрөө энэ бүхэнд гараа огтхон ч хүргээгүй.

Энэ нь та өөрийн зориулалт, бууж өгсний тэмдэг болгож, Их Багшдаа итгэх итгэл сүсэг, мөн аминч бусыг илтгэх тэмдэг болгож юм бүхнээ Их Багшийн өлмий дор зөвхөн оюун санаандаа л өргөж байгаа хэрэг юм: “Надад юу ч байхгүй, би өөрөө ч; юм бүгд Их Багшийнх.” гэдэг. Тэгээд одоо хэдэн зуу, мянган жилийн дараа хүмүүс үүнийг өөр янзаар ойлгож тайлбарлах болжээ: та хамгийн эхний хургаараа эсвэл ямар нэг эхний зүйлээрээ эхний тахилыг өргөх хэрэгтэй гэж. Хэн хэзээ ийм цусан тахил хүсэх вэ? Их Багшийг ярихаа байя, дунд хэрийн л нигүүлсэх сэтгэлтэй аливаа хүмүүн өөрөө ямаа алаад цусыг нь ууж, ямар нэг юмыг нь идэж, тэгээд аз жаргалыг мэдэрнэ гэдэгт итгэж чадах юм уу? - Тун ховор! Одоо үед хүмүүс түүнийг зүгээр л зах дээр мөнгөөр худалдаад авчихдаг болохоос алж байгааг нүдээр хардаггүй, зовоож байгааг нүдээрээ хардаггүй. Тэд ширхэг шоколад шиг л худалдаж аваад, амьтны зовлон тарчлааныг огт мэдрэхгүй иддэг. Харин нэгэн Их Багш, бүх төрөлхтөнг хайрлах сэтгэл бүхий Их Багш хэмээгдэгч цусан золиос шаардана гэдэгт та итгэх юм уу? Хэн ч үүнд итгэхгүй!

Исламын сургаал номлол дахь Үнэн (3)

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Франц улсын нийслэл Парис, 1993 оны 4-р сарын 25 (Дүрс бичлэг №360)
(Эх нь Франц, Англи хэлээр)

Асуулт: Энэ асуулт маань Ариун Судруудын талаар юм: Би Библи болон Коран сударт нэлээд эргэлздэг. Библид “Би атаархагч Бурхан” гэжээ, мөн Христ “Би энд энхийн төлөө биш харин дайны төлөө ирсэн.” гэж хэлсэн. Коран сударт, бид дайнд оролцож, олон эхнэртэй болно гэж хэлдэг. Эдгээр нь алдаа эндүүрэл байв уу?

Их Багш: Би Таван Удирдамжийг мөрдөхийг та нарт захиана: амь хөнөөхгүй, бэлгийн зүй бус харилцаанд орохгүй, веган хоол хүнс хэрэглэх, хулгай хийхгүй, мөрийтэй тоглохгүй байх. Энэ бас таны амьдралд их амархан; ердөө л үүнийг мөрд, хоёр цаг хагас бясалга. Таны уншсан ямар нэг өөр бусад номыг би хариуцахгүй.

Харин тэд аль хэдийн Мусульман болсон бол тухайлбал, би тэднийг амьдралаа өөрчил гэж мэдээж хэлэхгүй. Жишээ нь, хэрэв тэд намайг мэдэхээсээ өмнө аль хэдийн уламжлалаа дагаж арван эхнэртэй болсон байвал би тэдэнд энэ эхнэрүүдээсээ сал гэж хэлэх ёстой юм уу? Тэд нэг нэгэнтэйгээ эвтэй сайхан байна; арван эхнэр нь хамт амьдардаг, хэнд ч гэм хийдэггүй.

Бид энд дэлхийг биш өөрийгөө өөрчлөхийн тулд байгаа юм. Хэрэв мусульманчууд тийм байдаг бол тэднийг тайван орхи. Одоо тэдэнд дахин “faire la guerre” шаардлагагүй болсон; тэд дахин дайн хийх албагүй болсон, тэгэхээр тэд намайг дагаж чадна. Тэд дайнч зангаараа үлдэхийг хүснэ гэвэл бидний тойргоос гадна үлдэж болно.

Зөвхөн Мусульманчууд дайн хийж байгаа биш, бас Христ, Буддистууд, өөр бусад нь ч бас тэгдэг, учир нь тэд үндсэн сургаал номлолоо буруу ташаа ойлгосон. Будда хэзээ ч дайн хийгээгүй байхад зарим Буддист дайн хийдэг.

Христ Өөрийгөө дайн хийхээр ирлээ гэж хэлээгүй. Тэр юу гэсэн гэхээр Тэр энх тайванг авч ирээгүй, харин илдтэй ирлээ гэж хэлсэн. Тэр хүүг нь аавынх нь эсрэг тавих болно гэх мэтээр хэлсэн. Үйл түйтгэрийн холбоог тасална гэх утгаар Тэр үүнийг хэлжээ; Тэр билиг ухааны илдтэй ирсэн; мөн тэр байтугай гэр бүлийн хэлхээ холбооны бүх хүлээс шунал ч байгаагүй мэт болох юм. Тийм учраас эцэг нь мах идэхэд итгэдэг атал хүү нь веган хоолтон болдог. Жишээ нь, өмнө нь хэрвээ гэр бүл бие биедээ сэтгэл хүлэгдэж хоргоддог, тун хязгаарлагдмал хайраар бие биентэйгээ холбогддог байсан бол, авшиг хүртсэний дараа, тэд бусад авшигтанг - бүх номын ах эгч нарыг хайрладаг шигээ биесээ хайрлана. Тэр энэ санааг л хэлсэн юм.

Таны мэдэж байгаачлан, манай бүлгийн дотор бас л ижил зүйл тохиолддог. Эцэг эх нь эцэг эх гэх хүчээ ашиглан хүүхдүүдээ мах идүүлэхээр хүчилдэг, гэвч тэд идэхгүй. Тэгэхлээр энэ нь “эцэг эхийнхээ эсрэг байх” гэх маягийн зүйл юм. Энэ тохиолдолд ийм байна. Харин Христ хэзээ ч дайныг зөвтгөөгүй. Тийм ч учраас Тэр “Цезарт хамаарах бүхнийг Цезарт өг.” гэж хэлсэн, мөн хүмүүс Түүнийг цовдлох үед Тэр чадах байсан ч тэдний өөдөөс эсэргүүцээгүй. Түүнийг Жүүдийн хаан болгохыг хүсэж дэмждэг олон шавь Түүнд байсан, харин Тэр үүнийг хүсээгүй. Тэр “Миний хаанчлал энэ Газар дэлхий дээр байхгүй.” гэж хэлсэн. Тэгэхлээр Христ энх тайвны төлөө хүн байсан байгаа биз. Түүний өгүүлсэн дайн бол Майягийн хий хуурмаг үзэгдлийн эсрэг, Майягийн заль мэх, урхи занга, Майягийн хүч, хий хуурмаг үзэгдэл, биднийг уяж хүлсээр байдаг харанхуйн хааны эсрэг бид, шавь нарын тэмцдэг сүнслэг дайн юм – бид тэрэнтэй тэмцдэг.

Ер нь би оюун ухааны мэтгэлцээнд дургүй ч та нарыг шинэ хүмүүс гэж ойлгож байгаа тул чадахаараа доошилж, танд хань бараа болохыг хичээх болно. Эс бөгөөс би мэтгэлцээн, оюуны өрсөлдөөнд тун дургүй. Тэгэхлээр, Коран сударт заасны дагуу бол хүмүүс дайн хийхгүй, тэмцэж болно, гэхдээ өөрсдийгөө хамгаалж чадна. Та нар Эш үзүүлэгч Мухаммед өөрийгөө төдийгүй өөрийн шавь нараа олсон тэр цаг үе, нөхцөл байдлыг бодож үзэх хэрэгтэй.

Тэр үед олон хүн амьд Их Багш гэж юу байдгийг ойлгодоггүй байсан тул тэднийг хавчиж мөрдөж байсан. Хүмүүс яагаад Есүсийг алж, Буддаг гүтгэж, хороохоор завдсан шалтгаан яг ижил.

Өдгөө цагт бас л ийм зүйл тохиолдож байна. Зарим хүн бас ташаа ойлгосноосоо болж намайг гүтгэж, надад маш их бэрхшээл учруулдаг. Тэд миний юу сургах гэж оролдож байгааг ойлгож мэдэхэд цаг гаргахгүй байна. Тэд магадгүй алдаатай хэвлэгдсэн эсвэл буруу тайлбарлагдсан ганц хоёр өгүүлбэрийг үзээд эсвэл зөвхөн бусад хүний ярихыг сонсчихоод л асуудал тарих гээд байдаг. Гэхдээ та нар шиг олонх сайн хэдээсээ хамаагүй цөөхөн, тиймээс асуудал болохгүй.

Гэвч Эш үзүүлэгч Мухаммедыг амьд сэрүүн байх үед аймшигтай байсан. Тэднийг хаа сайгүй мөшгөж, хавчиж байсан тул өөрсдийгөө хамгаалахаас өөр аргагүй болсон. Дайны дараах үр дагавар нь тэд олон эхнэр авсан явдал юм. Олон эрчүүд тулалдаанд орж үхэж үрэгдэн, олон эхнэр бэлэвсэрч, олон хүүхэд өнчирч хоцорсон тул Эш үзүүлэгч буюу удирдагч нь “Сул дорой, өнчин үлдэгсдийг гартаа авч, халамжил. Тэднийг яг л өөрийн эхнэр, хүүхэд шигээ хайрла.” гэж захисан. Мэдээж хэрэг! Гэхдээ энэ нь үргэлж бие махбодын харилцаа байх албагүй.

Жишээ нь, заримдаа манай авшигтны нөхөр нас барсан ч юм уу, эхнэр нь нас бараад хүүхдүүд нь үлдэхэд бид тэднийг бас өөр авшигтны гэрт аваачин, асран халамжилдаг. Гэхдээ энэ нь бие махбодын харилцаа байх ёсгүй; зүгээр л тэднийг ах эгч, дүү нар шигээ, өөрийн хүүхэд шиг, эхнэр эсвэл нөхөр шигээ харж хандах л явдал юм. Тийм учраас л Эш үзүүлэгч хэлэхдээ, “Хэрвээ та гэртээ олон эхнэр аваачсан бол бүгдийг нь адил тэнцүү халамжлах хэрэгтэй.” гэжээ. Ийм болзолтойгоор л та гэртээ олон хүн аваачиж болно. Жишээ нь, та өөрийн эхнэртээ үнэт эдлэл авч өгвөл бусдад нь бас адилхан авч өгөх боломжтой байх хэрэгтэй. Тэгвэл та тэднийг гартаа авч, халамжилж чадна.

Энэ нь өнөөгийн аюулгүй байдлыг хангах системтэй адил юм, маш соёлжсон. Хэрвээ та хүүхэд үрчилж авахыг хүсвэл банкинд хангалттай мөнгөтэй, хэр хэмжээний өмч хөрөнгөтэй гэдгээ засгийн газарт мэдүүлэх хэрэгтэй, энэ нь хүүхэд өсгөж халамжилж чадахыг тань харуулах юм. Тэр үед аюулгүй байдлын тухай хууль байгаагүй ч гэсэн их соёлтой байсан байгаа биз. Мусульманчууд ийм л байдаг. Тэгэхлээр бид шашны судрыг судлахыг үнэхээр хүсэж байгаа бол ямар ч эргэлзээгүй болтлоо эцэс хүртэл нь судлах хэрэгтэй. Харин ганц хоёр өгүүлбэр сугалж авчихаад: “Энэ сайн биш байна; Мусульманчууд сайн биш.” гэж хэлбэл бид өрөөсгөл ойлголттой болно.

Арьяабалын бясалгалын Арга бүх сайн шашинтай нийцдэг

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Франц улсын нийслэл Парис, 1993 оны 4-р сарын 24 (Дүрс бичлэг №359)
(Эх нь Франц хэлээр)

Асуулт: Таны сургаал Лалын шашинтай нийцэх үү?

Их Багш: Тийм ээ, яагаад үгүй гэж? Лалын шашин хүмүүсийг энэ Газар Дэлхийд сайн зочин бай, мөн амьд ахуйдаа Диваажинг олох нь чухал шаардлагатай гэж сургадаг. Би бас л үүнийг санал болгодог. Бидэнд Газар Дэлхий дээр энх тайван, эрхэм ариун чанар, билиг ухаан өгдөг Таван Сахил зарчмыг хүндэтгэ гэж танд хэлдэг. Би бас Бурханыг агшин зуур олох тэр Зам Мөрийг танд санал болгодог. Тийм учраас манай Зам Мөр бүх сайн шашинтай нийцдэг.

Бусад сүнслэг бүлгийн талаарх сэтгэгдэл

АНУ-ын Флорида дахь Бясалгалын төвд
Цагаан сарын баяр тэмдэглэх үеэр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай
шавь нартайгаа хийсэн ярилцлагын эшлэл. 1999 оны 2-р сарын 15
(Дүрс бичлэг №635) (Эх нь Англи хэлээр)

Асуулт (АвишигтанА): *Би 14 жилийн турш нэгэн Энэтхэг их багшид шавилсан.*

Их Багш: 14 жил ээ! Их урт хугацаа байна.

Асуулт: *Тэдний ашрамд маш олон хувь хүний хөгжлийн бүлгүүд байдаг. Тэд эмчилгээний аргууд, илгээ заадаг, та мэднэ.*

Их Багш: Бүх төрлийн юмс, тийм ээ, би мэднэ.

Асуулт: *Био-энергитэй хооллолт гэх мэтчилэн.*

Их Багш: Энэ чинь сайн байна.

Асуулт: *Тэгээд суларсныхаа дараа тэд аз жаргалтай, сэргээг харагддаг.*

Их Багш: Хэр удаан тийм байх вэ?

Асуулт: *Энэ л асуудалтай байдаг. Тэд тодорхой нэг түвшинд гацдаг гэж би бодож байна.*

Их Багш: Тэд Арьяабалын Арга заадаг уу?

Асуулт: Үгүй.

Их Багш: Үгүй юу, тэгвэл өөр юм байна, ойлгож байна уу.
(А: Тийм ээ) Арьяабалын Арга бол таны хийх ёстой сүүлчийн алхам. Хэрэв бид Арьяабалын бясалгалыг хийхгүй бол гаднах үйл ажиллагаа, байгууллага эсвэл тэдний санал болгож буй эмчилгээний талаар ярих нэмэргүй, эдгээр зүйл бүгд бие махбодын болон сэтгэц оюуны түвшинд л үйлчилдэг. Сэтгэл зүйн зөвлөгөө тусламж ч бас сэтгэцийнх юм.

Орчлонгийн чичирхийллээс ирдэг жинхэнэ язгуурын илааршил байхгүй бол бүх зүйл түр зуурынх бөгөөд ахиц дэвшил гарахгүй. Тиймээс бид энд ямар ч эмчилгээ хийдэггүй. Хүмүүс зүгээр л илааршдаг. Бидэнд ямар ч эмчилгээ байхгүй. Хүмүүс зүгээр л дээрддэг. Тэд зааварчилсан зүйлийг биелүүлж л байвал ахиц гардаг.

Мөн энэ бол таных, мөнхийн, танд хадгалагддаг учраас жинхэнэ зүйл нь юм. Их Багш тантай хамт байгаа эсэхээс үл хамааран энэ зүйл танд байгаа; та үүнийг хадгалж байгаа.

Арьяабалын Арга бол таны хүртэж болох хамгийн шилдэг арга юм. Энэ арга таны төлөө бүх зүйлийг анагаадаг. Их Багшийн хий гэж хэлснийг зүгээр хийчихэд л бүх зүйл төгс болж, танд ахиц дэвшил гарна. Тодорхой хугацаанд эдгэрэхийн тулд та надад найдаад, дараа нь дахин буцаж ирэх ёстой гэсэн үг биш юм. Энэ бол ялгаа юм. Тэгэхээр энд ч гэсэн бидэнд маш их эрх чөлөө бий.

Хүмүүс юу дуртайгаа туршиж болно. Би тэдэнд ямар нэг юм хийхийг нь хориглож байгаа ч юм биш. Би тэдэнд зүгээр л сайн ба муу талыг нь хэлж өгдөг; тэгээд тэд сонгодог. Тэдний ихэнх нь энэ зүйл үр дүнгээ өгдөг гэдгийг мэдэх хангалттай ухаалаг учраас зүгээр л үлдээд, зааврын дагуу үргэлжлүүлэх сонголт хийсэн. Энэ зүйл нэг л ажилласан юм чинь үргэлжлэн ажилласаар байхыг тэд мэддэг. Энэ зүйл ажиллаж, тэдэнд таатай сайхан санагддаг. Тийм ч учраас тэд өөрчлөхийг хүсдэггүй; түүнээс биш би тэдэнд үүнийг өөрчлөх эсвэл туршихыг хориглосон юм биш. Тэгээд ч би тэдний ямар нэг зүйл хийх урам зоригийг мохоодоггүй. Тэд зүгээр л хийдэггүй. Би хориглосон юм биш харин тэд өөрсдөө хэдийн мэдэж байгаа учраас тэр. Магадгүй тэд үүнийг ойлгохуйц хангалттай төлөвшсөн эсвэл хэдийн хангалттай оролдоод үзчихсэн.

Мэдээж би хүмүүсийг сэтгэл түгших гэх мэт байдалд орохыг дэмжихгүй. Тэгэхээр жишээ нь, номын ах асуудалтай байвал, “Зүгээр ээ, өөр найз охинтой болж болно шүү дээ.” гэж хэлдэг. Эсвэл номын эгч асуудалтай байвал “Та гэрлэж болно шүү дээ, зүгээр” гэж би хэлдэг. Хайр бол зүгээр. Бясалгалд саад болохгүй л бол гэрлэж болно. Танд төвөг удаж, сүнслэг дэвшилд тань саад болохгүй л бол секс ч зүгээр. Гэвч ихэнхдээ л саад болдог, учир нь сэтгэл санаа үүнийг давж гарч чаддаггүй. Бэлгийн мэдрэмж туршлага бол хүмүүс зохицуулахад их хүчтэй зүйл. Тийм учраас л ихэнх их багш шавь нартаа үүнээс хол байхыг захидаг.

Энэ яг л архи лугаа юм. Үнэхээр хор юм; гэвч та жаахныг уулаа гэхэд таныг үхүүлчихгүй, тамд унагачихгүй. Гол нь өнөөдөр бага шиг уучихлаа гэхэд маргааш улам ихийг ууна, дараа нь бүр илүүг ууна, ингэсээр бие махбод, тархи, бүр оюун санаагаа гэмтээнэ. Иймд Их Багш “Үүнээс холхон бай” гэж захидаг. Их Багш тань хүмүүсийг захиргаадан тушааж эсвэл хянаж байгаа ч юм биш. Тэр зүгээр л чухам юу сайн, юу муу гэдгийг мэднэ. Харин сонголтыг та бид өөрсдөө л хийдэг.

Тэгэхлээр, хүмүүс амьдралдаа хангалттай туршиж мэдсэн учраас өөр бусад зүйлийг нэн чөлөөтэй туршихыг нь би урамшуулж дэмждэггүй. Би тэдэнд секс, архи, чөлөөт сонголт, зэрлэг амьдралын талаар зааж өгөх хэрэгтэй юм гэж үү? Үүнийг хийхийг тань би бүр дэмжих хэрэгтэй юм гэж үү? Зарим нэг хүнд энэ үнэхээр хэрэгтэй байгаа бол тэр л биз, гэхдээ тэд тодорхой хэмжээгээр хэдийн мэддэг болсон. Жишээлбэл манай шавь нар Таван Сахилыг аль хэдийн мэддэг; тэд хэмжээ хязгаар гэгчээ хэдийн мэддэг тул хаана зогсох ёстойгоо мэдэж чадна. Хэрэв тэд бага зэрэг туршиж мэдэрснээр байвал зүгээр, гэхдээ энэ нь буруу гэдгийг тэд мэдэж байгаа. Учир нь Арьяабалын Аргыг дадуулах нь чухам юу сайн бишийг аяндаа шууд мэдэх тийм хурц мэдрэхүй таньд өгдөг. Та үүнийг туршиж үзэх ч бүтэхгүйг нь аль хэдийн мэдэж л байдаг.

Асуулт (Авишигтан В): Би олон жилийн турш олон ашрамд очиж үзсэн. Нэг үе би энэ талаар судалгаа хийж байсан. Тэгээд би 50 эсвэл 70 ашрамд очсон байх.

Их Багш: Хөөх! Дээд амжилт тогтоожээ.

Асуулт: Намайг тэнд нэг юмуу хэдэн сар бясалгахад тэдний зарим нь их ялгаатай байсан. Эдгээр өөр өөр бүлгүүд, уламжлалуудыг хараад би яагаад бүлэг бүр өөр өөрийн гэсэн зан чанар бүрдүүлсэн байдаг юм бол гэж үргэлж гайхдаг байсан. Мөн бүлгүүдийн хүмүүсийг анзаарч таних боломжтой, тэд хувийн шинж чанараа хөгжүүлсэн байдаг, харин би хүн бүр нь өөрийн онцлог шинж чанартай бүлгийг дандаа гайхдаг байсан. Хийж байгаа бясалгалаасаа болоод

ихэнх хүмүүс нь тун түгшүүртэй эсвэл сул задгай байсан.

Их Багш: Хэтэрхий туйлширсан, тийм үү? Аль аль талаараа.

Асуулт: Гэхдээ би энд мэдэрсэн зүйл нь тэр хүмүүсийн дунд ямар нэгэн сайхан, задгай энерги байдаг юм шиг санагдсан. Тэгээд их сайхан; нээлттэй.

Их Багш: Бид бол зөөлөн аядуу. Бид аль нэг тийш туйлширдаггүй. Өдөр бүр хоёр цаг хагас бясалгахыг хамгийн сайнаараа хичээ гэж би захидаг, тэгээд л болоо. Энд бид өөрийгөө чөлөөтэй бие даан хөгжүүлж болно, бас бусдын адил гэрийн даалгавраа хийдэг, харин ингэснээр бид өөрийнхөө чадлаар хөгждөг. Тийм ч учраас би хүмүүсийг энд ирж, миний төлөө ажиллахыг, тэр байтугай өөрийнхөө мөнгөөр энд үлдэж байхыг дэмждэггүй. Хэрэв би энд байгаа бүх хүмүүст гурав, зургаан сар, хоёр долоо хоног, ямар ч байсан энд ирж үнэ төлбөргүй ажиллахыг зөвшөөрвөл би сайхан сууж байх болно. Учир нь тэд ч бас үүнийг хийхдээ баяртай байх болно. Гэхдээ ингэх нь тэдэнд сайнаар нөлөөлөх эсэхийг би бодож байна. Тийм учраас би янз бүрийн хэв маягийн сургуулиудыг тань шиг өөрөө танилцаж мэдсэний дараа л та нарт юу сайн байхыг бодох ёстой гэдгээ өмнө нь хэлж байсан.

Асуулт (Авишигтан В): Манай Их Багш бол хамгийн сайн, яагаад гэвэл манай бүлэг хамгийн сайн бөгөөд бидэнд хамгийн сайн бүхэн бий гэж би боддог. Бид нийтээрээ бясалгах, бас даяанд оролцох, мөн Их Багштайгаа дандаа уулзах боломжтой. Би үүнд үнэхээр талархдаг. Би нэг америк хүнтэй хамт ажилладаг, түүний их багш нь Энэтхэгт байдаг. Миний ширээн дээр байсан Их Багшийн зургийг тэр хараад “Энэ хатагтай хэн бэ?” гэж асуухаар нь “Энэ бол миний Багш” гэж хэлсэн. Тэр хэлэхдээ Сан Хосе дахь Таны веган хоолны ресторанд очсон, мөн Арьяабалын Аргаар бясалгадаг гэсэн.

Их Багш: Тийм ээ, энэ үнэн. Ганц би ч биш, нэлээн хэдэн багш Арьяабалын Аргыг заадаг. Би та нарт үүнийг олон удаа ярьсан.

Асуулт: Би түүнээс авишиг хүртсэний дараа их багшийгаа харсан уу? гэж асуухад ердөө харж байгаагүй гэсэн. Тэр түүнийг ганц удаа л харжээ.

Их Багш: Энэ хангалттай. Тэр түүнийг хэзээ ч хараагүй.

Асуулт: Би түүнээс бусадтай нийтийн бясалгал хийж байсан уу? гэж асуухад “Үгүй” гэсэн. Тэр зөвхөн өөрөө бясалгадаг. Тэгэхлээр би түүнийг хэдийн хангалттай зүйл хүртсэн гэж би мэдэж байна, бид нэлээд ихийг хийж чадах болохоор би үнэхээр талархдаг. (Алга ташилт)

Их Багш: Тэр их багшийгаа харахаар Энэтхэг явж чадах уу?

Асуулт: Би мэдэхгүй. Тэр сонирхохгүй байж мэднэ. Тэр явж байгаагүй, түүний амьдардаг газарт тэдний бүлгийн цөөн хэдэн номын ах эгч нар байдаг ч нийтийн бясалгал хийх талаар боддоггүй юм байна лээ. Их Багш бидэнд нийтийн бясалгал хийх боломж өгсөн үед манай бүлгийн зохион байгуулалт миний мэдэхээр бол үнэхээр сайн байдаг гэж би боддог. Хэрвээ би анх л надад тусалсан энэ номын ах эгч нартай уулзаагүй байсан бол би асуудлаа даван туулж чадахгүй байх байсан. Эхэн үедээ надад энэ үнэхээр хэцүү байсан. Тиймээс, Их Багш аа, надад тусалсан ах эгч нартаа бүгдэд нь би үнэхээр их баярлаж талархаж байна. (Бараг уйлав) Бусадтай харьцуулах юм бол би хамгийн азтай хүн гэж боддог. Баярлалаа Их Багш аа. Би үнэхээр баярлаж байна. (Алга ташиг)

Их Багш: Миний туршлагаас харах юм бол манай бүлэг дэлхий даяарх бүлгүүдээс хамгийн өндөр давтамжтай бясалгагчдыг бий болгосон гэж би боддог. Би тантай уулзахаасаа өмнө зарим ашрамд очиж үзсэн, бид бузгай сайн, тун тэнцвэртэй байгаа гэж би бодож байна.

Бүлэг 2

Авшиг бол Орчлон дахь хамгийн үнэт эрдэнэ

Түүний энэхүү тэнгэрлэг ур чадвар үнэхээр давтагдашгүй өвөрмөц билээ. Ийнхүү, энэ амжилтаараа Их Багш “Сүнслэг бясалгагч өөрийн дотоод дахь бүхнийг чадагч Хүчийг нээчихвэл боломжгүй зүйл гэж байхгүй болно!” гэсэн сургаалаа нотолсон юм.



Авшиг бол хамгийн үнэт эрдэнэ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Флорида, АНУ, 2001 оны 6-р сарын 11 (Дүрс бичлэг №717)
(Эх нь Англи хэлээр)

***Асуулт:** Саяхан би Кабирын “Хайрын Далай” номыг уншсан; Кабир бол жинхэнэ Бурханы амьд хувилгаан байсан. (Их Багш: Тийм, тийм) Тэр Калын амны талаар ярьдаг. Авшиг аваагүй сүнс нас барсны дараа эрлэгийн элч ирж, тэднийг хуурсан. Сүнснүүд Кал руу очиход Кал тэднийг зажилчихдаг. Энэ ямар утгатайг би ойлгохгүй байна.*

Их Багш: Хэрвээ та авшиг хүртээгүй байвал, Кал тань уруу ирнэ, сөрөг хүчин гэсэн утгатай үг. Кал нь Самгарди хэл дээр сөрөг хүч гэсэн утгатай. Та авшиг хүртсэн бол, Их Багш нь ирнэ, Кал таныг мэхэлж чадахгүй. Авшиг хүртсэний дараа сүнс түүнд дахин харьяалагдахгүй болсон болохоор Кал танаас холдоно; тэр таныг хянаж чадахгүй болно. Гэвч тэр таныг хуурч мэхлэхээр оролдох нь мэдээж. Тэр саад учруулахаар байнга оролдоно, энэ нь түүний ажил юм. Харин таны хийх зүйл бол өөрийнхөө замаар л явна, тэр юу хэлэх огт хамаагүй.

***Асуулт :** Аймаар санагдаж байна.*

Их Багш: За үгүй дээ, амьдрал аймшигтай шүү; төгсгөл нь үргэлж үхлээр дуусдаг! (Багш болон бүгд инээлдэв)

***Асуулт:** Авшиг хүртээгүй хүмүүст л аймшигтай.*

Их Багш: Харин та авшигтан, тиймээс та үргэлж Их Багшаар хамгаалуулна. Хэрвээ та үнэхээр Гэртээ харихыг чин сэтгэлээсээ хүсвэл 10,000 Кал байгаад ч таныг яаж ч чадахгүй.

***Асуулт:** Бидний хайрладаг хүмүүс болон дотны найзуудад ч гэсэн энэ хамаарах уу?*

Их Багш: Тийм! Лавтайяа тийм. Их Багш тэдэнд бүгдэд нь санаа тавих болно. Энэ бол авшиг хүртсэн байхын аугаа, асар их ач буян юм.

Хэрэв та энэ тухай мэдсэн байсан бол, энэ авшиг гээч ямар аугааг мэдээд цочирдож, баярлаж талархсандаа үхэх байсан. Үнэхээр л энэ бол гайхамшигтай.

Ямар гайхамшигтай гэдгийг би дүрсэлж хэлж чадахгүй. Би зөвхөн таны өмнөөс баярлаж чадна. Та үнэхээр азтай – тийм ээ, тун их азтай. Үнэндээ танд ямар ч төсөөлөл байхгүй. Бурханы нигүүлслээс өөр юу ч танд үүнийг худалдаж авч өгч чадахгүй, та үүнийг юугаар ч сольж авч чадахгүй, юу ч танд үүнийг олж өгч чадахгүй. Мэдээжийн хэрэг, энэ бас таны цаг болсных юм. Тэгэхгүй бол та мянган жил залбирсан ч энэ бэлгийг авахгүй.

Энэ бол таны энэ бүхий л Сансар орчлон даяар олж авч чадах хамгийн аугаа зүйл юм. Үүнийг олж аваагүй хэн ч бай, тэр байтугай танаас өндөр дээд сүнслэг төрөлхтөн ч танд атаархах болно. Яагаад гэвэл та их багшийн зиндаанд аваачдаг зам дээр байгаа учраас тэд танд тун их атаархах болно, харин тэд ердөө л тэнгэрүүд (дева нар), сүнслэг төрөлхийтөн, тэнгэр элчис (Диваажингийн янз бүрийн түвшинд амьдрагсад) л юм. Тэд нэг л өдөр үхнэ, харин та үхэхгүй. Тэд доошилно, харин та тэгэхгүй. Та улам алдаршин, илүү гоо үзэсгэлэнтэйгээр тэдний дэргэдүүр зөрөн өнгөрч, тэднээс илүү өндөр рүү ямагт дээшээ явсаар байх болно. Та ер нь л юм юмтай байх болно. Тэднийг Гурван Ертөнц дотроо л замчлал эрэн хаа нэгтээ сэлсэн хэвээр явахад харин та Оройн Дээд Бурханы дэргэд байх болно.

Ийм авшгийг олж хүртэх үнэхээр хэцүү. Аяа! Бурхан минь, би энэ тухай бодохоор Ай даа! Гайхалтай! гэдэг. Хонжворт сугалаанд зургаан сая доллар яаж хожихыг та мэдэх үү? Сүнслэг ертөнцөд бол үүнтэй л харьцуулахаар зүйл юм. Хэрвээ та дэндүү ихийг мэдчихвэл магадгүй зүрхний багтраа болж мэднэ. Харин та нар хэр их азтай байж чадах вэ? Энэхүү орчлон даяар та нар бол хамгийн сайн нь, сонгогдсон нь, шилэгдмэлүүд нь, хамгийн, нэн их зол заяатай нь юм.

Үнэхээр цаг нь иртэл та юу ч мэдэхгүй. Заримдаа та энэ дэлхийд ажиллах хэрэгтэй байдаг, тиймээс Бурхан танд тун багыг мэдэх боломж өгнө.

Түүнчлэн, бид шоронд байсаар л байна, эцэг эх чинь таныг тайтгаруулахаар хичнээн ч юм өгөөд нэмэргүй. Тэнд танд магадгүй зурагт эсвэл радио байгаа. Гэхдээ та хурдан машин, нисдэг тэрэг, ордон, агааржуулагчтай зочны өрөө, усан бассейн гэх зэрэг тун олон юмтай байж чадахгүй. Шоронд таныг зөвхөн тав тухтай л байлгана; танд зөвхөн амьдарч болмоор нөхцөл л байна.

Гэвч та тэнд нэгэнт орчихсон, таны хугацаа дуусаж, ялаас чөлөөлөгдөх хэдий ч хүнд суртлыг хүлээх нь хэвээрээ байх болно. Мөн тэнд та анхаарал тавих хэрэгтэй зарим зүйл байгаа байж магадгүй. Эсвэл таны хугацаа дуусаагүй байгаа байх, гэсэн ч та удахгүй суллагдана; хуульч танд илүү хурдан суллагдахад тань тусалсаар байгаа, та цаазын ял аваагүй юм чинь суллагдах нь лавтай. Гэсэн ч та хүлээх хэрэгтэй хэвээрээ. Шоронд байхдаа та хоригдлын хувьд тухтай байж болно; танд энэ шоронд хамгийн сайн юмс нь байна. Гэвч та хоригдол хэвээрээ. Хэдийгээр та бүх хэрэгслийг эдэлж ашиглаж байгаа ч гэсэн шоронд байгаа хэвээрээ л байна. Тийм учраас, эцэг эх тань таныг Гэртээ угтан авахаар танд зориулж юу бэлдсэн байгааг та үнэхээр мэдэх юм бол ... Бурхан минь, та үүнийг төсөөлж ч чадахгүй!

Авшгийн Үнэ цэнийг эрхэмлэхүй

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Олон улсын гурван өдрийн даяан, ХБНГУ-ын Гамбург хот
1995 оны 8-р сарын 25-27 (Дүрс бичлэг №493)
(Эх нь Англи хэлээр)

Би шинэ авшигтнуудад нэг зүйл хэлье. Авшиг гэж та нарт үнэхээр ямар утгатайг би мэдэхгүй, гэвч надад бол маш их утга учиртай. Энэ нь та энд суугаад, заавар сонсоод, намайг өөрийнхөө багш гэж хүлээн зөвшөөрмөөр үнэ цэнтэй эсэх эсвэл энэ авшиг хүлээж авахуйц үнэ цэнтэй зүйл мөн үү үгүй юу гэж өөр дотроо тэмцэлдэх явдал биш юм. Энэ тийм юм биш. Энэ бол сая жилд ганц л удаа тохиолдох боломж. Энэ нь танд хэр зэрэг утгатайг Би мэдэхгүй. Харин таны авшгийн өмнө ба дараа Би хэр их зүйл хийх хэрэгтэй байдгийг та нар мэдвэл зохино.

Энэ бол та энд нуруугаа налж суучихаад, надтай үлдэх үү эсвэл явах уу гэж гайхширан байх явдал биш юм. Үлдэх эсвэл явах нь таны л асуудал. Энэ бол таны эрх бас таны сонголт. Надад танд биеэр, оюун ухаанаар болон сэтгэцээр ямар нэг юм хийх гээд эсвэл таныг барьж тогтоох, байлгаж байх санаа сэдэл ердөө байхгүй. Би зүгээр л нэн нөхцөл болзолгүй найзын хувиар дэргэд чинь байж байх болно. Танд миний хэрэг гарвал, та ирж болно. Та явахаар шийдсэн бол явсан ч болно. Хэрвээ авшгийн утга учир таньд ердөө ингээд л болчих юм бол та зүгээр л дэлгүүр хэсэж байгаатай адилхан байна. Ердөө таны сэтгэл нэн төгс биш байгаа болохоор та жинхэнэ очир эрдэнийг шилнээс ялгаж танихгүй байна; тиймээс л та тэмцэлдэж байна. Гэхдээ энэ ямар утга учиртайг та мэдэхгүй; үнэхээр мэдэхгүй.

Наад зах нь та үхэхдээ мэдэх болно. Авшиг танд ямар утга учиртайг мэдэх болно. Тэр үед таны эргэн тойронд хэн ч байхгүй, хэн ч таныг дагалдахгүй. Ямар ч мөнгө танд тэр хүчийг авч өгч чадахгүй.

Ямар ч байр суурь таныг тамын галаас хамгаалахгүй. Яг тэр мөчид тань руу ирэх цор ганц нь Их Багш тань л байна. Тэгээд л та мэднэ.

Та юу ч хийсэн чин сэтгэлээсээ хийх ёстой. Тэгвэл л та эцсийн нийлбэр үр дүнг хүртэнэ. Тэгэхгүй бол та юу ч хүртэхгүй. Авшиг хүртэх явцад ч гэсэн та зүгээр л суугаад өмнөх их багшаа, урьд цагийн Буддагаа, эсвэл өнгөрсөн юм бүхнээ бодоод байвал та юу ч олж хүртэхгүй. Тэгчихээд надаас би яагаад юм хүртсэнгүй вэ? гэж асууж шалгаадаг. Та яагаад энд ирснээ, өөрт чинь энэ зөв үү буруу юу гээд л гайхдаг.

Хэрэв та бүх зүйлийг өөрийнхөө аргаар хийсээр байвал бүх насаараа гайхсаар байх болно. Мөн хэн ч танд хангалттай хариулт өгч чадахгүй. Таны цаг хугацаа минийх шиг их үнэ цэнтэй. Хэрвээ таны цаг хугацаа үнэ цэнтэй биш бол минийх үнэ цэнтэй. Намайг аль хүссэн үедээ хараг гээд явж очихын төлөө надад автобус болон онгоцоор зугаалж явах цаг зав байхгүй. Гэтэл та нар энүүгээр хэсүүчлэн, холхиж зугаалан, хүссэн ямар нэг юмаа хийж явдаг. Тэгчихээд л та ирээд би юу ч хүртсэнгүй гэж гомдоллодог, гэвч та яагаад энд ирсэн, яагаад энд сууж байгаагаа, эсвэл яагаад энэ тэрийг ба бусад зүйлсийг хийж байгаагаа мэддэггүй. Намайг өөрийнх нь төлөө юм бүхнийг хийнэ гэж хүлээдэг атлаа өөрөө юу ч хийдэггүй, тэр байтугай энд орж ирээд суухыг ч хийхгүй байна.

Бид та нарын төлөө бүх зүйлийг зохион байгуулдаг, тэгэхлээр та нарт зохион байгуулах шаардлага ч алга байна! Хийх юм байхгүй, та юу ч хийхгүй. Хоолны хүмүүс таны хоолыг бас хийчихнэ. Гэтэл та нар тэр өчүүхэн хариуцлагаа ч биелүүлэхгүй байна. Та юу гэж бодож байна? Ингэх нь зүгээр байх болно гэж та бодож байна уу? Ийм замаар та Бурханы адислалыг хүртчихнэ гэж бодож байна уу? Тэгээд та надад бүх зүйл байгаа гэж боддог, гэтэл бүх зүйлийг би хийх ёстой болдог. Тэгээд та нарын зарим нь шүүмжилсээр л байдаг!

Дээр үед, хэрвээ их багштай эсвэл ямар нэгэн багштай болохыг хүсвэл та юу хийсэн байх хэрэгтэй байсныг мэдэх үү? Өдгөө цагт ч коллежид орох бол та төлбөр төлөх хэрэгтэй. Хэрэв та биш бол эцэг эх чинь төлдөг. Тэд шууд төлөхгүй байлаа ч төр засагтаа татвар төлдөг, тэгээд төр засгаас багш нарт цалин өгдөг. Та тийшээ очиж нэрээ бүртгүүлж, шалгалт өгч тэнцэх ёстой байдаг. Үүнд их хугацаа орж, төвөгтэй байдаг.

Та нар намайг яагаад гадуур явж лекц уншин, дэлхийн хүмүүсийг аврахгүй байна гэж асууж шалгаасаар байдаг. Хүмүүсийг аврах тийм амархан юм уу? Өнөөдөр авшиг хүртээх үеэр хамгийн дээд Бурханы хүч аль хэдийн энд буугаад ирчихсэн байхад ч тэдний заримд нь хүрч чадахгүй байгаа. Зөвхөн тамын гал л шатааж чадна. Энэ нэн хэцүү; зарим хүний зүрх сэтгэл маш хатуу байна, бүр Бурхан ирчихсэн байхад, Бурханы хүч дотор сууж байгаа хэрнээ л сэтгэл нь хөдөлдөггүй.

Би энэ тухай бодохоос ч айдас хүрч байна. Хамгийн Оройн Дээдийн Хүч ч хөндөж чадахгүй ямар хатуу хүмүүс байдаг юм бэ? гэж бодохоор айж сүрдэм байна. Тийм ч учраас хорвоо дэлхий энэ байгаагаараа байгаа юм. Яагаад энд дайн, зовлон гамшиг эсвэл аллага байна гэж надаас бүү асуу. Хөөрхий Ноён Бурхан юу хийж чадах гэж? Энэ бол уулыг нурааж, ус далайг ширгээж, эсвэл бүх орчлонг ч тоос болтол үйрүүлж ч чадах хүч юм. Тийм хэр нь л зарим хүмүүсийн зүрх сэтгэлийг хөндөж чадахгүй байна. Бид ямар болчихоод байгаа нь үнэхээр аймшигтай байна.

Тийм атлаа та нар надаас ийшээ ир, тийшээ яв, бидэнтэй ярь, хамт бай, бидний найзуудыг авар, гэр бүлийг авар, энэ тэр ба элдэв бусад зүйлийг хий гэж байнга хүсдэг. Хэрвээ би татгалзвал, “Их Багш яагаад ажлаа хийхгүй байна? Тэр яагаад хүн төрөлхтөнг энэрэн хайрлах сэтгэлгүй байгаа юм бэ? Тэд хангалттай зовж байна шүү дээ.” гэхчлэн боддог. Би хэрвээ чадах байсан бол хийчихнэ. Есүс хэрвээ чадах байсан бол, Тэр үүнийг хийчихсэн л байх байсан. Бид энэ цаг үе хүртэл хүлээхгүй л байх байсан. Хэрвээ Есүс бүх дэлхийг аварч чадах байсан бол Тэр үүнийг хийчих л байсан.

Хэрэв Будда бүх дэлхийг аварчихсан байсан бол миний ээлж ирэхгүй, мөн таны ээлж ч ирэхгүй байх байсан.

Энэ ямар хэцүүг та ойлгож байна уу? Яагаад гэвэл бид дэндүү бардам, мөн дэндүү ихэмсэг байна. Бид маш их зүйл мэддэг гэж боддог. Бид энэ судрыг мэднэ, тэр Библийг мэднэ, үүнийг, тэрнийг мэднэ гэдэг. Бид бүгдийг нь цээжилчихсэн, тэгээд өөрийн тэнэг мэдлэгээрээ ихэд бахархаж, бид бүхнийг мэднэ гэж боддог. Бидэнд хэн нэгэн ямар нэг шинэ зүйл сургах гэвэл бид татгалздаг. Эсвэл бид өө сэв хайх гэж оролддог, шүүмжлэхийг завддаг, бид тэр хүнээс илүү мэднэ, бүхнийг мэднэ, бид үнэхээр гайхалтай гэж бусдад үзүүлэхийг эрмэлздэг. Гэтэл үүгээрээ бид зөвхөн өөрийгөө л хорлож байдаг, эрх чөлөөнд хүрэх, жинхэнэ мэдлэгт хүрэх замаа хаадаг. Бид ердөө л бүх зар сурталчилгааг жинхэнэ зүйл шиг хүлээн авч, тэрэндээ сэтгэл бардам байдаг.

Их Багш Хайр,
Билиг ухаан, Гоо
үзэсгэлэнгээр
бидний амьдралыг
өнгөлөг болгодог.



Сүнслэг бясалгалын нууц - Их Багшид бүрэн итгэн бишрэх

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Долоон өдрийн даяан, Илан, Формоса, 1988 оны 8-р сарын 12-18
(MP3№CRO1) (Эх нь Хятад хэлээр)

Миний сүнслэг бясалгалын нууц бол: Энд ямар ч нууц байхгүй! *(Их Багш болон бүгд инээлдэв)* Би үнэхээр гэнэн! Өнгөрсөн хугацаанд би өөрийгөө тэр чигээр нь Бурханд, мөн Их Багшдаа Түүнийг амьд байхад нь өгсөн байсан. Түүнийг явсны дараа би хүн бүрийг өөрийн Их Багш мэт үзэх болсон билээ. Энэ бүх хугацаанд миний Их Багш намайг үргэлж харж хандаж байгаа гэж би үнэхээр их итгэдэг. Намайг хаана ч явсан Тэр намайг халамжилж байдаг. Хэн ч намайг гэмтээж чадахгүй. Тийм учраас би хүн бүрт итгэдэг.

Би Их Багшдаа яаж ханддаг байсан шигээ хүн бүрд сайн ханддаг, учир нь би түүнийг хүнийх нь хувьд хүндлэх гэхээсээ илүү хүн бүрийн дотор байгаа Их Багшийг харж чаддаг учраас юм. Би хэн нэгний дотоод Бурхан Чанарыг маш тодорхой харж чаддаг. Би Бурханы Гэрэл хаа сайгүй гэрэлтэж буйг хардаг. Бүхий л мэдрэхүйт төрөлтөн бүгд Бурхан Чанар агуулж байдаг. Юм бүхэн оройн дээд Их Багшийн биежилт байдаг.

Харин та үүнийг дуурайж чадахгүй, учир нь та энэ түвшинд одоогоор хүрээгүй байна. Тиймээс болгоомжтой байх нь дээр. Би ойр хавьд ч байж л байна. Надад итгэл сүсэгтэй байх нь танд хангалттай. Хэрэв таны зүрх сэтгэл дэндүү тогтворгүй байвал та анхаарал төвлөрлөө сарниулахгүй бясалгаж чадахгүй. Хэрвээ та надад итгэхгүй байгаа бол холбоогоо тасал. Явж өөр хэн нэгэнд итгээд, түүндээ бүрэн анхааралтайгаар үйлчил. Түүний үгийг дага. Хичээгээд үз, ямар үр дүн гарахыг хар.

Ингэвэл илүү дээр юм. Хоёр завин дээр зэрэг зогсох хэрэггүй; тэгвэл та тун удалгүй далайд унах болно.

Би өөрийнхөө сүнслэг бясалгалын нууцын тухай ярьж чадахгүй. Үнэн хэрэгтээ надад нууц гэж байхгүй. Миний ганц нууц гэвэл миний гэнэн зан л байх. Бурхан гэнэн хүмүүсийг харж хандаж байдаг. Тийм хүмүүс нялх хүүхэд шиг арчаагүй байдаг учир хүн бүр л тэднийг хамгаалахыг хүсдэг. Хаягдаж орхигдсон, өрөвдөлтэй нялх хүүхдийг харахаараа бид эцэг эх нь биш хэрнээ хурдхан өргөж тэвэрдэг биз дээ. Уйлахыг нь хараад бид аргадна. Өлссөнийг нь мэдээд хурдхан хооллоно. Нялх хүүхэд хэтэрхий гэнэн, бүтэлгүй болохоор л тэр шүү дээ. Тийм л болохоор хүн бүр түүнийг асарч хандахыг хүсдэг.

Миний нууц гэвэл “гэнэн зан” минь л байх. Биднийг гэнэн цайлган байвал Эзэн Бурхан биднийг харж хамгаална. Бид байнга л Түүний дэргэд байх болно, учир нь Тэр биднийг орхихгүй. Бид ердөө л хэтэрхий гэнэн. Тэр биднийг орхичихвол бид үхчихнэ. Өөдөсхөн жаахан, гэнэн, юу ч хийх чадваргүй нялх хүүхдийг бид хорин дөрвөн цагийн турш дэргэд нь байж хамгаалдаг. Хэрэв бид нялх хүүхэд шиг бол байнга л Эзэн Бурхантай хамт байна, бүх зүйлийг “томчууд” хийгээд өгнө.

Та нарт Үнэн Ёсыг дамжуулахдаа би Оройн Дээд Бурханы хүчинд даатгадаг. Миний хийж буй бүх зүйлийг Оройн Дээд Бурхан хийдэг, энэ эгэл хүний бие хийдэг юм биш. Ингэсэн нь ч найдвартай, учир нь эгэл хүн олон алдаа гаргаж магадгүй, харин Оройн Дээд Бурхан тэгэхгүй. “Мэргэн хүн тэнэг харагддаг” гэж ярьдаг шиг. Хэрвээ бид тэгтлээ тэнэг байх юм бол Эзэн Бурхан биднийг ойшоохгүй орхиж чадахгүй. Тэр бүхнийг хийж өгнө, бид харин алдаж эндэхгүй.

Би шавь байхдаа бусад шавь нар намайг буруу ойлгох, гадуурхах үе гарахад тэднийг зүгээр л ойшоохгүй үлдээдэг байв. “Их Багш минь бүгдийг харж мэдэж байгаа. Тэр учрыг нь олно биз.” гэж бодсон. Би асар их итгэл сүжигтэй байсан бөгөөд гомдоллосонгүй, эсвэл өөрийгөө тайлбарлах гэсэнгүй.

Би өөрийгөө - үг хэл, бодол, үйл хөдлөлөө - бүх амьдрал - өнгөрсөн, одоо, ирээдүйгээ Их Багшдаа бүрэн дүүрэн даатгасан. Тиймээс ч би өөрийн санаачилгаар юу ч хийхгүй, нялх хүүхэд шиг аюулгүй байв. Энэ л миний нууц байх. Үүрэг хариуцлага хүлээхгүй би тун ч амар аюулгүй мэдрэмжтэй байлаа. Тийм болохоор надад гуних, санаа зовох юмгүй, тун ч амар тайван байсан, “учир нь гэвэл миний Их Багш бүхнийг мэднэ. Тэр бол хамгийн аугаа нь”. Зүрх сэтгэлд маань ингэж л мэдрэгдэж байсан.

Өдийг хүртэл надад харамсах зүйл ер гараагүй. Урьд өмнө нь хамаг зүйлийг Их Багш зохицуулна гэж даатгачихаад, бүх юм төгс сайхан байсан. Сэтгэл зүрхэндээ би Их Багш минь намайг халамжилна гэдгийг мэдэж байсан учир гомдоллох юм ер байгаагүй. Надад байдаг ганц нууц энэ: бүрэн дүүрэн итгэл бишрэл. Хэрвээ та нар надад итгэхгүй байгаа бол Оройн Дээд Бурхан, хамгийн дээд Буддад итгэ. Тэр хамаг төрөлтөн бидний үйлдлийг харж чаддаг ба бүхнийг зохицуулна. Тэр үнэхээр л тэгнэ!

Их Багш Үнэнд хүрсэн нууц

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Гэрээс гарсан шавь нартаа айлдсан, Шихү төв, Формоса
1995 оны 12-р сарын 3 (Эх нь Хятад хэлээр)

Би хэрхэн Үнэнд хүрснийг та нар мэдэх үү? Би дандаа юм бүхнийг бусдын төлөө хийдэг байсан учраас л тэр. Бүх амттай хоол хүнсийг өөрөө л идэх гэж шүүрэн авдаг, мөн бүх гоё сайхан бүхнийг өөртөө хадгалдаг үе шатанд таны сүнслэг бясалгал дадал хаагдаж гацсан хэвээр байна. Та бусдад өгөх дуртай биш болохоор л танд юмс элбэг дэлбэг биш байгаа юм.

Бид их өгөх тусмаа их хүртдэг гэдэг үнэн юм. Би маш ихийг өгсөн болохоор идэж чадахаасаа хангалттай илүү их хоол хүнстэй байна. Тийм учраас намайг дахиж хүлээж авч чадахгүй болох хүртэл адислалт хариу шагнал нь ирсээр байх вий гэж эмээгээд би саяхан хандив тусламж үзүүлэхээ зогсоосон! (Их Багш болон бүгд инээлдэв.)

Би Үнэнд хэрхэн хүрсэн бэ? гэдэг зарим нууц энд байна. Нэгт, би бусдад тун их анхаарал халамжтай ханддаг. Хоёрт, би багш нараа маш их хүндэтгэдэг.

Бага сургуулиас дээд сургууль хүртэл олон багш нар надад сайн байсан. Тэднийг маш их хүндэлдгийг маань тэд дотроо мэдэрдэг байснаас тэр болов уу. Надад ямар нэг зүйл байдаг байж мэднэ. Магадгүй би тэдэнтэй үйлийн барилдлагатай байх.

Өсөж том болсон хойноо би олон их багш нарыг дагасан. Хэдийгээр тэд тийм ч их гэгээрээгүй байсан ч би тэдний зааврыг бүрэн дагаж байсан. Өчүүхэн ч үл хүндэтгэл, эсэргүүцэл надад байгаагүй.

Миний их багш нар надад сайхан хандсан гэж бодож байна уу? Үгүй! Тэд заримдаа намайг зүхэж загнадаг л байсан. Бидний одоогийн түвшинтэй харьцуулбал тэд бага ангийн багш нар шиг байсан, харин би бага ангийн сурагч байсан! Тэд надад онцгойлон сайн байгаагүй. Би тэдэнд тусалж, их зүйл зориулж байсан ч тэд заримдаа намайг зэмлэж, үгээр чичлэн гомдоож, намайг чи юу ч биш гэж хэлж байсан.

Жишээ нь, намайг гэрлэсний дараа, миний эмэгтэй их багшийн хэлсэн эхний үг нь: “Чи түүнтэй гэрлэх эрхгүй.” (*Их Багш инээв*) Тэр намайг нөхөртэйгээ гэрлэх эрхгүй гэж хэлсэн. Тэр “чиний эмэгтэй найз л түүнтэй гэрлэвэл зохино” гэж хэлсэн. Бид хэдийн гэрлэхсэн байхад л тэр ийм юм хэлж ярьсан даа?”

Би их багшдаа, “Миний эмэгтэй найз гэрлэхсэн. Тэр надаас өмнө гэрлэсэн байсан. Тийм биш байсан бол би таны үгэнд орж, бие биедээ зохицох юм чинь тэднийг нийлэхийг зөвшөөрөх байлаа.” гэж хэлсэн. Түүнээс хойш тэр юм хэлэхээ больсон. Ямар ч байсан би огт уурлаагүй. Би “Их Багш аа, та яаж ийм юм ярьж чадаж байна?” гэж ер хэлээгүй.

Энэ тал дээр та нар өөр юм шиг надад санагддаг. Би таныг буруутгаж байгаа юм биш; зүгээр л энэ нууцыг мэдэг гэж л хүссэн юм.

Их Багш ба Шавийн хоорондын ялгаа

Би та нарыг хааяа лекц уншуулахаар явуулдаг болохоор заримдаа бид сүнслэг бясалгал маань хэдийн их сайн болжээ гэж боддог. Буцаж ирээд та нар: “Би төгсчихлөө. Их Багш зургаан сарын дотор төгссөн, харин би ихдээ зургаан жилийн дотор чадна!” гэж боддог. Эргэж ирэхдээ та нар өөр болдог! Үүнээсээ болж өөрсдийгөө хохироодог. Та нар өөрсдийгөө их сайн гэж боддог, гэвч тийм сайн биш!

Би ч бас та нарыг их сайн гэж боддог, тэгэхээр энэ бол хачирхалтай зүйл! Би энэ дэлхий дээрх хамгийн тэнэг нь; тийм болохоор би олонтоо сэтгэл өвдөж, гонсойж, урам хугардаг. Учир нь би бас та нарыг их сайн гэж бодоод, та нар надаас ямар ялгаатайг бодож тооцож чаддаггүйгээс болдог.

Заримдаа би мэддэг. Та нартай хамт байх эсвэл хамт ажиллах үедээ үнэхээр том ялгаа байгааг би мэддэг. Эс бөгөөс би мэддэггүй. Хэрвээ ажил байхгүй бол би та нарыг шавь гэдгийг бүрмөсөн мартдаг. Бид адил харагддаг бас нас ойролцоо; зарим нь надаас бүр ахмад байдаг. Тэгээд та бидний хоорондох ялгааг би төсөөлж чаддаггүй. Би та нарыг надтай л адил, бид бие биесээ ойлгоно гэж боддог; тиймээс би ярьсаар л байдаг. Эцэст нь хэн ч ойлгодоггүй, тиймээс би үнэхээр тэвчиж чадахгүй байна. Тэгээд сэтгэл гонсойн суудаг. Энэ бүх дэлхийд зөвхөн би л ганцаараа өөрийгөө ойлгодог юм шиг бодогдож, үнэхээр харамсдаг.

Эрт дээр үеэс л Гэгээрсэн Их Багш нар хүмүүстэй харилцахад бэрх байсан бололтой. Би бас л тэдний нэг шиг санагддаг. Үүнд нэн их чармайлт ордог. Та нар маш энгийн зүйлийг ч ойлгодоггүй; би маш удаан ярихгүй л бол. Та нар өөртөө маш их тээг саад тавьдаг. Та дэндүү ярвигтай – ийм ч тийм ч байх ёстой гэж бодсоор л байдаг. Үнэхээр ярвигтай, тун хүндрэлтэй.

Та нар ойлгодоггүй, тэгсэн хэрнээ бусдаас суралцахыг ч хүсдэггүй. Та нэр нүүрээ барахаас айж багшаас суралцахыг хүсдэггүй: “Би үүнийг ганцаараа хийж чадна! Өөрөө хийхийг минь зөвшөөр!” - яг ийм байдаг, ингээд л та олон алдаа гаргадаг.

Өөрийгөө анзаарч шинжсэнээр та өөрөөсөө олон дутагдал олох болно. Би ч бас өөрийгөө өдөр бүр шалгадаг, харин би ямар нэгэн гэм буруу олдоггүй. (Их Багш болон бүгд инээлдэв)

Бүхэлдээ Бурханы багаж бол

Би Бурханы ажилд өөрийгөө бүхэлд нь зориулсан цагаас хойш надад үндсэндээ өөр сонголт байхгүй. Би өөрийн үйлдлээ эсвэл нөхцөл байдлыг хянаж чадахгүй. Би үүнд үнэхээр дургүй, хүсэхгүй байсан ч хийх л болно. Би өөрийгөө бүгдийг нь өргөн зориулж байгаа юм чинь яагаад ямар нэг юм хадгалж үлдэх хэрэгтэй гэж? “Миний зан чанарт тохирохгүй учраас надад энэ таалагдахгүй байна, тэр зүйл миний нэр хүндийг унагаж, намайг муухай харагдуулна.” гэж би хэлж чадахгүй.

Энэ бол Бурханы ажлыг хийдэг арга байдал биш юм.

Ердөө экскаватор шиг л юм, та хаашаа чиглүүлнэ тэр тийшээ явдаг. Ухахаар чиглүүлсэн тэр газар л ухах болно. Тэр экскаватор “Би өнөөдөр сэтгэл санаа тааруу байна, би энд ухахыг хүсэхгүй.” гэж хэлж чадахгүй. Тэр ажилладаг арга замаараа ажлаа хийх л ёстой. Энэ бол зүгээр л нэг багаж хэрэгсэл бөгөөд Их Багш бас л тийм байдаг. Би тэр чигээрээ Бурханы багаж хэрэгсэл болсон, хувь хүнээрээ орших юм огт байхгүй.

Би та нарт муугаар хандаж байх тэр үе бол үнэндээ сайнаар хандаж байгаа мөч юм. Би та нартай найрсаг сайхан харилцаж байх үедээ та нарыг үүнийг тэсэж даахгүй байх вий гэж эмээдэг, энэ бас хүний төвшний л сэтгэлийн хөдөлгөөн юм! Би үүнийг хүмүүст хандах тохиромжтой арга гэж боддог, ийм байдал нь танд илүү таатай санагддаг. Чухамдаа энэ бол үнэхээр “хүний” зан байдал юм. Би та нартай үнэхээр илэн далангүй, тун шулуухан, биеэ барихгүйгээр харилцаж байгаа мөч бол би танд үнэхээр сайн хандаж байгаа хэрэг юм - та нарыг Бурхан өөрөө шууд зохицуулж байгаа нь тэр.

Гэвч хэрвээ та нарыг өдөр бүр ингэж шууд зохицуулдаг байсан бол та нар аль эрт үхчих байсан. Энд ганц ч сүнс үлдэхгүй. Тиймээс юмсыг бага зэрэг эготой хийх шаардлагатай болдог юм. Хэрэв би та нарыг өдөр бүр Бурханаар зохицуулуулах аваас би өөрөө ч тэсэж чадахгүй! Хэт их, дэндүү эрчимтэй хэрэглэгдэх тул миний бие, оюун ухаан үүнийг тэсвэрлэхгүй!

Хэрвээ та хаазаа гишгэсэн чигээрээ л - машинаа амраахгүй, зогсоохгүй булан тойрохдоо ч 170 миль хурдтай давхивал, энэ маш туйлдуулна, та хэт хүчлэх болно.

Хааяа бид чинь хүн гэдгээ санаж, жаахан тайвширч байх хэрэгтэй. Юм идэж, эсвэл сэтгэлд хөнгөн сэдвээр ярилцах хэрэгтэй, энэ бас л их чухал. Байшин хоосон байвал бид ашиглаж чаддаг шиг л юм; хэрвээ шүүгээ, үнэтэй тавилгаар дүүрчихсэн байвал ашиглаж чадахгүй.

Үнэнд хүрэхийн тулд зүрх сэтгэл энгийн, цэвэр ариун байх учиртай

Хэтэрхий хатуу эсвэл хүчтэй зан чанартай байх нь хүсүүштэй биш. Үргэлж ялах шаардлагагүй. Үргэлж бусдын дээр гарах гэж эсвэл багшаас илүү болох гэж оролдохын оронд яаж уян хатан, ухаалаг байхыг мэдэх хэрэгтэй. Багшаас илүү дээр байх нь сайн ч одоохондоо хэт эрт байна. Одоогоор та нарын хэн нь ч багшаасаа илүү дээр биш байна! Би илэн далангүй л хэлчихье, би биеэ тоож байгаа юм биш харин та нарыг өөрсдийгөө шинжиж, дотоод билиг ухаан ба зан чанараа тохируулах ба сургахыг чармайж, дутагдлуудаа хаана байгааг олж мэдээсэй гэж би хүсэж байна.

Гэсэн ч үргэлж дутагдлынхаа ард нуугдах нь муу юм. Ингэх нь хэтэрхий сөрөг, өөрийгөө жигших, хэтэрхий гутранги үзэл юм. Бид алдаа дутагдлаа ердөө л мэдэх хангалттай биш! Бид алдаагаа залруулж, хийхээ больж, алдаагаа нөхөх эсрэг арга барилаар биеэ авч явах хэрэгтэй.

Алдаа дутагдлаа мэдэх нь өөрийгөө буруутгаж, өөрийгөө агуйд түгжин, тэндээ өдөр бүр “хаалттай даяан” хийж; есөн жилийн дараа яст мэлхий болж, мөн гарч ирэхдээ хүмүүсийг үхтэл нь уйтгарлуулахыг хэлж байгаа юм биш. (Инээлдэв) Энэ нь өөрийгөө буруутгах, өөрийгөө бачууруулахыг хэлэхгүй; харин дээшээ авирч, өөрчилж, эсрэг байдлаар нь үйлдэх хэрэгтэй. Энэ л жинхэнэ гэмшил болно, зөвхөн өвдөг сөгдөн өөрийгөө шийтгэхийн оронд; энэ зөвхөн нэг хэсэг нь л юм. Хамгийн сайн гэмшил бол сөрөг чанарыг бүрмөсөн зогсоож, эсрэг байдлаар нь үйлдэх, эерэг хувь нэмэр оруулах явдал юм. Энэ нь л гэгээнтэнлэг байхын нууц юм - зүрх сэтгэл илүү энгийн бөгөөд цэвэр ариун болно.

Би модон Буддагийн дүр тахиад ашиггүй гэж одоо хэлдэг хэдий ч 10 жилийн өмнө Буддаг шүтэхдээ үүнийг нэн чин сэтгэлтэй хийж байсан. Би хангалттай шүтсэн болохоор ашиггүйг нь мэднэ. Миний багш нар намайг Буддаг тахь, аль таалагдсан Буддагийн дүрс баримлыг худалдаж ав гэж хэлсэн. Би Майдар Бурхан их уужим сэтгэлтэй гэж бодсон. Миний зөв байсан; одоо надад үнэхээр хэрэгтэй байна. (Их Багш болон бүгд инээлдэв) Тэр бас их баяр хөөртэй байсан. Энэ чанарууд надад үнэхээр хэрэгтэй байсан болохоор би Майдар Бурханы дүрс баримлыг худалдаж авсан юм.

Тэр өдөр миний их багш нар Буддагийн баримлыг гэрт маань залах ёслол үйлдсэн. Тэд хүж асааж, мөргөж, намайг хүслээ хэл гэсэн. Би ганцхан л хүсэл хэлсэн: “Ирээдүйд би хэн нэгэнд тусалж чадах бол би үүнийг хийхэд бэлэн байх болно, гэхдээ тус хүргэчихлээ хэмээн ухамсарлан мэдэхийг надад үл зөвшөөрнө үү.” Энэ хүсэл одоо үнэхээр биелсэн; Би хэнд тусалснаа хэзээ ч мэддэггүй. Миний их багш хэрэв хүж уугиж цагариглаж байвал хүсэл биелдэг гэж хэлсэн. Үнэхээр цагаригласан тул үүнийг биеллээ гэж би итгэсэн!

Их багш маань надад гэртээ ямар нэг ном судраас унших хэрэгтэй гэж хэлсэн. Би Манал Бурханы Судрыг дуудан уншихыг хүсэхэд ч тэр зөвшөөрөөгүй. Тэр “Чи тэр түвшинд хүрээгүй байна, одоо Их Нигүүлслийн Тарнийг унш.” гэсэн. Түүнээс хойш нэлээд хугацаа өнгөрсний дараа тэрээр Лянхуа Судрыг унш гээд надад өгсөн. Тэд их чангаар уншсан, намайг ч бас тэгээрэй гэв. Намайг бас нэг модон загас (дуудахдаа хэрэглэх дугуй модон хэрэгсэл) худалдаж аваад, өдөр бүр товшоорой гэсэн. Би их нухацтай хандаж, уншлага хийхээр эрт босдог байсан.

Өглөөгүүр хоолой маань сөөнгө байсан тул би ус нэлээд уудаг байв. Уншлагаа орой ч бас дахин давтаж байсан. Эгэл хүмүүс бол голдуу тийм нухацтай хандахгүй ба ганц удаа унших хангалттай. Гэтэл би их чин сэтгэлтэй байв, бүр ийм хэмжээнд тулгал нь их багшийнхаа хэлсэн бүрийг хийж байсан.

Надад та нараар ямар нэг юм хийлгэх хэцүү байгаа одооны байдалтай адилгүй. Та нараар чулуу шүтүүлж тахиулах нь байтугай чулуу зөөлгөх ч хэцүү юм.

Ийнхүү Би өдөр бүр гэртээ хариад сударт мэхийн мөргөж, судар уншиж, Буддад тахил өргөж байсан; мөн Би ахуй ойлголт үзсэн. Үнэхээр чин сэтгэлтэй байвал та дотоодын ахуй ойлголт үздэг. Би нэлээд олон ахуй ойлголттой ч тэр бүгдийг ярьж чадахгүй.

Би их багшаасаа судрыг яагаад ийм чанга дуудах шаардлагатайг асуусан. Би “Гэртээ ч гэсэн ийм чанга унших хэрэгтэй юу?” гэхэд Тэр “Чангаар дуудах нь илүү дээр, тэгвэл үл үзэгдэх төрөлтөн ч мөн ач тус хүртэнэ.” гэж хэлсэн.

Би түүнд итгэж, дуу хоолой гарахгүй болтлоо их чанга дууддаг байсан. Тэр байтугай үл үзэгдэх төрөлтнүүд орж ирж чадахгүй байх вий хэмээн эмээж би цонхоо онгорхой орхидог байсан. (Их Багш болон бүгд инээлдэв)

Төсөөлж байна уу? Би гурав биш гучин настай байсан, тэгсэн хэр нь тийм л гэнэн байсан! Их багш юу л хэлнэ би хийдэг байсан. Магадгүй би үнэхээр дүйнгэ байсан болохоор л Үнэнийг зах зухаас нь таньжээ. Та нар шиг их ухаантай хүмүүс Үнэнд хүрэх хэцүү. Та нар үзэл санаагаар дүүрсэн байдаг; та нарын бодол санаа дэндүү ухаантай, хэтэрхий зальтай, дэндүү ихийг мэддэг!

Өвөл байлаа, нэгэн удаа гадаа хүнээс өндөр цас орсон, бас их хүйтэн байв. Тэгсэн ч би үл үзэгдэх төрөлтнүүд орж ирж чадахгүй байх вий хэмээн бүх цонхоо дэлгэж, мөн урьж буйгаа илтгэн хөшгөө хүртэл буулгаж зүрхлээгүй. Үл үзэгдэх төрөлтнүүд цонхоор орж ирэх албагүй, гэтэл би “зарим нь орж ирж чадахгүй бол яана?” гэж бодсон. Нөгөөтэйгүүр, хэрвээ би цонхоо хааж, хөшгөө татчихвал тэд уригдахгүй, улмаар орж ирж зүрхлэхгүй гэж санагдав. Би тэр байтугай “хөршдөө саад хийхээс эмээн хаалгаа онгойлгож чадсангүй” тэднээс уучлал гуйсан. (Их Багш болон бүгд инээлдэв)

Их Багшийгаа сонс, тэгвэл Бурхан уярна

Их Багшийгаа сонс – Тэр эрэгтэй, эмэгтэй алин ч бай, та буруудна гэж байхгүй. Бурхан уярах болно. Энэ хүн тун ч дүйнгэ юм байна гэж анзаараад Бурхан түүнийг хамгаална, түүнд ямар нэг юм ойлгуулна. Тэгэхгүй бол хэрвээ тэр бүх амьдралынхаа турш дүйнгэ үлдвэл юу болох билээ?

Тиймээс л Бурхан дүйнгэ хүмүүсийг үргэлж анхаарч байдаг. Бид хэлгүй дүйнгэ байх ёстой үедээ тийм л байх хэрэгтэй. Ажиллах хэрэгтэй үед хамгийн сайнаараа ажилла; билиг ухаанаа ашиглах хэрэгтэй үедээ ашигла, харин та сонсож байх ёстой үедээ билиг ухаанаа бүү ашигла. Бид хоёр чихтэй харин зөвхөн ганц амтай. Гэтэл танд хоёр ам, нэг чих ургасан юмуу (Их Багш болон бүгд инээлдэв) эсвэл тэд буруу газар ургасан бололтой байдаг. Би та нарт ямар нэг юм хэлсэн даруйд их хурдан үлээгдэн замхарч, өчүүхэн үр нөлөө үлдсэн юм шиг санагддаг.

Олон хүн энд ирсэн хойноо ч урьдаас дассан төсөөлөл, үзэл баримтлал, санаагаа тээсэн хэвээр байдаг. Тэдэнд өөрсдөө аугаа санагдаж, Их Багшийг доош татах дуртай. Намайг өөрсдийнхөө түвшин рүү доош татахын оронд өөрсдийгөө дээш татах нь илүү өлзийтэй. Мэдээж, Их Багшийг доош татах өөрт илүү тааламжтай болно, ингэвэл та “Тэр яг л над шиг юм!” гэж хэлэн надад илүү ойртсон мэт санагдана.

Гэвч энэ танд муу. Би үргэлж дээшээ авирч эсвэл доош бууж чадна, харин би багшийн хувьд үнэнийг хэлэх үүргээ биелүүлэх ёстой. Та дотроо бол үүнийг тун тодорхой ойлгож байгааг чинь би мэдэж байна, харин оюун бодол чинь л тэмцээд байгаа юм. Та энд ирсэн зорилгоо тодорхойлох хэрэгтэй, бодлоо битгий сонс. Тэгэхгүй бол бодол санаатай тэмцэлдсээр бид хоёулаа их ядарна.

Би үргэлж л таны бодолтой тэмцэлддэг, энэ ёстой ядаргаатай. Би хэн нэг тодорхой хүний талаар бодох бүртээ түүний сүнсэнд хүрэх миний замыг хаасан элдэв зүйлсээр түүний бодол санаа бүхэлдээ дүүрсэн байгааг мэдэрдэг. Орох хаалгыг тэр бодол санаа бат бөх гэгч манаж байдаг. Энэ тун туйлдмаар! За боллоо! Одоо хүн бүр ойлгов уу? (Хариулт: Тэглээ!)

Бүх гайхамшгийн эх нь итгэл бишрэл юм

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Ёнгдон төв, Солонгос, 2000 оны 5-р сарын 13 (Дүрс бичлэг №639)
(Эх нь Англи хэлээр)

Та нарын дунд олон хүн миний энэ бие махбодоос болж бус, харин Их Багшийн сургаалаас болж Их Багшийн сургаалд жинхэнэ итгэл бишрэлтэй байгаад сэтгэл их хөдөллөө. Мөн та нар ингэж л энэ дэлхий дээр шарх шалбархайгүй амьдарна; та нар итгэл бишрэлээрээ үргэлж хамгаалагддаг. Есүс хэлсэнтэй яг ижил, Итгэл бишрэл таныг бүхэл бүтэн болгож чадна. (“Thy faith hath made thee whole.” Matthew 9:22)

Итгэл бишрэл олон зүйлийг давж чадна. Энэ бас бэлэг юм; та итгэл бишрэлтэй байхыг хүсэхэд л олоод авчихаж чаддаг юм биш. Зарим хүн их урт хугацаагаар гүн хордсон байдаг; тэд итгэл бишрэлийн төлөө залбирдаг ч тийм болж чаддаггүй. Тэгэхлээр ийм хүмүүсийг та нар уучилж ойлгох хэрэгтэй, энэ тэдний буруу биш юм. Тэд бүхий л төрлийн сөрөг нөлөө, сэтгэхүйгээр тархиа угаалгасан, тиймээс өндийж босох тэдэнд маш хэцүү. Өө, та нарын хувьд бол, азтай хүмүүс, та нарыг хараад би нэн баяртай байдаг, учир нь та нар үнэхээр давгүй байна. Та нар надад итгэдэг учраас энэ биш, учир нь тэгээд ч “надад гэх би” байхгүй; та нар надад тал зассан үг хэлж, надад итгэсэн учраас би баяртай байгаа юм биш; энэ тийм биш. Та бүгд давгүй байгаад би баяртай байна, та нар хамгаалагдсан бөгөөд жаргалтай байна, тиймээс би залуус та нарын төлөө санаа зовох хэрэггүй байгаа учраас тэр юм. Ингэвэл би маш их цаг хэмнэж, өөр бусад “өвдсөн” үрсэд санаа тавих боломжтой болж байна. Мөн та нар давгүй сайн байгаа болохоор надад өөр шинэ хүмүүсийг, хүч тэнхээ дутмаг хүмүүсийг анхаарч халамжлах туслах боломж бий болдог.

Ийм учраас би баяртай байна, та нар надад итгэдэг учраас биш, надад итгэх үгүй эсэхээс болоод биш; надад итгэвэл өөрт тань л сайн. Учир нь итгэл бол гайхамшиг бүхний ээж нь юм. Таны Их Багш сайн биш байлаа ч таны итгэл бишрэл сайн байх нь өөрт тань өлзийтэй сайн. Үнэхээр тийм юм, учир нь та тун цэвэр ариун. Тийм болоод л таны хувьд танихгүй бас хамааралгүй хүнд та итгэж байгаа юм. Энэ таны сайн байгааг илтгэнэ. Энэ бол миний сайн эсвэл сайн биш эсэхийг хэлж буй юм биш; Би үүнийг хараахан мэдэхгүй байна. (Их Багш инээв; сонсогчид “Тийм, Та сайн” гэгцгээв.)

Миний хэлсэн санаа гэвэл Би сайн, эсвэл сайн биш байж магадгүй, харин та надад итгэж байвал энэ нь та өөрөө зуун хувь сайн гэсэн үг. Энийг л та мэдэж байвал зохино. Миний сайн эсвэл сайн бишийг хэлэхэд хэцүү байж магадгүй, харин та надад итгэдэг байх нь таныг сайн гэдгийг бэлээхэн илтгэж байна. Энэ таньд гарцаагүй сайн хэрэг юм.

Хулгайч гарч ирдэг тухай түүх ярьсныг минь санаж байна уу? Ямар ч сүнслэг удирдамжгүй, хүсэл тэмүүлэлгүй их удсан нэгэн хосын тухай түүх байдаг юм, тэд өөрсдийгөө одоо нэгэнт хөгширсөн юм чинь гадуур явж сүнслэг Их Багш эрж олъё гэж шийджээ, гэвч тэд хэнийг эрж олохоо мэдэхгүй байв. Ийн тэд ойд очиж суугаад залбирчээ, мөн хамгийн түрүүнд гарч ирсэн хэн ч бай түүнийг Их Багшаа болгоно гэж Бурханд амлав. Гэтэл нэг хулгайч хүрч ирээд (Инээлдэв) тэднийг тэнд үлд гэхэд тэд үлджээ, гэтэл Бурхан үзэгджээ. Энэ тэдний итгэл бишрэлээс болжээ, учир нь Бурхан таны дотоодод байдаг. Би та нарт Бурхан бий болгож өгөөд байгаа юм биш.

Тиймээс л та надад итгэх нь та тийм ариун гэсэн үг, Би сайн эсвэл сайн биш байхаас хамаарахгүйгээр, та үнэхээр цэвэр ариун тул итгэл бишрэлтэй, энэ итгэл бишрэл таныг бүхнээс хамгаалдаг. Энэ чинь л таныг энэ болон дараагийн дэлхийд өгөгдсөн адислал, бэлэг нь болгодог юм. Тийм учраас би баяртай байна; та нар надад итгэдэг болохоор би баяртай байгаа юм биш. Би ийм цэвэр ариун хүмүүстэй найз байгаадаа баяртай байдаг. Та нар миний амьдралын бэлэг байгаа нь миний хувьд нэр төрийн хэрэг юм. Ийм учраас би баяртай байгаа юм.

Гэгээнтэн болохын тулд нэг арга дээрээ төвлөр

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
АНУ-ын Флорида, 2001 оны 6-р сарын 8 (Дүрс бичлэг №716)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: Их Багш бүхэн сургахдаа “Өөр багш дээр битгий оч.” гэж хэлэхийг би сонсдог. Хэрэв хоёр дугуйг зэрэг унах гэвэл дугуй унаж сурахгүй гэж Та хэлснийг би мэднэ. Үүний зэрэгцээ хаа нэгтээ, ямар нэгэн байдлаар бид Нэгэн цогц гэдгийг би ойлгож байна. Гэвч яагаад энэ Нэгэн цогц байдал нь Их Багш хувь хүнээс давж гардаггүй юм бэ?

Их Багш: Учир нь та аль хэдийн тусдаа болсон байна. Дахиад бүх төрөлхтөнтэй нэг болоход цаг хугацаа, хүч, мөн төвлөрөл шаардана. Тиймээс та тусдаа байх хугацаандаа эхлээд мэддэг зүйлдээ анхаарлаа төвлөрүүлж, байгаа зүйлээ судалж үзсэн нь дээр. Эс бөгөөс та хоорондоо зөрчилдсөн мэт олон онол, сургаалаар өөрийгөө дарж живүүлэх болно.

Жинхэнэ Их Багш нар нэг л ижил Үнэнийг заадаг ч тодорхой хүмүүст үүнийг өөр өөрөөр илэрхийлж болно. Мөн энэ Их Багшийн шавь нартайгаа тогтоосон барилдлага нь бусад их багш нартай таны тогтоосон барилдлагаас ялгаатай юм. Гэхдээ та хэт олон хүчин зүйлээр өөрийгөө дарчихвал үүнийг боловсруулж шингээж авч чадахгүй. Энэ нь таны дэвшлийг удаашруулна, учир нь та өөрийгөө төөрөлдүүлж, энэ зам мөрийн талаар эргэлздэг. Гэсэн хэдий ч та өөр зам мөр лүү очиж чаддаггүй, учир нь төстэй юм шиг санагддаг, учир нь аль нь ямар болохыг ялгаж салгах, эсвэл бүгд Нэгэн цогц юм гэж ижилсгэн ойлгох чадвар тань хангалттай хөгжөөгүй байдаг. Тиймээс та ердөө өөрийнхөө л үнэний түвшинд, түүнээс дээшээ явах хүртлээ хэвээр үлдэж магадгүй. Ингэвэл мэдээж та бусад хүн төрөлтнийхөө ижил түвшин эсвэл түүнээс дээш түвшин, өөр түвшинд очих нь байтугай там руу ч явж мэднэ.

Нэг удаад нэг зүйлтэй зууралд. Хориотой зүйл гэж байгаа юм биш; зүгээр л англи хэлийг нэг профессороос суралцаж байж англи хэлний өөр нэг профессор дээр явж очих хэрэг байдаггүй, учир нь тэр танд өөр төрлийн хичээл өгч, өөрөөр зааж магадгүй. Тэр нэгэн механикчид таныхаас өөр нэр томъёо хэлж өгдөгтэй адил. Та сантехникийн мэргэжлээр суралцаж байгаа тул тэр танд өөр нэр томъёо ашиглах болно. Тэд хоёулаа л англи хэл заадаг, гэхдээ та нэг удаад нэг зүйлийн тухай судална.


Хэрвээ та хүсвэл хожим бусад багштай нэгдэж болно. Гэхдээ тэр үед ингэх шаардлагагүй болсон байдаг. Тиймээс одоо шаардлагагүй; хожим ч шаардлагагүй болно; энэ хэзээ ч шаардлагатай байгаагүй, мөн хэзээ ч шаардлагатай болохгүй. Нэг л багштайгаа үлд. Хэрэв та энэ багш Үнэн Ёсыг бүтнээр нь заадаг гэж итгэдэг бол түүнтэйгээ үлд. Хэрэв та итгэхгүй бол энэ багшийг орхиод өөр газар очиж, зөвхөн тэр багштай үлдэж болно. Гэвч та хөдлөхөөсөө өмнө болгоомжтой байгаарай. Эс бөгөөс та голж шилж явсаар цаг хугацаагаа дэмий үрнэ.

Итгэл бишрэл уулыг ч хөдөлгөж чадна. Мөн та нарт заасан бүхэн маань бүхэлдээ үнэн гэж би амлаж чадна. Үгүй бол би Бурханы шийтгэлээс айж байна. Би заах чадваргүй байсан бол зааж зүрхлэхгүй байсан, учир нь би бас нэгэн хатагтай, эмэгтэй хүн шүү дээ. Би бол хүн, бас Бурханаас эмээдэг. Би "тэнд" байхгүй байсан бол зүрхлэхгүй. Та зүрхэлж магад, харин би Бурханаас эмээдэг тул тэгж чадахгүй. Би мэдэхгүйдээ тэгэх байсан уу? Учир нь надад ямар нэг юм хэрэгтэй гэж надад санагдахгүй байна. Зүрх сэтгэлээ өнгийн харахад надад юу ч хэрэггүйг би ухаардаг.

Тэгэхлээр хэрэв би танд багшилж байгаа бол энэ нь би хийх ёстой, бас мэддэг учраас юм. Миний мэддэг зүйл, танд өгч байгаа зүйл бол хамгийн дээд Үнэн гэдгийг л би мэднэ. Хэрэв би надад та нар хэрэгтэй, эсвэл мөнгө, нэр алдар гэхчлэн хэрэгтэй учраас та нарт зааж сургаж байгаа бол би буруу хийж магад эсвэл зүгээр л алдар нэр, ашиг олохын тулд үүнийг хийдэг байж магадгүй юм.

Харин би сэтгэл зүрхээ өнгийн хараад надад юу ч хэрэггүйг ойлгосон! Миний мэддэг бүхэн бол Үнэн Ёс гэдгийг би мэднэ. Энэ бол Үнэн Ёс гэдгийг бидний олон хүн мэднэ - бид дахин дахин нотолж болно.

Тэр байтугай би андуурч эндүүрсэн байсан ч та нар бүгд эндүүрсэн байж таарахгүй. Мөн Би Диваажин ба Газар Дэлхийгээр эрж хайсаар байсан: миний та нарт зааснаас илүү дээр зүйл гэж байхгүй. (Алга ташив) Энэ нь та нарыг элсүүлж авах санаа агуулсан юм биш. Та нар асуусан учраас л би хэлж байна. Харин мэдээж, та нарын дэс түвшин ямар байна, тэрчлэн намайг ойлгоно эсвэл намайг ойлгохгүй. Би таныг хүчилж чадахгүй. Би ердөө л амлалт, андгай, өчил байдлаар хэлж байна, хэрвээ танд энэ баталгаа хэрэгтэй бол та тэрийг авлаа.





Жинхэнэ Их Багшийг болон зөв Зам Мөрийг ОЛОХ НЬ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
ХБНГУ-ын Гамбург хот, 1995 оны 8-р сарын 25
(Дүрс бичлэг №493) (Эх нь Англи хэлээр)

Бид жинхэнээсээ чин сэтгэлтэй байх үед л Бурхан биднийг хамгийн тохиромжтой зам мөр дээр аваачих болно. Энд их багш нь сайн уу үгүй юу гэдэг асуулт байхгүй. Энд шавь сайн уу үгүй юу гэдэг л ганц асуулт байдаг. Бид хараахан бэлэн болоогүй цагт, Оройн Дээдийг жинхэнээсээ, чин сэтгэлээсээ хайгаагүй байгаа цагт олон янзын түвшний их багш нартай учирсаар л байхаас биш хамгийн дээд нэгэнтэй учрахгүй. Таныг Оройн Дээдийг жинхэнээсээ эрж буйгаа мэдэх хүртэл асуулт танд үлдэнэ, тийм биш бол та ид шидийн хүч эрж байна, эсвэл ямар нэг сонууч зан болно. Цаг гаргаад, зүрх сэтгэлээ шалга. Таныг зөв мөр зам дээр байгаа гэдэгт би итгэлтэй байна. Гэвч хэрвээ энэ таны итгэл биш бол миний итгэлтэй байгаа нь танд тусалж чадахгүй. Хэрвээ та надад итгэж чадах юм бол, таныг хамгийн зөв зам мөр дээр байна гэж би танд Бурханы нэрээр зуун хувь хэлж чадна. Гэвч энэ бол та өөрөө юм; та өөртөө итгэх ёстой. Өөрийн зөн совиндоо, билиг ухаандаа, чин сэтгэлдээ итгэ, тэгээд та энэ зөв үү үгүй юу гэдгийг мэдэх болно.

Үр жимсээрээ тэд танигдана

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Лай И, Пиндун, Формоса, 1992 оны 12-р сарын 29
(Дүрс бичлэг №302)
(Эх нь Англи хэлээр)

Олон саад бэрхшээлийг бид өөрсдөө бий болгосон байдаг. Хэрвээ бид хэн нэгэн хүнд итгэл бишрэлгүй байгаа бол өөрийг олж болно. Бид аз жаргалтай байгаа л бол боллоо; зүгээр л аз жаргалаа ол, хэрэв хүсвэл хаа сайгүй сэлж, шилж сонгоод яваарай. Би хэнийг ч хэзээ ч саатуулж хүлдэггүй. Та юу ч хийсэн аз жаргалтай байгаа бол бүх зүйл зүгээр. Харин та явахын өмнө, хаашаа явж байгаагаа сайн мэдэж бай, мөн өөр тийшээ явж очих үедээ тэнд энэ газраас илүү дээр үгүй эсэхийг шийдэх хэрэгтэй, тэгэхгүй бол та дэмий л цагаа үрнэ. Та магадгүй зүгээр л энд суугаад, дугуйгаар илүү хурдан давхиж болно. Хэрвээ та бүх зүг рүү явчих гээд байвал нисэх онгоцоор явсан ч болж бүтэхгүй. Тиймээс та хаашаа явахаа нягталж хар, эсвэл явах хэрэгтэй юу, зүг чигээ солих уу үгүй юу гэдгээ шийдэх хэрэгтэй. Бид энэ замаар явган эсвэл дугуйгаар явбал их хугацаа орно. Магадгүй бидний тэсвэр тэвчээр барагдана, тэгвэл итгэл алдарч мэднэ. Гэвч бид ирж буцаж буй хүмүүсээс энэ зөв зүг чиг мөн эсэхийг асуух, эрж хайх хэрэгтэй. Хэрэв тэд зөв чигт явж байвал бид дугуйгаар, моторт дугуйгаар, машинаар, нисэх онгоцоор алин нь ч бай өөрсдийгөө зөв замаар явж байна гэдгээ мэднэ. Өөрийгөө дэндүү удаан явж байна, тээврийн хэрэгсэл маань тун удаан байна гээд л хаа хамаагүй газар бүхэн рүү явган харайлгаж эсвэл гүйх гэх хэрэггүй. Зам чинь зөв. Тиймээс бид үүнийг хүлээн зөвшөөрнө.

Тэгэхлээр та голж шилж явахаасаа өмнө анхааралтай харах хэрэгтэй, тэгээд л боллоо. Хэрвээ бүх хүн сайн ахуй ойлголттой болж, гэгээрлийг олж авч байгаа бол энэ зүгээр юм байна гэдгийг та мэднэ, Төгс Гэгээрсэн Их Багш нь зүгээр гэдгийг та мэднэ. (Алга ташив) Энэ бол шүүн тунгаах цорын ганц зам нь. Тэд үр жимсээрээ танигдана. Үгүй бол, та юугаар шинжих вэ? Та модон дээрх жимсэнд хүрч чадахгүй байгаа бол магадгүй таны гар хэт ахар юм. Энэ нь мод үр жимсгүй гэсэн үг биш. Жимсийг нь хүн бүр иддэг, та харж чадна. Та түүнд хүрч чадахгүй учраас л идэж чадахгүй байна. Энэ таны өөрийн буруу. Та илүү чармайн оролдох эсвэл дээшээ авирах хэрэгтэй. Та модыг буруутгаж болохгүй.

Хэрвээ бүх хүн үүнийг иддэг, идэж байхыг та хардаг, тэнд жимс байгааг хардаг ч та түүнийг идэж чадахгүй байгаа бол модыг буруутгах аргагүй. Зөвхөн хэн ч хэзээ ч идээгүй эсвэл модон дээрээс та жимс олоогүй, модны жимсийг хэн ч хэзээ ч амталж үзээгүй, хүмүүс идэж байгааг та харж байгаагүй л бол энэ мод жимсгүй юм байна гэж та хэлж болно. Харин бүх хүн идэж байгааг харж байгаа бол та мэднэ. Хэрвээ та чадахгүй байгаа бол асуудал танд байгаа байх.



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Малайз улс, 1992 оны 2-р сарын 27 (Дүрс бичлэг №220)
(Эх нь Англи хэлээр)

Зам мөр дээрээ үлдэхэд чин сэтгэл шаардагдана, учир нь уруу татах зүйлс гадаа асар их байдаг. Заримдаа та нар бүтэлгүйтдэг гэдгийг би мэднэ, гэвч та нар эргэж ирээд дахин эхэлж болно. Та нар гадуур дэлгүүрээр явж болно, сүнслэг дэлгүүрээр, гэвч эргэж ирэх хэрэгтэй болдог, яагаад гэвэл өөр илүү дээр зам танд байхгүйг би мэдэж байна. Би бүх дэлхийн дэлгүүрээр яваад үзчихсэн. Хэрвээ илүү дээр зам байсан бол би та нарт аль эрт өндөр үнээр худалдаж аваад өгчих л байсан. Учир нь би гэгээрлийн арга юмуу Их Багшийг эрэн хайж эргэн тойрон явж, халаасны мөнгө, цагаа зарцуулсан. Би эрсэн, оролдсон, хэдэн арван зазэн (zazen) бясалгал хийсэн, бас зэн зэн (zen zen) хийсэн, йог ч хийсэн, ер нь бүх төрлийн юмс хийж үзсэн. Өдөрт ганц удаа хооллосон, унтчих вий гээд нүдээ анихгүй олон цагаар суусан, бүх төрлийн оролдлогыг хийсэн. Би очиж уулзах өөр Гэгээнтэн байхгүй болтол бүх Гэгээнтэнд бараалхсан. Би таны сонссон, нэрлэж чадах, дурдаж ярьдаг бүхий л тарнийг давтсан. Би тэдэнд өвдгөө намрын навч шиг чичиртэл мөргөсөн. Би адислал, гэгээрлийг эрж мөргөлийн бүх л газруудаар явсан. Би гэтлэхүйн хамгийн сайн замд суралцахын тулд өөрийн хүч чадал хүрэх бүхнийг хийсэн. Ингээд миний сонгосон нь энэ юм, хүүхэд ба том хүн, хөгшин ба залуу гээд хүн бүрт тохирно. Гэвч энэ зам хүн бүрийнх биш гэдэг нь лавтай. Хэдийгээр бид хүн бүрд нээлттэй байдаг ч хүн нэг бүр ирдэг юм биш. Яагаад гэвэл энэ бол гадна талын үзүүлбэр биш. Хүмүүс зөвхөн миний сургаалд татагдсан юм биш, зөвхөн миний харагдах төрх байдал юмуу хувийн зан чанараас болсон юм биш, хамгийн чухал нь тэдний хүсэн тэмүүлж буй сүнс юм.

Жинхэнэ Авшиг

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Лондонд хийсэн нийтийн бясалгал, ИБУИНВУ, 1998 оны 3-р сарын 10
(Дүрс бичлэг №631) (Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Их Багш аа, хэрвээ хэн нэгэн хүн урьд өмнөх Их Багшаас авшиг хүртсэн ч Ариун Нэрсийг давтаагүй, бас бясалгалд суугаагүй бол - үхэх цагт нь Та түүн дээр очих уу?*

Их Багш: Үгүй.

Асуулт: *Яагаад үгүй гэж? Тэр өмнө нь авшиг хүртсэн болохоор.....*

Их Багш: Гэвч тэр буцаж явахыг хүсэхгүй байна!

Асуулт: *Яагаад гэвэл авшиг хүртэх үед авшиг нь махан бие рүү биш сүнс рүү очно.*

Их Багш: Би мэдэж байна. Гэхдээ тэр сүнс хүсэхгүй бол...

Асуулт: *Учир нь миний хүү авшиг хүртсэн, гэвч тэр бясалгадаггүй.*

Их Багш: Би мэднэ. Би одоо танд энийг л хэлэх гэж хичээж байна. Тэр авшиг хүртэхээр хүрч ирвэл сүнс авшиг хүртэнэ. Магадгүй тэр ирдэг, гэтэл сүнс нь үүнийг хүсдэггүй; түүний бие нь л ирсэн байх. Тийм учраас авшиг хүртсэнийхээ дараа тэр бүх зүйлээс буцаж орхисон. Тэр зүгээр л сониуч зантай. Тэр тэнд явж очсон, гэтэл сүнсэндээ амлалт үүрэг аваагүй байна.

Тэгэхлээр сүнс маш чухал. Хэрвээ тэр тэнд очсон, бас сүнс нь бэлэн болоогүй хэвээр байгаа бол тэр Гэртээ харихыг хараахан хүсэхгүй байна. Тиймээс л тэр бясалгадаггүй; Ариун Нэрсийг давтдаггүй; тэр Сахилуудыг сахидаггүй. Ингэвэл энэ түүний мэдэх хэрэг. Энэ түүний эрх чөлөө. Би түүнийг Гэртээ харихыг нь хүчилж чадахгүй.

Асуулт: *Тэр Их Багшаас авшиг хүртчихсэн учраас.....*

Их Багш: Тийм л дээ, гэвч тэр өөрөө үүнийг хүсэх хэрэгтэй.

Асуулт: *Их Багш өөрийг нь авч явахыг тэр хүсдэг, тиймээс би түүнд авшиг авахуулсан юм, тэгвэл тэр энэ насандаа Эзэн рүү буцаж явж чадна.*

Их Багш: Хэрвээ тэр үүнийг хүсэж л байвал.

Асуулт: *Энэ нөхцөлд тэр Эзэн рүү явах болов уу?*

Их Багш: Хэрвээ тэр үүнийг хүсдэг бол. Би гэхдээ та хүсэх л юм бол, Гэртээ буцаж чадна гэж бас хэлсэн. Сүнс тань л үүнийг хүсэж байвал та буцаад ирж болно. Би үүнийг ч бас хэлсэн. Сүнс үүнийг хүсэх хэрэгтэй, харин бие биш.

Асуулт: *Бие биш ээ.*

Их Багш: Тийм ээ. Тэгэхлээр, авшиг хүртэх үед хэрвээ түүний сүнс үнэхээр үүнийг хараахан хүсээгүй юм бол, та аав нь болохоор, энд Их Багш байгаа учраас тэр тантай хамт ирнэ, гэвч тэр жинхэнээсээ амлалт үүрэг аваагүй. Хэрвээ энэ сүнс энэ насандаа, эсвэл дараагийн насандаа энэ амьдралыг амсаж мэдрэхийг хүссээр байгаа бол тэр ахин чөлөөтэй амсаж мэдэрч болно. Тэгвэл тэр өөр нэг удаад өөр нэгэн Их Багшийг олох болно. Учир нь би жинхэнэ авшгийн талаар ярьж байна.

Асуулт: *Их Багш очиж түүнтэй уулзах ёстой, яагаад гэвэл тэр Эзэнд хамаардаг; тэр Эзэнийг талархан биширдэг.*

Их Багш: Тэгвэл тэр өөрт оногдсон ажлаа хийх хэрэгтэй. Би залхуу хүмүүст авшиг өгдөггүй! Авшиг таныг Бурханы Хаант улсад аваачна гэж би хэлээгүй. Би авшиг нь танд гэгээрлийг өгнө гэж хэлсэн. Бясалгал, сахилга бат, веганизм, мөн сүнсний тэмүүлэл танд Бурханы Хаант улсыг өгөх болно. Та орлогоо өөрөө хөдөлмөрлөж олох хэрэгтэй. Тийм биш бол би “Зүгээр, наашаа ир, хүрээд ир, хүрээд ир, хүн бүр авшиг ав; танд веган хоол ч хэрэггүй, тэгээд Гэртээ харина.” гэж хэлэх болно. Энэ шударга биш! Номын ах аа, та хямд хоол хүсэж байна. (Инээлдэв.)



Диваажингийн урам зориг:

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн загварууд нь Орчлонгийн хамгийн гүн гүнзгий билиг ухааныг илэрхийлэн дамжуулснаар бүх хүн төрөлхтний сүнс болон амьдрах-хүчийг сэрээдэг юм.

Зүрх сэтгэлийн тэмүүлэл бол Бурханы Хаант улсын түлхүүр юм

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Лондонд хийсэн нийтийн бясалгал, ИБУИНВУ, 1998 оны 3-р сарын 10
(Дүрс бичлэг №631) (Эх нь Англи хэлээр)

Гол нь бие биш, гадна тал биш харин сүнс гэж авшигтан та бүхэнд би хэлдэг. Хэн нэг нь дандаа л Ариун Нэрсээ давтдаг байх, гэвч Их Багшийн сургадаг сайн зүйлсийг хийдэггүй. Тэд Эзэн Бурханыг жинхэнээсээ хүндэлж хүсэмжилдэггүй. Харин яг л тариачин шиг цэвэр ариун, гэнэн цайлган хүн бол Эзэн Бурхан ба Ариун Нэрсийг зориудаар мартана гэж үгүй, мөн зүрх сэтгэлдээ Их Багшдаа тэмүүлж байдаг. Хэдийгээр тэр мартагнаж магадгүй ч Их Багшийг эргэн санаж, хүсэх л болно.

Тэгэхлээр Таныг Бурханы оронд аваачих нь зөвхөн Ариун Нэрс биш байна. Энэ бол сүнс. Тэр хүн үнэхээр л хүсэж байвал Их Багш ямар нэг юм хийдэг. Бүр авшиггүйгээр ч Их Багш тэднийг авч явах болно. Тэдэнд авшиг хэрэггүй. Дөхөм Арга заалгасан хүмүүс Диваажинд очиж чадна. Их Багшийг зүгээр л ганц удаа харсан хүмүүс дараа нь үхэхийн цагтаа сэтгэл зүрхэндээ залбирч байвал Их Багш хүрээд ирнэ.

Гэвч зарим авшигтан гэжүүд байдаг. Авшиг хүртчихсэн юм чинь юу хүссэнээ хийж болно гэж тэд боддог. Тэд өөрсдийн хичээлээ сурах хэрэгтэй. Хэрвээ тэд сансрын хүрдэнд эргэлдэх хүсэлтэй байгаа бол энэ тэдний өөрийн сонголт юм. Их Багш хөндлөнгөөс оролцохгүй; Их Багш ердөө тусалдаг. Энэ бол янз бүрийн уламжлалтай олон авшигтанд байгаа асуудал юм, үүнд магадгүй манайхан ч багтаж байгаа. Тэд Их Багшийн хүчинд найддаг. Авшиг тэдэнд бүхнийг өгнө гэж боддог. Тэгээд гадуур явж, буруу юм хийдэг. Энэтхэгт болон хаа нэгтгэх сект гэгдэх олон бүлэглэл нь хүмүүст гэм

халтай олон буруу зүйл хийдэг; хүмүүс тэднээс айдаг. Их багш авшиг хүртээсэн л бол юу хүссэн бүхнээ хийж болно, хэзээ ч сансрын хүрдэнд эргэлдэхгүй гэж тэд боддог. Энэ чинь буруу!

Харин зүрх сэтгэлдээ ядахдаа хичээн оролддог хүмүүс байна. Тэд ямар ч нөхцөлд өөрсдийн чадлын хэрээр хамгийн сайнаараа хичээдэг. Энэ нь тэд Эзэн Бурхан юмуу Их Багшийн тааллаар хамгийн сайнаараа оролдох ёстой гэж байгаа биш, харин өөрсдийн чадвар боломж, хүч чадлын хэр хэмжээнд хамгийн сайнаар оролд гэсэн утгатай. Боломж олгогдсон ч бүр оролдож үзэхийг ч хүсдэггүй хүмүүс бол Эзэн Бурханыг биш хорвоог хүсэж байна гэсэн үг юм. Мөн тэд хүссэн газар луугаа буцаад явах хэрэгтэй болно.

Ганцаараа бол энэ тун хэцүү. Тиймээс бидэнд хамтын бясалгал хэрэгтэй. Хэрвээ хүн бясалгадаггүй, Ариун Нэрсээ давтдаггүй, мөн веган хоол иддэггүй бол өөрийнхөөрөө л явна. Хэдийд тэр бэлэн болно, тэр үед Их Багш дахин ирнэ. Харин үхэх цагтаа тэр бас л бэлэн биш байсаар байвал, хэрвээ Их Багшийг дуудахгүй байсаар, анхаарч ойшоохгүй байсаар, энэ хорвоо дэлхий рүү л буцахыг хүссээр байвал тэр тэгж болно. Байдлаас хамаарна.

Заримдаа хүмүүс гадна байдлаараа тийм сайн бясалгадаггүй ч дотооддоо зүрх сэтгэлдээ хийж байдаг. Тэгэхээр хүн сэтгэл зүрхэндээ хүсэж байгаа эсэх нь бас тун чухал. Гэвч энэ бол дандаа үгээр тайлбарлачихаж болдоггүй нарийн зүйл. Та үүнийг зүрхнээсээ мэдэх хэрэгтэй. Жишээ нь, та нэг эмэгтэйд дурласан бол түүнийг зүгээр л хайрладаг - та зүрхэндээ л мэддэг. Тэр бол таны дурласан цорын ганц эмэгтэй. Та үүнийг тайлбарлаж чадахгүй, та хэн нэгэнд үүнийг баталж нотолж чадахгүй. Харин зүрх сэтгэлдээ л түүнийг цор ганц эмэгтэй чинь гэж та мэдэж байдаг. Эргэн тойронд хичнээн олон эмэгтэй байгаад ч та зөвхөн тэр нэгнийг л хайрласаар байдаг.

Сүнслэг амлалт үүрэг ч үүнтэй адил юм. Миний юу хэлэх хамаагүй, таны юу хэлэх хамаагүй - та Бурханыг хүсэж байгаа эсвэл Бурханыг хүсэхгүй байгаагаа зүрхэндээ л мэддэг. Энэ л хамгийн чухал нь. Та олон цаг суусан, эсвэл олон удаа хамтын бясалгалд явсандаа гол нь биш. Хамтын бясалгал танд зөвхөн тусалдаг. Та үнэхээр Бурханыг хүсэж байна гэж бодъё, тэгвэл хамтын бясалгал танд тусаа илүү их өгдөг. Энэ таны итгэл бишрэлийг бэхжүүлж, илүү дээр суулгана.

Харин хамтын бясалгалд олон очих нь та Бурханыг хүсэж байгаа гэсэн үг биш. Тэгэх албагүй! Та зэргэлдээ хаалганы хатагтайг харахыг хүссэн байж болно, дотогшоо орж харахаар явахын оронд. Энэ яг хайр дурлал шиг. Танд тэр зүйл байгаа эсвэл байхгүй. Хэн ч таныг өөр хатагтайг хайрла гэж хүчилж чадахгүй, хичнээн үзэсгэлэн гоо, оюунлаг эсвэл чинээлэг байсан ч. Та тэр л эмэгтэйгээ хайрладаг, тийм л юм. Та үүнийг мэднэ. Тэр нь эцсийнх. (Алга ташив.)

Энэ маш энгийн. Би та нарт авшиг биетээр дангаараа таныг Бурханд аваачна гэдэг буруу ухагдахуун өгөхийг хүсэхгүй байна, учир нь энэ алдас болно. Ингэвэл үүнийг хийхийг танд албадсан болчихно. Та дараа нь бодлоо өөрчлөхийг хүсдэг юм гэхэд. Би таныг Бурханы хаант улсад очихыг албадаж чадахгүй. Та чөлөөт хүслээрээ ирдэг, мөн чөлөөт хүслээрээ л үлддэг. Мөн та амьдралын сүүлчийн мөчдөө өөрийн хамаардаг газартаа буцаж ирэх нь таны чөлөөт сонголтоор болно. Эцсийн мөчид, та бодлоо өөрчлөөд, “Үгүй, Их Багш аа, март! Баяртай! Хажуу айлын тэр хатагтайг харахаар буцаад явахыг хүсэж байна.” гэж хэрвээ хэлбэл. Тэгвэл та явах болно. Бид бүгдээрээ Бурхан, санаарай!

Хэн ч танд байхгүй байгаа эсвэл хүсээгүй зүйлийг тань өгч чадахгүй. Авшиг зөвхөн таны өөрийн Бурханы хүчийг сэрээдэг, хэрэв та тэрийг хүссэн бол. Хэрвээ та хүсэхгүй бол өмнөх шигээ үүнийг хойш нь тавьж болно, тэгээд мунхаг амьдралаа үргэлжлүүлээрэй, асуудалгүй. Авшиг бол тусламж, нийтийн бясалгал бол тусламж, ургамал хооллолт бол тусламж, мөн сахилга бат ч тусламж. Эдгээр нь хамгийн дээд нь биш. Эдгээр нь төгсгөл нь биш. Эдгээр нь зөвхөн зорилгодоо хүрэх хэрэгсэл юм. Таны зүрх сэтгэл үүнийг юм бүхнээс дээгүүр

хүсэх ёстой. Тэгвэл энэ бүх зүйл танд тус болно.

Хэрвээ та Бурханыг хүсэхгүй бол мянган жил ургамал хоол идээд ч, хоёр мянган жил суугаад ч, гурван мянган удаа авшиг хүртээд ч, та хаана ч хүрээгүй хэвээрээ л байх болно. Тэдгээр нь хүмүүс явж очоод энэ тэрд мөргөдөг шиг ердөө л гадна талын зан үйл юм. Тэд ойлгодоггүй; өөрийгөө зориулдаггүй. Гэтэл олигтой сайн бясалгадаггүй юм шиг харагддаг хүмүүс байдаг, мөн тэд Ариун Нэрсээ ч зөв хэлж чаддаггүй. Харин Бурхан мэддэг. Мөн Бурханыг хүсэж байна гэдгээ тэд мэддэг. Ийм энгийн! (Алга ташив.)

Кали Эринд бясалгах боломжоо нандигна

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Флорида төв, АНУ, 2001 оны 6-р сарын 9 (Дүрс бичлэг №719)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Таны лекцийн эмхтгэлүүдийн нэгэнд Та Кабирын “Хайрын Далай” шүлгийг дурдсан байдаг. Тийм ээ?*

Их Багш: Тийм, Би Кабирын шүлгүүдийн тухай олон удаа ярьсан, харин “Хайрын Далай” шүлгийн тухайд юу гэж?

Асуулт : *Энэ нь Сат Пүрүш гэж дууддаг Оройн дээд Бурханы тухай юм; Тэр эрин үе (Yuga) болгонд өөр өөр дүрээр бууж ирдэг. Тэгээд Кали Юга эринд Сат Пүрүш олон сүнсийг Гэрт нь буцааж хариулахаар Кал (Гурван ертөнцийн эзэн) -тай хэлэлцээр хийсэн байдаг.*

Их Багш: Тийм, энэ бол Кали Эрин, Харанхуй эрин. Ийм үед аугаа хүчтэй нэгэн бууж ирэн бүгдийг нь дээшээ татах хэрэгтэй! Том машинтай! Хүчтэй! (Их Багш инээв)

Асуулт: *Тийм учир олон сүнс ийм хялбархан гэтлэгдэж болж байгаа юу?*

Их Багш: Тийм, яг зөв; та үүнийг мэддэг юм байна. Мэдээж тийм. Энэ бол одоогийн мөчлөгийн сүүлчийн эрин. Тэгэхээр ард хоцорсон хүмүүс хэн байна: Бушуулаарай! Бурхан бүгдийг нь дээш нь татаж байна; тийм учраас ч нэн өгөөмөр байна. Гэхдээ үүнд маш их хүч ордог, яг л далайн хар салхи асар их ус авчирдагтай адил. Далайн хар салхи л асар их усыг эх газар дээр авчрахаас биш ердийн бороо бол чадахгүй.

Тэгэхлээр, энэ цаг үед “бөөндөж” байгаа гэсэн үг юм. Учир нь хүн бүрт хүрэлцэхээр их зай, их өршөөл аврал байгаа учраас хүн бүхэн үүнд багтаж болно. Ямар ч асуудал байхгүй. Та нар азтай шүү! (Алга ташив.) Оройн Дээд Бурхан бол өгөөмөр нигүүлсэнгүй, гэхдээ Тэрбээр өмнө нь хэзээ ч одоо шиг ийм нэн өгөөмөр байгаагүй. Эрт дээр үед сайндаа л хэдхэн хүн, магадгүй мянгаад хүн гэтэлсэн байх. Хэзээ ч ийм олон хүн гэтлэгдэж чадаж байгаагүй, мөн бүх зүйлийг үл харгалзан ийм

нээлттэй цугларч чадаж байгаагүй. Та нар мөн ч их азтай улс шүү.

Эрт дээр үед хүмүүс хамтдаа бясалгахыг хүсвэл хаа сайгүй зугатан нуугдаж, нууц үг дохио, нууцаар гар барилцах, чагж зэрэг нууц гар дохио, эсвэл та нарын хэрэглэдэг мэндчилгээг ашигладаг байсан - тэр байтугай үүнийг (Их Багш дохио зангаа хийв) - билгийн нүдээ сана, Ариун Нэрсээ унш, Гуан Инь хий, тэгвэл бид хамт байна. Энэ бол Христийн шашинтнуудын номын ахан дүүс биесээ танихын тулд хэрэглэдэг нууц дохио нь байжээ. Яагаад гэвэл тэр үед Есүс нуугдах хэрэгтэй болж байв; шавь нар нь ч мөн адил нуугдаж байжээ. Тэд “Би Түүнийг мэдэхгүй” гэж хэлээд олны өмнө Их Багшийгаа ч хүлээн зөвшөөрч зүрхлээгүй. Тэр ч байтугай хамгийн тэргүүн шавь Питер нь Түүнийг гурвантаа үгүйсгэсэн.

Сөрөг хүч - тийм аугаа хүн Есүс ч, тийм чин бишрэлт шавь Питер ч ам нээж чадахааргүй дарангуйлж байсан байна. Тэгэхээр тийм л харгис дарангуй байжээ. Харин орчин цагийн бид тун азтай хүмүүс юм.

Бид бол хамгийн азтай йогч

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
АНУ-ын Флорида төв, 2001 оны 6-р сарын 9 (Дүрс бичлэг №719)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: Танаас асуух нэг зүйл байна. Үхсэнийхээ дараа буцаж ирэхгүйн тулд бид сүнслэг хөгжлийн хувьд энэ насандаа хэр өндөр түвшинд хүрэх ёстой вэ?

Их Багш: Аль болох л өндөрт хүр. Эс бөгөөс Их Багш таныг өөд нь түлхэх болно; Их Багш таныг аль ч түвшинд хүргэхээр тэнд байж байх бөгөөд үргэлжлүүлэн дээш замчилна. Эс бөгөөс, та нар Гурван Ертөнцийг туулан өнгөрөх ёстой байдаг. Өөр аль нэг их багшийг дагавал та эргэж ирэхгүйн тулд Гуравдугаар Түвшнийг туулах ёстой болдог. Харин энэхүү Дээд Номын Аргаар бол та чадна. Яагаад гэвэл өндөр түвшинд хүрч чадаагүй нь заримдаа та нарын буруу биш байдаг.

Жишээлэхэд, өнөөдөр авшиг хүртээд маргааш нь үхлээ гэж бодъё. Таныг энэ бие махбодоо орхин явахад, эсвэл Их Багш биеэ орхин явахад та хаана байсан тэр түвшнээс цаашаа таныг дээшээ авч явах нь Их Багшийн үүрэг юм. Бид зүгээр. Одоо цагт хүн бүрт туслах бүрэн нээлттэй гэр бидэнд байна. Чин сэтгэлтэй хэнд ч Их Багшийн хүч энэ удаад, нэн өгөөмрөөр тусална. Энэ зуун үнэхээр их нигүүлсэнгүй, маш өгөөмөр байна.

Асуулт: Яагаад энэ зуун маань мянган жилийн өмнөхтэй адилгүй ийм онцгой байгаа юм бэ?

Их Багш: Учир нь Диваажин хааяа “хямдралтай бөөний худалдаа” зарладаг юм. (Их Багш болон бүгд инээлдэв) Яг гараашдаа юмаа хямдруулж зардаг шиг. Бүх бараа нэг доллар. Гэхдээ энэ нь ямар Их Багш бууж ирснээс шалтгаална. Та нар харж байгаа, бид бүгдээрээ л Их Багш. Гэхдээ зарим Их Багш өөрийгөө дөнгөж шинээр эргэн санасан; тэд ердөө энэ төрөлдөө ахин гэгээрчихээд байна. Зарим Их Багш бол үргэлж л гэгээрсэн байсан. Зарим Их Багш хэзээ ч Диваажинг орхилгүй байж байгаад энэ удаад л дөнгөж бууж ирээд байна. Харин зарим нэг нь ирж буцаж байдаг, байнга ирээд л, яваад л байдаг, ингэсээр

байгаад энэ дэлхийн олон төрөлтнүүдтэй барилдлагатай болсон байдаг. Тэгээд Тэрээр дахин бууж ирэхдээ, бүх хуучин найзуудаа “Та нар юу ч хүссэн хамаагүй, зүгээр. Бид бие биенээ таньдаг юм чинь.” гэдэг. (Алга ташив) Магадгүй бид хуучин анд найзууд байсан байх; тэгээд л тэр.

Дөнгөж шинээр бууж ирсэн Их Багшид тийм ч олон төрөлтнүүдтэй барилдлагатай байдаггүй. Тиймээс эхлээд хэдэн шавьтай болж байгаад, дараагийн удаа ахин дахин үргэлжлүүлдэг. Хэрвээ тухайн Их Багш өөрийгөө Будда гэдгийг дөнгөж энэ төрөлдөө ахин санасан бол мэдээж илүү туршлага хуримтлуулах ёстой. Их Багш юм мэдэхгүй гэсэн үг биш, харин ердөө л юу ч хийсэн адилхан дадлагажих хэрэгтэй байдаг. Хүмүүний сэтгэлтэй хэрхэн ажиллах, энэ дэлхийн хүнд сурталтай хэрхэн харилцах, энэ гараг дээрх элдэв дарамт шахалтаас өөрийгөө хэрхэн хамгаалж, өөртөө элдэв төвөг тарилгүй хүмүүст чимээгүйхэн туслахын тулд өөрийгөө хэрхэн бүрэн бүтэн авч явах тал дээр дадлага туршлага суух юм.

Гэтэл шинэхэн Их Багш үүнийг мэддэггүй. Шинэхэн Их Багш сүр бараатай, бүрээ бишгүүр хангинуулан гарч ирдэг. Магадгүй гурван жил хагас, эсвэл хоёр жил хагас, эсвэл бүр гурван сар хагасын дараа сураг тасарч алга болж мэднэ. Сүнслэг хүч ч ялгаагүй; энэ нь орчлонгоос ирдэг. Харин шавь нарыг хэрхэн зохицуулах болон энэ дэлхийн улс төртэй учраа ололцох арга зам - эдгээр нь тархины түвшний ажил тул үүнд суралцах ёстой байдаг. Эдгээр нь юмыг хийх ур чадвар ба үр дүй юм. Эдгээр нь гэгээрэл болон сүнстэй ямар ч холбоогүй. Мэдээж хамаатай л даа, жишээ нь хэдий их гэгээрсэн байна, юмыг төдий чинээ хурдан сурдаг. Харин Тэр Эмэгтэй буюу Тэр Эрэгтэй олон төрөл дамжихдаа хэдийн туршлага хуримтлуулсан бол тийм их суралцах шаардлага байхгүй.

Учир нь хүн ганцхан төрөлдөө яаж тийм их зүйл сурч чадах вэ? Гэгээрсэн байсан ч гэсэн авто механик, онгоц ба усан завь жолоодох, нягтлан бодох бүртгэл, компьютерийн программ хангамж, техник хангамж гээд юм бүхнийг сурч барахгүй шүү дээ. Сурч болох хэдий ч, амьдрал дэндүү богино.

Эдгээр зүйлс бол сүнстэй хамаагүй. Оюун ухаан, уураг тархи болон гар, биеэрээ хийж байж ойлгож, сурч эзэмших зүйлс юм. Тэгэхлээр, Их Багш хэрвээ “хэрхэн” байх тухайд бус харин хэрхэн Их Багш байх талаар энэ бүх зүйлийг хэдийн сурчихсан бол Их Багшийн хувьд маш олон зүйлтэй тулгарч бас хийх чадвартай байх ёстой.

Тийм учраас, ийм төрлийн Их Багш байх илүү амархан бөгөөд хурдан. Арай хялбар. Энэ ердөө л дэлхийн юмыг хэрхэн хийхийг мэдэж байх (know-how) гэсэн үг юм. Номлол адилхан, арга адилхан, хүч чадал адилхан, Үнэн ёс адилхан. Харин Их Багш Өөрөө олон нийттэй харилцаж, шавь нартаа ахиж дэвших хамгийн шилдэг, хурдан аргыг хэрхэн заах талаар чадвартай юу, чадваргүй юу гэдэг тухай юм. Их Багш нэг л ижил аргыг нэг ижил хүмүүст зааж өгч болно. Мөн хоёр өөр Их Багш нэг адил аргыг хоёр өөр шавьд зааж өгч болно. Гэтэл нэг Их Багшийн шавь нөгөө Их Багшийн шавиас арай өөрөөр эсвэл илүү хурдан ахиц дэвшил гаргаж болно. Ийм байдаг. Энэ нь мөн сургаал номлолоо шавийн сэтгэлд хэрхэн суулгаснаас шалтгаална. Учир нь хэрвээ бодол сэтгэл чинь ойлгохгүй, хүлээж авахгүй бол та нар хурдан дэвшиж чадахгүй. Та нарт ийм сайхан санагдахгүй. Мөн ийм их итгэл үнэмшил төрж, эсвэл өөртөө итгэлтэй байж чадахгүй. (Алга ташив.)

Та нар өөрсдөө Их Багш

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Лос Анжелест болсон Олон улсын 3 өдрийн даяан, АНУ,
1998 оны 12-р сарын 16-18 (Дүрс бичлэг №639)
(Эх нь Англи хэлээр)

***Асуулт:** Бид Алтан Эрин үе рүү шилжсэнээр, бидний олон авшигтан Тавдугаар Түвшинд ялгаран гарч, их багш болно гэсэн үг үү? Хэрэв тийм бол би Тавдугаар Түвшинд хүргүүлэх хүсэлтэй байна, яагаад гэвэл би энд доор байсаар залхаж байна.*

Их Багш: Та хүссэнээрээ өндөрт байна. Тэгэхлээр та тийм байхыг л хүсэх хэрэгтэй. Хүн бүр залхсан. Харин би таныг аль хэзээний их багш гэж бодож байна. Хэрэв та Алтан Эрин ирэхийг хүлээж байгаад том их багш болохыг хүсэж байгаа бол би хаашаа явахаа мэдэхгүй байна. Та хэдийн хувь заяагаараа өөрийнхөө их багш мөн; танд хүссэн бүх юм чинь байна. Дахин “дөрөв дэх” эсвэл “тав дахь” гэж дугаар тавих хэрэг байхгүй. Энэ бол Буддагийн хэрэг. Бид үүнд санаа зовох хэрэггүй.

Бид аз жаргалтай байх ёстой, мөн өөртөө итгэлтэй, эерэг өөдрөг байх хэрэгтэй. Өөрийгөө доогуур дэстэй гэж бодох бүрийдээ тэр бодлоо таягдан зайлуул. Сэтгэл санаа хямарсан, эсвэл сул дорой болсон мэт санагдах болгонд тэр бодлоо гаргаж хая! Энэ бэрх л дээ, гэхдээ ингэж байж л та нар гуниг гутралаасаа сална. Тэгснээр та нар дэвшиж чаддаг юм. Та Тавдугаар Дэсэд байхыг хүсэж байгаа хэрнээ хажуугаар нь өөрийгөө доогуур дэстэй гэж бодсон, үйлийн үрдээ дарагдсан, сөрөг байж болохгүй. Би танд тусалж чадахгүй. Аль дэсэд байхыг хүсэж буйгаа та л шийднэ, би шийдэхгүй. Та л өөрийгөө адисладаг; би таныг адисалж чадахгүй.

Би “За, та Тавдугаар Дэс рүү яв; би адислая” гэж хэллээ гэж бодъё. Гэвч таны сэтгэл сөрөг бодох, сэтгэлээр унах, гутрангүй байхад дасчихсан хэвээр байдаг. Та нар сэтгэлээ сургах ёстой.

Түүнд өөрийгөө их багш гэж гэж хэл; түүнд юу бодохыг нь, юу хийхийг нь, юу мэдрэхийг нь, ямар дэсэд удирдахыг нь ч хэл. Үүнийг хийж чадвал та өөрийгөө их багш болжээ гэж мэднэ. Өөртөө итгүүлэхэд л хэцүү байгаа болохоос биш та нар хэдийн их багш юм шүү дээ. Та өөрөө өөртэйгөө ажиллах хэрэгтэй.

Толин тусгал

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Флорида, АНУ, 2002 оны 5-р сарын 11 (Дүрс бичлэг №736)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Саяхан би бясалгалдаа Их Багшид хандан эндээс явахаараа чигээрээ Тавдугаар Түвшинд очмоор байна гэж хэлсэн. (Инээв) Би энд буцаж ирэхийг үнэхээр хүсэхгүй байна.*

Их Багш: Та их юм гуйгаагүй байна. (Инээв) Сайн байна, ёсоор болгох болно.

Асуулт: *Яах нь надад хамаагүй.*

Их Багш: Үүнийг хийх болно, санаа зовох хэрэггүй.

Асуулт: *Энэ удаад би хангалттай юм амсаж тууллаа.*

Их Багш: Санаа зоволтгүй, та өөрчлөгдөх болно.

Асуулт: *Энэ боломжтой гэж Та бодож байна уу?*

Их Багш: Тийм ээ, боломжтой. Хэрвээ та үүнийг л хүссэн бол, та үүнийгээ хүртэх болно. Асуудал алга. Хэрвээ та сэтгэлдээ энэ санаагаа үхэх хүртлээ хадгалж байвал та тэнд хүрэх болно.

Асуулт: *Хэрвээ би бүр үхэхээсээ өмнө Тавдугаар Түвшинд хүрэхээр ажиллах юм бол би энд Их Багшид илүү дээр туслах чадвартай болно.*

Их Багш: Өө, тэгнэ, тэгэлгүй яахав.

Асуулт: *Хэрвээ энэ боломжтой бол.*

Их Багш: Энэ бас боломжтой байдаг. Харин танд боломжтой эсэхийг би мэдэхгүй. Энэ танаас л хамаарна.

Асуулт: *Би юу ч байсан хийнэ.*

Асуулт: Хэн ч танаар ямар нэг зүйл хийлгэх хэрэг байхгүй. Та тархиа хянах хэрэгтэй. Та ямар нэг зүйл хийх хэрэгтэй гэсэн үг биш. Энэ нь та зуун удаа үхсэнээр Будда болно, эсвэл та ямар нэг өргөл өргөөд Будда болно гэж байгаа юм биш. Энэ тийм биш. Энэ нь ердөө л сүнс чинь энэ амьдралдаа үүнийг хүсэж байна уу үгүй юу гэдэг дотоод зоригдол юм.

Асуулт: *Тэр ирэхээсээ өмнө үүнд бэлтгэх хэрэгтэй юү?*

Их Багш: Байдлаас хамаарна. Бүгд үүнд бэлтгэхийг хүсдэг. Харин бууж ирсэн хойноо тэд ойр зуур бага зэрэг гуйвж дайвдаг. Учир нь хий хуурмагийн хаан гэх Майя тэнд таныг хүлээж байгаад хэлдэг: “Аа, хаа! Гэртээ тавтай морил, нялх хүүхэд минь. Хэр хүчтэйг чинь харъя. Энд хөөрхөн хүүхэн, тэнд ерөнхийлөгчийн албан тушаал, их мөнгөтэй том компани байна.” гэж. Ингээд та үхтлээ ажил хийдэг, охидод үйлчилдэг, тэгээд байдгаараа ядарчихаад та Их Багшийг олохыг хүссэн ч, хаана байгааг мэдэхгүй. Та хамаг эрч хүчээ алдаад, өвчин тусаад нас барна. Тэгээд та “За яахав, одоо явах цаг минь болж. Дараагийн удаа дахин хичээе.” гэдэг.

Асуулт: *Найруулагч нь “Тасал” гэж хэлдэг.*

Их Багш: Тийм, “Тасал”. Гэвч энэ үнэндээ хамаа алга. Та ямартай ч Бурханыг олохоор шийдсэн. Бид энд бууж ирэхээсээ өмнө үүнийг л хийх гэж байсан юм. Бид “Бурхан биш” байснаар Бурхан гэдгээ мэдэхийг хүсдэг. Та нүүрээ харахын тулд толь олохыг хүсдэг. Толь хэдий хий хуурмаг үзэгдэл ч гэсэн танд толь хэрэгтэй. Тэрэн дотор буй хүн бол та биш, гэхдээ танд өөрийгөө харахад тэр хэрэгтэй. Та толинд хараад, өөрийгөө таньдаг. Та үүнээс өөрөөр өөрийгөө яаж харах билээ? Би энд зогсоод өөрийгөө харж чадах уу, эсвэл хаана гэж? Толь бол хий хуурмаг үзэгдэл. Дотор нь харагддаг хүн та, тэгсэн ч энэ та биш. Тэгэхлээр, энэ дэлхий Бурханаар дүүрэн байна, тэгсэн ч энэ Бурхан биш юм. Бурхан энд гаднах Бурханыг хараад дотоодод байж байна.

Асуулт: *Энэ нь жинхэнэ юмны муу тусгал, тийм үү?*

Их Багш: За, энэ сайн тусгал юм. Гол нь бид толинд хараад төөрөлдчихдөг, учир нь Майя-гийн толь өөр. Энэ бол илбэтэй толь, “ханан дээрх толь”*. Энэ бол толь биш, харин толины ойлт юм. Тэгээд бид энд эндүүрч төөрөлдөн, бүх юмс толин дээр хамт туссан байна гэж хардаг. Тэгээд, “Оо, тэнд байгаа тэр юм юу вэ? Тээр тэнд юу байна? Тэр юу вэ?” гэж хэлдэг.

Тэр байтугай өөрийн дүрсийг ч харахаа мартана, толь маш том. Тэр толь бүгдийг өөртөө тусгана, та тэр хий хуурмаг дотор төөрдөг. Та юм юмны араас хөөцөлдөнө. “Өө Бурхан минь, энэ сайхан харагдаж байна. Тэр ч бас сайхан юм аа.” гээд л. Ингэж та өөрийн толиндоо төөрөлддөг. Та мартдаг. Энэ бол толь байна гэж та таних хугацаа бол секундын ганц хором байх. Харин Буддагийн хутгийг танихад бас л сансар орчлонгийн цагаар секундын ганц хормын хугацаа орно.

* “Толь, ханан дээрх толь” гэдэг нь “Цасан Цагаан” нэртэй шидэт үлгэрээс гаралтай. Уг үлгэрт хойд ээж нь ханан дээрх толины тусгалыг жинхэнэ гэж итгэдэг.



Гоо үзэсгэлэнтэй харагдах хамгийн шийдэг арга бол 24 цагийн турш ялдам инээмсэглэл, найрсаг зочломтгой, халуун дулаан уур амьсгалыг өөртөө тээх юм.~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Бүлэг 3

*Сэтгэлд таатай эрдэнэс -
бясалгалаар өөрийгөө адисал*

Өөрийгөө бясалгалаар адисал

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Олон улсын 5 өдрийн даяан, АНУ-ын Флорида хот,
2002 оны 12-р сарын 25 (Дүрс бичлэг №766)
(Эх нь Ау Лак хэлээр)

Асуулт: Би өөрийгөө хэт ноцтой хүн гэдгээ мэдсэн, жишээ нь, дөнгөж бясалгаж эхэлж байхад, бясалгах цаг болоход би “Ёох, Өө! Бясалгалын цаг болчихжээ!” гэж хэлээд сэтгэл бухимдах шиг болдог байв. Харин “Ай даа! Бурханыг харах цаг болжээ!” гэж бодоод, Ариун Нэрсээ уншиж төвлөрөхөд аятайхан болдог.

Их Багш: Энэ зөв! Тийм шүү. Үүнийг таашаал мэт хий. Энэ бол таашаал.

Асуулт: Би үүнийг ажиллахдаа ч бас хэрэгжүүлдэг. Жишээ нь, ажлаас болж хүч чадал барагдаж, ядарч, эрч хүчгүй болсон мэт мэдрэмж төрдөг, тэгээд өөрөөсөө эрч хүч хаанаас ирдэг вэ? гэж асуудаг, энэ нь миний биеэс биш, Орчлонгийн Эх сурвалжаас ирдэг гэдгийг өөртөө сануулдаг, тэгээд би гэнэт шавхагдашгүй хүч чадлаар дүүрснээ мэдэрдэг. Би ядардаггүй, ядарсан ч гэсэн хурдан сэргэдэг. Тиймээс бидэнд хоёр сонголт байгаа гэж бодож байна; бид нэг бол энэ даруухан “Би”-г сонгосон ч бид их хязгаарлагдмал байна, эсвэл “Би юу ч биш. Би хэн ч биш. Бүх зүйлийг Орчлонгийн Хүч хийдэг.” гэж зүгээр л бод. Энэ байдлаар надад их сайхан байдаг. Надад ямар ч асуудал үүсдэггүй.

Их Багш: Тийм ээ энэ зөв. Бид суусан үедээ тайвширч амрах хэрэгтэй. Энэ зөв. Бид амрах хугацаа өгсөнд Бурханд талархах хэрэгтэй. Бусад йогийн сургуульд бясалгахыг голдуу “амрах цаг” гэж үздэг. Одоо үед, ердийн нэг сонин, сэтгүүл уншихад л бясалгахыг сануулж, эсвэл яаж эрүүл, удаан амьдрах тухай ярьсан байгаа харагддаг, тэд “амрах”, тайвшрах эсвэл бясалгах цаг гаргах хэрэгтэй гэж эрхбиш дурдана. Тэд бясалгалыг дурддаг л юм.

Бясалгал одоо их түгээмэл болсон. Тэд “Бурханыг олохын төлөө бясалгах” талаар хэлдэггүй, харин “амрахын тулд эрүүл болох, илүү сайн болох, удаан амьдрах, мөн амжилттай байхын

тулд бясалга” гэж хэлдэг Өөрөөр хэлбэл, бүх талаараа амжилттай байхын тулд өдрийн цагаар амрах цаг сонгох хэрэгтэй, унтах биш харин бясалгана, эсвэл амьсгал авч, амьсгалаа гаргах юмуу эсвэл өөр ямар нэг юм хийнэ. Одоо шинжлэх ухаан үүнийг нотолсон тул хүн бүр энэ тухай мэддэг. Бид өдрийн цагаар амрах, бясалгах цаг сонговол бид илүү эрүүл болно. Хамгийн сайн аргын нэг нь бясалгал; тогтмол цаг сонгоод өдөр бүр бясалгах юм. Одоо бүх сэтгүүл, хамгийн тааруу нэг нь ч үүнийг дурддаг. Шинжлэх ухаан болон хүмүүс дэлхий даяар бясалгалыг хүлээн зөвшөөрөөд байна. Тэгэхлээр, “Оө Бурхан минь! Би одоо бясалгах хэрэгтэй; эс бөгөөс нийтийн бясалгалд оролцож чадахгүй, эсвэл холбогч ийм тийм юм хэлнэ.” гэх байдлаар үүнийг тийм зовлонтой санагдах зүйл болгох хэрэггүй л дээ. Энэ тийм биш юм. Бясалгал өөрт чинь ач тустай, сайн зүйл.

Энэ бол таны нандигнах цаг юм. Бид бүх л өдөржин энэ дэлхий болон бусдыг анхаарч завгүй ажилласан. Тэгэхлээр, бясалгах цаг мөч бидэнд зориулагдсан байдаг юм. Бид эхлээд өөрсдийгөө хайрлах хэрэгтэй - бусдыг ч хайрла гэхдээ өөрсдийгөө ч бас. Бид бясалгах цаг мөч бүрдээ бүх л үнэт эрдэнэсийг зөвхөн өөр лүүгээ хураан төвлөрүүлж, бие махбод болон сэтгэлээ тэтгэдэг. Энэ нь таныг хангалттай бясалгах хэрэгтэй, эс тэгвээс ийм тийм юм болно гэж би хэлдэг учраас биш юм. Үгүй. Энэ нь та нарт өөрсдөд чинь маш сайн. Таны төрсөн цагаас үхэх хүртэлх хамгийн эрхэм нандин цаг бол бясалгалын цаг юм. Энэ бол таны өөртөө зориулж байгаа хамгийн сайн зүйл мөн. Хэн ч танд үүнийг өгч чадахгүй; зөвхөн та л үүнийг өөртөө өгч чадна. Энэ бол та нарын өөрийн төлөө хийж чадах хамгийн сайн зүйл - бясалгал юм. Үүнийг та өөрийнхөө төлөө хийж байх үед бусад чинь аяндаа ач тусыг хүртэх болно. Таны гэр бүл, төрөл садан, нохой, муурнууд бүгдэд нь ач тусаа өгнө. Мод, цэцэг бас ач тус хүртэнэ. Үүнийг би аль эрт та нарт хэлсэн.

Тэгэхлээр, биднийг бясалгахад хүмүүс болон бидний эргэн тойрны бусад бүх юмс ач тус хүртдэг, харин хамгийн их ач тусыг бид өөрсдөө хүртдэг. Энэ бол бидний өөртөө хийж чадах хамгийн сайн зүйл, таны биеийг тэтгэх хамгийн сайн эм,

таны тархийг тэтгэх хамгийн хүчтэй энерги, таны билиг ухааныг хөгжүүлэх хамгийн сайн ном юм. Та ямар ч сайхан машинтай байх, ямар том сувд авах, тэдгээр нь ямар өндөр үнэтэй байх нь ер хамаагүй, тэд таны өөрийнхөө төлөө бясалгах цаг хугацаа шиг тийм эрхэм нандин биш. Энэ бол бүхий л орчлонд таны өөртөө зориулж чадах хамгийн үнэтэй эрдэнийн чулуу юм. Нэг авшигтны хэлсэнчлэн, бясалгал бол биднийг амрааж, сэргээн тэтгэж, өөрийгөө гоёж гоодохоор хамаг л нандин үнэт эдлэл, зүүлт чимгийг авчрахыг хэлж байна. Үүнийг хүсэхгүй хэн байх вэ? Бидний сэтгэл “үнэт эрдэнийн чулуу” гэхийг сонсмогцоо “Болж байна!” эсвэл “амар” гэж хэлнэ, эсвэл “Зүйтэй. Би үүнд дуртай. Би ажиллах дургүй. Тайвширч үз, хүн гуай! Зүйтэй, би бэлэн байна” гэдэг. Ердөө тархи л ингэж бодно.

Бидний тархи зөвхөн “сайн” ба “муу”, эсвэл “хар” ба “цагаан” гэж л ялгаж чадна. Ажил бол асуудал, эсвэл “албан ажил,” “Оө, үгүй!” Тэр хэдийн өдөржин ажиллачихсан. “Үгүй. Үгүй шүү. Үгүй ээ.” гээд л. Харин та “За завсарлая” гэж хэлбэл энэ зүгээр. Бидний сэтгэл юу “сайн” эсвэл “муу,” эсвэл “амрах” эсвэл “шаргуу ажиллах” гэж ямар утгатайг л мэднэ. Тэгэхлээр бид юу хэлнэ, тэр тэгж л ойлгодог. Бид түүнд зааж сургах ёстой. Түүнчлэн бие махбодын эсүүд бүгд биднийг сонсдог. Хэрвээ та энэ бол сайн гэж хэлбэл тэр зүгээр, харин муу гэж хэлбэл мөн тэгж бодно. Тийм учраас “Бүх зүйл бодол сэтгэлээр бүтээгддэг” гэж Будда хэлсэн. Бид өөрийн бодол сэтгэлээ бүтээх хэрэгтэй; бид сайн зүйл ярьж, сайн зүйлийг л бодох хэрэгтэй, тэгвэл бид сөрөг зүйлийг эерэг рүү өөрчлөх болно. Бид биеийн эсүүдээ эергээр бодоход сургана. Та ямар нэг сайн зүйлийг бодох юмуу ярихад л таны сэтгэл, таны бие, таны биеийн олон сая, тэрбум эсүүд бүгд түүнийг тэр дор нь л сонсоно. Тийм учраас таныг өөрөө өөрийнхөө их багш гэж би хэлдэг. Би та нарт хэрэггүй, гэвч та нар өөрсдийгөө яаж сургахаа мартчихаад байна.

Та нар өдөржин муу муухай зүйл сонссоор байгаад сөрөг хүчинд доош татагдаж, улмаар энэ хогоо толгойдoo давтдаг. Таны сэтгэл юу л сонсоно, тэр байдлаар бодохыг та түүнд зөвшөөрчихдөг. Тиймээс би та нарт, “Муу юм бүү сонс, муу юм бүү бод, муу юм бүү ярь” гэж хэлдэг.

Энэ нь таны үг, үйлдэл, бодлыг ариусгадаг. Та ямар нэг муу юм сонсвол, түүнийг зогсоож, гаргаж хая. Хэрвээ хэдийн сонсчихсон бол өөртөө “Энэ бол худлаа. Энэ буруу. Түүнийг битгий сонс.” гэж хэл. Бид өөртөө ингэж хэлэхэд бидний бодол “Аа! Эдгээр юмс буруу мэдээлэл байна. Тэдгээрийг гаргаж хая. Хогийн саванд хий.” гэж ойлгодог. Учир нь бид үүнийг хүлээж авбал бидний сэтгэл энэ мэдээ зүгээр гэж бодоод бүртгээд авчихна, тэгээд хожим түүнийг амнаасаа гаргах болно. Амьдралынхаа сайн муу бүх л зүйлсийг бид өөрсдөө бүтээдэг. Биднийг сайн зүйлс хэлэхэд бодол маань түүнийг хүлээж аваад, “За! Энэ сайн” гэж боддог. Биднийг муу зүйл хэлж ярихад бодол маань сонсоод, “За! Энэ муу” гэж боддог. Тэгэхлээр биднээс өөр хэн бидний их багш байх билээ?

Жишээ нь, та юм уухыг хүсвэл өөрийнхөө гарт хандаж усаа аваарай гэж хэлдэг, эсвэл усаа ав гэж гартаа хэлүүлэхээр хөршөө гуйдаг уу? Та өлсөхөд бодол чинь идэх юм хайхыг танд хэлдэг үү? Тушаал өгч байгаа хүн та биш гэж үү? Та ажилдаа явахдаа, автобус хайх хэрэгтэй эсвэл оффис руугаа өөрөө машинаа бариад явдаг. Бид юм бүхэнд өөрийнхөө дарга нь юм. Тиймээс, бидний амьдрал өдөр бүр сайжирч байхын төлөө бид өөрсдийгөө эерэг өнцгөөр буян ба сайн сайханд чиглүүлэх хэрэгтэй. Бидний амьдралд тохиолддог муу бүхэн бидний өөрсдийн бүтээсэн зүйлс юм - хэрвээ тэд одоо байхгүй байлаа ч өнгөрсөнд байсан. Бид тэднийг энд тавьсан ч цэвэрлэж хаяхаа мартсан, тэгээд сүүлд биднийг гэмтээхээр эргэж ирдэг. Тиймээс хэнийг ч битгий буруутга. Одооноос эхлэн, муу юм сонссон ч та өөртөө энэ бол үнэн биш, сайн биш, сөрөг, бидэнд ч ер нь хэнд ч ач тусгүй мэдээ байна гэж даруй хэлэх хэрэгтэй. Үүнийг зогсоо. Та үүнээс яаралтай салж ангижрах хэрэгтэй. Та харих замдаа, шөнө, Ариун Нэрсээ уншиж үүнийг цэвэрлэж хаяарай. Тэгээд өглөө нь гадагш гарахынхаа өмнө халаасаа том нөөцөөр дүүргэ. Тиймээс та өглөөд, шөнөөр, гэртээ ирмэгцээ бясалгах хэрэгтэй, хэрвээ зарим гадны хог новш халаасанд тань үлдсэн байвал цэвэрлэж хаяхаар бясалга.

Та өөрийгөө их цэвэрлэх тусам илүү сайн; та халаасандаа илүү их нөөцтэй байх тусмаа сайн; тэгвэл та ямар нэгэн ашиггүй мэдээлэлтэй тулгарвал даруй өөрийгөө цэвэрлэж чадах тул түүнийг гэртээ авч харих шаардлагагүй болно.



Бясалгалын ач тус

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Ёндун дахь төв, Солонгос, 1998 оны 5-р сарын 9
(Дүрс бичлэг №620) (Эх нь Англи хэлээр)

Та нарын өдөр бүр бясалгалдаа зориулж буй хоёр цаг хагас тань өнө урт хугацааны үр дүн, олон мянган жилийн үр дүн өгөх болно, бясалгалаараа та нар мөнх оршихуйд нэвтрэх үед цаг хугацаа зогсчихдог юм. Энэ бол ердөө хоёр цаг хагасхан төдий биш. Энэ нь хувьсал хөгжлийн мянга мянган жил, олон эрин галав юм. Та цаг хугацаа, орон зайн өөр бүс рүү ордог. Ингэж та дахин цэнэглэгдэж, шинэчлэгдэн буцаж ирдэг. Ийнхүү та шинэчлэгдэх эсвэл өөрийгөө танихын тулд дахин нэг бүтэн амьдрал туулахаар буцаж ирсээр байх шаардлагагүй болно, учир нь бидний хүн нэг бүрийн эргэж төрөхийн зорилго нь өөрийгөө дахин танин мэдэх байдаг. Тэгээд л тэр. Энэ төрөлдөө үүнийг хийж чадахгүй бол ирэх төрөлдөө, дараа дараачийн төрөлдөө хийх хэрэгтэй болно. Одоо бидэнд хоёр цаг хагасын зав байгаа бол бид өдөр бүр бясалгавал зохино. Тэр бол бид аль хэдийн сая сая жилийн бясалгал хийж байна гэсэн үг. Хоёр цаг хагас бясалгах бүртээ та нар дөнгөж хоёр цаг хагас гэх буюу эсвэл хэтэрхий урт хугацаа гэж бүү бодоорой. Таны зориулсан минут бүр нь нэг насны амьдралтай тэнцэнэ. Учир нь мөнх оршихуйд хоёр цаг хагас эсвэл нэг минут гэж байдаггүй. Дандаа мөнх л гэж байна. Бид цаг хугацаанд хоригдчихоороо цаг хугацааг мэддэгээс л болж түүнийг тоолдог. Цаг хугацаанаас гараад явчихаар цаг хугацаа гэж байхгүй.

Бясалгалын цаг маш их үнэ цэнтэй. Энэ нь таны зуу зуун галавын хувьсал хөгжлийг нэг дор шахаж багтаасан байдаг. Яг компьютерийн нягт чип юм. Иймхэн жаахан компьютерийн чипэнд хэдэн мянга, заримдаа бүр хэдэн сая бит нэгж мэдээллийг агуулдаг. Тиймээс хэмжээ гол нь биш. Бидний дасаж сурсан цаг хугацаа, тоо ширхэг биш. Бясалгалын үе бол тэс өөр цаг хугацаа, орон зай юм. Иймд та энэ цаг хугацаагүй, хязгааргүй орон зайд хэдий чинээ их нэвтэрнэ, (Их Багш инээв) өөрт тань төдий чинээ сайн. Өөрийгөө улам илүү танин мэдэх тусмаа улам л эрх чөлөөтэй болно.

Сэтгэл оюуныг сургах нь

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Олон улсын гурван өдрийн даяан, Их Британи улс
1999 оны 6-р сарын 11, (Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Би маш түгшиж, ер нь л тэмцээд л, зүдрээд л байсан.*

Их Багш: Юутай тэмцэлддэг гэж?

Асуулт: *Бясалгалаа хийх гэж л.*

Их Багш: Өө тийм үү. Бясалгалыг битгий ажил болго, энэ бол тайвширч амрах цаг шүү дээ. Юу ч хийх хэрэггүй, зүгээр л тэнд тайвшраад сууж бай гэж сэтгэлдээ хэл. Хэрвээ удаан сууж чадахгүй бол хэвтэж амарч болно. Тааламжтай бясалга.

Өөрийнхөө урд цэцэг тавиад, гоё хувцсаа өмсөж болно. Хэрвээ сайхан санагдаж байвал бясалгалаа ёслолын ажиллагаа шиг болго. Ийм учраас л зарим хүн хүж асааж, цэцэг тавьдаг нь сэтгэлээ баясгах гэснээс л тэр юм. Бясалгалаа хийхэд тань таатай л байвал юуг ч хийж болно. Баяс! Эсвэл хэвтэж амар. Тэгэх зуураа харин эндээ (билгийн нүдэн дээрээ) төвлөрөөрэй.

Юун түрүүнд бясалгалаа таатай болго. Сэтгэлд тань дэндүү хэцүү бэрх болгох ёсгүй, тэгвэл түүнд энэ таалагдахгүй. Тэр ажил хийх дургүй. Хэрвээ та хэтэрхий ноцтой чухал хандвал сэтгэл чинь “Надад энэ таалагдахгүй байна; би зугаацмаар байна; би найз нартайгаа хөгжим сонсож, кофе уумаар байна. Би ингэж суухыг хүсэхгүй.” гэж эсэргүүцнэ.

Тиймээс бясалгалаа зүгээр л таатай сайхан болго. Сайн найз нар, авшигтнуудаа гэртээ урь. Эсвэл тэднийхээ гэрт очиж, эхлээд кофе уун, ярьж хөөрч, эсвэл цугтаа ямар нэг юм хий. Тэгээд дараа нь цуг суугаарай, тоглоомынхоо, зугааныхаа нэг хэсэг мэт хий. Эхэн үе иймэрхүү байж болно. Сүүлдээ та бясалгалдаа дасаад ирэхээр энэ мэт тоглоом хэрэггүй болно. Та хаана ч сууж бясалгахад сайхан санагддаг болно.

Эхлээд сэтгэлээ тайвшруул. Олонх тохиолдолд бид бүгд Будда болох гэж ихэд яарч байдаг, түүнээс л болж бидэнд асуудал бэрхшээл үүсдэг. Бид сүнс болоод сэтгэлээ хооронд нь зохицуулах гэж тэмцэж зүдэрдэг. Сүнс бясалгахыг хүсэж; сэтгэл зугаацахыг хүсдэг. Тийм учраас бид сайн бясалгасныхаа дараа, өөртөө дуртай хоолоо өгөх мэтээр сэтгэлээ шагнаж болно. Гадуур гар, эсвэл найз охинтойгоо уулз, ер нь бясалгасныхаа дараа ямар нэгэн зугаатай юм хий. Тэгвэл сая тархи чинь “Болж байна. Энэ чинь зүгээр юм байна.” гэж ойлгох болно. Тархиа яг л нохой сургаж байгаа юм шиг сурга. (Инээлдэв) Та нар нохой яаж сургадгийг мэднэ. Нохой хийх ёстой юмаа сайн хийвэл та нар түүнийг шагнадаг. Тэгж байж л тэр нохойг сайжруулна.

Бидний сэтгэл заримдаа яршигтай! Хэрвээ заримдаа үнэхээр бясалгамаар санагдахгүй байвал зүгээр л орхичих. Өөрийгөө битгий их хүчил. Зүгээр л өөр юм хий: ямар нэг дасгал хийж, эсвэл гүйж болно. Тэгээд ядрахаараа суумаар санагдана. Бодол сэтгэл чинь ч саад болохгүй. Ер нь ганцаараа байхын бэрхшээл энэ юм: зарим үед сэтгэл маань биднийг маш их хуурдаг. Ийм үед биднийг зоригжуулж, гараас маань хөтлөх хэн нэгэн хүнгүй бол бид тийм хурдан ахиц гаргаж үргэлжлүүлж чадахгүй. Тиймээс бидэнд багш, найз нөхөд, хамтран бясалгагчид хэрэгтэй байдаг юм. Тэгвэл бид тэдэндээ бэрхшээлээ хэлж болно, заримдаа тэд тусална.

Тийм учир нийтийн бясалгалд аль болох байнга оролцохыг хичээ. Хамтран бясалгагч нартайгаа асуудал бэрхшээлээ хэлэлцэж болно. Хоорондоо найзал; бие биеэ гэртээ урин хамтдаа цай, кофе уу, мөн үүний эсрэгээр өөрөө зочил. Үүнийгээ баяр зугаа болго. Заримдаа гадуур цуг яв, зугаатай бай. Кино театрт оч, хамтдаа ямар нэгэн юм хий, тэгвэл бясалгал чинь нөхөрлөл, зугаацлын нэгэн хэсэг болно. Эхэндээ зарим хүнд энэ бол зайлшгүй хэрэгтэй зүйл. Та нар сэтгэлээ юунд дуртайг олж мэдэх хэрэгтэй. Тэгээд тэр зүйлийг нь бага багаар өгч бай; түүнд хэтэрхий хатуурхах хэрэггүй.

Зарим хүнд бол ингэх шаардлага байхгүй. Өөрсдөө дуртай тул тэдний хувьд бясалгал хялбар байдаг. Гэсэн хэдий ч

бид бясалгалын тодорхой шатанд хүрэхээрээ тэндээ гагцхив явдал бий. Гэнэтхэн л цаашид бясалгамааргүй санагдана. Бид Будда (гэгээрсэн төрөлтөн) нартай бишгүй л хамт байлаа гэдэг. Гэхдээ энэ ердөө түр зуурынх юм. Хожим нь хүмүүстэй нөхөрлөн, сүнслэг амьдралын талаар ном уншин, сүнслэг сэдвээр бичлэг сонсож, эсвэл магадгүй бүр гүнзгийрч Бурханы судар шаштир уншдаггүй юм гэхэд ядаж л амьдрал, үхэл, бясалгал, мөн Диваажингийн орны тухай өөр бусад хүмүүсийн ойлголт туршлагыг бичсэн орчин үеийн номууд уншвал ямар нэг байдлаар илүү урамшиж, тэдгээр хүмүүстэй адилхан ойлголт туршлагатай болохыг хүснэ. Ингэж та улам их чармайх болно.

Бид аливаа зүйлийг хийхдээ өөрсдийнхөө амьдралын хэмнэл болоод хэв маяг, сэтгэлгээ, дадал зуршилдаа тохирсон аргыг олох хэрэгтэй. Дадал зуршлыг өөрчлөхөд хэцүү байдаг. Хурдан өөрчлөх боломжгүй бол аажмаар өөрчлөх хэрэгтэй.



Бид хоол хийж байхдаа
хүмүүсийн бие болон сүнснийг
хооллох нь өглөг өгөх лүгээ нэн
ариун ажил үүрэг юм гэдгийг
мэдэж байх хэрэгтэй.
~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай



Бясалгалын зорилго — Өөрийгөө таних ба Дотоодын аз жаргалд хүрэх юм

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Шиху, Формоса, 1995 оны 6-р сарын 19 (Дүрс бичлэг №481)
(Эх нь Англи хэлээр)

Үнэндээ бид маш жаргалтай байхдаа бясалгах их хэцүү. Их шаналж зовж байх үедээ бясалгах бас л хэцүү байдаг. Тиймээс бид энэ хооронд тэнцвэрээ хадгалахыг байнга хичээдэг, ингэвэл жинхэнэ аз жаргал дотор минь оршиж буйг мартах хэмжээнд хүртлээ ийм туйлшралуудыг амсахгүй. Үнэхээр, тийм шүү!

Бид хэн нэгнийг хэр хайрлах эсвэл хэн нэгэн биднийг хэр хайрлах ер хамаагүй. Нэг л өдөр тэр урмыг тань хугалдаг. Ингээд сэтгэл өвтгөнө. Бид буруу ойлгодог ч байж магад эсвэл заримдаа энэ үнэн болдог. Гэвч сэтгэл өвтгөдөг. Тэр байтугай нөхөр хүүхдүүдээ биднийг хайрлаасай гэж үнэхээр хүсвэл тэдний бүх л хүслийн төлөө бүтэн 24 цагийн турш яг л боол мэт зүтгэх хэрэгтэй болно. Тэд жаргалтай байвал тэр нь бидэнд наалддаг байж мэднэ. Гэхдээ магадгүй л гэж байгаа юм.

Заримдаа хүүхдүүд эцэг эхээ буруу ойлгосноос болж тэдэнд хүндрэл учруулдаг, эсвэл тэд эцэг эхээ үргэлж дэргэд байж, тэдэнд бүх цагаа зориулахыг хүсдэг. Гэвч заримдаа эцэг эх нь тэднийг сэтгэл хангалуун байлгаж чадахгүй бол зүгээр л анхаардаггүй. Заримдаа хүүхдүүд ч эцэг эхийгээ их шаналгадаг. Мөн заримдаа эхнэр, нөхөр бие биеэсээ хэтэрхий их юм горьдож хүлээх эсвэл ердөө жирийн хүлээлтээс болж зовоодог.

Гэсэн ч тэд үүнийг үргэлж амархан биелүүлэх бололцоогүй. Таныг өнөөдөр хайрлаж байгаа тэр хүнийг маргааш нь бас л тийм байхыг эсвэл бүр илүү сайн байгаасай гэж та хүлээдэг. Гэвч маргааш нь ямар нэг юм тохиолдоно. Ингээд тэр хүн уцаартай, ааштай болж, тантай ярихыг хүсдэггүй. Энэ таны буруу биш байж магад. Гэтэл та “Та надад санаа тавихгүй юм бол би танд санаа тавих ямар хэрэгтэй юм бэ?” гэнэ. Та хоёр хоёул ингэж хэлнэ, ингээд салах юмуу наад зах нь бие биедээ дургүй болдог. Буцаад эвлэртлээ олон хоног болно, эсвэл хэзээ ч эвлэрэхгүй байж мэднэ. Заримдаа ялихгүй зүйл хүмүүсийг салгаж, маш их сэтгэл өвтгөдөг. Сэтгэл өвтгөдөггүй зүйл биш. Хэрвээ сэтгэл өвтгөөгүй бол зүгээр байх сан. Гэвч өвтгөдөг л юм даа.

Чухамдаа бид дотоодын аз жаргалдаа үнэхээр тулгуурлаваас бүх зүйл ирнэ. Тэгвэл бид хэзээ ч гонсойхгүй, хэнд ч найдах хэрэггүй болно. Хэн нэгэн хүрээд ирвэл болж л байна, ирэхгүй байсан ч зүгээр. Бид дотооддоо тийм их өвдөлт мэдэрч, шаналж зовохгүй.

Тэгэхээр бүх шаналал, уйтгар гуниг, ганцаардал нь гаднаас, бусад хүмүүсээс ирдэг юм биш. Эдгээр нь дотоод мунхаг байдлаас л ирдэг. Бид хэн нэгнээс хэтэрхий ихийг, юм бүхнийг хүлээдэг, тэгээд л урам хугардаг. Тэгэхлээр, аз жаргалын цорын ганц эх булаг дотоод чинь байдаг юм. Бясалгал хийх бүртгээ тэр эх сурвалжтай холбогдохыг хичээгээрэй. Өөрийнхөө төлөө, өөрийн аз жаргалын төлөө, сэтгэл хангалуун, тааламжтай байхын тулд, хүн бүрийн дотор байдаг энэ баяр баясгалангийн төвтэй холбогдохыг үргэлж хичээх хэрэгтэй. Тэнд чинь л Их Багшийн Хүч байдаг юм. Тэнд чинь л орчлонгийн гайхамшиг бүр биелж чаддаг юм. Тэр бол тэр чигээрээ нинжин сэтгэл, тэнд л хайр ба нинжин сэтгэл төрдөг юм. Тэнд л таны таньж нээх бүхий л Буян, Гоо үзэсгэлэн, Үнэн Ёс унтаад байж байдаг юм.

Эс бөгөөс бид эрт орой үхэх л болно, хаашаа ч юм явна, хэнд хамаатай юм бэ? Ядахдаа бид амьд байхдаа, хүн болж төрсний хувьд маш үр бүтээлтэй амьдрах хэрэгтэй. Бид аз жаргалтай байж, амьдралаа баяр баясгалантай үргэлжлүүлэх тэнхээтэй байх хэрэгтэй. Учир нь энэ нь дэлхийн бүх амьтдын “Дээд Арав”-т байгаа хүн төрөлтөн бидний нэр төрд нийцдэг. Бид бол материаллаг бүтээлийн оргил нь юм. Бид одоогоор энэ орчлонгийн оргил нь мөн гэдгээ хараахан мэдэхгүй байна. Үгүй байж ч магад, гэвч ядахдаа эндээ, бид бол бүтээлийн оргил юм. Тиймээс бид амьдралаа хүмүүн төрөлтний хэмжээнд нэр төртэй авч явах, түүнчлэн ялангуяа бидэнд үргэлж ашиглаж чадах дотоод эрдэнэс бидэнд байж байхад бүх зүйлээс айх, тэнэглэх, шаналж зовохоо зогсоох ёстой.

Энэ бол бясалгалын цорын ганц зорилго юм: та өөрийгөө таньж, жинхэнэ аз жаргал гэж юу вэ? гэдгийг мэдэж авах явдал юм, харин Их Багш ингэж хэлсэн, та Их Багшийг дагах хэрэгтэй учраас биш юм. Танд сайн зүйл учраас та Их Багшийг дагадаг, харин та яагаад гэдгийг мэдэж байх хэрэгтэй. Та энэ нь Их Багшийн төлөө биш, харин таны төлөө л хэрэгтэй гэдгийг мэдэх ёстой. Их Багшид хамаагүй. Надад хамаагүй. Хэрвээ та бясалгахгүй гэвэл та бясалгахгүй. Энэ бол таны л амьдрал. Би таныг хянаж чадахгүй, энийг би хүсэхгүй. Хэрвээ та өөр хэн нэгнийг хянавал, та түүнд уягдана. Яг л цагдаа гэмт хэрэгтэн хоёр хоёулаа гавлуулаад явдаг шиг. Цагдаа хоригдлыг анхаарах хэрэгтэй байдаг.

Би тэр байр суурин дээр байхыг хүсэхгүй. Ямартай ч танд л сайн гэж би хэлдэг, хэрвээ таны сонсож байгаа зүйл утга учиртай бөгөөд та үүнийг мэдэж байгаа бол үргэлжлүүлээрэй. Би таныг хүчилж байгаа ч юм биш, тийм зүйл биш. Ийм нууцыг мэдэх боломжтой таарах нь хүндэтгэл юм, давуу байдал юм, бидний амьдралын хамгийн дээд зол завшаан юм. Энэ нь албадуулсан хэрэг биш, тохиролцоо ч биш, ямар нэг үүрэг хариуцлага ч биш юм. Бүх зовлон зүдгүүрээс өөрийгөө чөлөөлөх ийм үүд хаалгыг бидэнд тун хялбархан харуулж байгаа нь мянга мянган жил, сая сая жилийн амьдралд тохиох

хамгийн шилдэг давуу эрх дарх, хамгийн шилдэг аз завшаан юм. Тиймээс үүн дээр л ажилла. Чухам үүнд л байгаа юм. (Алга тавшив)

Заримдаа би их орой болтол ажилладаг, арван хоёр, нэг, хоёр цаг хүртэл, гэсэн ч унтахаасаа өмнө заавал бясалгадаг. Өөрийн бүх л үүрэг даалгавраас гадна бясалгахыг би үргэлж хүсэж тэмүүлдэг. Бясалгах хэрэггүй, их хэцүү гэх мэтээр хэзээ ч боддоггүй. Хэзээ ч үгүй! Энэ бол баяр хөөр, амарч тайвшрах эх сурвалж, дахин цэнэглэх арга зам, тэр байтугай бие махбодыг ч бас.

Энэ бол Будда болох, өөр нэгэн болох тухай яриа биш. Хэрвээ нэг өдөр л бясалгахгүй бол бүтэн өдрийн ядаргаа, нийгмийн бүх л төрлийн сэтгэл санааны сөрөг бөмбөгдөлтөөс хэзээ ч өндийж сэргэхгүй. Та ядарсан бол, ийм тийм, элдэв янз байгаа бол, надад битгий гомдол ярь. Хэрвээ та хангалттай бясалгаагүй бол тийм л байх болно. Энэ бол таны төлөх үнэ. Эхэндээ та тогтворжоогүй байж мэднэ. Гэвч та бясалгах тусам ийм л байдгийг, энэ л ганц арга нь юм гэж илүү их мэдэрнэ. Тэр байтугай хэн нэгэн ирж нэг сая доллар өгөөд, Их Багшийгаа соль эсвэл энэ аргаа өөрчил гэсэн ч та тэгэхгүй. Та хэзээ ч тэгэхгүй. Учир нь та үүнийг зүгээр л мэдэж байгаа болохоор; та худал хэлэхгүй. Та энэ арга надад таарахгүй юм байна гэж худал хэлж чадахгүй. Бясалгал тань тааруухан байсан ч энэ зөвхөн өөрийн таны буруу гэж та мэдэж байдаг. (Их Багш болон бүгдээрээ инээв) Та үүнийг шударгаар мэднэ.

Тэгээд дотоод сэтгэлийнхээ гүнд нэвтэрсэн үед: Арьяабалын Арга бол цорын ганц арга зам, тийм үү? Тэгээд л боллоо, цэг, дууссан, маргах зүйлгүй, “гэвч”, “хэдийгээр”, “тийм байтал” гэх юм байхгүй. Ингээд л боллоо. Энэ бол бидний зүрх сэтгэлд байгаа мэдрэмж, бидний мэддэг зүйл юм. Мөн энэ бол таны итгэлтэй байж болох цорын ганц зүйл юм. Тиймээс хэрэв та тэрийг мэдэж байгаа бол та мэддэг юм байна. Би танд хэлэх шаардлагагүй.

Зориулал үнэн зүрхнээс төрдөг

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Лондон хотод болсон нийтийн бясалгал, Англи улс,
1998 оны 3-р сарын 10 (Дүрс бичлэг №631)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Илүү түргэн дэвшихийг хүсэж байгаа хүнд бясалгалаа ахиухан хийх тустай байдаг юм болов уу, хэр илүү хийж байж дэвших вэ?*

Их Багш: Хэр ахиухан хийж дийлэх, эсвэл хэр ихийг хийхийг хүсэж буйг та өөрөө мэдрэх ёстой. Зөвхөн бясалгалд гол нь байгаа юм биш; зүрх сэтгэл, зориг шийдвэрээс хамаарна. “Ай, би үнэхээр үүнийг л хүсэж байна.” гэж дотроос чинь өгүүлэх зориулал байхыг хэлж байна. Та дотооддоо үүнд хүсэн тэмүүлэх нь бас л бясалгал юм. Суух төдийхөн ч биш л дээ.

Асуулт: *Өдөр тутмын амьдралдаа аливаад хэрхэн хандах, сэтгэл санаа ямар байх нь бас нэмэртэй байх уу?*

Их Багш: Тийм, тийм, тийм: юмыг ямар байр сууринаас харж, яаж өнгөрөөж байгаагаас шалтгаалдаг. Бид энэ талаар эцэс төгсгөлгүй ярьж болох хэдий ч хүн бүр Бурханд хүрэх өөрийн замтай. Хурдан эсвэл удаан хүрэх нь өөрийнх нь сонголт юм. Та зүрх сэтгэлдээ юу хийхийг тушааж чадахгүй; би ч чадахгүй. Танд хүсэл байвал тэр, байхгүй бол тэр. Нэг л өдөр та энэ дэлхий, энэ худал хуурамч, хоосон төөрөгдлөөс ядарч залхана. Ингээд та сэтгэл дотроо амлалт үүрэг хүлээнэ. Хичнээн удаан сууж бясалгасан ч хамаагүй болно, та өөртөө үүрэг хүлээчихсэн. Та зүрх сэтгэлдээ Оройн Дээд Бурхантай үргэлж хамт байна. Энэ л жинхэнэ бясалгал юм. Ийм байх нь танд их таатай сайхан болно. Ингэж та үүнийг мэднэ; за үнэнч гэдгээ мэднэ. Эс бөгөөс урьд өмнө нь та өөрийгөө зориулахын тулд маш их чармайж байсан, гэвч ердөө чармайлт л байсан хэрэг. Ялгаа нь энэ юм!

Хамгийн сайн бодол бол Бурханы тухай юм

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Шихү, Формоса, 1991 оны 9-р сарын 25 (Дүрс бичлэг №152)
(Эх нь Англи хэлээр)

Бодол нэн чухал, Бурханы оршихуй ба чанар маш хүчтэй гэдгийг та мэдэж байгаа - тиймээс тэр мөчид эсвэл ядаж л бид бясалгах, Бурханыг санах үед бидний бодол ариун, гэгээн, нөхцөл болзолгүй байдаг. Тиймээс бид муу зүйл үүсгэдэггүй - зөвхөн ариун чичирхийлэл, хүчтэй адислалыг л бий болгодог.

Иймээс энэхүү хүчирхэг адислал, энэ бодлын хүч эргэн тойронд болон бидний хүрээлэн буй орчинд бий болох үедээ дээш өсөн дэвжинэ, улмаар бусад ариун гэгээн бөгөөд бясалгадаг хүмүүс ч бас адилхан бодол, адилхан адислал, адилхан хүчийг үүсгэдэг. Ижил зүйл ижлээ татдаг шиг эдгээр нь бие биеэ татсанаар энэ дэлхийд бүхий л сөрөг, хорон муу нөлөөллийг ялан дийлэх нэн чадалтай хүч болдог.

Дэлхий ингэж л өдрөөс өдөрт ариусан сайжирч байдаг юм. Тэр байтугай өглөг буяны ажил хийхгүйгээр, гадагш гарч ном айлдахгүйгээр бид ингэж дэлхийдээ тусалдаг юм. Тийм ээ, мэдээж бид гадуур явж номлох үедээ сонсогчдын оюун бодол дотор, оюун бодол руу зарим дээд чичиргээг түргэн зуур авчирч, тэднийг хэсэг зуур, урт хугацаанд эсвэл магадгүй бүр мөсөн өргөн дээшлүүлдэг. Мөн энэ хүмүүс энэ чичиргээг өөртөө тээсээр харьдаг, тэд үүнийг тэтгэн арвижуулж, энэ ариун гэгээн уур амьсгалд өөрөө тогтворждог. Тэд бас гэгээнээр өсөж хөгждөг – цэвэр ариун бөгөөд тогтвортой. Харин үүнийг хийхэд хүчирхэг хүн байх хэрэгтэй. Тийм биш бол бид хүмүүст нөлөөлж чадахгүй. Эсрэгээрээ бид тэдний нөлөөнд орох болно. Учир нь масс буюу хүмүүсийн дийлэнх нь илүү олон санаа бодлыг нэгтгэсэн байдаг, харин бидэнд ганц л бодол санаа бий.

Бид энэ бүх олон санаа бодлыг хучиж дийлэхүйц хүчирхэг байхгүй бол тэд биднийг залгиж, бид аюулд орно.

Гэвч бид тэгэх албагүй. Бид ердөө л өөрийнхөө буланд, унтлагийн өрөөнийхөө нэг нам гүмхэн буланд суугаад, өөрөөсөө сайн бодол, сайн чичирхийлэл, хүчтэй адислалыг дэлхийдээ, бүр томоор бол орчлон руу илгээж чадна. Тийм учраас бид бодлоо цэвэрлэхээр бясалгах ёстой.

Ямагт Бурханыг дурсаж, үргэлж Бурханы Ариун Нэрсийг санаж байх цагт бид ариун чанар, гэгээн хутаг ба адислалаар дүүрч хүчирхэгжинэ. Хэн ийм адил ухамсартай байна, бидэнтэй ижил түвшинд байна, тэр мөчид тэр бидэнтэй нэгдмэл байх болно. Мөн бид үүнийг хүч рүү, эерэг хүчний энерги рүү нэмснээрээ дэлхийг ариусгаж, дэлхийг илүү сайн, илүү дээр газар болгоно, мөн бидэнтэй ижил сэтгэлгээтэй хүмүүст улам хүчирхэгжихэд тусална, бидний бодол санаатай харилцсан, бидэнтэй биеэр харилцсан тэдгээр хүмүүст бүр хүчтэй болж, өөрсдийгөө дэвшүүлэхэд нь тусална. Энэ бол дэлхийдээ туслах хамгийн сайн арга зам юм.

Мэдээж хэрэг, бид энэ дэлхийдээ туслахдаа өөртөө тус хүргэдэг, бид түүн дээр амьдардаг учраас. Уур амьсгал цэвэрших тусам хөршид маань төдийгүй бидэнд ч бас их сайн. Тиймээс бусдад тусалснаараа өөртөө тусалж байгаа юм. Тэгэхлээр, цаг үргэлжид, бид маш цэвэр бодол, нөхцөл болзолгүй хайр, сайн хүсэл санааг- үргэлж- ямарваа хариу горьдолгүй бий болгож байх хэрэгтэй. Энэ бол хамгийн сайн арга зам. Бид ариун хутагтын түвшинд юмуу нэн аугаа Бодьсатва эсвэл Буддагийн түвшинд хүрээгүй байгаа ч наанадаж л өөрийгөө цэвэр ариун байлгаж, эргэн тойрныхоо сөрөг хүчний нөлөөнд орохгүй авч явбал зохино. Учир нь энэ дэлхий дээр ийм сайн сайхныг дадуулдаггүй, Бурханд үнэнээсээ итгэдэггүй олон хүн бий, тэд цаг үргэлж муу бодол үүсгэдэг. Тэд бодол, үйл, үг хэлээрээ ч орчноо бохирдуулж байдаг.

Хэрвээ бид ариун бамбайгаар, өөрийн сэтгэл санааны хамгаалалтаар, өөрсдийн цэвэр ариун байдал ба сайн санаагаараа хучигдаагүй байх юм бол эргэн тойрны энэ бөөн сөрөг хүчинд живэх болно. Тийм учраас авшгийн үед Их Багшийн Хүчээр цэнэглэсэн тэрхүү Бурханы Ариун Нэрсээ байнга давтан унших ёстой. Үүнийг л сүнслэг дамжлага эсвэл дээдийн номын удам гэж нэрлэж байгаа юм. Хэрвээ бидэнд ийм удам юмуу сүнслэг дамжлага байхгүй байвал бид Нэрсийг хоосон үг мэт л давтана; үүнд ямар ч хүч байхгүй.

Үнэхээр ийм байдаг юм. Эд материалын сайн сайхантай адил. Мөнгөгүй хүн бусдад мөнгө өгч чадахгүй. Тэр мөнгөний чекэнд гарын үсгээ зурсан ч тэр нь хоосон чек байх болно - ямар ч баталгаа байхгүй, чекийг батлах банкны данс байхгүй. Түүнтэй адил, сүнслэгээр хоосон хүн бусдыг сүнслэг хүчээр цэнэглэж чадахгүй, бусдын сүнслэг хүчийг эргэн сэргээж чадахгүй. Хэдийгээр сүнслэг хүч оршин байгаа нь харагддаггүй боловч оршиж байдаг. Хүмүүст, хүмүүсийн дотоодод нь тэдний өөрийнх нь сүнслэг хүчийг дахин сэрээх нэгэн Гэгээнтэн юмуу нэгэн Их Багшийн төлөө энэ хүч нь оршин байж байх ёстой. Эс бөгөөс, тэр хүч энд санамсаргүй зогсоод өөрөөсөө гал гаргаж чадахгүй. Гал хэдийгээр модноос гардаг ч гэсэн түүнд ямар нэг юм хэрэг болно, түүнийг шатаах өөр нэг хэрчим түлээ хэрэгтэй, эсвэл галыг дотроос нь асаах хэрэгтэй.

Үүн лүгээ, Их Багш бол Өөрийн сүнслэг хүчээ мянга мянгаар нь, сая саяар нь, бүх л дэлхийд, бүхий орчлонд нөлөөлж чадах хэмжээнд хөгжүүлсэн нэгэн мөн. Их Багш хүчирхэг байх тусам нөлөө нь илүү том байна. Үүнийг бид тэр Их Багштай холбоо тогтоосноор мэдэж чадна. Бид сүнслэг Их Багштай хамт суухад нэн амгалан тайвныг мэдэрдэг. Бид бусад хүмүүстэй, зарим муухай бодолтой эсвэл их харгис хүмүүстэй хамт гадуур явахдаа нэн тайван бус болж, айж сүрдэж байгаагаа мэдэрдэг. Энэ бол дотоод оршихуйн үл үзэгдэх нөлөөлөл бөгөөд бид үүнийг хэлж чадахгүй ч мэдэрдэг.

Иймд бид Их Багшийн хэм хэмжээнд хүрч амьдрахыг хичээдэг. Ингээд бид бясалгадаг; бид бодлоо ариусгахыг хичээн оролддог. Хамгийн сайн бодол бол бодолгүй байх юм. Тиймээс та Бурханы Ариун Нэрсийг л давтахад хангалттай. Энэ бол хамгийн дээд бодол. Эдгээр нь нэн төв голч, тун ариун, нэн хүчтэй. Энэ мөчид та өдөр тутмын бодол, эгэл бодол санаа үүсгэх хэрэггүй болно. Учир нь бид хэдий сайн зүйл бодсон ч гэсэн, заримдаа энэ нь тухайн орны заншил, ард түмний маань дадал хэвшил, нийгмийн чиг хандлагаар нөхцөлдсөн хэвээр байдаг.

Тиймээс зүгээр л Бурханыг бодох нь хамгийн сайн бодол юм. Учир нь Бурхан бол хамгийг чадагч, хүчирхэг. Бурхан бүхнийг хийж чадна. Энэ нь тэр мөчид бид өөрийн хүсэл тааллыг Бурханы таалалд захируулдаг гэсэн утгатай. Бурханд орчлонг захирахыг нь зөвшөөр, ингээд бид ачааллаас чөлөөлөгддөг.

Өглөө эрт босож бясалгах дадлыг хэрхэн бий болгох вэ?

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Окленд, Шинэ Зеланд 2000 оны 4-р сарын 27 (Дүрс бичлэг №686)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Өдрийн сэрүүн байх цаг хүрэлцэхгүй үед өдөр тутмын бясалгалынхаа хуваарийг яаж зохицуулах вэ?*

Их Багш: Та сэрж чадахгүй байна уу? Би ч бас. Дулаан хөнжилдөө шигдсэн хэн ч байсан сэрэх дургүй, гэвч бид хичээх хэрэгтэй. Та ажил албатай хүн гэе, ажилдаа эрт явахын тулд та босох л ёстой. Сарын хоёр мянган доллар гэх мэт зүйлийн төлөө та өглөө бүр таван цагт сэрдэг. Гэтэл Оройн Дээд Бурханы төлөө сэрдэггүй! Тэгэхээр чинь би яах вэ? Та нар өөрсдөө л юу хамгаас чухал гэдгээ шийддэг. Бид ердийнхөөсөө жаахан эртхэн сэрж болно, үүнийгээ дадал болгож болно.

Жишээ нь, гурван цагт босох хэт эртдэж байвал битгий бос; ажилдаа явахаар жирийн үед таван цагт босдог бол эхний удаад тавд хорин минут дутуу байхад бос, бүр тавд арав дутуу, бүр тавд тав дутуу байхад ч бос л доо. Дараачийн өдөр юм уу, дараа долоо хоногт тавд арван минут дутуу байхад бос. Өөрийгөө энэ санаандаа дасгаж, бас сайн шагна. “Өнөөдөр эрт босвол чамд хоёр цагариг боов, бас нэг аяга кафе латте нэмж өгнө шүү.” гэж өөртөө хэл. Сэтгэлдээ таалагддаг зүйлээр өөрийгөө шагна.

Бид өөрийгөө хайрлах ёстой, яагаад гэвэл, үнэнтэйгээ нүүр тулъя л даа, бид ганц л биетэй, заримдаа бид маш ядардаг. Энэ машинаа ажиллуулж байхын төлөө л өдөрт бид наймаас арван цаг ядартлаа хөдөлмөрлөдөг. Бас дээрээс нь хааяа гэр бүл: эхнэр, хүүхдүүд, эцэг эх, найз нөхөд, хөршүүд, садан төрлүүд гэх мэт бусад ажилд бас зүтгэх хэрэгтэй байдаг. Бид энэ махан биеэсээ үнэндээ хэтэрхий их юм шаарддаг.


Тархи бодлоо бүү дага; тэр чинь ердөө л компьютер. Бодол маань “Алив ээ, унт. Унтах биед чинь сайн.” гэдэг. Гэтэл тэр бол Бурханы дуу хоолой биш. Бурхан тэрний ард нь байгаа юм.

Тэгэхлээр, өглөө бясалгахаар босож чадахгүй байгаа бол мэдээж өөрийгөө уучлахаас өөр яах билээ. Өөртөө хэт хатуурхалгүй, зугуухан сургаж ав. Зурагт үзэхээ багасган, өглөө эрт босохын тулд арай эртхэн унт. Уйдахаараа цаг нөхцөөж хэт их хийдэг байсан зүйлдээ зарцуулдаг байсан тэр цагаа Бурханыг таньж мэдэхэд зориул. Энэ бол зохион байгуулалтын асуудал. Би бас хэрэндээ л завгүй. Та нар итгэхгүй байж мэднэ; би энд сайхан харагдаад сууж байгаа хэдий ч, тун завгүй хүн. Надад ч бас өглөө эрт босох заримдаа хэцүү байдаг. Гэхдээ та сэрүүлэг тавихаас өөр аргагүй болно. Заримдаа ийм үе байдаг.

Эртний Энэтхэг уламжлалаар нэгэн Гэгээнтэн шөнөжин сэрүүн байдаг байжээ, гэхдээ тэр хэвтэхийн оронд суугаа чигтээ унтдаг байсан, ингэхээр ялгаагүй байжээ. (Инээлдэв) Манайхан ч бас адилхан даа. Даяанд ирсэн үедээ давгүй сайхан сууж харагдана, гэхдээ янз бүрийн хэв загвартай сууна. Чадахаараа хичээ; тэр чинь л чухал. Энэтхэгт над шиг урт үстэй нэгэн Гэгээнтэн үсээ таазнаас уячихдаг байсан! Би тоглоогүй. Тэгж их хичээсэн учраас тэр Их Багш болсон. Тэр үсээрээ таазнаас уячихаад зүүрмэглэж толгой дохихоороо “Өө, за, ёох ёох” гэнэ. (Инээлдэв)

Би та нарыг үсээ ургуул, эсвэл үүнийг хий гэж байгаа юм биш. Харин өөрийн гэсэн аргаа олоорой. Жишээ нь та өглөө эрт босож чадна; жишээлбэл би саванд мөстэй ус хийж тавих хэрэгтэй болж байв. Тэгээд сэрүүлэг дуугармагц гараа сунган мөс шүүрч аваад нүүр лүүгээ цацдаг байв: Ай! Мөс хувцас хунар, хамаг юм руу нэвчихээр, орноосоо огло үсэрч босохоос өөр яах вэ.

Та нар тэгэх албагүй; өөрийнхөө аргыг олно биз. Гэхдээ хүн юмыг болгоё л гэвэл болдог. Та нар өөрсдөө бурхад учраас чадна гэдэгтэй итгээрэй. Бурханд боломжгүй юм гэж байхгүй. Бурхан дотоодод чинь оршиж буйг л саначих, тэнд өөр хэн ч байхгүй.



Бясалгах хамгийн сайн цаг нь өглөө

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Окленд, Шинэ Зеланд, 2000 оны 4-р сарын 27 (Дүрс бичлэг №686)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Их Багш аа, өглөөгүүр бясалгах нь яагаад тийм чухал юм бэ?*

Их Багш: Та нар хэдийд ч бясалгаж болно. Ихэнх хүн шөнөдөө амарч тайвширсан байдаг болохоор өглөөгүүр зүгээр. Бас өглөөгүүр ер нь нам гүм байдаг. Гурваас зургаан цагийн хооронд ихэнх хүн унтаж л байдаг: замын хөдөлгөөн, шуугиан байхгүй, хүүхдүүд үймүүлж, утас дуугарахгүй. Шөнө унтаж амраад сэтгэл чинь тайван болсон байдаг. Бие махбод бүрэн идэвхжээгүй байдаг. Иймээс та илүү сайн сууж, самади буюу Диваажинд илүү хурдан хүрч чадна. Та нар гэртээ бясалгавал илүү сайн. Учир нь та гэртээ илүү амар тайван байдаг; танд нам гүм, найдвартай байдаг.

Өглөөний цагууд хамгийн сайн. Гэхдээ та нар өглөө л бясалгах хэрэгтэй гэсэн үг биш. Хэдийд ч бясалгаж болно: автобусанд, машинд. Манайхан машин жолоодохоос бусад цагт хаана ч бясалгадаг, гуйя. (Инээлдэв)

Цаг хугацаагаа бясалгахад зориул

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Бостон Төвийн авшигтнуудтай хийсэн видео конференц, МА, АНУ
2002 оны 9-р сарын 28 (Дүрс бичлэг №763) (Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Эрхэм хүндэт Их Багш аа, би амласнаараа хоёр цаг хагас бясалгахыг чадлаараа хичээдэг. Гэхдээ зарим үед амьдралын өдөр тутмын ажил үйлээс болж энэ шаардлагыг хангах амаргүй байдаг. Энэ асуудлын талаар зөвлөнө үү.*

Их Багш: Би яаж зөвлөж чадах вэ? Таны амьдрал ингэх боломж олгохгүй байна гэж та хэлж байна, тэгэхлээр би юу хийх гэж, таныг бас эргэн тойрны бүх хүнийг алчихвал та бясалгах цагтай болох юм уу? Мэдээж, амьдрал ийм л байдаг. Үүнд бүү захируул. Та амьдралаа захирах ёстой. Амьдрал таныг захирахыг бүү зөвшөөр. Та ердөө ганц амьдралтай. Таны ирээдүй ямар байхыг та хэзээ ч мэдэхгүй, тиймээс одоо энэ амьдралдаа үүнийг хий. Бясалгалдаа цаг гаргахыг хичээ. Чухал биш юмсыг хая, утсаар цөөн ярь, сонин бага унш, телевиз бага үз, хүмүүстэй цөөхөн холбогд, кофе бага уу; боломжтой үедээ бясалга, таван минут ч бай, арав ч бай. Цаг зав гарах болгонд бясалга. Ямар ч үед хамгийн сайнаараа хичээ! Зүгээр л бясалгалын суудалдаа зохистой суусан үедээ цаг тоолох албагүй. Та зав чөлөөтэй болсон аль ч үедээ цаг тоолж болно, нүдээ аниад Бурханы тухай бодож, бясалга. Аливаа нэг завсарлагаа бясалгалын цаг болго. Мусульман хүмүүс өдөрт таван удаа мөргөл хийдэг, харин ядаж л нэг юмуу хоёр удаа гэж би танаас гуйж байна. Үүнийг хий. Үүнд шалтаг байхгүй.



Удаан сууж бясалгах нууц

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Шихүд хийсэн 7 өдрийн даяан, Формоса
1989 оны 2-р сарын 13-18
(MP3 №CRO4) (Эх нь Хятад хэлээр)

Бид маш их бясалгаж, гэхдээ ядрахгүй байхыг хүсвэл яах хэрэгтэй вэ? Үүний нууц бол: бага ярь, эргэн тойрноо бүү хар, бусдын сайн муугийн тухай бүү бод, тэгээд зүгээр л хорин дөрвөн цагийн турш Ариун Нэрсээ л уншаарай. Аялгууны бясалгалын үед нэг л тогтворгүй байгаад байвал Ариун Нэрсээ хэдэн хором уншчихаад дахин Аялгуу ажсаарай. Биеийн чинь аль нэг хэсэг өвдөх юмуу мэдээ алдаж хөшвөл анхаарсны хэрэггүй! Тэгсхийгээд самадид орчихоороо бүтэн биеэ оршиж буй эсэхийг ч мэдрэхгүй. Иймд энд тэндээ маажиж хэрэггүй. Аялгуу ажисж байгаад ядарвал байрлалаа өөрчилж Гэрэл ажсаарай. Хөл чинь үүнд тун их талархах болно. Учир нь хөл их өвдөж, толгой өмнөх байрлалаас болж хөшчихсөн байгаа. Энэ үед нь байрлалаа сольж Гэрэл ажвал хамаагүй аятайхан санагдана. Иймд Гэрэл, Аялгууны бясалгалыг солбиж хийх хэрэгтэй, ингэвэл эдгээр нь харилцан дэм өгч, та ядрахгүйгээр илүү удаан бясалгах боломжтой болно.

Манай зарим бясалгагч шөнөжин сууж чаддаг. Үүний учир нь тэд Гэрэл, Аялгуу ажихдаа солбиж бясалгадаг. Гэхдээ үүнийг ойр ойрхон хийж, таван минут тутамд байрлалаа солиод байх хэрэггүй. Тэгвэл ямар ч хэрэггүй. Нэг байрлалдаа удаан байх тусмаа л сайн. Гэрэл ба Аялгууны бясалгал бие биедээ харилцан тусалж байдаг. Заримдаа Гэрэл ажисж удаан суугаад, бүр чилж ядарвал энэ маягаар байрлалаа өөрчилж Аялгуу ажсаарай. Ингэвэл хамаагүй сайхан санагдана, учир нь найдах ямар нэг зүйл байна. Бясалгал дадуулахад байдаг энэ нууцыг олон хүн мэддэггүй.



Бид зөвхөн хичээнгүй бясалгалаар Дэлхийдээ тусалж чадна

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Шихү, Формоса, 1992 оны 4-р сарын 12 (Дүрс бичлэг №241)
(Эх нь Хятад хэлээр)

Бясалгал бол машинд түлш хийж цэнэглэдэгтэй адил; эсвэл хүн ажиллах эрч хүчээ сэлбэхийн тулд хоол идэхтэй адил юм. Бид өдөр бүр ажиллах чадвартай, эрүүл байхын тулд өдөр тутамд боломжоороо хоол идэх хэрэгтэй байдагчлан бид бас сүнсээ энергиэр цэнэглэх хэрэгтэй, тэгснээр л бид аугаа үйл хэрэг бүтээж чадна. Бид яагаад аугаа үйл бүтээхийг хүсдэг вэ? Бид алдарших гэсэндээ эсвэл өөрсдийгөө том гэж үзсэндээ биш, харин энэ дэлхийд маш их шударга бус зүйл хардаг учраас юм. Зарим хүн дэндүү шаналж зовдог. Зарим нь хүний үнэ цэн эсвэл хүн байхын наад захын нэр төрийг эдэлж таашаах боломжгүй байна. Хүмүүс бие биедээ зэрлэг хүн шиг ханддаг. Ийм болохоор л бид энэ дэлхийдээ туслах гээд байгаа юм. Дэлхийдээ туслахын тулд бид эхлээд өөрсдийгөө хөгжүүлэх хэрэгтэй, хичээнгүйлэн бясалгаж, өөртөө зарчимч бай, тэгвэл л бид үүнийг хэрхэн хийхийг мэдэх болно. Эс бөгөөс бид хүссэн ч ингэх боломжгүй.

Онч Үг



Арьяабалын Арга бол хамгийн дээд эрдэнэ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
АНУ-ын Лос Анжелес хот, КА, 1999 оны 1-р сарын 1
(Дүрс бичлэг №643) (Эх нь Англи хэлээр)

Бидэнд тохиосон хамгийн сайн зүйл бол: Арьяабалын бясалгалын Арга гэдэг нь үнэн юм гэж би та нарт хэлье. Заримдаа та маш их зүйл мартдаг, эсвэл ямар нэг бэрхшээл юмуу асуултыг яаж шийдэхээ мэддэггүй, харин та хэсэг зуур Гуан Куан (Хятадаар: Гэрэл ажин бясалгах), мөн тэгээд Гуан Инь (Аялгуу ажин бясалгах) хийвэл, таньд бүх хариулт нь тун хурдан ирдэг. Үүнийг та мэднэ. Тийм учраас “Та эхлээд Бурханы Хаант улсыг эрж ол.” Бясалга! Эхлээд бясалга, тэгвэл бүх зүйл дагаад ирнэ. Тийм үед тэр зүйл ирэхгүй бол “Зүгээр, энэ танд хэрэггүй.” гэсэн үг юм.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Мехико хот, Мексик, 1998 оны 5-р сарын 23 (Дүрс бичлэг № 627)
(Эх нь Англи хэлээр)

Бид энэ ертөнцийн хэл ам, амьд үлдэхийн төлөөх эцэс төгсгөлгүй тэмцэл, мэдрэлийн ядаргаанаас залхаад, хэсэг хугацаанд Арьяабалын бясалгал хийвэл бидний дотоодод сүнсэнд маань аз жаргал урсан байгааг мэдэрдэг юм.

Залбирал ба бясалгалын хоорондын ялгаа

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Окленд, Шинэ Зеланд, 2000 оны 4-р сарын 27 (Дүрс бичлэг №686)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: Залбирах нь бясалгал мөн үү?

Их Багш: Тийм ээ, энэ нь бясалгалын нэг хэлбэр. Гэвч залбирал нь зөвхөн нэг урсгалтай бясалгал юм. Бид Бурханд “Өв Бурхан минь, үүнийг хийж өгнө үү!” гэж хэлдэг. Харин бид Түүний юу гэж харцулахыг сонсдоггүй. Ийм учраас л нэг урсгалтай зам юм. Бясалгал бол хоёр урсгалтай харилцаа юм. Бид өөрсдийн шаналал зовиур, гуниг зовлон, аз жаргал болон талархлаа Бурханд өргөдөг. Харин Тэр хариуд нь бидэнд одоо юу хийх хэрэгтэйг мэдүүлж өгдөг. Бид Бурхантай харилцаатай, бас бид Бурхантай холбоотой байна. Залбирал нь нэг хүний л яриа байдаг; бид Бурхан юу хэлэхийг огтхон ч сонсдоггүй. Харин бясалгалд, бид сонсдог; бид мэддэг. Бурхан биднийг замчилдаг. Тэр дотоодод маань бидний амьдралыг мянган нараар гэрэлтүүлдэг. Тэр биднийг гэрэлтсэн, энхрий, ухаантай, ухаалаг мэргэн, хошин хөгжөөнтэй, дотроо ч гаднаа ч үзэсгэлэнтэй болгодог. Ялгаа нь энэ юм.



Билгийн мэлмийгээ сана, Ариун нэрсээ унш,
Гуан Инь хий, ингэвэл бид хамтдаа байдаг.
~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Бүлэг 4

***Бэлгийн мэлмий -
Хамгийн ер бусын хүрд***

Хамгийн ер бусын хүрд

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Кэйп Таун хот, Өмнөд Африк, 1999 оны 12-р сарын 2 (Дүрс бичлэг №676)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: Та гуравдагч нүд болон чакра - хүрдний талаар ярьж өгнө үү?

Их Багш: Гуравдагч нүд бол бидний оршихуйн жинхэнэ нүд юм. “Хэрвээ энэ нүд ганц бол бүхий л бие Гэрлээр дүүрнэ.” гэдэг. Энэ нь гуравдагч нүд юм. Ихэнхдээ бид бие махбодын нүдээрээ л Бурханы биеэр заларсан хувилгаан дүрийг хардаг. Харин Бурханы жинхэнэ оршихуйг нь харахыг хүсвэл гуравдагч мэлмий гэж бидний нэрлэдэг сүнслэг нүдээ ашиглана. Бие махбод дотор Тэнгэр ба Газар Дэлхий хоорондын холбоос нь тэр гуравдагч мэлмийний төвд байдаг. Үнэндээ бясалгалын үеэр та заримдаа тэр мэлмийг, ганц мэлмийг хардаг, яг л таны биеийн хоёр мэлмий шиг боловч зөвхөн ганц мэлмий. Үүнийг гуравдагч мэлмий гэдэг, эсвэл сүнслэг мэлмий, билгийн мэлмий, эсвэл тэнгэрлэг мэлмий гэдэг. Юу гэж нэрлэсэн ч бай адилхан.

Зүрхэн хүрд нь зүрх байгаа газар биш, харин зүрхийг тойрон оршдог үл үзэгдэх зүрхний энерги юм. Энэ нь таны биеийг хүрээлж байдаг аура шиг зүрхийг хүрээлдэг аура мөн. Зүрхэн хүрд нь хайрын тухай, тэр ч байтугай үзэн ядалт гэх мэт аливаа зүйлийн талаарх мэдрэмжээ эрчимжүүлэхийг хүсвэл та анхаарлаа төвлөрүүлдэг тэр газар юм. Та зүрхээ ашиглаж байхад ийм байдаг. Харин бид билиг ухаанаа мэдье гэвэл, өнөөх л гуравдагч мэлмий буюу билиг ухааны хүрд дээр төвлөрөх хэрэгтэй.

Бидний бие махбод дотор янз бүрийн хүрд бий: тохойн хүрд, өвдөгний хүрд, бэлгэ эрхтний хүрд, ходоод гэдэсний хүрд буюу наран сүлжээ, зүрхний хүрд, хоолой төвөнх дээрх хүрд, мөн энд байдаг хүрд (Их Багш билгийн мэлмийн төвийг заав), бас титэм хүрд. Та эрлийнхээ зорилгоос хамаарч тэр хүрд дээрээ анхаарлаа төвлөрүүлдэг.

Та билиг ухааны нүд дээр төвлөрвөл бүх зүйл эрчимждэг. Энэ бол бүх хүрдний төв, бидний оршихуйн удирдлагын төв газар нь юм. Тэгэхлээр, бид тэндээ төвлөрчихсөн үедээ бид өөрсдөө чөлөөтэй болж, алив бүгдийг эрчимжүүлнэ. Та тэр байтугай илүү их хайрлана, юмсыг илүү сайн ойлгоно. Таны хоол ч улам амттай болно. Та илүү сайн ажиллана; илүү сайн бодно; та улам сайн хийж бүтээнэ, та сайн зурна гэх мэт. Бүх зүйл эрчимжинэ.

Билиг ухааны үл үзэгдэх эх сурвалж

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
АНУ-ын Лос Анжелес хот, КА, 1999 оны 10-р сарын 30 (Дүрс бичлэг №665)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Би билгийн мэлмий дэх билиг ухаан, зүрхэн дэх билиг ухаан ба бодол сэтгэл дэх дуу хоолой хоорондын ялгааг мэдээж болохсон болов уу?*

Их Багш: Бодол санаанд билиг ухаан гэж байхгүй. Бодол санаа зүгээр л өдөр бүр танд юу тохиолдсон, өөр лүү нь юу оруулсныг л бичиж бүртгэж авдаг. Жишээ нь, ээж чинь “Мөхөөлдөс идэж болохгүй, учир нь, учир нь, яагаад гэвэл.....” гэж ахин дахин захидаг. Тэгээд танд мөхөөлдөс харагдах болгонд “.....учир нь, учир нь, яагаад гэвэл.....” гэж бодол чинь хашхирч эхлэх ба та түүнийг иддэггүй. Яг л пянз тоглуулагч шиг.

Зүрх бол билиг ухааны төв биш; энэ бол мэдрэмжийн төв. Тийм учраас л та хэн нэгэнд дурлахаараа, “Өө! Энэ бол зүрхний хэрэг явдал.” гэдэг. Билиг ухааны төв энд байдаг. (Их Багш духныхаа голд нь заав) Бид энэ махбодод байгаа учраас хаа нэг газар байгаа гэж би хэлэх хэрэгтэй. Билиг ухааны төв мэдээж тэнд байхгүй. Гэвч та бие махбодод байгаа бол түүнийг тэндээс олох хэрэгтэй. Таны уураг тархины дотор голд нь нэг цэг бий. Үүнээс эхлэх юм. Хожмоо та өөрийгөө энд тэндгүй байгааг олж мэднэ. Та бол билиг ухаан; танд билиг ухааныг олох шаардлага байхгүй. Гэхдээ та хаа нэгтэйгээс эхлэх хэрэгтэй. Зүрхэн хүрд бол өөр бусад шалтгааны төлөө үүрэг гүйцэтгэнэ, билиг ухааныг эрж олохын тулд биш. Түүнчлэн, жинхэнэ зүрх бол таны цээжинд цохилж байгаа тэрхүү биет зүрх биш юм.

Гуравдагч мэлмийг хөгжүүлэх нь

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Хонолулу, Хавай, АНУ, 1993 оны 3-р сарын 28 (Дүрс бичлэг №343)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Бэлгийн мэлмийг хэрхэн хөгжүүлэх вэ?*

Их Багш: Та гуравдагч мэлмийг хөгжүүлдэггүй; тэр тэнд хэдийнэ байж байна. Бид материаллаг бус зүйлийг хөгжүүлж чадахгүй. Гуравдагч мэлмий бол зүгээр л хэлдэг арга, мэлмий гэж огт байдаггүй. Энэ нь зүгээр л бид хоёр нүдтэй бөгөөд аливаа зүйлийг хязгаарлагдсан хараагаар хардаг гэсэн үг юм. Харин бидэнд нөгөө нүд буюу гуравдагч мэлмий байгаа бол орчлон ертөнцийг бүхэлд нь харж чадна. Тиймээс үүнийг гуравдагч мэлмий гэж нэрлэдэг. Үнэндээ сүнсэнд харах нүд, сонсох чих, аливаа зүйлийг мэдрэх мэдрэхүйн аппарат хэрэггүй. Энэ бол хамгийн дээд Үнэн, энэ бол ямар ч махан биеийн хэрэгсэл ашиглахгүй хамгийн дээд ухамсарлах чадвар юм. Энэ бол бидний сүнсний хүч юм, бүх зүйлийг мэддэг, бүх зүйлийг бүх замаар, хаа сайгүй сонсдог, бидний дотоод дахь Төгс Гэгээрсэн Их Багш (The Supreme Master) юм.

Үүнийг л бид олох ёстой. Яагаад гэвэл бид бүх орчлонгийн Төгс Гэгээрсэн Их Багш нь, та ямар аугаа гэдгээ төсөөлж байна уу, та одоо энэ төрөлдөө яаж амьдарч байна вэ? (Их Багш дохио үзүүлэв) Тийм учраас би та нарын төлөө тун их харамсдаг. Та нар энд намайг сонсохоор ирдэг, уг нь тэгэх хэрэггүй юм! Бид бүгд адил тэнцүү, бид яг ижилхэн, бидний хүч ч адил. Та нар намайг хүндлэх ч хэрэггүй; энэ их гуниглам зүйл. Та нар миний хэлснийг хүлээн зөвшөөрвөл үүнийг ойлгож мэднэ, мөн миний мэддэг зүйлийг, Христийн мэддэг зүйлийг, Буддагийн мэддэг зүйлийг та бүхэн мэдэх болно.



Төгс Дээд Мэлмий

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Калифорни, АНУ, 1989 оны 10-р сарын 14 (Дүрс бичлэг №101А)
(Эх нь Англи хэлээр)

Бид өөрийн Мөн чанараа буюу Бурхан Чанараа харъя гэвэл өөр нүдээр, өөр ухамсраар харах хэрэгтэй. Энэ нүдийг бид билгийн мэлмий, тэнгэрлэг мэлмий, Христүүдийн нэрлэдэг цорын ганц мэлмий юм. Есүс “Хэрэв нүд ганц байвал, бүхий л бие Гэрлээр дүүрэн байх болно.” хэмээжээ. Энэ ямар учиртай вэ? Бид нүднүүдээ нийлүүлээд солир нүдтэй хүн шиг ганц болгох юмуу? Энэ тийм биш, бүр ингээд ч бид гэрэл харахгүй. Тэгэхлээр, Буддизмын судар айлдвар, Христийн Библи болон бусад сударт энэ махан нүдийг биш, харин бидний ухамсрын далай дахь, билиг ухаан доторх ганц мэлмийг дурджээ. Чухамдаа мэлмий гэж байхгүй. Харин бид Диваажингаас там хүртэлх, энэ дэлхийгээс Бурханы Орон хүртэлх бүх юмыг үзэж чаддаг болохоор түүнийг мэлмий гэж нэрлэдэг. Тэгэхлээр, энэ мэлмийг нээхийн тулд үүнийг хэрхэн хийх аргыг зааж чадах хэн нэгэн бидэнд хэрэгтэй, жишээ нь бид машин жолоодож сурахыг хүсвэл жолоо барихыг хэдийн мэддэг хэн нэгэн бидэнд туслах хэрэгтэй байдаг шиг.

Мөнхийн аз жаргалын эх булаг

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Шихү, Формоса, 1995 оны 6-р сарын 19 (Дүрс бичлэг №481)
(Эх нь Англи хэлээр)

Аз жаргалын цорын ганц эх үүсвэр нь дотоодод байдаг. Тиймээс бясалгах бүрдээ энэ эх сурвалжтай холбогдохыг хичээ. Энэ бол тархи гэгчийн дотор байрладаг ердөө ганц жижиг төв юм. Энэ нь тархины дотор бодитоороо байдаг. Жижиг мэдрэл болон төв бүхэн бидний оршихуй дахь - сэтгэл зүйн, сэтгэл хөдлөлийн, материаллаг гээд ямар нэг зүйлийг хариуцдаг. Харин өөр нэг нь бидний мөнхийн аз жаргал болон гэгээрлийг сүнслэгээр хариуцдаг. Энд нэг жижиг төв, тархины бараг голд биетээр байдаг. Эндээс (Их Багш духныхаа голд заагаад) бас эндээс (толгойн оройд) толгойн гуравны хоёр руу дотогшоо явна. Билгийн мэлмийн төв үнэхээр энд, дотор талд байх ёстой.

Тэгэхлээр билгийн мэлмийгээр харах үедээ та тэр төвтэй холбоо тогтоохыг хичээж байгаа хэрэг юм. Тэр байтугай ердөө хааяа ч гэсэн та тэнд хормын төдий ч болов холбогдох үед тэр дороо өөр мэдрэмж төрнө. Гэрэл ганц гялбаж харагдахад л та удаан хугацааны турш баяр хөөрийн мэдрэмжтэй байдаг. Мэдээж, та энэ төвтэй үргэлж холбоотой байж чадахгүй, эсвэл энэ төвтэй байнга ухамсартайгаар холбоотой байхгүй. Гэхдээ бясалгаж дадуулаад л бай. Дасгал дадуулалт Их Багш болгодог. Энэ бидний хийдэг зүйл. Би одоо болтол хийсээр л байдаг. Та бүхэнтэй “харилцах”-ын тулд аз жаргал маань надад хэрэгтэй! Хэрэв надад ажлаа үргэлжлүүлэхийн тулд ямар нэгэн зүйл өдөр бүр өгөх ийм баяр хөөртэй энерги байхгүй байвал би үхэх болно.

Та байнга үргэлжлүүлэн өгөөд байж чадахгүй. Та жирийн хүний биеийн бодит хүч чадлаар юмуу би үзлээр өгнө гэвэл хоосрох болно. Та сүнслэг бясалгал дадалдаа уруудах ба бүтэл муутай, гунигтай болно. Зарим гүрү гэгддэг олон хүн хэсэг хугацааны дараа муудсан, уруу дорой, уцаартай баргар болдог учир нь ийм юм. Эхэндээ тэд их цэвэр, их ариун, их гэгээнтэнлэг байсан байх. Гэвч тэдний бясалгалын арга зөв биш байсан, мөн тэднийг энэ үүрд өгдөг, мөнхийн ханамжтай төв рүүгээ (Их Багш билгийн мэлмийнхээ төв рүү дохив) чиглүүлээгүй учраас, тэд байсан бүхнээ хамгийн сайн санаагаар өгсөн, тэгсээр дараа нь сүйрчээ. Тэд нийгмийн дарамт, эргэн тойрны нөхцөл байдал гэх мэт бүх төрлийн урхи занга, уруу таталтад автан бууж өгсөн.

Гэвч эдгээр хүмүүс маш өрөвдмөөр юм. Хэрэв тэд ийм хүмүүс юм бол бид тэдний төлөө тун харамсана. Учир нь тэд өөрсдөө зогсох чадваргүй байж албадуулж гүйсэн. Тийм ч учраас тэд бүтэлгүйтсэн. Тийм учраас л та нарыг бясалгах ёстой гэж би үргэлж онцлон сануулдаг. Та нар сайн шавь болохдоо биш, үгүй, харин өөрсдийгөө аврахын төлөө юм.



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Шихү, Формоса, 1995 оны 6-р сарын 6 (Дүрс бичлэг №478)
(Эх нь Англи хэлээр)

Үргэлж, цаг ямагт анхааралтай бай, эс бөгөөс зүгээр л нэг өдөр, хоёр өдөр, гурван өдөр өнгөрөөн, өөрийгөө - хуурах байдлаар, муу зуришлдаа уягдан, ухамсрын өндөр түвшинд хүрэлгүй, сүнслэг амьдралын гүнзгий утгыг ойлгох чадваргүйгээр бүхий л амьдрал тань өнгөрөх маш амархан.



Будда, Бодьсатва, Нигүүлслийн Дара эх, Мария, Есүс гэх мэт төрөл бүрийн трансцендент хэлбэрүүд бүгд нэг Хүчнээс гаралтай. Тэд мэдрэхүйт-төрөлтний таашаалд нийцүүлэхийн тулд байнга өөрчлөгдөж байдаг. Тэд Газар Дэлхийн өнцөг булан бүрт байгаа мэдрэхүйт төрөлтнийг гэтэлгэхийн тулд өөр өөр хэлээр ярьдаг.

~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Билгийн мэлмийдээ ямагт төвлөр


Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Флорида төв, АНУ, 2001 оны 6-р сарын 9 (Дүрс бичлэг №719)
Хян Зүгийн яриа, Шихү, Формоса, (Эх нь Хятад хэлээр)

Асуулт: Бид хэн нэгний билгийн мэлмий рүү харвал тэдэнд ч бас сайн гэж Таны хэлснийг дүрс бичлэгээр сонссон. Үүнийг хийх надад үнэхээр сайхан санагдсан, тэгэхээр үүнийг санана гэдэгтээ итгэлтэй байна. Энэ бусад хүмүүст хэрхэн тус болохыг сайн ойлгож авахыг хүсэж байна.

Их Багш: За, та хийж байгаа зүйлээ мэдэж байгаа тэр үе юм. Хэрэв та билгийн мэлмийг хэдийн бодож байгаа бол та өөрөө билиг ухааны болон гэгээрлийн сүнслэг төвийг өөртөө сануулж байна гэсэн үг. Мөн хэрвээ та өөрөө үүнийг дурсан санаж байгаа бол, мэдээж таны уур амьсгал сүнслэг байх болно. Тэгэхлээр тэр хүн танаас мэдээж ач тус хүртэнэ. Энэ нь усан оргилуурын дэргэд зогсож байхтай төстэй: та тийшээ шууд үсрээд орчихгүй ч нүүр лүү тань ус үсэрч та сэрүүцнэ. Түүнтэй адил, үнэртэй ус цацаж байгаа хүний дэргэд зогсоход та өөртөө түрхээгүй ч танд үнэр нь үнэртэнэ. Тэгэхээр та бол чухал. Та ямар л байна, нөгөө хүн тиймээр хүлээж авах болно. Тийм учраас бид сүнслэг төвийн талаар, жинхэнэ Би-гийнхээ талаар ямар нэгэн зүйл санаж дурсаж байхад дэргэдэх хүн ач тус хүртэж байдаг. Энэ ингэж л ажилладаг.

(Эх нь Англи хэлээр)

“Адамыг бүтээсэн нь” уран зургийн нууц



Микеланжелогийн сонгодог бүтээл
“Адамыг бүтээсэн нь”



Адамыг бүтээсэн нь уран зургийг хүний тархины зурагтай давхцуулан харахад, сахиулсан тэнгэрийг хүрээлж буй хошиг нь тархины гадуур шугамтай яг нарийн давхцаж байгаа нь харагдаж байна, мөн билгийн мэлмийн байрлал нь Бурханы зүүн ташаа байгаа цэг орчимд байрлаж байна.

Италийн уран барималч, зураач, архитекторч, яруу найрагч Микеланжело нь Леонардо да Винчи болон Санцио Рафаэл нарын хамт Сэргэн мандалтын үеийн гурван алдарт зураач гэдгээрээ алдартай. Түүний олон бүтээлийн дунд “Адамыг бүтээсэн нь” уран зураг олон нийтэд танигдаж дэлхий даяар ихэд үнэлэгдсэн бөгөөд

Үүсэл гарлын Ном (Book of Genesis)-ноос сэдэвлэсэн ханын цуврал зураг - анхны сонгодог сэдэвлэсэн ханын цуврал зураг - анхны сонгодог бүтээлийнх нь маш чухал хэсэг юм. Бурхан Адамыг бүтээж байгааг дүрсэлсэн зургаа тэр дөрвөн жил зуржээ. Бурханы гарын хуруунууд нь шинэхэн бүтээсэн Адам руу сунаж, Адам газарт хэвтээгээр түшсэн, хүч чадалгүй байдалтай,



Хүний тархины
хөндлөн
огтлолын зураг:
Тойрог нь
боргоцой
булчирхай
буюу билгийн
мэлмийн
байрлалыг
үзүүлжээ.

Бүтээгчээс амьдрал ба хүчийг авахаар хүлээж байх агшинд Түүнийг сахиулсан тэнгэрүүд тойрон хүрээлсэн байгааг үзүүлжээ.

Эрт цагаас, хүмүүс Үүсэл гарлын Библийн Номд бичигдсэн тохиолдлуудтай танил байсан. Ийм маягаар Адамыг бүтээснийг талархан, тэд шинэ төрсөн Адамаас гэрэлтэх залуухан эрүүл, гоо сайхныг бишрэн, мөн эсрэгээрээ нэлээд хөгшин харагдах Бурханаас цацарч байгаа билиг ухаан, өршөөлийг таашаан татагдсан байна. Гэсэн хэдий ч, бид сүнслэг бясалгагчийн зүгээс энэ зургийг судлах юм бол түүний ард маш гүн гүнзгий утга учир нуугдаж байгааг нээн илрүүлж гайхан шагсрах болно. Микеланжело нь “Адамыг бүтээсэн нь” бүтээлээрээ билгийн мэлмийн далд нууцыг илрүүлэхийг хичээж байсан! Энэ зураг дээр Бурханыг хүрээлэн буй сахиулсан тэнгэрүүдийг анхааралтай ажиглах юм бол, сахиулсан тэнгэрүүдийн гадуурх шугам нь хүний тархины нарийн тодорхой жишиг зураг юм гэдгийг харж чадна. Сахиулсан тэнгэрүүдийг тойрсон хөшиг нь тархины хөндлөн огтлолын дүрсийг тодорхой илэрхийлжээ. Бурхан баруун гараа сунгахад тархи (сахиулсан тэнгэрүүдийг тойрсон хөшиг)-тай огтлолцож байгаа тэрүүхэн хэсэг бол духны цохыг - Их Багшийн бидэнд анхаарлаа хандуулахыг байнга сануулдаг тэр цэгийг илэрхийлж байна. Зураг дээр энэ цэгээс ахиулан явсаар Бурханы зүүн ташаа орчимд ирэхэд хүний тархины боргоцой булчирхай байна – энэ бол билгийн мэлмий байгаа байршил юм. Бурхан хүнийг бүтээсэн цагаасаа эхлэн энэ дэлхийд билгийн мэлмийгээр хүн төрөлхтөнтэй үргэлж харьцсаар байсныг; Бурханаас заяасан амьдрал ба хүч чадал ч мөн адил эгэл хорвоо дэлхийг Диваажингийн Хаант улстай холбодог энэхүү нууц гарцаар мөн дамждаг гэдгийг Микеланжело ингэж туйлын уран мэргэн бөгөөд зүйрлэн илчилж энэхүү ханын уран зургаа бүтээжээ.

Бид бол Бурханы сүм гэж Библид хэлсэн байдаг. Микеланжело өөрийн уран зурагтаа Бурханы титмийн байрлалыг зааж, орчлонгийн мөнхийн далд нууцыг энэ дэлхийд илрүүлэх бас нэг алхмыг хийсэн юм. Түүний олон салбарын ер бусын онцгой авъяас болон уран бүтээлийн амьдралын замналыг нь шүүн тунгаахдаа бид Микеланжело бол аль хэдийн, таван зуун жилийн тэртээ Бурханы сүмийг олж нээгээд,

Диваажингийн Хаант улсын шавхагдашгүй үнэт эрдэнэсийг олж эзэмшсэн юм байна гэж таамаглах боломжтой юм.

Нууцлаг Боргоцой булчирхай

Формоса дахь Мэдээний баг эмхэтгэв.

“Боргоцой булчирхай” гэдэг нэр томъёог дурдахад л нууцлаг аура үүсгэдэг. Францын алдарт философич, сэтгэл судлаач, физикч, байгаль судлаач бөгөөд математикч Рене Декарт (1596-1650) боргоцой булчирхайг “сүнсний суудал” гэж нэрлэсэн. Өөр хүмүүс энэ бол “амьдралын код”-ыг тээж явдаг Төв бөгөөд бие махбодод тушаал зааврыг дамжуулдаг гэж итгэдэг. Сүүлийн үеийн онолын судалгаагаар боргоцой булчирхай нь нүдэнд байдаг торлог бүрхэвч шиг ажилладаг гэрэл мэдрэгч эсүүдийг агуулдаг гэсэн нээлт хийсэн бөгөөд энэ нь боргоцой булчирхай “харж” чаддаг гэсэн баримтыг нотолж байна. Тиймээс үүнийг “гуравдагч нүд” гэж нэрлэдэг. Боргоцой булчирхай мелатонин ялгаруулдаг тухай орчин үеийн судалгаа нь түүний нууцыг ямар нэг хэмжээнд тайлсан байна.

Боргоцой булчирхай ба мелатонин

Боргоцой булчирхай нь хавтгай, буурцгийн хэмжээтэй шовгор дүрстэй эрхтэн бөгөөд дунд тархины төвд байдаг. Энэ нь бага насанд хамгийн том хэмжээндээ хүрдэг боловч нас ахих тусам шохойжиж, агшдаг.

Боргоцой булчирхайнаас ялгарах мелатонин нь хүлээж авсан гэрлийн хэмжээгээр тодорхойлогддог, учир нь энэ булчирхай гэрэл мэдрэмтгий, нойрны мөчлөгийг зохицуулдаг тул биеийн цагны үүрэг гүйцэтгэдэг. Шөнийн унтлагын цагаар, бие дэх мелатонины түвшин ихэсдэг, 23 цагаас шөнийн 2 цагийн хооронд оргил хэмжээнд хүрээд үүр цайхад илт зогсдог.

Мелатонин ялгаруулалт нь хүний наснаас хамаардаг, төрөөд гурван сартайгаас эхлэн өсөж зургаан нас хүрэхэд оргилдоо хүрээд, бэлгийн хөгжлийн дараа зогсож эхэлдэг.

Хүний биед мелатонины үр нөлөө

Мелатонин нь энгийн химийн бүтэцтэй, гэхдээ биеийн эрхтэн, булчирхайнуудыг хянан шинжиж, гормоны ялгарлыг зохицуулан, хүний биеийн үйл ажиллагаанд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Мөн зүрхний цохилтыг удаашруулж, цусны даралтыг бууруулахын тулд симпатик мэдрэлийн хэт их өдөөлтөд хяналт тавьж, ингэснээр зүрхэнд үзүүлэх нөлөөг хязгаарладаг. Бас сэтгэл санааны түгшүүр хямралыг намдаан тайвшруулж, нойрыг сайжруулж, биеийн биологийн цагийг тохируулна, бие махбодын хоногийн хэмнэл алдагдахыг арилгана, дархлааг хүчтэй болгож, нян вирусийн эсрэг биеийн эсэргүүцлийг ихэсгэх ба хорт хавдар, зөнөглөлөөс сэргийлнэ.

Мелатонин ялгаралт нь цусны судсыг агшаан, мэдрэл дамжуулагчийн үүрэг гүйцэтгэдэг серотонин гэдэг химийн бодистой урвуу пропорциональ хамааралтай. Хүний бодол санаа өдрийн цагаар хамгийн эрчимтэй байдаг ба хяналтгүй болж анхаарал сарних үед мэдрэлийн эсүүдийн шаардлагаар серотонины хэмжээ өсдөг. Шөнө эсвэл бясалгалын явцад бодол санааны идэвх багасахад серотонин багасаж, мелатонин ихээр ялгарч, нөхцөл байдал өөрчлөгддөг. Хэдий тийм боловч нүд гэрэл мэдрэх үед мелатонины ялгарал буурна. Шөнийн ажилчид болон гэрэлтэй унтдаг тэдгээр хүмүүс өвчний эсрэг дархлаа багатай болж, хавдраар өвчлөх нь бусдаас илүү байдаг.

АНУ-д хийсэн хоёр судалгаагаар хурц тод гэрэл мелатонин ялгаралтыг багасгадаг ба эмэгтэйчүүдэд эстрогены ялгаралтыг албадаж, шөнийн ээлжийн ажилтай эмэгтэйчүүдийн хөхний хавдрын тохиолдлыг ихэсгэдэг нь харагдсан. Нялхсын гэнэтийн үхлийн синдром (SIDS)-оор нас барсан нялхсыг судалсан судалгаагаар нялхсын боргоцой булчирхай нь дутуу хөгжсөн байснаас болж мелатонины ялгарах түвшин багасаж, чөлөөт радикал (хослоогүй электронтой молекул) зохицуулах тархины чадварыг сулруулсан, ингэснээр тархийг чөлөөт радикалийн хор хөнөөлд эмзэг өртөмхий болгодог гэдгийг олж тогтоожээ. Хүүхэд болон насанд хүрэгчдийн дунд, санаа дагаж өвдөх эмгэгийн талаар хийсэн өөр нэг судалгаа нь сэтгэл мэдрэлийн өвчтэй хүмүүсийн мелатонины түвшин эрүүл хүмүүсийнхээс бага байгааг сануулсан.

Мелатонины эх үүсвэр

Мелатонин нь овъёос, чихэрлэг эрдэнэ шиш, цагаан будаа, цагаан гаа, улаан лооль, гадил, арвай зэрэг олон хүнсний ургамалд багахан хэмжээгээр агуулагддаг. Хүрэн замаг, шар буурцаг, хулууны үр, тарвасны үр, бүйлсний самар, газрын самар, талхны хөрөнгө, амуу соёолж зэрэг хоол хүнсийг хэрэглэх нь биеийн мелатонин ялгаралтыг өсгөхөд тусалдаг.

Хоол хүнс бага хэрэглэх нь мелатонины хэвийн түвшинг баталгаажуулна. Судалгаагаар, бага хоол өгсөн хөгшин хулгануудын боргоцой булчирхай нь залуу хулгануудынх шиг эрүүл байсан ба мелатонин ялгарлыг тогтмолжуулж чадаж байсан. Тэдгээр хулганы мелатонины хэмжээ залуу хулганад байдаг хэмжээний 80 хувь байсан бол хоолыг нь хязгаарлаагүй хөгшин хулганы мелатонины түвшин 40 хувь байсан байна.

Дүгнэлт

Хэдийгээр мелатонин хүний биед чухал үр нөлөөтэй боловч эрүүл мэндэд мелатонины нэмэлт хангамж ач тустай эсэх талаар тодорхой дүгнэлтэд хүрээгүй байна. Судалгаагаар, бясалгал хийдэг эмэгтэйчүүдийн мелатонины ялгаралт илүү өндөр байгаа нь харагдсан. Хөлийн эрхий хурууны дасгал мелатонин ялгаралтыг ихэсгэдэг. Өдөр хийсэн биеийн тамирын дасгалууд мелатонины түвшинг ихэсгэдэг ба шөнө хийх нь эсрэг үр дүнтэй. Тийм учраас, бага ид, бясалга, өдрийн гэрэлтэй үед тогтмол дасгал хий, сахилга баттай амьдралаар амьдар гэж зөвлөж байна.



Хэрэв бид үргэлж Диваажинд байж, ямагт Бурхад байгаад байх юм бол өөрсдийгөө Бурхан гэж ухаарч таньдаггүй. Тиймээс бид өөрсдийн аугаа байдлаа дахин таньж мэдэхийн тулд өөрсдийгөө доошлуулж, энэ физик түвшинд бууж ирэх хэрэгтэй болдог. Энэ бол бидний сонголт, ийм учраас бид энд ирсэн.

~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Бүлэг 5

*Шинжлэх Ухаан ба Сүнслэг
хөгжил, тэдгээрийн нийцэл*

Хувьсал хөгжил

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Австралийн Брисбейн хот, 1993 оны 3-р сарын 22 (Дүрс бичлэг №338)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Хүндэт Их Багш аа, хувьсал хөгжлийн талаар нэг асуулт миний санааг зовоосоор удаж байна. Хувьсал хөгжлийн тухай хязгаарлагдмал мэдлэгээрээ би олон жил багшилж байгаа ч оюутнуудын асуултад яаж хариулахаа мэдэхгүй байна. Миний асуулт бол Газар Дэлхий дээрх амьдрал нь бидний нийтлэг өвгө дээд үеэсээ уламжлан хувьсан хөгжиж, олон хэлбэр маяг авсан юм уу эсвэл Бурхан бүгдийг тэр үед бүтээсэн юм уу?*

Би шашны ба шинжлэх ухааны мэдлэгийн хооронд ихэд будилж байна. Шашны итгэл үнэмшил дээр зогсвол Бурхан юм бүгдийг бүтээсэн гэж би хэлнэ. Тэгвэл бид гэртээ харьж унтъя; цаашаа ямар ч асуулт алга. Харин шинжлэх ухааны зүгээс тайлбарлавал, яг Чарльз Дарвины санал болгосон шиг, бид нийтлэг өвгө дээдсээсээ салаалсан гэсэн нэг ойлголттой байна. Ингээд би ядмаг мэдлэгээрээ үүнд хариулж чадахгүй байна. Диваажингийн мэдлэгтэй аугаа Их Багшийгаа хүлээх хэрэгтэй байна гэж би оюутнууддаа хэлсэн. Би та нарт энэ тухай хожим тайлбарлаж чадах байх гэсэн.

Их Багш: Шашин ба шинжлэх ухаан зөрчилдөхгүй гэдгийг та харж байна. Тэд янз бүрийн л нэр томъёо ашигладаг. Заримдаа шинжлэх ухаан бүх зүйлийн үндсэн зарчмуудыг зааж хэлдэггүй эсвэл тэд олж мэдээгүй байдаг. Жишээлбэл, надад, танд байдаг яг адилхан бодис (элемент) бүх зүйлд - ургамал, мод гээд бүгдэд нь мөн л оршиж байдаг гэж шинжлэх ухаан хэлдэг. Шашин, жишээ нь, Христэд итгэгч нар юмс бүгд нэг мөн чанараас, Бурханаас бүтээгдсэн гэж хэлдэг. Буддын шашинд бүх төрөлтөн Будда чанартай гэж хэлнэ. Тао шашинд бид бүгдээрээ нэгэн цогц гэж хэлнэ. Энэ нь танд, надад байдаг бодисууд мөн ургамал, ой, мод гээд бүгдэд нь байдаг гэж шинжлэх ухаан хэлдэгтэй адилхан.

Харин юу бидний элементүүдийг хөдөлдөг, ярьдаг, боддог болгодог вэ? Элементүүд мод, ургамлыг ярьдаг болгоогүй. Мөн хэрвээ бүх зүйлд адилхан элементүүд байгаа юм бол, мэдээжийн хэрэг, энэ хөдөлгөөнийг хийхэд бидэнд мөн ижил хүч хэрэгтэй. Энэ зөв үү? Тийм ээ! Тиймээс л үнэндээ бид бүгдээрээ Бурханаар бүтээгдсэн юм. Та үүнийг Бурхан эсвэл сансрын энерги гэж нэрлэж болно, аль нь ч зүгээр. Хамгийн эхэнд зөвхөн сансрын энерги л байсан. Үүнийг Бурхан юмуу эсвэл Будда чанар гэж нэрлэх хэрэггүй; тэгвэл олон хүн будилна. Бид шинжлэх ухааны нэр томъёогоор ярья. Бүх мэргэн ухааны үр, мөн өргөжиж, өсөх чадвартай бүх материйн үр бүхий сансар огторгуйн энерги унтаа байдалд байсан. Гэвч сансар огторгуйн энерги дотроо бага зэрэг өдөөгдөхөд үүний дагуу бүх үр нь соёолж, өнөөгийн оршиж байгаа бүх зүйл болжээ. Тиймээс бид тэрийг Бурхан гэж нэрлэж болно, эсвэл Будда чанар гэж нэрлэж болно.

Хэрвээ өөрийнхөө оршихуйн эх сурвалжийг мэдэхгүй бол бид сансрын хуульд нийцэн амьдрахгүй бөгөөд энэ бидэнд асуудал тарина. Тийм учраас л бид одоо энэ бүх оюун ухааны эх үүсвэрийг олохыг хичээн бясалгаж, бодож цэгнэх хэрэгтэй. Бид түүн рүү эргэх юм бол, эсвэл ядаж түүнтэй нийцэн зохицвол, бидний амьдрал бүх сансартай илүү таарч нийцнэ, тэгвэл бид аз жаргалтай байна! Бидэнд ямар ч саад бэрхшээл байхгүй болно. Бид хаа сайгүй жолоодох биш харин зохих эгнээгээр, зөв хурдаар жолоодно. Энэ нь шинжлэх ухаантай огт зөрчилдөхгүй. Харин шинжлэх ухаан бүх зүйлсийг хөдөлгөдөг тэр хүчийг зааж хэлж өгдөггүй байх.

Шинжлэх ухаан, танд, надад болон бүх зүйлд байдаг элементүүд, материйн талаар л ярьдаг. Энэ тухайд тэд гайхалтай их зүйлс нээчихсэн байгаа. Гэхдээ тэд ямар ч бодисгүй зүйлийг шинжлэх ухааны аргаар яаж олж илрүүлэх гэж? Энэ бол бидний бүх зүйлийг хөдөлгөдөг сансрын хүч бөгөөд сүнс гэж нэрлэгддэг бид түүний нэг хэсэг юм; энэ сансрын хүчний нэг хэсэг.

Аугаа их өдөөх хөдөлгөөний тэр цагт юмс нь энэ сансрын эргүүлгийн төв хүчнээс хэр хол байснаас хамааран янз бүрийн ялгаатай оршихуй болж ирдэг. Тийм учраас бид дүрс хэлбэр, хэмжээ, энерги, билиг ухаантай, бодох ба хөдлөх чадвараараа ялгаатай байдаг. (Алга ташив) Тиймээс бүх юм буцаад тэрхүү төв хүч рүүгээ буцаж очно, ингээд тэд хувьсан хөгжинө. Хэрвээ тэд улам ойрхон ирэхийг хүсвэл илүү ухаантай байх ёстой болно, яагаад гэвэл тэр төв дээр билиг ухаан байдаг. Тиймээс л тэд хувьсаж хөгждөг. Энэ бол хувьсал хөгжлийн шалтгаан юм, ойлгов уу. Тэд хувьсаж хөгжих хэрэгтэй, улам ухаантай, улам аугаа, илүү ухаалаг болсоор л болсоор л байх болно, тэгснээр тэд төв рүү дөхөж ойртож чадна, яагаад гэвэл төв бүх юмыг буцаан татаж, тэгээд дараа нь дахин гадагш нь түлхдэг, үргэлжид хувьсаж хөгжиж байдаг аугаа их соронзон хүчтэй.

Гэхдээ заримдаа энэ сансрын хүч ч бас амарч, бүх зүйл зогсох болно. Тэгээд дахин сэрэх үед бүх зүйл ажиллаж эхэлдэг. Ийм зүйл олон эрин галав дамжин болдог. Эдгээр зүйлийг тайлбарлах надад жаахан хүндрэлтэй юм, гэвч миний хэлснийг ойлгохыг зүгээр л хичээгээрэй.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Австралийн Брисбейн хот, 1993 оны 3-р сарын 22 (Дүрс бичлэг №338)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: Хэрэв Бурхан орчлонг болон Газар Дэлхийг бүтээсэн юм бол, орчлон Газар Дэлхийгээс өмнө бүтээгдсэн үү, эсвэл нэгэн зэрэг бүтээгдсэн үү?

Их Багш: Орчлонд их олон газар дэлхий байдаг. Бид зөвхөн ганцаараа биш. Та зочлох цаг гаргаж болно! Тиймээс бид Үл таних нисдэг биет (UFO) гэх мэт олон зүйлс хардаг. Эдгээр нь тодорхой зүйлс юм. Хүмүүс ба амьдрал бүхий, биднийхтэй адилхан олон газар дэлхий байдаг. Эрдэмтэд заримыг нь хальт үзсэн л байдаг, гэвч тэд түүнийг илчилж хэлээгүй байна, учир нь тэдэнд нотлох баримт дутаж байгаа, мөн гарагууд асар хол байна, тэд энэ нь юу вэ? гэдэгт итгэлгүй байна. Эдгээр гарагийн зарим нь Газар Дэлхийтэй төстэй; бидэн шиг хүмүүстэй, маш их газар тариалан гэх мэт зүйлтэй байдаг. Бусад гарагууд Газар Дэлхийтэй адилгүй. Тэдгээр нь илүү сүнслэг гарагууд, тэнд хүмүүс байдаг боловч сахиулсан тэнгэрүүдэрхүү, бидний нүцгэн нүд, эрдэмтдийн нүд, мөн бүх дуран авайн нүдэнд үл үзэгдэх юм. Тиймээс бид сүнслэг биеэрээ тэдэн дээр зочилж, сүнслэг нүдээ ашиглан тэдэнтэй холбогдох буюу тэднийг харах хэрэгтэй. Үүнийг эрдэмтэд хийж чадахгүй л байна. Жишээ нь өчигдөр, уржигдар ирсэн нэлээн хүмүүс маш гоё газар, цайз шилтгээн, бас хүмүүсийг харлаа гэж хэлсэн, гэвч Газар Дэлхий дээр биш. Бид хангалттай дадлагажвал ямар нэгэн гараг руу гэрлээрээ аялж чадна. Гэвч энэ нь бидний жинхэнэ зорилго тэгээд ч биш юм. Юу ч байж болно, бид тийм тусгай зүйлс сонирхохгүй.

Шинжлэх ухаан, сүнслэг хөгжил ба тэдгээрийн нийцэл

АНУ-ын Мэдээний баг
(Эх нь Англи хэлээр)

“Чин Хай” гэж нэрлэгдсэн эрдэмтэн дэлхийн болон Орчлонгийн нууц далд явдлуудыг өгүүлж буй олон төрлийн дүрст болон дуу авианы бичлэгтэй лекцүүдийг та сонсвол гайхан шагшрах болно. Түүний үгс Есүс: **“Та эхлээд Бурханы хаант улсыг эрж ол, тэгвээс юм бүхэн дагаад ирэх болно.”** гэж хэлснийг баталдаг. Их Багш Чин Хай их сургуулийг хэлний мэргэжлээр дүүргэжээ, гэвч бүрэн гэгээрснийхээ дараа Тэрээр Орчлонгийн гарал үүслийг энэ гарагийн ямар ч физикчээс илүү тайлбарлаж чадаж байна. Шинжлэх ухаан, шашны хооронд зөрчилдөөн байхгүй, шинжлэх ухаан нь гэгээрсэн хүмүүсийн хэдийн мэддэг зүйлийг батлахыг оролдож байна, бусад гарагийн шинжлэх ухаан манайхаас тэрбум, их наяд дахин илүү хөгжсөн гэж Их Багш хэлжээ.

Их Тэсрэлтийн Онол

Бүх цаг хугацаа, орон зай агуулагдаж байсан ганц нягт цэг буюу - “Онцгой цэг” (Singularity) гэнэт гадагшаа жижиг бутархай галт бөмбөлгүүд болон тэлэн дэлгэрч, улмаар одоогийн галактикууд, одод, гарагуудыг хэлбэржүүлсэн гэх “Их тэсрэлт” - ээр энэ орчлон эхэлсэн хэмээн Америкийн Одон орон Судлалын Нийгэмлэгийн жил тутмын өвлийн уулзалтын үеэр нэр хүндтэй одон орончид дүгнэсэн талаар Индианаполис Стар сонинд (1998 оны 1-р сарын 15) нийтэлжээ. Гэвч эрдэмтэд тэрхүү “Онцгой цэг” гэж юу болох, Их тэсрэлтийн дараа юу болохыг мэдэх тал дээр амжилт олоогүй байна. Орчлон үүрд тэлэх үү эсвэл сүйрэх үү, эсвэл "Их хямрал" (Big Crunch) буцаж ирэх үү?

Нэгэн онолоор орчлон ертөнц хэзээ нэгэн цагт анхныхаа үүсэл рүү буцаж агших болно гэж үздэг.

1993 оны 4-р сарын 21-нд Швейцарт лекц унших үеэр нь Их Багш Чин Хайгаас Газар Дэлхийн уг сурвалжийн талаарх шинжлэх ухааны “Их тэсрэлтийн онол”-ыг зөвшөөрч байна уу гэж асуухад Тэр “Тийм ээ, би зөвшөөрч байна. Гэвч эрдэмтэд аливаа зүйлийн зөвхөн материаллаг болон биет талыг тайлбарладаг. Тэд Их тэсрэлтийн цаана байгаа үл үзэгдэх хүчийг, жинхэнэ мөн чанарыг олж нээгээгүй байна. Гэвч энэ нь бас сүнслэг үзэл бодол ба бүтээлийг ойлгоход тусална.” гэж хариулжээ.

1993 оны 3-р сарын 22-нд Австрали улсын Брисбейн хотод асуулт, хариултын хурал дээр, Их Багш орчлон ертөнц хэрхэн үүссэн талаар тодорхой тайлбар өгчээ. Шинжлэх ухааны нэр томъёогоор “Онцгой цэг” гэдэг зүйл нь Бурхан, билиг ухаан, эсвэл сансрын энерги юм. Энэ билиг ухааны төв хүч нь хөдөлж байх үед түүнээс төрөл бүрийн хэлбэр, хэмжээтэй, энерги, билиг ухаантай, хөдөлж сэтгэх чадвартай бүхий л хэлбэрийн бүтээл бий болдог. Учир нь энэ төв нь асар их "соронзон хүч"-тэй, бүх зүйл төвийн хүч рүүгээ эргэн ирнэ, ингэж дахин хувьсаж хөгжинө. “Онцгой цэг” нь бидэнд хувьсан хөгжиж, өсөх боломж өгөн аль хэдийн олон удаа тэлсэн ба агшсан. Мөн Их Багш 1994 оны 9-р сарын 26-нд Сингапурт айлдвараа хэлэх үеэрээ шинжлэх ухааны хэлээр бол энэ процесс “Их тэсрэлт”-ийн онолтой их төстэй, харин үүнийг хүний хэлээр ойлгуулах тун бэрх юм гэж тайлбарласан билээ.

Шашингүй үзэлтний эргэлзээ

Метан, аммони, нүүрсхүчлийн олон исэл, нүүрс хүчлийн давхар исэл, устөрөгч, усны уурын “пребиотик” шөл дэх молекулуудын санамсаргүй мөргөлдөөний үр дүнд Газар Дэлхий дээр амьдрал үүссэн гэдгийг нотлохыг оролдож эрдэмтэн

Миллер, Урей нар 1950-иад оны алдартай лабораторийн туршилтаар энэ нөхцлийг сэргээжээ. Цахилгаан гүйдлийн оч гялбаа (цахилгааныг эрчимжүүлэх учиртай) нь уургийн барилгын материал болох амин хүчлийг бий болгосон.

Гэсэн хэдий ч Сэр Фред Хоел хэдийгээр шашингүй үзэлтэн боловч дээрх туршилтаас гаргасан дүгнэлттэй санал нийлээгүй бөгөөд Дэлхий дээр амьдрал санамсаргүй байдлаар үүссэн байх боломжгүй гэж үзэж байна. Дезоксирибонуклейн хүчил (ДНХ/DNA) нь физикийн хуулиудаар үүснэ гэхэд дэндүү нарийн бөгөөд жигд бус юм. Орчлон ертөнц бүхэлдээ анхдагч шөл (primordial soup)-өөс бүрдсэн байдаг ч бай, нэгэн санамсаргүй тохиолдол нь амьдралыг үүсэхэд хүргэж чадахгүй байсан гэж Хоел дүгнэжээ. Түүний хэлснээр санамсаргүй үйл явдлууд амьдралын хэв маягийг бий болгох магадлал нь "хогийн цэг дундуур хар салхи шуурч, Боинг 747 онгоц бүтээхтэй адил" аугаа юм. Францис Крик (Генийг нээгчдийн нэг) болон бусад олон эрдэмтдийн хамт Хоел амьдрал хаа нэгтээ өөр гараг дээр үүсэж, ийшээ тээвэрлэгдэж ирсэн гэж одоо үздэг. Гэсэн хэдий ч Хоел болон бусад хүмүүс тэрхүү нөгөө гараг дээр амьдрал хэрхэн үүссэнийг тайлбарлаж чадахгүй байна!

Орчин үеийн физикийн нээлтүүд

Орчин үеийн физикийн онолын нээлтүүд нь шашин, шинжлэх ухааны хоорондын нийцлийн өөр нэгэн сайн жишээ гаргаж өгч байна. Молекулын шинжлэх ухаан хөгжсөнөөр хүмүүс энэ дэлхийн материаллаг юмсын тухай ойлголтоо өөрчилж эхэлсэн. Янз бүрийн цул хатуу биет юмс жинхэнэдээ “цул хатуу” биш бөгөөд энэ дэлхийн бүх юмс хоорондоо том зайтай янз бүрийн молекулаар бүтээгдсэн гэдгийг ойлгож мэдсэн. Физикийн ухаан улам хөгжих хэрээр хүмүүс орчлонгийн бараг тоймгүй олон төрлийн молекулууд нь тоолж болохуйц атомуудаас бүтээгдсэн ба атом нь электрон, протон, нейтрон гэх зэрэг хязгаарлагдмал төрлийн бөөмсөөс бүрдсэн гэдгийг мэджээ.

Хүн төрөлхтөний материаллаг ертөнцийг үзэх үзэл нь ХХ зууны эхээр квантын механиктай танилцсанаар дахин эрс өөрчлөгдөв. Квантын механик материаллаг ертөнцийн үндсэн бөөмсүүд нь “бөөмс” биш харин янз бүрийн чичирхийллийн төлөвт байгаа долгион буюу энерги юм гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, бидний харж мэдэрч байгаа аяга, сав зэрэг юмс оршдоггүй, тэд ердөө л аяга, сав гэж бидэнд мэдрэгдсэн тодорхой давтамжтай энерги юм. Нэг үгээр хэлбэл, энэ дэлхийн бүх эд юмс хуурмаг бөгөөд чичиргээт энергигэс бүрдсэн байгаа юм.

Энэ нээлт нь Аугаа Их Багш бидний энэ ертөнц бол хий хуурмаг гэж хэлсэн сургаалтай нийцэж байна. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай 1994 оны 1-р сарын 1-нд Тайландад тавьсан лекцдээ “Бид дотогшоо харах (бясалгах) юм бол юу ч олохгүй; ямар ч физик биет, эд юмсыг олохгүй; харин жинхэнэ оршин тогтнол, жинхэнэ энергийг олно. Бид тэндээс ирсэн тэр газар юм. Бид өөрсдийгөө энэ махбодон бие гэж үзэхгүй байх аваас, тэндээс л ирснээ ухаарч мэдэх болно. Энэ бол юм бүхэн үүсч гарсан жинхэнэ энерги мөн.....” гэж хэлсэн.

Бүх юмс аугаа их Аялгуу (Дао, Үг эсвэл Чичиргээ гэдэг) –наас бүтээгдсэн гэдэг сүнслэг сургаалтай энэхүү Квантын механик нь мөн л нийцдэг. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай 1986 оны 3-р сарын 6-нд Формоса-гийн Тайбэй хотод тавьсан лекцдээ дараах тодорхой тайлбарыг өгсөн: “Энэ Аялгуу нь бүтээл эхлэхэд оршиж байсан. Энэ Аялгуу оршин гарч ирэхэд юм бүхэн оршин гарч ирсэн. Энэ Аялгуу бол Бурхан; энэ Аялгуу бол Бүтээл. Орчлонгийн бүх зүйл энэ Аялгуугаар хамтдаа холбогддог. Дээрээс доошоо бүх л ертөнц энэ Аялгуугаар дамжин бие биетэйгээ холбогддог. Орчлонгийн бүх юмс, чулуу, ургамал, эсвэл хүмүүс, өөрсдийн онцлог давтамжаар чичирхийлж байдаг.”

Дээрх жишээнээс бид материаллаг шинжлэх ухаан нь сүнслэг ухаандаа хамаарч багтаж байгааг харж чадлаа. Ихэнх эрдэмтэд анхаарлаа зөвхөн материаллаг түвшинд хандуулдаг, мөн хэдийгээр олон гайхалтай нээлт хийсэн ч тэдний нээж илрүүлж чадах боломжтой зүйлс нь хязгаарлагдмал юм. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай нэг удаа хэлсэн шиг “Эрдэмтэд зөвхөн материйг л нээсэн. Тэд бүх л энергийг матери гэж нээсэн, харин энергийн ард байгаа уян хатан оюун ухааныг нээгээгүй.

Тиймээс энд ялгаа байна. Хүмүүс энергийг амьдралаа илүү тав тухтай болгох, мөн амьдралаа тэтгэх хэрэгсэл болгож ашигладаг. Харин тэд энергийн ард уян хатан оюун ухаан, билиг билгүүн байдаг гэж мэддэггүй.” (Харвардын Их Сургуульд 1989 оны 10-р сарын 27-нд айлдсан лекц)

“Арьяабалын Аргад нэгэн түлхүүр, арга хэрэгсэл бий, тэрүүгээр та өөр газар сурахаар очиж чадна.” (Формоса дахь Жяи хотод 1989 оны 1-р сарын 16-нд тавьсан лекц) “Одоо цагт манай Газар Дэлхий дээр дэвшиж хөгжсөн шинжлэх ухааныг сургадаг шинжлэх ухааны сургууль байхгүй л байна. Тиймээс та Арьяабалын Аргаар бясалгах хэрэгтэй, тэгвэл билиг ухаанаа аажмаар хөгжүүлнэ. Эсвэл та сурахаар өөр гараг уруу явж чадна, тэгснээрээ буцаж ирээд дэлхийдээ үйлчилж чадна.” “Өөр гарагаас аугаа эрдэмтэд машин зохион бүтээж, биднийг янз бүрийн салбарт боловсролтой болгохоор энд ирдэг ч, бид өөрсдийгөө урьдчилан дээшлүүлэн хөгжүүлж бэлдэх л хэрэгтэй. Бид өндөр түвшинд билиг ухаанаа бэлтгэсэн байх хэрэгтэй, тэгвэл л бид тэдний сургах шинжлэх ухаан, мэдлэгийг эзэмшиж чадах болно. Юу ч байсан, бид билиг ухааныг хөгжүүлж, тэтгэхийн тулд билиг ухааны аргыг бясалган дадуулах хэрэгтэй. Тэгвэл бид юу ч хийж чадна.” (Хонг Конгд 1992 оны 2-р сарын 19-нд айлдсан лекц)

Адислах Хүчний гайхамшиг

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Зул сарын дөрвөн өдрийн даяан,
Флорида, АНУ, 2001 оны 12-р сарын 26 (Дүрс бичлэг №728)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Ямар нэг зүйлийг адислахад түүний молекулын бүтэц өөрчлөгддөг болохыг үзүүлсэн физикийн нотолгоо өнөөдөр байна. Жишээлбэл, Японы нэг голоос жаахан бохир ус авч байсан Япон эрдэмтнийг би интернэтээр харсан. Ингээд тэр усыг хөлдөөж, 500 дахин томруулж харжээ. Мөн тэрнийхээ зургийг дарсан байна. Ус их бохирдсон, хэлбэр дүрсгүй байсан; шавхай шиг, яг том шавар шавхай л харагдаж байсан.*

Дараа нь тэр нэгэн сүмд ороод нэг ламаас усыг адислаж өгөөч гэж гуйсан, яг тэр усыг, адилхан дээжээс авсан ус. Тэр үүний дараа өнөөх усаа хөлдөөгөөд зургийг нь авчээ, шаварлаг байдал маш үзэсгэлэнтэй талст бүтэц болсон байв. Яг цасан ширхэг шиг. Тэгээд тэр туршилтаа үргэлжлүүлэхээр шийдсэн. Тэр өөр уснаас дээж аваад, усны саван дээр “Баярлалаа” гэсэн үг бичиж наажээ. Тэгээд зургийг нь авахад түүний бүтэц өөрчлөгдсөн байсан, ус хэл ойлгодог юм шиг өөр зураг гарч ирсэн.

Тэр мөн ус аваад, “Усанд зориулан хөгжим тавьцгаая” гэж хэлжээ. Тэгээд усаа хүнд рок, хүнд металл рок, маш шуугиантай хөгжмийн дэргэд тавьсан. Тэгэхэд тэр ус бүхэлдээ гажиж, дотор нь нүүр царай байгаа юм шиг харагдсан ажээ. Ингээд тэр хүн усыг аваад, “Махатма Ганди” эсвэл “Тереза Эх” гэж түүний дэргэд хэлье гээд тэр хэлсэн. Бодол тус бүр эсвэл үг тус бүр өөр өөр дүр зургийг бий болгож байжээ. Ус нь удаа бүрт өөрчлөгдсөн, бохир ус ч гэсэн. Тиймээс бид Их Багшийн адистай хоолны тухай, тэр байтугай өөрсдийн тухай бодож байхдаа ч хоол хүнс эсвэл усны бүтцийг хүртэл өөрчилдөг гэдэг нь үнэхээр гайхалтай юм. Үүний физикийн нотолгоо байж байна.

Их Багш: Юу гэхээр, би их ичимхий л дээ. Намайг ямаршуу хүч чадалтай вэ? гэж та нар хэтэрхий асууж шалгаахад надад үүнийг тайлбарлах хэцүү байдаг. Тэгэхлээр, би тэд хоолонд дуртай, тэд бялуунд дуртай гэх ч юм уу, иймэрхүү л зүйл хэлнэ байх. Харин та өөрийнхөө төлөө эрж олох хэрэгтэй. Би тийм ч сайн зар сурталчилгааны зууч биш. Би иймэрхүү зүйлсийн талаар ховорхон ярьдаг.

Хэрвээ ямар нэг юм хэлэх бол би "Их Багш" эсвэл "Их Багшийн хүч" гэж хэлдэг. Миний яриад байгаа зүйл бол миний тухай биш. Их Багш эсвэл Их Багшийн хүч, энэ нь хувь хүн биш юм. Гэхдээ зүгээр л биет нотолгооны хувьд ямар ч санваартан эсвэл сайн санаатай хэн ч ямар нэг зүйлийг адислаж, юу ч биш байснаас дээр болгож чадна. Хэн нэгэн сүнслэг хүчээр усыг адислахад ус гэрэлтдэг. Та үүнийг харж чадна. Энд адислагдсан, адислагдаагүй хоёр өөр ус тавихад адистай ус Гэрэл цацрааж байдаг.

Хүүхэд эсвэл нохой адистай ус руу л очно. Тэдэнд аль нь адистай гэдгийг хэлэх хэрэг байдаггүй. Тэд нөгөө усыг биш, адистай тэр усыг нь л авдаг, учир нь тэд Гэрэл харж чаддаг. Хүүхдүүд бүгд харж чадна гэсэн үг биш; балчир хүүхдүүд хардаг, бас нэлээд ноход хардаг. Нохой гэхэд л хүний сүнслэг гэрлэн бүрхүүл (аура)-ийг хардаг. Тийм учраас нохой зарим хүн рүү хуцаад, зарим руу нь хуцдаггүй.

Тэгэхлээр янз бүрийн хүмүүсийн ялгаатай энерги, сүнслэг хүч гэх зүйл байдаг ажээ. Заримдаа та аль нэг ресторанд хооллохоор ороход, их цэвэрхэн харагдаж байсан ч, бохир юм шиг танд санагддаг. Энэ бол энерги; зарим нэг адислалын хүч дутагдаж байна. Тиймээс олон хүн сүм хийдэд хүнсний зүйл авч очоод, тахилч, тусгай эрх мэдэлтэн, гэлэнмаа, ламаас түүнийгээ адислаж өгөхийг гуйдаг. Хэдий тэр лам, гэлэнмаа нар үнэхээр Гуан Инь, эсвэл өөр ямар нэг аргаар бясалгадаггүй байж магадгүй ч энэ нь ямар нэгэн нөлөө үзүүлдэг.



Бид аль нэгэн сүнслэг төвийн тухай, жинхэнэ Би-гийнхээ
тухай ямар нэг зүйлийг санах бүрд бидний дэргэдэх хүн
ач тус хүртэх болно.

~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Гэвч тэд чин сэтгэлтэй, цэвэр ариун бөгөөд тэдэнд адислах хүч байдаг. Тиймээс энэ нь тодорхой хэмжээнд үр дүн өгдөг, гэвч гэгээрсэн хүнийх шиг сайн байхгүй нь мэдээж. Гэвч юу ч биш байснаас л дээр, жишээ нь тэр япон эрдэмтэн хүний үзүүлсэн шиг. Та хэн нэгэнд “Өө, зүрх сэтгэлээ адислаарай!” эсвэл “Бурхан таныг адислах болтугай.” гэж ерөөх нь үнэхээр нөлөө үзүүлдэг юм. Тиймээс ийм зүйлсийг хэлж байгаарай. Хүмүүст сайн сайхныг ерөөж байгаарай.

Бодол ба сэтгэл хөдлөлийн хүчийг нүднээ үзүүлэхүй

Авшигтан эгч Софи Лапейр, Сан Хосе, КА, АНУ
(Эх нь Англи хэлээр)

Саяхан Флоридад хийсэн Зул сарын даяаны үеэр нэгэн номын ах Их Багшаас, яагаад Барууныхан адистай чихэр, жимс авахаар ирэхдээ хэдхэнийг чимээгүйхэн эелдгээр авдаг байхад, Ази ах эгч нар илүү түрэмгий бөгөөд уралдаж өрсөлдөх хандлагатай бас нэг дор атга дүүрнийг шүүрч авдгийг асууж байсан. Барууныхан адистай идээний талаар тэдэнд хэлээгүй өнгөрөөсөн, тэд мэдэхгүй өнгөрч буй ямар нэг зүйл байгаа эсэхийг тэр ах их эвтэйхэн асуув. Номын ах мөн адистай идээний талаар барууныханд хэлээгүй, тэд мэдэхгүй өнгөрч буй ямар нэг зүйл байгаа эсэхийг эвтэйхэн асууж байсан. Үүнээс үүдэн их чин сэтгэлийн харилцан яриа эхэлсэн юм, ингээд Их Багш хариулахдаа, хоол адислах үед нь юу болох талаар ярихаас тун ичдэг, гэвч Тэрбээр хүнсийг сайн сайхан - эрүүл энх, аз жаргал, гэгээрэл, энэрэл хайрын ерөөлөөр дүүргэдэг учраас хүмүүст энэ нь онцгой сайхан мэдрэмж төрүүлдэг байх гэж хариулсан. Түүнийг Азид ном сургаал айлдаж эхэлсэн цагаас хойш Азийн бясалгагчдад адистай хүнсийг амтлах, туршиж үзэх цаг олонтоо олдсон байж магад тул тэд илүү үнэлдэг байх гэж Тэрээр нэмж хэлэв.

Энэ ярианаас үүдэн би хэдэн сарын өмнө интернетээс бидний бодол санаа, сэтгэл хөдлөлөөс хамаарч хүрээлэн буй орчин өөрчлөгддөг тухай бодит нотолгоог тайлбарласан нийтлэлийг эргэн саналаа.

Захиас санаа бүх хэлбэрээр ирдэг. Заримдаа бид номын хуудас санамсаргүй эргүүлэхэд гэнэт гарч ирдэг, заримдаа огт танихгүй хүний үгнээс гарч ирэн зөвхөн бидний мэддэг асуултыг давтдаг. Тэд бас далайн эрэгт угаагдан хэвтэж буй шилэн лонхноос олддог. Ус гэх мэт амьдралын наад захын үндсэн зүйл ч бидэнтэй харилцаж чадах төрөлхийн оюун ухаантай байдаг.

Орчин үеийн технологи нь бидний бодол санаа, сэтгэл хөдлөл нь зөвхөн бидний бие махбодыг төдийгүй бидний эргэн тойрон дахь ертөнцийг хүртэл өөрчилж чадна гэдгийг харуулж чадаж байна.

Шинжлэх ухааны салбарт бол ямар нэг туршилтыг хөндлөнгийн ажиглагч давтан хийх боломжтой биш байх юм бол, тухайн нээлтийг нь хүчингүй гэж тооцдог. Тэгэхлээр Японы алсын хараатай судлаач Др.Масарү Емүто яг үүнийг хийсэн юм. Тэрбээр олон давтагдах боломжтой туршилт хийснээр хүний бодол, сэтгэлийн хөдөлгөөн усны молекулын бүтцийг өөрчилж чадахыг үзүүлсэн. Тэгэхлээр, анх удаагаа, бидний бодлын хүч нь бидний эргэн тойронд байгаа зүйлсийг өөрчилж болохыг үзүүлсэн физик нотолгоо ийнхүү гарч иржээ. Энэ нээлтийн долгионы нөлөө болон квант үсрэлт нь дэлхий даяар маш хурдан тархаж байна. Хэрвээ та тээнэгэлзсэн бөгөөд танд баталгаа нотолгоо хэрэгтэй байвал, одоо танд ийнхүү олдлоо!

1994 онд Др.Масарү Емүто янз бүрийн эх үүсвэрээс усны дээж авч хэдэн дуслыг хөлдөөж, харанхуй талбайн микроскопоор шалгаж, гэрэл зураг авснаар энэ бүгд эхэлжээ. Эхлээд тэр Япон дахь нэгэн цэвэр усны нөөцөөс авч туршсан. Зураг маш гоё талст хэлбэрийг илрүүлсэн. (Зураг 1) Дараа нь ойролцоох бохирдсон голоос ус авч бас зургийг нь даржээ.



Зураг 1: Японы цэвэр эх үүсвэрээс авсан ус



Зураг 2: Залбирлын өмнөх бохирдсон ус


Үр дүн нь маш сул бүтэцтэй, толботой шавхай байсан. (Зураг 2) Ингээд сүмийн нэг ламыг гуйж бохирдолтой ус руу залбирал хийлгээд, сониучирхан туршилтаа давтжээ. Түүнийг гайхшруулан өөр нэгэн талст бүтэц гарч ирсэн байна. (Зураг 3) Энэ туршилтыг олон удаа давтсан ба үр дүн адилхан байв. Судлаач усны дээжээ янз бүрийн төрлийн хөгжмийн дэргэд тавьсан.



Зураг 3: Залбирлын дараах усны гоёмсог талст бүтэц



Зураг 4: Сонгодог хөгжмөөр усанд үүссэн талст бүтэц



Зураг 5: Хүнд рок хөгжмөөр усанд үүсгэгдсэн талст бүтэц

Сонгодог хөгжим үргэлж их гоё хээ тусгасан. (Зураг 4) Харин хүнд метал эсвэл рок хөгжмийн ая нь гажсан, хэлбэргүй, толботой дүрс гаргасан. (Зураг 5) Хөгжмийн ийм төрлүүд молекулын чамин гоё тэнцвэрийг эвдэж байсан.

Тэрбээр туршилтаа үргэлжлүүлж, энэ удаад цаасны өөдсөн дээр үгс бичээд тунгалаг шилэн сав дээр наагаад юу болохыг харжээ.



Зураг 6: Япон хэлээр “Баярлалаа” гэсэн үгээр үүссэн талст бүтэц

Тэр “Хайр” эсвэл “Баярлалаа” гэх мэт эерэг үгс ашиглажээ. (Зураг 6) Тэр болгонд маш гоё, чамин талст бүхий хээ ажиглагдсан.



Зураг 7: “Чи намайг өвчлүүлж байна. Чамайг ална даа.” гэсэн үгсээр үүссэн талст бүтэц

Тэр “Чи намайг өвчлүүлж байна. Чамайг ална даа.” гэхэд гажсан, айдас хүрэм, шавхайн хээ үзэгдэв. (Зураг 7)

Тэр байтугай “Ганди”, “Тереза Эх” (Зураг 8), мөн “Титлер” (Зураг 9) гэх мэт нэрс дээр туршихад адил төрлийн үр дүнгүүд гарсан байна. Др.Емүто оршин байгаа бүх юм амьд, бас чичирхийлэх давтамжтай, соронзон цуурайн орчинтой, бүх бүтээгдсэн зүйлийн ард энергийн эх үүсвэр байдаг гэдгийг удалгүй ойлгосон байна. Тэр энэ туршилтдаа бас Соронзон Цуурайн Задлан шинжлэгч (MRA) ашиглаад хэмжилт хийж чадсан. Энэ судалгаа нь Аялгууны бясалгал яагаад тийм хүчтэй байдгийг үнэхээр тайлбарладаг юм. Бид Арьяабалын Аргаар бясалгахын төлөө өөртөө хүлээдэг хэдхэн амлалт үүрэг бол



Зураг 8: “Тереза Эх” үгнээс үүссэн талст бүтэц



Зураг 9: “Титлер” гэсэн үгнээс усанд үүссэн бүтэц



Зураг 10: “Хайр ба Талархал” үгнээс үүссэн талст бүтэц

хамгийн цөөн, хамгийн энгийн хэрнээ бас хамгийн хүчтэй бөгөөд өөрчлөх туршлагуудыг бидэнд өгч чадахыг ойлгохгүй нэг ч өдөр гэж үгүй билээ. (Үүнд дагалдах гаж нөлөө гэж ер байхгүй!)

Их олон туршилт явуулсны дараа Др.Емүто, өөрчлөн хувиргах хүч чадлаараа бодлын хамгийн хүчтэй хослол бол “Хайр ба Талархал” гэдгийг олж нээжээ. (Зураг 10)

Энэ нээлтийг гайхалтай болгож байгаа зүйл нь бид хуурай газраас илүү усаар бүрхэгдсэн гараг дээр амьдардаг бөгөөд хүний бие нь гол төлөв уснаас бүрддэгт байгаа юм. Тэгэхлээр, хэрвээ бид ердөө эерэг бодлын төлөвүүдийг үүсгээд л биднийг бүрдүүлэгч орчны бүтцийг өөрчлөх хүч бүрээрээ сэргээн засаж чадна.

Хоолныхоо өмнө талархаж залбирах нь таны эрүүл мэндэд юу өгч чадах талаар бодоорой. Энэ нь өдөр тутмын оюуны ажил хэргээ завсарлаж, өөрийгөө илүү хүлээн авах орон зайд оруулах сайн арга зам гэж би итгэдэг байсан. Би одоо идэх гэж байгаа хоол маань ч хувирч өөрчлөгдөнө гэдгийг мэддэг болсон.

Хэрвээ бидний Газар Дэлхий дээрх зорилго маань үнэхээр түүнийг адислахад байгаа бол бид өөрсдийн төлөө бодлын болон сэтгэл хөдлөлийн чанараа хадгалахад сонор сэрэмжтэй, хяналттай байхын тулд Арьяабалын Аргаас илүү сайн зам өөр юу байх вэ? Энэ ойлголт өөрийгөө дадлагажуулахад үнэхээр шинэ утга санааг авчирдаг. Одоо бид мунхаг дүр эсгэж, эсвэл үүнийг шашны асуудал гэж хэлээд байж байх боломжгүй болсон. Мөн бид заримдаа ядарч туйлдан, өөрсдийгөө үнэхээр өөрчлөлт гаргаж чадаж байна уу гэж гайхах тэр үедээ дахин бодож тунгааж үзэх хэрэгтэй!

Тэмдэглэл:

© Фото зургийг Япон улс дахь IHM General Institute байгууллагаас хуваалцав.

Фото зураг 1 - 9:

Эх сурвалж: <http://www.rainbowjaguars.com/hadoindex.html>

Фото зураг 10:

From <http://www.spiritofmaat.com/archive/nov1/cwater.htm>

Энэ сэдвээр дэлгэрэнгүй мэдээлэл үзэх хаяг:

<http://www.Hado.net>



Та нарын өдөр бүр бясалгалдаа зориулж буй хоёр цаг хагас тань өнө урт хугацааны үр дүн, олон мянган жилийн үр дүн өгөх болно, бясалгалаараа та нар мөнх оршихуйд нэвтрэх үед цаг хугацаа зогсчихдог юм. Энэ бол ердөө хоёр цаг хагасхан төдий биш. Энэ нь хувьсал хөгжлийн мянга мянган жил, олон эрин галав юм. Та цаг хугацаа, орон зайн өөр бүс рүү ордог. Ингэж та дахин цэнэглэгдэж, шинэчлэгдэн буцаж ирдэг.

~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай



Бүлэг 6

***Аугаа өөрчлөлт нь өсөж
дэвших туршлага болж чадна***

Өсөж дэвших туршлага

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай
Шотланд улсын Эдинбург хот, 1999 оны 6-р сарын 5 (Дүрс бичлэг №648)
(Эх нь Англи хэлээр)

***Асуулт:** Таны бодлоор бидний цаг үед, ялангуяа 1985-2010 онуудад болж буй өөрчлөлт нь дэлхий даяар илүү том өөрчлөлт хийх боломж олгож байна уу?*

Их Багш: Тийм ээ. Энэ бол өсөж дэвших нэг хэлбэр. Учир нь асар их хэмжээний сүнслэг энерги нэг цаг үед цугларах юм уу нягтрах үед ердийнхөөс илүү их хүсэл эрмэлзэл үүсдэг. Ялангуяа гараг дээр их үймээн самуунтай, маш их түгшүүртэй, нөхцөл байдал их ширүүн, илүү их дайн дажин, гамшигтай үед Бурханы ивээл бүр ч их шаардлагатай. Учир нь эдгээр хүнд хэцүү үед илүү олон хүн Бурханы нигүүлслийн төлөө залбирдаг. Хүмүүс улам чин сэтгэлээсээ залбирах тусам Бурханы нигүүлсэл энэ гараг дээр илүү ихээр буух болно.

Гэрэл ба Аялгуу бясалгах нь бидний цор ганц өмөг түшиг

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай
Камбож улсын Райсинг төв, 1996 оны 7-р сарын 30 (Дүрс бичлэг №568)
(Эх нь Англи хэлээр)

Зөвхөн дотоодын Гэрэл болон Аялгуу л энэ дэлхий дээрх ямар нэгэн нөхцөл байдалд бидэнд тусалж чадна. Тиймээс бидний хувьд өнгөрсөн, одоо, ирээдүйн үйлийн үр, аливаа төрлийн ачаа дарамттай харьцахад энэ дэлхий дээр найдах өөр зүйл байхгүй. Гэрэл ба Аялгуу бол бид энэ дэлхий дээр бууж ирээд өөрсдийгөө хамгаалах, Бурханы Хаант улсыг санах, Бурханы Хаант улсыг олох замд маань тааралдсан аливаа хүндрэл, саад бэрхшээлийг даван туулж чадахын тулд Бурханаас бидэнд соёрхсон цорын ганц арга, цор ганц төхөөрөмж хэрэгсэл юм. Энэ дэлхий дээрх таны ажил, гэр бүл, хайр сэтгэлийн харилцаан дахь аливаа саад бэрхшээл нь чухамдаа таныг Бурханы Хаант улс руу буцах аян замаас чинь хазайлгахын тулд танд төвөг учруулах гэж л байдаг. Бурхан үүнийг урьдаас мэдээд бидэнд Гэрэл болон Аялгуу гэдэг эл төхөөрөмжийг өгсөн бөгөөд ингэснээр бид бүгдийг нь тас цавчиж, цааш урагшлах болно. Гэрэл ба Аялгуугүйгээр бид Гэртээ харьж хэзээ ч чадахгүй..... хэзээ ч, хэзээ ч үгүй. Энэ нь онгоцонд суулгүйгээр Камбожид ийм хурдан бөгөөд асуудалгүй хүрч ирж чадахгүйтэй яг адил.

Тиймээс танд өөрт тань, хайртай нэгэнд тань, эрхэлдэг ажил, бизнест тань юмуу ямарваа зүйлд хэдийд ч бай ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгарвал, зүгээр л суугаад бясалга. Тэгвээс танд асуудал ойлгомжтой болж, яаж шийдэхээ мэдэх болно, эсвэл тэр асуудал өөрөө аяндаа байхгүй болно.

Заримдаа бид сандардаг, учир нь дэлхий биднийг тодорхой зүйлээр, эсвэл тодорхой цаг хугацаанд, тодорхой эрэлт хэрэгцээгээр шахаж шаардаж байгаа мэт санагддаг. Бид сандраад, “Өө, Бурхан минь! Би үүнийг хийж чадахгүй. Надад ердөө ганцхан өдөр эсвэл хагас өдөр л байна, би өөр ямар нэг зүйл хиймээргүй байна. Би яг одоо энэ зүйлийг хиймээр байна, бусад зүйлс зүгээр л намайг шахаж тулгамдуулж байна.” гэж хэлдэг. Харин хэсэг зуур бясалгасны дараа энэ дэлхий биднээс нэхэлт шаардлагаа буцаан авдаг, эсвэл асуудал зүгээр л өөр тийш явчихна, ингээд бид дэмий л сандралд орсноо мэддэг. Тиймээс зүгээр л догь бай. Д-О-Г-Ь. (Инээлдэв) Догь байгаарай, хонгор минь, (Их Багш болон бүгд инээлдэв) бүх зүйл сайхан болно.

Дотоод зөн совингоо сонс. Заримдаа энэ хэцүү. Та аль нь хамгийн хүчтэй зөн совин чинь байгааг харж, тэр хамгийн хүчтэй зөн совин дээрээ тууштай байх хэрэгтэй, учир нь танд заримдаа үүнийг хийх ёстой гэж санагдан энэ ажлаа үргэлжлүүлдэг, гэтэл өөр хүмүүс ирээд өөр ажил хийхийг шаарддаг, бас өөр бусад хүмүүс ирээд энэ нь илүү дээр, энэ одоо ашиггүй гэж зааварчилдаг - “Энэ ашиггүй болно. Чи нөгөө зүг рүү хурдан гүйж очоод энийг ч, тэрийг ч хий.” гэж хэлдэг. Гэхдээ та үүнийг хийх ёстой гэж дотроо мэдэрдэг ч энэ нь таныг хүч чармайлт гаргахад хүргэж, өөр өөр чиглэлээс тасарсан мэт сэтгэгдэл төрүүлдэг. Тэгэхээр та суугаад бясалгаж, танд юу хийхийг хэлж өгдөг чимээгүй дуу хоолой, дотоод зөн совингийн дуу хоолой, өөрийнхөө Будда-гийн дуу хоолойг сонсох хэрэгтэй. Эсвэл ядаж тайвшир, ингээд та аль чиглэл нь танд илүү сайн байхыг өөрөө харж чадна.

Би үүнийг та нарт өөрийн туршлагаасаа хэлж байна. Ямар нэг номноос биш. Ном бидэнд ийм төрлийн зүйлсийг тийм их сургадаггүй. Мөн энэ үргэлж үр дүнгээ өгдөг, учир нь бид өөр хаашаа гүйж чадна гэж, ийм л байдаг дэлхийтэй харьцахын тулд өөр юу ашиглаж болно гэж?

Энд жижигхэн амьтад бидэн дээр тоймгүй их зовлон шаналал, маш их дэмий юмс, нэн их дарамт ирдэг, заримдаа бид юу хийхээ үнэхээр мэддэггүй, улмаар бидний сэтгэл их түгшиж, амар тайван биш болдог. Гэрэл ба Аялгуу ажин бясалгах нь ийм зайлшгүй тулгамдсан нөхцөлд бидний хийж чадах цорын ганц зүйл юм.

Халдварт өвчний эсрэг хамгийн сайн ерөндөг - Арьяабалын бясалгалын Арга

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Пиндун, Формоса, 1988 оны 11-р сарын 2 (Дүрс бичлэг №15)
(Эх нь Хятад хэлээр)

Энэ дэлхий Алтан Эринд орчихоод байна! Алтан Эрин бол сүнслэгээр хөгжсөн хүмүүсийн амьдрах үе; тохиромжгүй нэгэн аажмаар арилж алга болох юм. Тийм учраас өмнө сонсогдоогүй улам л олон өвчин гарч байгааг та нар харж байна.

Харваас ойлгомжтой байна, энэ дэлхийд, хэрэв энд гай гамшиг биш юм гэхэд дайн дажин гарна; хэрэв дайн биш юм гэхэд байгалийн гамшиг эсвэл шуурга гарна; учир нь энэ бүхэн цөм бидний ёс суртахуунгүй үйлдлээс үүддэг; үйлийн үр дэндүү хүнд байна, хамтын үйлийн үр бүр асар их хүчтэй! Тиймээс, ийм хамтын үйлийн үр нэг хоёр хүний үхлээр арилахгүй байвал халдварт өвчин болж, их олон хүнийг үгүй хийж чадна. Энэ дэлхийн амьдрал итгэх аргагүй. Бид бүх цагт эм тарианд найдаад байж болохгүй, заримдаа тухайн үед эм ч биднийг аварч чадахгүй.

Бурхан маш ухаалаг; Тэр бидний аль эрт мэдэх өвчнийг байлгаад зогссонгүй, бас өөр шинэ өвчин бий болгодог, тиймээс бид мөнхөд Түүний араас гүйсээр байх болно. Бид өөрсдийгөө их соёл иргэншилд хүрсэн гэж боддог, гэвч Үйлийн үрийн Хуулийн Хаан бүр ч ухаантай. Тэр хүсвэл биднийг бариад л авдаг, бид тийм хурдан хариу үзүүлэх чадваргүй! Өндөр халуурмагц бид үхэж магадгүй, эмч дуудах гэтэл дэндүү оройтсон байх болно. Эмч ч бас болохгүй, тэр бас адилхан өвчин туссан байж мэднэ.

Хэрвээ цаг нь дуусаж, үйлийн үрээ төлөх ёстой болсон учраас тэдгээр хүн өвдсөн бол тэд бас явж магадгүй. Гэвч ийм байдлаар явахад баталгаа байхгүй; Арьяабалын Аргаар бясалгал хийдэггүй хүмүүс хорвоогоос гэнэт явах болбол амжиж аврагдахгүй байж мэднэ, мөн тэдний сүнс итгэж түших зүйлгүй байх болно. Бид эрт орой хэзээ нэг цагт үхнэ, гэхдээ үхэхдээ найдах “Бүхнээс-хүчирхэг Даатгалын Компани”-тай байх нь хамгийн найдвартай. (Инээлдэж алга ташив) Үнэхээр, бид Арьяабалын Аргаар бясалгаад нэн аюулгүй байдлыг мэдэрдэг. Тэр байтугай өвчин туслаа ч тэгтлээ их түгшиж сандрахгүй, учир нь бид асуудал гарахгүй гэж мэдэж байдаг. Бидний сүнс их тайван, амар амгалан байх шиг санагддаг, бид яагаад амар тайван, нам гүм амгалан байгаагаа мэддэггүй, харин бидний билиг ухаан, бидний сүнс мэддэг, бид аугаа ихийг мэдэрдэг!

Бүхнийг чадагч Арьяабалын Даатгал

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Пиндун, Формоса, 1988 оны 11-р сарын 2 (Дүрс бичлэг №15)
(Эх нь Хятад хэлээр)

Бид сүнслэг дадал бясалгал хийх хэрэгтэй, эс бөгөөс бид тун харамсах бөгөөд өрөвдөлтэй байх болно! Бид тэр байтугай эхний Гурван Ертөнцийн дотор хаан эсвэл Эсэрваа Тэнгэр боллоо ч хэн ч биднийг аврахгүй, үхсэний дараа хэн ч бидний араас тахил өргөхгүй. Бид гар хоосон л буцна. Тэр цагт бид маш сэтгэл санаагаар унасан, ямар ч найз нөхөр дагалдахгүй ганцаараа байх болно. Тиймээс сүнслэг бясалгал дадал хийдэггүй эдгээр хүмүүсийн төлөө би харамсдаг! Тэдний тухай бодох бүртээ би уйлдаг. Нэгэнт унасан бол дахин өндийж босох хүртэл санаанд багтамгүй урт хугацаа буюу хэдэн их наяд жил шаардагдана. Энэ тийм амар биш. Тэд энд буцаж ирэхдээ ч шууд хүн төрөлд ирсэн байх албагүй. Тэд ирсэн байлаа ч, Их Багшийн нэрийг сонсох боломжгүй ч байж мэднэ, эсвэл тэднийг хамгаалж, хайрлаж, халамжлах, удирдан чиглүүлэх, тайвшруулах юмуу гараас нь барьж өндөрт татан авч чадах нэгэн Их Багш олдохгүй байж мэднэ. Ийм төрлийн Их Багш олох тийм хялбар биш.

Арьяабалын Аргаар бясалгадаг бидний хэн ч бай цаг нь болоход, өвчтэй ч байсан, хорвоог орхин явж чадна. Тэглээ ч бид явах үедээ аль хэдийн даатгалтай, найдаж болох газартай болсон байдаг. Бид хамгийг чадагч даатгалын компаниас хамгаалалт авсан байдаг. (Инээлдэж алга ташив) Энэ бол хамгийн аюулгүй зам. Арьяабалын Аргаар бясалгадаггүй хүмүүс нүд ирмэх зуур явна. Бурхан болон Гэгээнтнүүдэд тэднийг ирж аврах хангалттай хугацаа гарахгүй. Тэдний сүнс найдаж түших газаргүй.

Харин Арьяабалын аргаар бясалгадаг бид нэн аюулгүй байгаагаа мэдэрдэг. Бид өвчин зовлонд унасан ч сэтгэл түгших хэрэг байдаггүй. Бид энэ асуудалгүй гэж мэддэг. Бидний сүнс амар амгалан, тайван байна. Яагаад бид ийм амар тайван байдгийг би үгээр илэрхийлж мэдэхгүй байна. Бидний оюун бодол мэдэхгүй боловч харин билиг ухаан маань мэддэг. Бидний сүнс мэддэг. Бид гайхалтай сайхан байгаагаа мэдэрдэг. Тиймээс бид үйлийн үрийн шийтгэл юмуу тогтсон үйлийн үрээс зайлж чадахгүй байлаа ч бидэнд даатгал байдаг. Тиймээс бидэнд асуудал алга.

Жишээ нь, бид машин жолоодохдоо зам тээврийн осол гарч болохыг мэдэж байдаг. Машин маань эвдэрч ч мэднэ. Олон зуун мянган доллар ч нүд ирмэх зуур шатаж, эсвэл бид гэмтээд үлдэж мэднэ. Ямар ч гэсэн бид даатгалтай учраас машин маань олон зуун мянган долларын үнэтэй ч гэсэн бид машин барьж зүрхэлдэг. Аваар осол тохиолдвол даатгалын компани нөхөн төлбөр өгнө, энэ нь учирсан алдагдал, үнэ өртгөөс заримдаа илүү өндөр байх нь ч бий.

Манай бүхнийг чадагч Гуан Инь даатгалын компани үүнээс илүү хүчирхэг бөгөөд ашиг тустай. Тиймээс манай "машин" эвдэрсэн ч бид айхгүй. Хэсэг хугацааны дараа бид нөхөн төлбөрөө бүрэн авдаг. Бидэнд өөр бие махбод, илүү сайн хэрэгсэл, маш сайхан хувцас, илүү сайн оршин суух газар, таашаал авах сайхан ертөнц бий. Бид энэ дэлхийг алдвал бидэнд юу ч үлдэхгүй гэсэн үг биш юм. Биднийг илүү сайн ертөнц хүлээж байна. Тийм ч учраас бид маш их аз жаргалтай, аюулгүй байдлыг мэдэрдэг. Бидний сүнс мэддэг. Тэд дотроо лавтай мэддэг.

Ийм ч учраас, Арьяабалын Бясалгалын Аргатай танилцах зол завшаантай учрах хүртэл бидэнд маш олон их наяд эрин галав шаардагдана. Хэрэв бид энэ боломжийг эрхэмлэхгүй байх юм бол бүр Бурхан хүрч ирсэн байхдаа ч биднийг аварч чадахгүй. Энэ үнэхээр яг ийм байдаг!

Бясалгалаар үйлийн үрээ цэвэрлэ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Колорадо, АНУ, 1993 оны 4-р сарын 10 (Дүрс бичлэг №350)
(Эх нь Хятад хэлээр)

Асуулт: Өвчин шаналгаа нь үргэлж одоогийн үйлийн үрийн үр дүн байдаг уу? Тийм бол түүнийг яаж цэвэрлэх вэ?

Их Багш: Бид түүнийг эдэлж тэвчсэнээр цэвэрлэж чадна, учир нь үйлийн үрийн хүрдийг эргүүлэхэд хэдийн дэндүү оройтсон байна. Гэвч бид гэгээрснээр, авшиг хүртсэнээр, багшийн удирдамжаар Бурханы төгс төгөлдрийг өдөр бүр бясалгаснаар түүнийг нэн багасгаж, сулруулж чадна. Тэгвэл бид маш их зүйлийг нэн багасгаж чадна.



Онч Үг

Амь аврах - эцсийн дээд арга

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай
Шихү, Формоса, 1991 оны 6-р сарын 30 (Дүрс бичлэг №179)
(Эх нь Хятад хэлээр)

Манай бясалгал бол бидний сэтгэл санааны өвчин, үйлийн үрийн өвчин ба бие махбодын өвчин гэх зэрэг янз бүрийн өвчнийг анагаах хамгийн сайн арга юм. Бүгд эмчлэгдэж чадна. Биднийг бясалгахад энэ бүх өвчин яаж эмчлэгддэг вэ? Энэ бол бид өөрийн жинхэнэ Би-дээ эргэж ирдэг учраас юм; Ноён Ванг юмуу Хатагтай Лью гэх мэт эгэл бие хүний нэрийтгэлээ мартаад бид өөрийн уг дүрдээ эргэж ордог.

Тиймээс бид үхдэггүй, амьдардаггүй энэхүү эх сурвалждаа эргэж ирэхэд бидний бие махбод ч бас үхэхгүй эсвэл амьдрахгүй тийш илүү ханддаг. Гэсэн хэдий ч, бид хангалттай бясалгадаггүй учраас амьд байх ба үхэхийн шалтгааныг жамаар нь нөхөж чаддаггүй. Тиймгүйсэн бол бид бас үхэшгүй мөнхийн бөгөөд мөнхийн залуу байж чадна.

Өвчин бас л дохио сэрэмжлүүлэг юм

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Жоржтауны Их Сургууль, Вашингтон, АНУ, 1993 оны 4-р сарын 14
(Дүрс бичлэг №352) (Эх нь Англи хэлээр)

Асуулт: Хумхаа өвчин, ДОХ өвчин гэх мэт халдварт өвчнүүдийн зорилго нь юу вэ? Эдгээр өвчнийг эмчлэх арга олохыг оролдох нь байгалийн үйл явцад хүмүүс хөндөлсөж байгаа хэрэг мөн үү?


Их Багш: Та нар эдгээр өвчнийг эмчлэх арга олсон ч, ондоо өвчин өөрөө үүсэн гарах болно. Хүн төрөлхтөн Бурханд, бидний дотор байгаа Бүхнийг чадагч Хүчинд бүхнийг даатган бууж өгөх ёстой гэдгээ ухаарсан цагт л, хүн төрөлхтөн бүх өвчнийг эдгээх аугаа хүч өөрийнх нь дотор байдаг бөгөөд энэ хүчинд найдаж түших ёстой гэдгээ ойлгож ухаарсан цагт л бүх өвчин арилах болно. Эдгээр бүх зүйл нь биднийг Бурханд эргэж очих ёстойг хэлж байгаа дохио сэрэмжлүүлэг юм.



Галзуу Дэлхий дээрх Бүхнийг Чадагч хамгаалалт

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Виржинияд болсон нийтийн бясалгал, АНУ, 1994 оны 10-р сарын 29
(Дүрс бичлэг №454) (Эх нь Англи хэлээр)

Энэ дэлхий үнэндээ галзуу байна. Өнцөг булан бүрд л ямар нэгэн зүйл болж байна, бидний хувьд цорын ганц найдвартай эх сурвалж бол зөвхөн бидний бясалгал дадал, итгэл үнэмшлээсээ олж авсан, бидэнд ач тустай нь батлагдсан сүнслэг хүч чадал юм. Өнөөг хүртэл, авшиг хүртсэн өдрөөсөө хойш хичээнгүйлэн бясалгасан та нарын хэн нь ч Бүхнийг чадагчаас ирдэг энэхүү хамгаалалтын хүчийг мэдрэх болно. Мөн энэ хүч бол бидний дотоодод байдаг, учир нь Бурхан бидний дотоодод оршдог; Будда Чанар таны дотор байдаг. Шашин бүрийн ном сударт тийн дурдсан байдаг. Шашны ном судрууд эртний бясалгаж гээгээрсэн хүмүүсийн ахуй ойлголтыг өгүүлсэн байдаг. Тиймээс тэд мянган жилийн өмнө байсан ч бид одоо ч гэсэн өөрсдийн дотоод сүнслэг мэдлэг ололтоор баталгаажуулж чадна. Библи сударт юу ч гэж бичсэн байсан бид Арьяабалын Аргаар бясалгасаар байгаа учраас тодорхой ойлгож чадна.



Онч Үг

Зөвхөн сүнслэг бясалгал бүх өвчин зовлонг арилгаж чадна

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Пусан, Солонгос улс, 1992 оны 3-р сарын 23
(Дүрс бичлэг №234) (Эх нь Хятад хэлээр)

Бид сүнслэг бясалгалыг сайтар дадуулахад бидний үйлийн үр аригдан арилж, өвчин эмгэг аяндаа эдгэрэх болно. Энэ бол удаан үргэлжлэх ид шидийн хүч юм. Би та нарт ариун журам, сахил, веган хоол хүнсний тухай сургасан, энэ нь бүр ч илүү үүрдийн ид шидэт хүч бөгөөд бие болон оюун санааг сайжруулж, мөнхөд илүү сайн хамгаална, ингэж бид олон өвчнөөр өвдөх шаардлагагүй болно. Тиймээс та нарыг үйлийн үрээ сүнслэг чармайлтаараа арилгана гэдэгт би итгэлтэй байна, бас та нарын маш олон саад тотгор, өвчин хууч аяндаа багасна!

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Шихү, Формоса, 1991 оны 6-р сарын 13 (Дуу бичлэг №CG19)
(Эх нь хятад хэлээр)

Ер нь бид өнгөрсөн алдаагаа мэдсэн ч, наманчлах хүч чадал бидэнд байдаггүй. Гэсэн хэдий ч бид үнэхээр л наманчилж чадвал бидний үйлийн үрийн саад тотгор арилах болно. Бид наманчлахын тулд сүнслэгээр үнэхээр бясалган дадуулах ёстой. Тиймээс л бид бясалгах хэрэгтэй хэвээрээ юм.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Шихү, Формоса, 1991 оны 6-р сарын 28 (Дуу бичлэг №CG20)
(Эх нь Хятад хэлээр)

Сүнслэг бясалгагч нар үйлийн үрийн саад тотгор, шалтгаан, үр дагаврын уур амьсгалыг даван гарч чаддаг, ингэснээр бид илүү амарч тайвширснаа мэдрэх боломжтой. Тиймээс бясалгахын хэрээр бидний амьдрал илүү аз жаргалтай, саадгүй, тайван тогтуун болж байдаг. Бид үйлийн үрийн саад тотгорын үйл явцаас зугтан зайлсан учраас бид үүнд удаан баригдаж хүлэгдэхгүй болсон байдаг, яагаад гэвэл бид тэр бүхнээс дээшээ гарсан.

Дотоодын анагаах энергиэ хөгжүүл

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Австрали Улсын Сидней хот, 1993 оны 3-р сарын 16 (Дүрс бичлэг №333)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: Би амьдралд илүү сүнслэг хандах шаардлагатай байна. Миний эргэн тойронд байгаа сөрөг зүйлд би хэрхэн хариу үзүүлэх вэ?

Их Багш: Хэрвээ бид сүнслэг хандлагатай бол сөрөг нөлөөлөл, амьдралын аливаа сөрөг үзэл бодол зэрэг бүх зүйлд илүү тэвчээртэй ханддаг. Бид илүү тэвчиж хүлцдэг, илүү ойлгодог. Тиймээс бидний эерэг Би-гээс анагаах энерги ялгарч, сөрөг уур амьсгалыг бага зэрэг засах болно.

Тиймээс бид үнэндээ юу ч хийх хэрэггүй. Бид үнэхээр сүнслэг бол, юмс ямар нэгэн хэмжээгээр өөрсдөө сайн болно. Хүмүүс бидэн дээр ирж зөвлөгөө авах эсвэл илүү сайжрахыг хүслээ гэхэд бид тэдэнд юу хийхийг санал болгох байр сууринд байх болно.



Төрөлх хамгаалалтын тогтолцоогоо ашигла

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Сингапурт болсон нийтийн бясалгал, 1994 оны 9-р сарын 28
(Дүрс бичлэг 446) (Эх нь Англи хэлээр)

Эрүүл бөгөөд энгийн амьдралаар амьдар - энгийн амьдрал, өндөр дээд сэтгэлгээ. Үргэлж эерэг бодож сэтгэ. Ердөө л бодол сэтгэлгээ хүртэл таны амьдралын хэв маягийг өөрчилдөг, тэр өдрийг тань өөрчилдөг, аз завшааныг тань өөрчилдөг. Тиймээс үргэлж эерэг байхыг хичээ. Тэгвэл маш олон осол, олон өвчнөөс сэргийлж чадна. Хэрвээ та эмч, сувилагч, заримдаа нийгмийн ажилтан бол цаг үргэлж эерэг байх тун хэцүү; учир нь хүмүүс тань дээр өвчинтэйгээ, өөрсдийн асуудалтайгаа, маш дорд бодол санаатай, уйтгартай энергитэйгээ ирдэг. Гэвч энгийн хүмүүсийн төлөө та үргэлж өөрийн эерэг энерги хадгалж чадна. Бурхан таны эргэн тойронд байгаа гэж үргэлж бод, арван зүгийн Их Багш нар таныг ямагт хамгаалж байгаа гэж бод, учир нь энэ үнэн.

Өөрийн хамгаалалтын тогтолцоондоо анхаарал тавихыг хичээгээрэй, түүнийг эвдрэхийг бүү зөвшөөр. Өөрийн тогтолцоог эерэг үйлдэл, эерэг бодол, эерэг яриагаар хамгаалахыг хичээ. Энэ маш энгийн. Зүгээр л эерэг бодоход л танд хэдийн асар их тустай.



Эерэг чанараа хөгжүүлэхүй

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Япон улс, 2000 оны 7-р сарын 10 (Дүрс бичлэг №706)
(Эх нь Хятад хэлээр)

Айдастай мэдрэмжээсээ эмээж мэгдэх хэрэггүй, учир нь айх тусам айдас улам хүчтэй болно. Ямар нэг зүйлийн талаар их бодох тусам тэр улам хүчтэй болно. Тиймээс, “хайр”-ын тухай л бодчих. Бүх цагт, бид зүгээр л “хайр”, “хайрын хүч”-ний талаар бодох хэрэгтэй, бас эерэг бодлоо байнга хадгал, тэгвэл Их Багшийн Хүч аяндаа бүхнийг зохицуулах болно. Аажим аажмаар бид түүнд дасах ба саад тотгор үгүй болж, бүх айдас арилна. Бид Бурханы хүчинд итгэж найдаж, Бурханы хайрын хүчинд итгэх итгэлээ өдөр бүр бэхжүүлэх хэрэгтэй. Ингэснээр бид улам бүр хүчирхэг болж өснө.

Бурхан эсвэл чөтгөр байх эсэхээ бид бодлоороо бүтээдэг

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Бангкок хот, Тайланд улс, 1996 оны 6-р сарын 13 (Дүрс бичлэг №553)
(Эх нь Англи хэлээр)

Холера гэдэг нэгэн чөтгөрийн тухай түүх байдаг. Тэрээр нэгэн өдөр нэгэн бясалгагчийн хажуугаар өнгөрч яваад, “Сайн уу, Би Хятад явлаа.” гэж хэлж гэнэ. Сүнслэг бясалгагч хариуд нь “Өө! Чи дахиад л хэрэг тарих нь уу!” гэжээ. Холера зүгээр л инээмсэглэжээ, ингээд Хятад руу нисжээ.

Ингээд нэг сар орчмын дараа Холера Хятадаас буцаж ирээд дахиад л хажуугаар нь өнгөрч явахдаа “Сайн уу! Би буцаж ирсэн.” гэжээ. Тэр бясалгагч магадгүй Арьяабалын Аргаар бясалгадаг байсан байх, “Өө, чи нэг сарын дотор 50 000 хүн хөнөөчихөв үү?” гэхэд Холера чөтгөр, “Үгүй дээ үгүй, ердөө 25 000.” гэжээ. Тэр нэмээд, “Бусад 25 000 нь айснаасаа болж нас барсан. Надад тэдэнд гараа хүргэх ч хэрэг гарсангүй.” гэж гэнэ.

Заримдаа бодит байдал бидний төсөөлсөн шиг тийм аймшигтай биш байдаг. Хэрэв бид үүнтэй нүүр тулбал тийм ч муу биш байх болно. Харин тун их айж цочиж зугтах юм бол, зүгээр нүүр тулнаас хавьгүй их асуудал үүсгэдэг.

Будда “Би Будда байна; та ч бас Будда байх болно; хүн бүр эн тэнцүү.” гэж хэлснийг бид сонссон. Тиймээс ялгаа нь юу байна? Бид яагаад Будда биш байна вэ? Үүний учир нь бид яг Буддагийн аргаар боддоггүй; бид юмыг Буддагийн арга замаар хийдэггүй. Бид Буддагийн арга замаар үйлддэггүй; бид Буддагийн амьдралаар амьдардаггүй.

Будда, Тэр бясалгасан, дараа нь ямар ч эд хөрөнгөд шунаан хүлэгдээгүй. Хүмүүс Түүнд хоолны алтан аяга эсвэл хувцасны гоёмсог торго өгсөн байж болох ч, Тэр үүнийг авах эсвэл өмсөх байсан ч Тэр хэзээ ч эдгээрт шунаж сэтгэл хүлэгдээгүй. Тэрээр бусдад зааж сургахын тулд амьдралаа, цаг заваа ямагт золиосложээ. Тэрээр Буддагийн, хүн төрөлхтний эрхэм ариун үзэл санааны үлгэр жишээг бүтээхийг хүмүүст сануулахын төлөө цаг хугацаагаа ашиглажээ. Мөн бүх цаг үед Түүний оюун ухаан, Түүний сэтгэлгээ нь үргэлж Будда, хамгийн дээд үзэл санаа, хүн төрөлхтөн ба орчлонгийн хамгийн эрхэм ариун зорилгод чиглэгдсэн байв. Тэр өөр юу ч бодож байгаагүй, юунаас ч айгаагүй. Тиймээс сөрөг хүчин гэгддэг Майя ирж, Түүнд мэхийн ёсолсон. Гэтэл энд бид сөрөг Майя-гийн өмнө суугаад мэхийж байна. Энэ бол ялгаа нь юм. Айдас бидэнд маш их бэрхшээл учруулдаг; энэ биднийг нэр төрөөс маань дордуулдаг. Тиймээс бид амьдралын өөр хэв маягийг сонгох ёстой.

Хэрэв та нар эдгээр сөрөг зүйлийн талаар бодохгүй бол тэд оршихгүй. Тийм учраас би та нарт тэдгээр бүх муу киног битгий үз гэж хэлдэг. Чөтгөртэй кино битгий үз, мөн тэдгээр бүх мэдээллийн хэрэгслийг битгий хар. Дараа нь та "Өө! Түүний дотор чөтгөр ирж байна." гэж итгэдэг. Тэгээд та гэртээ хариад "Өө! Энэ чөтгөр намайг дагаад гэрт ирсэн байх. Магадгүй чөтгөр намайг царайлаг гэж боддог байх." гэж боддог. Ийм зүйл бидэнд ч нөлөөлдөг.

Гэхдээ энэ бол зөвхөн бидний мэдрэмж; энэ нь бодит биш юм. Заримдаа айдас, шунаан дурлах сэтгэл нь биднийг хэрэв айж эмээгээгүй эсвэл илүү их тайтгарал, амар хялбар амьдралын хэв маягт тэгтлээ их шунаж дурлаагүй байсан бол анхнаасаа хийж болох байсан эсвэл хийчих байсан олон зүйлийг хийхээс саатуулж зогсоодог. Тиймээс чөтгөр дээр биш Будда дээр үргэлж анхаарлаа төвлөрүүлэхийг хичээгээрэй.

Гамшгаас зайлсхийж, бие сэтгэлээ гэрэлтүүлэхийн тулд Ургамал хоолтон болоорой

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Колумбын Их Сургууль, Нью Йорк хот, АНУ, 1989 оны 11-р сарын 4
(Дүрс бичлэг №102В)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: Хүн зон бултаараа амсдаг зовлонгийн талаар тайлбарлаж өгнө үү. Хүмүүс урд өмнөх үеэсээ гэм буруутай юу, үүнээс шалтгаалж зовж байгаа юу?

Их Багш: Хэн ч гэм зэмгүй биш. Би ерөөсөө хэнийг ч буруутгахгүй. Энэ бүгд хичээлд суралцах үйл явц. Суралцах тун хэцүү. Та нэгэнт ухаарч сэрсэн бол, ямар ч гэсэн, юмсыг өөр гэрлээр хараад, энэ бүгд хичээл юм гэдгийг мэдэх болно.

Энэ махан биеэ зуун жил байлгахын тулд өдөр бүр үй олноор нь алж хөнөөж байгаа байдлаа хар л даа. Хичнээн олон амийг золих хэрэгтэй гэж – энэ бүх загас, сам хорхой, тахиа, гахай, үхэр гээд? Энэ бүх энерги дайн дажингүйгээр, зовлонгүйгээр, биеийн өвчин хуучгүйгээр сарниж алга болно гэж бодож байна уу? Бидний хийсэн бүхэн агаарт бичигддэг. Юу ч гээгдэхгүй; зөвхөн өөр энергид шингээгддэг. Зөвхөн өөр үйл ажиллагаагаар тэнцвэрждэг, гээгддэггүй. Энэ нь гээгддэггүй, зөвхөн өөр үйл ажиллагаагаар тэнцвэрждэг. Жишээлбэл, агаар эхлээд ус болоод дараа нь мөс болдог, хэрвээ та үүнийг алга болгоё гэвэл түүнийг буцаагаад агаар хэлбэрт оруулахын тулд түүн дээр нарны гэрэл, чийдэн тусгах, эсвэл дулаан өгөх хэрэгтэй болно. Тэгэхлээр, хэрвээ бид алж хөнөөсөөр, цаг үргэлж үй олноор нь алж хядсаар байх юм бол энэ бүх амьтад зовж шаналж байдаг, тэд ч бас ухамсартай, бодлын болон үзэн ядах энергитэй, энэ бүх үзэн ядалт, айдас нь хүчтэй энерги болж хувиран агаарт тогтдог. Дэндүү их болоод ирэхээрээ нийтийг хамарсан зовлон болж илэрдэг.

Бид энэ материаллаг ертөнцөд ашигладаг бүх зүйлдээ үнэ хөлс төлөх ёстой. Тиймээс, бүх Их Багш нар оршин тогтнолын янз бүрийн хэлбэрт хамгийн бага өртөг зардалтай веган хоолны дэглэм баримтлахыг онцолдог. Амьтан амьтай, ургамал ч бас амьдралтай, гэхдээ ургамал хамгийн бага зардал гаргадаг. Хэрвээ та нэг зуун долларын орлоготой ч хоёр зуун доллар зарцуулах гэвэл та мэдээж өр тавьж, асуудалтай болдог лугаа юм. Хэрвээ та хямд зүйлс худалдан авч, хамгийн бага зардлаар амьдралаа хангавал, та өр шир гэж санаа зовохгүй. Ийм учраас бид веган хүнс - жимс, самар зэргийг сонгодог. Эдгээр бүх зүйл гэм багатай, дотоод ухамсар багатай байдаг. Та модноос хэдэн самар авбал мод олон мянган самрын мод ургуулах самраар баян хэвээрээ үлдэнэ. Тэд алга болохгүй. Хэрвээ та нэг цэцэг юмуу ногооноос нэг мөчир огтлоход тэр шилбэнээс улам олон мөчир ургаж, түүнээс улам их ногоо ургадаг. Ийм байдлаар веган хоолны дэглэм нь хор хөнөөл багатай бөгөөд зардал багатай гэдгийг бид мэднэ.



Хэрэв та маш их
бясалгасан бол бүх
зүйлийг баяр хөөртэй
харж, сэтгэл санаа тань
амарсан байдаг.
~ Төгс Гэгээрсэн Их
Багш Чин Хай



Веганизм таныг улам эрүүлжүүлдэг

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Боулдер, Колорадо, АНУ, 1991 оны 3-р сарын 9
(Дүрс бичлэг №159) (Эх нь Англи хэлээр)

Одоо цагт, эмч гэх зарим хүмүүс амьд явахын тулд мах хэрэгтэй гэж үздэг хуучин онолд нэн дулдуйдсан хэвээр л байна. Гэвч шинжлэх ухааны бусад судалгаа ашиглан бичсэн хангалттай олон ном, мөн махны уураг бол хор хөнөөлтэй, хүний биед муу гэж хэлдэг өөр бусад олон эмчтэй та таарч болно. Тэд үүнийг мянга нэгэн хувь шалгаж тогтоогоод байна. Тиймээс ганц л онолыг сонсоод итгээд яваад байх хэрэг юун. Бидэнд махан хоол ерөөсөө хэрэггүй. Хэнд ч хэрэг болохгүй. Үнэндээ, ихэнх хүмүүс ургамал хоолтон болсны дараа өвчнөөсөө салж эдгэрдэг. Нөгөө онолыг сонсож дагахын оронд энэ хангалттай зоригтой байгаа биз? Бид нэг төрлийн онолд итгэн ховсдуулж, тэр онолд өөрийгөө үнэмшүүлчихээд, улмаар мах бидэнд нэн чухал гэж итгэхэд хүрдэг. Гэвч энэ үнэн биш.



Дархлааны дотоод Хүчээ идэвхжүүл

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Берkeleyн Их Сургууль, Калифорни, АНУ, 1989 оны 10-р сарын 13
(Дүрс бичлэг №101) (Эх нь Англи хэлээр)

Бид мэдэж байгаачлан, мал амьтанд идүүлсэн антибиотик, мал амьтны маханд хорт бодис бий болгодог түгшүүр зовлонгоос болж ихэнх өвчин мах идсэнээс үүсдэг. Учир нь бид бүгд л эдгээр антибиотикийг иддэг, бидний бие өвчин-эсэргүүцэх чадвараа гээдэг. Бие махбод маань ердийн байдлаар өвчнийг эсэргүүцэж чадна, гэвч бид дэндүү их антибиотикоор дүүргэгдсэн махаар хооллочихоор бие сульдаж, эсэргүүцлийн системийн хэвийн ажиллагаа алдагддаг. Тиймээс бидэнд аль ч өвчин нөлөөлж, улмаар амьдралыг төгсгөхөд хүрдэг. Энэ харамсалтай.

Гэтэл ихэнх хүн Есүс юмуу Буддад мөргөх юм бол энэ хангалттай гэж боддог. Харин миний бодлоор бол бид үүн дээрээ бясалгал болон ариун журам, эрүүл амьдрах арга замыг нэмэх хэрэгтэй санагдах юм. Тэгвэл бид өөрийн билиг ухаан ба гэтлэгдэхүйг түргэсгэнэ. Жишээ нь, бид Арьяабалын Арга гэж нэрлэдэг өөрсдийн аргаараа хамтдаа бясалгаж, дотооддоо Бурханы зааврыг сонсон, Тэнгэрлэг нүдээрээ Бурханы билиг ухааныг харж, ургамал хоолны хэв маягийг баримталж, ариун журамтай амьдардаг байх юм бол бид өвчнөөс айхгүй. Манай олон авшигтан нэг шөнийн дотор өвчнөө давсан. Би ихэвчлэн мэс засал хийх шаардлагатай эсвэл үхлийн аюул тулгарсан нэгнийг хэлж байна. Зарим хүн өөрөө ариун буянтай амьдарсныхаа хүчээр, мөн тэднийг хамгаалдаг Бурхан тэнгэрийнхээ хүчээр үхлийн орон дээрээс буцаж ирдэг. Хэрвээ бид энэ хүчийг зөв аргаар нээх юм бол Будда Чанар буюу бидний доторх Будда эсвэл Бурхан гэж нэрлэдэг тэр хүч хорин дөрвөн цагийн турш биднийг хамгаална, мөн энэ биеийг орхисны дараа ч биднийг хамгаалах болно.

Бид үнэндээ бүр ч сайхан амьдарч чадна

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Сингапур улсад хийсэн нийтийн бясалгал, 1994 оны 9-р сарын 29
(Дүрс бичлэг №446) (Эх нь Англи хэлээр)

Орчин үед олон өвчин зовиур, янз бүрийн архаг өвчин хүмүүсийг хөнөөдөг болжээ, жилд ойролцоогоор арван найман сая хүн. Учир нь бидний зарим нь ямар нэг зорилгын төлөө Газар Дэлхий дээр зарим даалгавар биелүүлэх, мөн өөрийн Бүхнийг чадагч Хүчээ таньж мэдэхийн төлөө Бурханаас бидэнд заяагдсан энэхүү эрхэм нандин хүмүүн биеэ хамгаалахын тулд урьдчилан сэргийлж анхаарал тавьдаггүй. Бид дэндүү их тамхи татаж, хэт их архи ууж, маш их мах идэж, махнаас бүх бактерийг өөрийн эрхтэн тогтолцоо руугаа урих зэрэг зүйлс хийдэг. Энэ бүх үхэлд хүргэх хүчин зүйлс бидний амьдралыг зовлонтой болгодог.

Үнэндээ, бид илүү эмх цэгцтэй болж, өөрийн биеэ илүү эрхэмлэх юм бол бүр ч сайн сайхан амьдарч чадна. Бид зүгээр л сайхан амт хөөхийн оронд энэ биеийнхээ төлөө шим тэжээлтэй хоол хүнсийг зохистой хэмжээгээр хүртэж зооглох аваас бидний эрүүл мэнд ийм том аюулд өртөхгүй. Ихэнх ургамал хоолтон хүмүүс улам эрүүлждэг гэдгийг та нар мэднэ. Тийм биш гэж үү? (Сонсогчид: Тийм ээ) Та нарын дунд олон хүн авшиг хүртэж, ургамал хоолтон болсны дараа эрүүл болсон. Тийм биш гэж үү? (Сонсогчид: Тийм) Яг үнэндээ бол эмнэлгүүд мах иддэг хүмүүсээр л дүүрсэн байна шүү дээ. (Инээлдэв) Асуудал алга; бид тэнд нотолгоо харчихаж байна.

Энэ нь зөвхөн ургамал хоол өөрөө эрүүл гэдгээр зогсохгүй бас чичирхийлэл долгион нь бидний биед их зохицолтой байдаг учраас юм, гэтэл мал амьтны хэлбэлзэл тийм зохицолтой биш, тайван амгалан биш. Үнэндээ энгийн бөгөөд эрүүл амьдрах их амархан. Үүнд тийм их эм, тийм олон тарилга хэрэггүй. Бидний олон хүн өөрсдийгөө хорлодог, учир нь биедээ хорт бодис оруулдаг. Эс бөгөөс хэрвээ бид хэрхэн амар хялбар, тэжээллэг, эрүүл амьдрахыг мэдчихвэл бидэнд үнэхээр эмч тийм ч их хэрэгтэй байхгүй. Тэгвэл эмчийн амралт нэмэгдэнэ, бас аль аль тал нь эрүүл байж чадна.

Чанагуух-ертөнцийн Эмчилгээ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Тайбэй хот, Формоса, 1985 оны 8-р сарын 3 (Дуу бичлэг №CEO1)
(Эх нь Англи ба Хятад хэлээр)

Би та нарт ондоо ертөнцийн тухай зарим зүйл хэлмээр байна. Бид хэд хэдэн биетэй; тэд өөр өөр нэртэй байдаг; энэ махан бие, нөгөө төрлийн биеийг сэтгэлийн бие гээ. Дарс уудаг, тамхи татдаг, мансууруулах бодис гэх мэт зүйлс хэрэглэдэг хүмүүс өөрсдийнхөө сүнслэг биеүдээ гэмтээж байдаг, материаллаг биеэ, бас сүнслэг биеэ. Нас барахаар нь Диваажингийн хүмүүс тэднийг эдгээж, эмчилж, эндхийн эмч шиг тэдэнд туслах хэрэгтэй болдог. Ийм төрлийн урт хугацааны эмчилгээ хийлгэсний дараа эдгээр хүмүүс сэргэн эдгэрч, дахин хүн болж төрдөг. Тэд сургамжаа авах хүртлээ ийм олон туршлагыг туулж, дараа нь сүнслэгээр бясалгахыг хүсдэг, ингэснээр тэд илүү өндөрт хүрч чадна.

Бидний “Сугар” гэж нэрлэдэг гараг дээр янз бүрийн хүмүүст зориулсан ийм олон жижиг “эмнэлэг” байдаг. Тийм Ариун Газар амьдардаг хүмүүс маш их ухаалаг, тун сүнслэг, нэн өндөр түвшинд байдаг. Тэд ихэвчлэн бараг л Их Багш шахуу юм, тэдний ихэнх нь Их Багш болж чадна. Тэд ийм хүмүүсийг эмчлэхэд эм, төхөөрөмж ашигладаггүй. Тэд ийм өвчтөнийг эмчлэхдээ өөр төрлийн энерги, цацраг буюу Гэрэл ашигладаг.

Энэ дэлхий дээр бид заримдаа хүмүүсийг эдгээх, хорт хавдрыг эмчлэхэд лазерийн цацраг ашигладагтай л адил юм. Эдгээр хүмүүс зөвхөн илүү өндөр эрдэмтэд, илүү дээр эрдэмтэдтэй адил. Их Багш нар бол зүгээр л илүү өндөр хөгжсөн эрдэмтэд юм. Тэд агаар мандал дахь энергийг хэрхэн өөрчилж, таныг хэрхэн өөр болгохоо мэддэг. Яг л та энэ дэлхийн сайн эрдэмтэн байсан бол нарны гэрлийг эрчим хүч, цахилгаан болгон өөрчилж чадах лугаа юм.

“Сугар” бол тэдгээр Диваажингийн ердөө нэг нь л юм. Нэр нэршил бүү хөөцөлд. Учир нь зөвхөн ганц Диваажин байдаг юм биш; ийм байдлаар хүмүүсийг эмчилдэг Диваажин олон байдаг. Бусад Ариун Газрын их олон мэдрэхүйт төрөлтнүүд бидэнд ямагт тусалдаг. Тэд тэндэх өвчтөнүүд, Газар Дэлхий дээрх хүмүүс, мөн тамд байгаа төрөлтнүүдэд туслахдаа Гэрлийн энерги ашигладаг. Тэд маш олон хөөрхийлэлтэй, цөхөрсөн хүмүүст, залбирч мөргөж байгаа, шаналж байгаа хүмүүст тусалдаг.

Тодорхой шалтгааны улмаас амиа егүүтгэсэн хүмүүсийн талаар та олонтоо сонсож дуулсан л байдаг. Гэхдээ энэ нь амиа егүүтгэх ганц арга биш юм. Амиа егүүтгэх хоёр төрөл байна. Энэ материаллаг биеийг хөнөөх их муу ч хамгийн муу нь биш. Та энэ сүнсэн биеэ алж хөнөөвөл бүр ч долоон дор. Та архи ууж, мансууруулах бодис хэрэглэж, зөвхөн материаллаг аж амьдралдаа анхаарч, сүм хийдэд нэг ч очихгүй, ямар нэг сүнслэг яриа хэлэлцүүлэгт огт очихгүй, хэзээ ч бясалгахгүй, сүнслэг бясалгал хэзээ ч дадуулахгүй, хэзээ ч Ариун Нэрс дуудахгүй, аливаа нэгэн шашны ач буянтай сургаалыг хэзээ ч авч хэрэглэхгүй, тэгээд зүгээр л нийтэч байж, өдөр бүр архи, махтай нөхөрлөж, бүжгэнд явж, хөгжим сонсон, зурагт үзэж, сонин уншин, сүнсээ анхаарахаас бусад бүх л төрлийн зүйлийг хийх байдлаар түүнийг хөнөөж болдог. Энэ нь сүнсэн биеийг сүйтгэсээр байдаг. Энэ аймшигтай.

Хэрвээ танд сүнслэгээр бясалгадаг, Үнэнд итгэдэг хамаатан садан байвал та ядахдаа үхсэнийхээ дараа Диваажинд очиж чадна. Энэ нь та түүнтэй хамт явна гэсэн утгатай биш, гэвч та тэдний буяны ачаар Диваажин руу дэвшинэ. Харин Диваажинд очсон хойноо үхдэл мэт байдаг.

Ер нь бол та үхсэнийхээ дараа Гэрлэн биетэй байдаг, гэвч ийм төрлийн хүмүүст Гэрэл байхгүй. Тэдний үзэгдэх байдал нь энэ бие шигээ байх боловч ямар ч мэдрэмжгүй. Учир нь таны сэтгэл материаллаг зүйлсэд маш их шунан хүлэгдсэн байдаг, та сэтгэлдээ тэр биеэ өөртэйгөө цуг Диваажинд аваачдаг.

Энэ нь өнөөх бие нь биш, харин тэд сэтгэл оюундаа энэ биетэй төстэй өөр биеийг бий болгодог. Тэр бие яг чулуу шиг, мод шиг харагддаг, ямар ч мэдрэмжгүй, ямар ч бодолгүй, оюун ухаангүй. Тэдний хамаатан садан бясалгадаг, эсвэл Үнэн Ёсонд итгэдэг учраас тэд үүнээс нь багахан буян хүртсэнээр цусан төрлийн холбоотой учраас тэдэнтэй хамт Диваажинд очих боломжтой. Гэвч тэнд тэдэнд тод ухамсар байхгүй байдаг, тэд нар хамаатан саднаа танихгүй. Сахиулсан тэнгэрүүд тэднийг авчирч эмнэлэгт хэвтүүлдэг. Тэд тэндээ өнө урт удаан хугацаанд яг л ширхэг чулуу мэт хэвтдэг.

Тэндэх хүмүүс, бүх сайн хүмүүс тэднийг тэнд өөрсдийн Гэрэл, өөрийн хүчээрээ эмчлэх хэрэгтэй болох бөгөөд өөрийн хүчээ ашиглаж, хайраа тэрхүү бие рүү нь юулж, тэр биеийг өөрийн хайр, Гэрлийн энергиэрээ дүүргэдэг. Маш урт хугацаанд ийм байж байгаад тэд дахин амьдарч эхэлдэг. Тэгснээр тэд тэнд амьдарч буй өөрийн гэр бүлээ, хайрлаж байсан хүмүүсээ таньж чаддаг. Ингээд тэд бүгдээрээ хамтдаа баяр жаргалтай байна.

Гэхдээ эдгээр хүмүүс хүнд үйлийн үрээрээ хэтэрхий хүнд болчихоогүй бол ийм байх юм, тийм биш бол олон хүн тусалсан ч тэдний тусламжийг авч чадахгүй. Зарим нь өөрсдийн муу бодол, амьдралын буруу хэв маягт маш их живж баригдсан тул энэ хайр дүүрэн тусламжийг хүлээн авч чадахгүй. Тиймээс тэд харанхуйд үүрд төөрдөг. Ийм тохиолдол мэдээж их гунигтай, гэхдээ тийм тохиолдол байдаг.

Тиймээс хүмүүс бясалгадаг, эсвэл наанадаж л явж очоод Библийн сургаал, Буддагийн сургаал үгсийг сонсдог бол тэд наад зах нь дээд хүчтэй холбоотой байж, зарим хамгаалалттай байна. Дээд хүч тэднийг бага зэрэг хамгаална. Та илүү их бясалгах тусам улам сайн.

Мэдээж, хэрвээ та Бурханы Гэрэлтэй шууд холбоотой болсон байвал та бүр энэ насандаа л Гэрэл харчихаж чадна. Мөн та илүү дээд бүс түвшин рүү очих нь гарцаагүй. Жишээ нь бидний Аргаар, авшиг хүртсэн анхны өдрөө л Гэрэл хардаг шиг. Үгүй бол, үүнийг аажуухан хийдэг эдгээр бүх хүн нас барсныхаа дараа Гэрэл хардаг, эсвэл олон жил бясалгасны дараа Гэрэл аажимдаа хардаг. Учир нь дээд ертөнцөд тэд бүх зүйлд зөвхөн Гэрэл ашигладаг, нялх хүүхэд бүтээхэд, хувцас, байшин, мод хийхэд, өөрсдөдөө ая тухтай зүйлс хийхэд гээд бүхий л зүйлийг Гэрлээр хийдэг. Диваажинд ч бас олон янзын түвшин байдаг, жишээ нь манай оронд зарим нь баян, ядуу, дундаж давхрага гэж байдаг шиг. Гэвч дээд Диваажинд тэд бие биетэйгээ өрсөлдөж тэмцэлддэггүй.



Бид аль нэгэн сүнслэг төвийн тухай, жинхэнэ Би-гийнхээ
тухай ямар нэг зүйлийг санах бүрд бидний дэргэдэх хүн
ач тус хүртэх болно.

~Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар

Бүлэг 7

Амьтай бүх бүтээл эн тэнцүү

Ахимса — Анд найз амьтдадаа хайраа тэлье

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Финляндын Хельсинк хот, 1995 оны 5-р сарын 30 (Дүрс бичлэг №663)
(Эх нь Англи хэлээр)

***Асуулт:** Олон хүн амьтдыг жигшиж, зүгээр л доромжилж эсвэл тэднийг ашиглаж, мөлжиж, үнэ цэнийг нь дорд үзэж, тамлан зовоодог. Би амьтанд хайртай, хэрэв боломжтой бол Та амьтны үнэ цэнийг ярьж хэлж өгнө үү гэж хүсье.*

Их Багш: За, би хүмүүст веган байхыг зөвлөдөг учир энэ юм. Бид өөрсдөөсөө сул дорой, хамгаалалтгүй байдаг ах, эгч, дүүсдээ хайр ивээлээ хүргэхийн тулд бид үүнийг хийдэг. Библи сударт Бурхан: “*Би бүх амьтдыг та нарын анд найз, туслагч чинь байг гэж бүтээсэн.*” гэжээ. Тэднийг идээрэй гэж Тэр бидэнд хэлээгүй ажээ.

***Асуулт:** Би одоогоор ургамал хоолтон биш ч гэсэн Бурхантай аз жаргалтай байж чадах уу?*

Их Багш: Та хариултаа өөрөө мэднэ. Та юу тарина, түүнийгээ хураана. Хэрвээ бид ямар нэгэн төрөлтөнд ямар нэг хэлбэрээр шууд эсвэл шууд бусаар зовлон учруулсан бол бид хэзээ ч гэм зэмгүй, бүрэн дүүрэн мэдрэмжтэй байхгүй, тиймээс бид бүрэн дүүрэн аз жаргалтай байж чадахгүй. Бид зөвхөн тодорхой хэмжээнд л жаргалтай байж чадна.

Амьтай бүхэн эн тэнцүү

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Шиху, Формоса, 1995 оны 12-р сарын 27 (Дүрс бичлэг №519)
(Эх нь Англи хэлээр)

Эрт дээр үеэс өдгөөг хүртэл Ази хүмүүс, ялангуяа Хятад, Аулак хүмүүс яст мэлхий их ариун амьтан гэж боддог, учир нь тэд их урт насалдаг. Заримдаа тэд юм ойлгодог, тиймээс хүмүүс ийм амьтдыг алж зүрхэлдэггүй.

Мэдээж, энэ үнэний хувьтай. Өмнө нь Аулак загасчид далайн гахай болон нөхөрсөг халимыг шүтдэг шиг. Учир нь, заримдаа хар салхи гэх мэт аюул тулгарсан нөхцөлд халим юмуу далайн гахай тэдний завийг замчилж, тэр байтугай аюулгүй чигт түлхэж тэдэнд тусалсан. Заримдаа тэд усанд живж байгаа хүмүүсийг уснаас дээш түлхэж гаргасан. Тиймээс хүмүүс ийм амьтдыг хэзээ ч алдаггүй байсан. Иймд аль нэг нь санамсаргүй үхэх эсвэл үхсэн байгааг мэдсэн бол загасчид юмуу энэ шалтгаанаар далайд сэлж байсан хүмүүс халим юмуу далайн гахайд зориулж бунхан босгож, өдөр шөнөгүй мөргөдөг байжээ.

Тэгэхлээр зарим амьтад тун ч оюун ухаан сайтай. Энэ ямар ч эргэлзээгүй, бид ч бас үүнийг мэднэ. Гахай, гэрийн тэжээвэр амьтад ч бас итгэлтэй, үнэнч шударга, нөхөрсөг, тусархаг чанараа түгшүүртэй нөхцөлд таниулсан. Олон сонин хэвлэл амьтдын үзүүлсэн гайхамшгийн талаар нийтэлдэг. Жишээ нь, нохой шатаж байгаа байшингаас хүүхэд авардаг, гахай олон бээр газар гүйж эзэндээ тусламж авчирдаг, хэдий тийм ч эзэн нь хэсэг хугацааны дараа хоолойг нь огтолж магадгүй. Эсвэл нэгэн морь эзнийхээ булшийг сахин, юу ч идэлгүй байсаар үхсэн байдаг. Нэгэн нохой асран халамжлагчийнхаа булшийг хэзээ ч орхиогүй гэх мэт. Энэ мэт олон гайхалтай явдал байдаг.

Тиймээс хүмүүс заримдаа амьтад биднээс дээр гэж боддог нь хачин жигтэй биш ээ. Зарим талаар энэ үнэн. Тэгээд ч бүх амьтдыг ямар ч байсан Бурхан бүтээсэн, тиймээс яагаад бидэн шиг тэдний дотор Бурханы оч байж болохгүй гэж? Тэд өөр дүр төрхтэй, өөр хэлтэй байх нь биднээс ямар нэг байдлаар бага үнэ хүндтэй гэсэн үг биш. Африкийн хүмүүс хар арьстай бас африк хэлээр ярьдаг, гэвч үүнээс болж тэднийг цагаан Америкчууд, эсвэл Азийн шар хүмүүсээс бага үнэ хүндтэй гэж хэлэх учир огт байхгүй.

Дэлхийгээ бүх төрөлтөнтэй хуваалцъя

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Сан Хосе Вежетариан өргөө, Калифорни, АНУ, 1994 оны 6-р сарын 30
(Дүрс бичлэг №437)
(Эх нь Англи хэлээр)

Ер нь энэ дэлхий бүгдэд, тэр дундаа амьтанд хамаатай. Тийм учраас бид веган бодлого мөрддөг. Яагаад гэвэл энэ гараг дээр оршин буй бүх төрөлхийтний сэтгэн бодох хүчээр энэ дэлхий бий болсон. Бид энэ газрыг хүссэн болохоор энэ оршиж байна, амьтад ч үүнд багтана. Гэтэл бид энэ дэлхийд ирсэн хойноо үүнийг бидний юм гээд бодчихсон. Хүн бүр үүнийг өөрийнх гэж бодсон. Тийм учраас бид улаан, хар, шар гэх мэт бусад “харийнхан”-аас ангижирч эхэлсэн.

Улаан нь цагаанаас ангижрахыг хүссэн. Тэгээд цагаан нь хараас ангижирсан. Дараа нь хар, цагаан, шар нь амьтнаас салж ангижирсан гэх мэт. Ингээд бид өөрсдийгөө энэ дэлхийн цор ганц эзэн биш харин хамтран эзэмшигч гэдгээ мартсан. Тийм учраас бид амьтдыг алж болохгүй, идэж болохгүй, ялангуяа бусад төрөлтөнг алах ёсгүй. Гэтэл улс төр, үндэсний хайр, шашин шүтлэг нэрээр заримдаа алдаг. Ингэсэн атлаа бид энэ аллагаа зөвтгөх олон гоё сайхан шалтаг тоочдог.

Үнэндээ энэ бол хийхэд зөв зүйл биш. Учир нь бид өнөөдөр албал дараагийн амьдралдаа өөрсдөө алагдана. Тиймээс манай дэлхийд дайн ямагт үргэлжилсээр байдаг, ингээд бид учир начрыг нь үргэлж гайхширдаг. Гэвч үүнд гайхаад байх зүйл үгүй. Бид ямар нэгэн зүйл тариад түүнийхээ үр жимсийг хурааж авдаг. Библи сударт ч ингэж хэлсэн байдаг: **Юу тарина, түүнийгээ хураана.** Дайн болон бусад мөргөлдөөний үр дагаврыг амсаагүй байгаа бидний нэг хэсгийн хувьд бол бид ийм хүчирхийллийн үрийг тариагүй гэсэн үг юм.

Тиймээс хэрвээ бид энэ замаа хадгалан үргэлжлүүлбэл, бясалгал хийдэггүй байсан ч, Бурханд, мэргэн ухаантанд албан ёсоор мөргөдөггүй байсан ч, бид аюулгүй, хамгаалалттай, эрүүл хүн болж дахин төрөх болно. Учир нь бид хохирол, дайн, хүчирхийллийн үрийг суулгаагүй.



Амьтад бидний анд найз

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Харвардын Их Сургууль, АНУ, 1991 оны 2-р сарын 24 (Дүрс бичлэг №155)
(Эх нь Англи хэлээр)

Хэрвээ бид үнэхээр л “Хөршөө хайрла” гэсэн замналаар амьдрахыг хүсэж байвал бидний хөршүүд гэдэгт амьтан анд найзуудыгаа багтаах ёстой, ялангуяа тэд бидэнд ямар ч гэм учруулахгүй учраас. Тэд бидний амьдралыг зөвхөн чимэглэдэг; тэд хайр татаж, бидний амьдралыг илүү амьд хөхиүн хөгжүүн, өнгөлөг бас сонирхолтой болгодог. Бид тэднийг хамгаалах, харж хандах, хайрлах бас тэдний байгааг таашаах хэрэгтэй. Бурхан үүнийг тодорхой болгосон; Тэр “Би бүх амьтдыг та нарын найз байг, та нарт туслаг гэж бүтээсэн.” хэмээн айлдсан билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Нью Жерси, АНУ, 1992 оны 6-р сарын 24 (Дүрс бичлэг 259)
(Эх нь Англи хэлээр)

Амьтад учир шалтгаантай болоод л энд байдаг. Тэд ч бас энэ Газар Дэлхийн оршин суугчид; бидэнд тэднийг хөнөөх эрх байхгүй. Зарим хүмүүсийн судалгаагаар амьтад заримдаа хүмүүсийн өвчнийг эдгээдэг нь магадгүй тэдний хайраас болдог байх гэж хэлэхийг би сонссон. Тийм ч учраас, хүнд учруулах түхгүйдэл, сэтгэл хүлэгдэх байдлыг үл харгалзан олон хүн нохой, муур тэжээх дуртай байдаг. Гэвч тэд үнэхээр хайр хүрмээр бөгөөд магадгүй ямартай ч хүмүүсийг тайтгаруулдаг учраас хүмүүст сайхан санагдаж, тэднийг байлгадаг.

Гэрийн тэжээвэр амьтнаа өөр шигээ хайрла

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Флорида, АНУ, 2001 оны 6-р сарын 6 (Дүрс бичлэг №714)
(Эх нь Англи хэлээр)

Та нохойтой бол түүндээ наанадаж өөр шигээ хандаж - сайн хооллож, хайрлаж, цэвэр байлгах хэрэгтэй. Тэр өөр дүр төрхтэй л болохоос гэр бүлийн гишүүнээс өөрцгүй. Нохойгоо салхилуулж, өвсөн дээр бие засуулах бүртээ “ялгас”- ыг нь түүж авах хэрэгтэй. Эсвэл түүнийг тосож авах гялгар уут бэлэн байлгах хэрэгтэй, тэгвэл бусад хүмүүст болон нохойнд өвчин, бохир зүйл тархахгүй. Нохой өвчтэй бол тэр хаана ч хамаагүй бие засдаг, тэгвэл бусад нохой түүн дээр нь гишгээд бас өвчилнө. Тиймээс нохойгоо бие засуулахаар гадагшаа авч гарах, мөн буцааж оруулж ирэхдээ тухай бүрд нь биеийг нь цэвэрлэх хэрэгтэй. Би та нарт яаж хийхийг үзүүлнэ.

Жишээ нь, та нар гал тогооны юмуу ямар нэг алчуур авна. Энэ (Их Багш барьж байгаа алчуураа үзүүлэв) дэндүү жижиг юм, гэвч зүгээр үзүүлэн болгочихъё. Гал тогооны алчуур илүү бөх. Бараг урагдахгүй. Нохойныхоо юм бүрийг арчиж цэвэрлэх хэрэгтэй, тэгэхгүй бол үнэр орж өмхийрнэ. Бүх биеийг нь цэвэрлэ, дээшээ доошоо гэх мэт. Эхлээд хөлийг нь цэвэрлэ. (Их Багш пүүдэл нохойгоо цэвэрлэв) Тэгээд түүний саврыг цэвэрлэ, бүх дөрвөн саврыг нь, мөн дараа нь бөгс, сүвийг нь. Тэгсний дараа түүнийг гэрт оруулна. Учир нь түүнд хуримтлагдсан ямар ч өвчин, бактери нь ариутгагддаг. Би нимбэгтэй ус ашигладаг, харин та өөр зүйл ашиглаж болно.

Гэрт химийн бодис тархахгүй байх үүднээс нимбэгтэй юмуу цуутай усаар гэрээ цэвэрлээрэй. Учир нь нохой шалан дээр унтдаг, бас идэж байгаад дусаавал шал долоодог. Тэд цэвэрлэгээний химийн бодистой юм идвэл үхэх юмуу өвчилдөг. Ингэвэл та хамаг мөнгөө бас цаг заваа эмчид төлбөр төлөхөд үрэх болно, эсвэл нохойгоо гаргаж хаяхад хүрнэ.

Энэ бол их олон хүнд тохиолддог асуудал. Тэд нохойгоо тэнэг, анхаарал болгоомжгүй, мөн хайргүй гэж шийтгэдэг. Ийнхүү олон нохой буруугүй хэрнээ амьтан асрах газарт хүргэгддэг. Энэ бол хүний л буруу, тэнэглэл. Олон хүн нохойтой байх гавьяагүй. Би гадуур машин жолоодож явахдаа Флоридагийн зуны шатам халуунд давхих ачааны машинуудыг олж хардаг; хүмүүс ачааны машины арын дээвэргүй тэвшин дээр хэд хэдэн нохой ачсан харагддаг. Дээр нь тулах юм юу ч байхгүй; зөвхөн төмөр. Мөн ноход хэт халуунцаг. Тэгээд тонгочиж байгаад, заримдаа машинаасаа уначихдаг.

Магадгүй тэд үүнд дассан байдаг байх. Тэд дассанаараа хэр удаан тэгж байхыг би мэдэхгүй. Харин гэртээ ирэхэд толгой нь өвдсөн байдаг байх. Толгой нь өвдсөн ч түүнийгээ хэлж чадах биш. Та тийм ачааны машины дээр удаан сууж явбал бас л толгой өвдөх байх. Мөн тэр байтугай үс ноосондоо дарагдсан байдаг. Тийм нохойнууд үнэхээр өрөвдмөөр. Зарим нохой богино үстэй; зарим нь огт үсгүй. Би үүнийг харахаараа хүмүүсийг нохойтой байх гавьяагүй гэж боддог. Нохой тун хайр татам, эелдэг, үнэнч амьтан. Тэд таны төлөө үхэж ч чадна. Аюул ирвэл тэд таны төлөө амиа өгдөг. Тэдний төрөлхийн хамгаалагч зөн совин гарч ирдэг, тэгээд хэдийд ч таны төлөө харамсахгүйгээр үхэж чадна!

Гэвч зарим хүн үнэхээр нохойтой байх эрхгүй. Хүмүүс амьтадтай ийм маягаар харьцаж байгааг харах бүрд зүрх шимширдэг. Үүний зэрэгцээ хэн нэгэн таныг амьтан гэж хэлэх нь хараал юм. Энэ нь та их доогуур, муу, тэнэг гэсэн үг. Гэвч зарим үед биднээс тэнэг хэн нэгэн байгааг та төсөөлж чадах уу? Бидний зарим нь тэнэг. Мэдээж хэрэг, зарим нохойг гадаа өсгөдөг.

Тэгсэн ч та тэднийг бөөстүүлэхгүй байх үүднээс анхаарч байх хэрэгтэй. Хамгаалалтын эм олон бий; үнэ өртөг нь ч хямд. Та сардаа нэг удаа нохойндоо өт хорхой, бөөсний эм хэрэглэвэл санаа зовох зүйлгүй болно. Сард ганц удаа байхад л болно. Эсвэл бөөсгүй байлгах үсний шингэн саван зэрэг зүйлс бас байдаг. Гэвч урьдчилан сэргийлэх нь алахаас илүү дээр. Бид алахыг хүсдэггүй. Өт, бөөс байсан ч бид тэднийг алахыг хүсэхгүй.

Тиймээс нохойгоо эрүүл, цэвэр байлгаснаар түүнийг хамгаална. Учир нь гадаа өвс нөгөө сайхан харагддаг ч заримдаа түүнд бактери өт хорхой юмуу өндөг наалдсан байдаг. Тэгэхээр бид гэртээ амьтан аваачихад гэр орон маань гадаахтай адил бохир болдог. Бидний олонх гэртээ гуталтайгаа явдаг, энэ бас л нохойг өвчлүүлнэ. Энэ нь таны гутал бохирдоо ч биш. Гутлаар дамжин гаднаас бохирдол орж ирдэг. Тэгж гэртээ авчирдаг. Заримдаа таны машины дугуйнд гаднаас өвчтэй нохойн ялгас, шээс наалдаж ирдэг. Түүнээс болж нохой чинь шал юмуу таны гутлыг долоогоод өвчилнэ.

Тиймээс тэжээвэр амьтантай байхыг хүсэж байвал та гэрээ шалан дээр унтаж ч болмоор цэвэр байлга, шалаа долоосон ч болмоор цэвэр бөгөөд тав тухтай байлгах хэрэгтэй. Та ус цуу тэнцүү холиод гэрээ цэвэрлэж болно. Тавь тавин хувиар. Түүгээр бүгдийг ариутгах, үнэр дарах байдлаар шүршиж цэвэрлэ. Тиймээс хэрвээ нохой тэнд шээх юм бол түүнд ахин юм үнэртэхгүй. Учир нь нохой шээснийхээ үнэрийг авчихвал дараа дахин тэндээ шээнэ.

Эдгээр нь ердөө зарим нэг жишээ. Харин та амьтантай болохыг хүсдэг бол эхлээд түүнийг хэрхэн арчлахыг сурвал зохино. Тодорхой нэг төрлийн амьтан таны зан чанар, амьдралын хэв маягт таарах эсэхийг бас судлах хэрэгтэй. Хүмүүс нохой юм уу муураа таарамжгүй учраас гаргаж хаядаг шалтгааны нэг нь энэ юм. Сул дорой, тамир тэнхээ муутай хөгшин эмэгтэй хүн бол их хөдөлгөөнтэй нохойг арчилж дийлэхгүй.

Эсвэл их заваан замбараагүй нохойг сургаж гаршуулж чаддаггүй. Их тоглох дуртай нохой бол тоглох дургүй юм уу тоглох завгүй хүмүүст таарахгүй. Тэгээд тэд нохой муу, маш муу гэж бодоод гаргаж хаядаг.

Тэгэхлээр танд нийцэж тохирч болохоор олон төрлийн нохой, амьтад байдаг. Гэхдээ та өмнө нь суралцах хэрэгтэй, мөн нохой, муур асрахад танд хүндрэлтэй байх эсэхийг мэдэж аваарай. Танд дэндүү хэцүү санагдвал түүнийг аваагүй нь дээр. Та шударга байх хэрэгтэй, тэгээд л боллоо. Энэ нь та бүх амьтдыг эн тэнцүү хайрладаггүй гэсэн үг биш. Аль алиндаа хайрыг бэрхшээл, өвчин болгон хувиргахгүйн тулд та ердөө яаж хайрлах, ямрыг нь хайрлахыг л мэдэх хэрэгтэй. Учир нь өнгөрсөн удаа, та нарын нэг миний нохойг хүнд өгч явуулсан, ингээд нохой маань зугтаж гүйгээд алдагдсан. Үүнд миний сэтгэл их удаан шаналсан.

Тэгэхлээр, та амьтан авах юм бол, юунаас ч үл хамааран үүрэг хариуцлагатай байх хэрэгтэй. Хэрвээ та чадахгүй бол түүнд сайн орон гэр олж өгөх хэрэгтэй. Түүнд хувийн сайн гэр олтлоо хүлээ. Амьтны дэлгүүрт очиж зарла. Тэд таны нохойд сайн айл олж өгөх болно. Тэгээд түүнийг өгчих, зарах хэрэггүй. Түүнийг найзаа гэж үзээд бэлэглээд өг. Хэн нэгэнд таны нохой таалагдах болно. Та нохойныхоо зан чанарыг нь тайлбарлаж өг, тэр юунд дуртай, юунд дургүй гээд. Тэгвэл ийм төрлийн нохой өөрт нь таарах хэн нэг хүн байж л байгаа. Тэд түүнийг дор нь авна.

Нохойгоо битгий мөнгөөр өгөөрэй, тэгвэл тэд түүнийг нэг өдрийн дотор алах болно. Заримдаа тийм юм болдог! Дандаа нэг өдөрт биш л дээ, нэг өдрөөс нэг долоо хоногт болдог. Хамгийн ихдээ хоёр долоо хоног л болно. Тэр тэнд тийм ч их удахгүй. Хэрвээ та үүнийг хүссэн бол яая гэхэв. Гэвч сайтар мэдээтэй байгаарай. Таны амьтныг яах ийхийн зуургүй л алаад хашаанд тавьчихсан байж мэдэхээр шүү, мэдээтэй байгаарай л гэж анхааруулж байна. Гэвч зарим хамгаалах байр "алахгүй" гэсэн дүрэмтэй. Та тийм газарт нохойгоо өгч болно.

Амьтныхаа хувийн шинж байдлын талаар бүгдийг тодорхойлж хэлж өг, ингэснээр хожим хамгаалах байр ийм зан чанартай амьтныг хүсдэг хүмүүст түүнийг олж өгч чадна.

Шийдэл үргэлж байдаг. Амьтнаа гаргаж хаяж болохгүй, учир нь тэд яг л бидэн шиг амьд төрөлтнүүд. Амьтны нүд үрүү харахдаа та заримдаа "Бид эн тэнцүү. Бид адилхан." гэдгийг ухаарах болно. Энэ мэдрэмж таны бүх биеийг чичрүүлэх ба хэзээ ч мөрөөдөж байгаагүй гэгээрлийг танд өгөх болно. Би та бүхэнд амьтад та нарыг сургаж чадна гэж хэлсэн, бас цэцэг, мод гээд юм бүхэн. Тэр биеэ ямар сайн авч явж байгааг харцгаа л даа. (Их Багш гар дээрээ унтаж байгаа пүүдэл рүү дохив) Ийм нохойг хэн хаяж чадах гэж? Тэр үнэхээр хайр хүрмээр шүү.



Бүлэг 8

Сүнсний Хос

Сүнсний хос гэж юу вэ?

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Кэйп Таун хот, Өмнөд Африк, 1999 оны 11-р сарын 27 (Дүрс бичлэг №669)
(Эх нь Англи хэлээр)

***Асуулт:** Ихэр сүнс болон өөрийнхөө эрэгтэй, эмэгтэй талуудын талаар тайлбарлаж өгнө үү.*

Их Багш: Ихэр сүнс гэж байдаггүй. Бид бүгд тусдаа. Харин заримдаа бид өөрт нэн таарамжтай хэн нэгэнтэй тааралдахаараа түүнийг сүнсний хос гэж нэрлэдэг.

Хэрэв бид урьд нь өөр өөр төрөлдөө тэр сүнстэй урт хугацаагаар хамт амьдарч, хайрлаж, ажиллаж байсан бол одоо өөр биед дахин төрөл авсан тэрхүү сүнстэй дахин учрахаараа танил мэдрэмж төрдөг. Учир нь урьд өмнө нь бид юмыг хамт хийдэг байсан; юм бүр амар, юм бүр нийцтэй, юм бүр зохицолтой байдаг.

Тиймээс үүнийг “сүнсний хос” гэж нэрлэдэг. Бид үүнтэй үргэлж тааралддаг. Сүнсний хос гэгдсэн хүмүүс бие биетэйгээ их аз жаргалтайгаар гэрлэдэг, эсвэл хамтдаа их сайхан эгч дүүс, ах дүүс болох юмуу, сайн эцэг эх, хүүхэд бололцдог. Ураг төрлийн харилцаа их сайн байдаг. Сүнсний хос гэдэг нь ийм учиртай.

Сүнсний хосын сүнслэг ач холбогдол юу вэ?

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Жоржтауны Их Сургууль, Вашингтон, АНУ, 1993 оны 4-р сарын 14
(Дүрс бичлэг №352) (Эх нь Англи хэлээр)

Асуулт: Энэ дэлхий дээр сүнсний хос гэдэг үзэгдэл байдаг уу? Хэрвээ байдаг бол холбоотой хүмүүстээ ямар сүнслэг ач холбогдолтой вэ?

Их Багш: Сүнсний хос бол та түүнтэй уулзахдаа бие биедээ маш их татагдаж, амьдралд, ялангуяа сүнслэг үйл явцад бие биенээ нөхөж чаддаг хүн юм. Тиймээс л сүнсний хос гэдэг. Гэвч хоёрдмол бус ертөнцөд сүнс ч гэж байхгүй, хос ч гэж байхгүй; энэ бол энэ дэлхий дээрх л нэр томъёо. Тиймээс хэн нэгэн танд маш сэтгэл татам, мөн өдөр тутмын амьдралд тань, түүнчлэн сүнслэг хүчин чармайлтад тань маш их тустай санагдаж байгаа бол, хэрэв танд хос ер нь хэрэгтэй байгаа бол, бидний энд байх хугацаанд тэр хүн бол таны хос юм.

Сүнсний хостойгоо холбогдох шаардлагатай юу?

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Кэйп Таун хот, Өмнөд Африк, 1999 оны 11-р сарын 29 (Дүрс бичлэг №674)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: Би Танаас сүнсний хосын талаар асуух хүсэлтэй байна. Сүнсний хостойгоо холбоо барих шаардлагатай юу, хэрэв тийм бол яах вэ?

Их Багш: Энэ амьдралд аливаа зүйл шаардлагатай бол зайлшгүй шаардлагатай. Хэрвээ шаардлагагүй бол шаардлагагүй. Та мэдэх болно. Бидэнд үнэндээ сүнсний хос хангалттай олон байдаг, зөвхөн ганц биш. Гол нь энэ тийм шаардлагатай биш учраас бидний замд үргэлж тааралддаггүй.

Сүнсний хостойгоо хэрхэн учрах нь

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Олон улсын 6 өдрийн даяан, Тайландын Бангкок хот, 1999 оны 12-р сарын 28
(Дүрс бичлэг №677) (Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Би ганц бие хүний хувьд, бусад ганц бие хүний өмнөөс ярьж гэж бодож байна. Сүнсний хостойгоо учрах хамгийн сайн арга зам юу вэ?*

Их Багш: Хэрвээ сүнсний хос гэж тийм зүйл байдаг юм бол, би ч бас мэдэхгүй байна, танд заримдаа байдаг, байхгүй ч байж мэднэ. Та үнэхээр мэдэхийг хүсвэл залбирч болох л юм. Өөрийгөө сүнсний хостой байгаагаар, мөн таны хүсэж байгаа сүнсний хосоо ийм тийм үзэсгэлэнтэй эсвэл тийм ариун журамтай, ийм сайн чанаруудтай байх хэрэгтэй гээд өөртөө дүрсэл. Чанаруудыг нь нэрлэж жагсаа. Сүнсний хосоосоо хүсэж байгаа чанаруудаа нэг нэгээр нь, тодорхой нэрлэж жагсаа. Нэг л өдөр тэр бүсгүйтэй уулзахдаа та мэдэх болно.

Та үүнийгээ дүрслэх хэрэгтэй: бичиж тэмдэглэ. Эсвэл таны бодож байгаа сүнсний хостой гадна байдлаараа адилхан харагдаж байж магад нэг эмэгтэйг харвал, эсвэл түүний төрх байдал танд таалагдвал, та тэрийгээ зурах хэрэгтэй. Эсвэл түүнтэй адил харагдах хэн нэгний зургийг харж төсөөл, тэгээд л болоо! Та тэрийг санаандаа төсөөлөх л хэрэгтэй, тэгэхэд нэг л өдөр биелэх болно.

Хаа сайгүй оршигч болох нь сүнсний хос олох шаардлагагүй гэсэн үг

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Сан Хосе, Калифорни, АНУ, 1994 оны 6-р сарын 30 (Дүрс бичлэг №437)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Хүн бүрд сүнсний хос байдаг уу? Хэрвээ тийм бол, гэтлэгдэхээсээ өмнө сүнсний хосоо олох шаардлагатай юу?*

Их Багш: Сүнсний хос гэж нэрлэгддэг зүйл байж болно. Зарим сүнсний хос аль хэдийн гэтлэгдээд явчихсан байдаг, тиймээс танд эндээс олдох хүн байхгүй. Гэвч зарим сүнсний хос ойр орчим байж байдаг, тэгвэл та хүлээх хэрэгтэй.

Үнэндээ, энэ бол онолын хэсэг: Хэрвээ та зүрх сэтгэлдээ тэмүүлэлтэй биш бөгөөд хүсэж санаашрахгүй байгаа бол, таны сүнсний хос Диваажинд, эсвэл тамд байсан ч танд хамаагүй хэрэг. Та өсөж өндийж, хүсэлгүй байх тэр түвшинд хүрч очих хэрэгтэй. Тэгсэн цагт сүнсний хос хаа сайгүй байна, бас хаана ч байхгүй, учир нь та хаа сайгүй оршдог болсон. Та хаа сайгүй оршиж байхад сүнсний хосын хэрэг байхгүй.

Сүнсний хамт олон

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Окленд, Шинэ Зеланд, 2000 оны 4-р сарын 27 (Дүрс бичлэг №686)
(Эх нь Англи хэлээр)

Та яагаад ийм сайн гэдгээ мэдэж байна уу? Учир нь та бол би шүү дээ. (Алга ташив) Бид итгэмээргүй сайн, учир нь бид нэг юм.

Сүнсний мөн чанар нь би энд байна, би энд нэг сүнстэй байна гэсэн үг биш юм. Энэ тийм биш. Миний сүнс ердөө энд байгаагаасаа илүү том. Сүнс маань энүүгээр нэг байж магадгүй. (Их Багш өрөөг тойруулан зааж үзүүлэв.) Энэ бүгдээрээ би байж болно, гэвч өөр өөр харагддаг. Бурхан ганцхан ба хүн бүр Бурхантай нэг гэдэг шиг биш. Энэ ийм утгаар биш. Энэ нь нэг бие хүн олон махбод гэгчийг багтаасан аугаа сүнстэй байж болно гэсэн утгаар юм. Тэгэхлээр бид бие биенээ хараад таньдаг шигээ таньж чадах юм.

Заримдаа хоёр өөр хүн нэг зэрэг яг адилхан юм бодсон байхтай энэ төстэй. Энэ бол тэд Бурхантай нэг юмуу, эсвэл бие биетэйгээ нэг учраас биш, харин нэг сүнс болохоор л тэр. Гэхдээ тэд яг л ихрүүд юмуу сүнсний хос шиг л нэг сүнс юм. Сүнсний хос гэдэг нь зөвхөн ганцхан байх биш, олон байна гэсэн утгатай. Учир нь зарим аугаа сүнс их олон төрөлтнийг өөрийн зорилгод багтаадаг. Тиймээс бид ах эгч шиг гэдгээ мэдэрдэг; бид нэг юм шиг санагддаг. Заримдаа та ах эсвэл эгчтэйгээ, ээж эсвэл аавтайгаа байх их сайхан санагддаг, учир нь энэ нь та юм! Та үүнийг гэр бүл болгодог, гэхдээ ердөө ганц нэг сүнс бөгөөд олон хувь хүмүүс. (Алга ташив.)

Тиймээс бид заримдаа “Би тэр хүнтэй барилдлагатай.” гэж хэлдэг. Эсвэл “Тэр эмэгтэй миний сүнсний хос; тэр эрэгтэй миний сүнсний хос.” гэдэг. Учир нь энэ бол та; үнэхээр та мөн. Энэ бол нэг сүнсэн доторх та нарын бие даасан сүнсний бүлэг гэж би бодож байна. Бурхантай нэг байхаас гадна, бусад хүмүүстэй нэг байхаас гадна, нэг сүнс мэтээр олон хувь хүний том бүлгийг багтааж чадах бие даасан сүнс бидэнд бас бий. Гэвч энэ нь өөр харагддаг.

Тиймээс бидэнд зарим хүмүүсийн дунд байх маш сайхан санагддаг. Бид тэдэнтэй илүү ихээр хамтрах тусам, улам хүчтэй болсноо мэдэрдэг, учир нь бид өөртэйгөө хамт өөрийн гэртээ байна. Бид хамтдаа, хамтдаа амар амгалан байна. Энэ бол гайхах зүйл биш; бид тун сайн ажилладагт гайхах зүйлгүй! Та нар бол би гэдгийг төсөөлж чадах уу? (Инээлдэв.)

Бид цөмөөрөө Орчлонгийн аугаа үйлсийн хэсэг

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Флорида, АНУ, 2002 оны 5-р сарын 11, (Дүрс бичлэг №736)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Их Багш аа, аугаа том сүнс заримдаа салгаж тусгаарлаж чаддаг, мөн Та бүх сүнсийг Өөртөө буцаан цуглуулж байгаа гэж Таны хэлэхийг би нэг айлдварын бичлэгээс сонссон юм. Энэ нь “Бурхан бол бүх зүйл.” гэдгээс ялгаатай юу? Би тэр бичлэг дээр хэлснийг сая санасан юм л даа, би Тантай маш их холбоотой гэдгээ мэдэрсэн учраас, Таныг ямар нэгэн байдлаар Өөрийнхөө бүх Би-г Өөр лүүгээ цуглуулж байгаа байх гэж би бодлоо.*

Их Багш: Боломжтой.

Асуулт: *Нэг аугаа сүнс ийм их байх, бас дараа нь дахин бусдыг өөртөө цуглуулж чадах уу? Хүн бүрийг хамарсан цорын ганц аугаа Оришихүй болох Бурханаас энэ өөр гэж үү? Таны хэлсэн санаа энэ гэж би бодсон юм.*

Их Багш: Энэ бол өөр нэгэн, тийм ээ.

Асуулт: *Гэхдээ үнэхээр үзэсгэлэнтэй байсан тул үнэн эсэхийг нь мэдэхийг хүссэн юм.*

Их Багш: Нэг ёсондоо үнэн. Учир нь бид бүгд нэг юм. Зүгээр л бүхэлд нь гүйцээн бүтээхийн тулд бид өөр өөр дүрд тоглох ёстой болсон. Биед гар, хөлийн хуруу, хамар хэрэгтэй. Жишээ нь, бүтэн бие ганц том хамар байж болохгүй биз дээ. (Инээлдэв)

Асуулт: *Тиймээс тэд Тантай уулзахаараа гэртээ байгаа мэт санагдаж, Тан руу сүнснүүд буцан ирж байгаа юм шиг санагддаг.*

Их Багш: Тийм ээ. Тэдний зарим нь аугаа зорилго шалтгааны төлөө ажиллаж, хамтын бүлэг ухамсар шиг л аугаа их үйлсийн хэсэг нь болж яваа юм. Тиймээс тэд нэг ижил зүйлийг хийхээр, эсвэл илүү сайн зүйл хийснээр өөрсдийгөө улам хөгжүүлэхийн тулд дахин буцаж ирдэг.

Асуулт: *Учир нь надад гэртээ байгаа ч юм шиг санагддаг...*

Их Багш: Тийм ээ, гэхдээ авшиг авсны дараа хэн ч ирсэн, бас чин сэтгэлээсээ хандана түүнд гэртээ байгаа мэт санагдана. Учир нь бид бүгдээрээ адил зорилготой ба бид бүгд нэг. Бид хэзээ ч салж тусгаарлагдаж байгаагүй болохоор дахин холбогдсон. Тиймээс хэрэв та холбогдсон бол та өөрийгөө намайг, эсвэл ядаж миний нэг хэсэг гэдгээ мэдэрдэг. Энэ бол хэвийн зүйл. Их Багш мэдээж Өөрийгөө хэдэн мянга, хэдэн сая төрөлтөнд хувааж, бүхэл дэлхийг бүтээж чадна. Гэвч энэ нь зөвхөн энэ төдий биш.

Асуулт: *Их Багш үүнийг хийдэг үү?*

Их Багш: Бас л тийм, заримдаа Их Багш Өөрийн “хуваагдал”-ынхаа заримыг Өөрийнхөө ажилд туслуулахаар авах шаардлагатай болдог. Тэгэхээр танд хэн их ажиллаж, чин сэтгэлтэй байж, сайн туршлагатай байгаа харагдана, тэр бүхэн тэрхүү Их Багшийн нэг жижиг хэсэг нь л байж таарна.

Асуулт: *Амьдралын минь бүх муу мөч бүрт надад тусалж байдагт Тандаа баярлалаа гэж хэлье. Тийм л байгаа.*

Их Багш: Муу мөчид үү, сайн мөчид үү?

Асуулт: *Муу сайн аль ч мөчид.*

Их Багш: Зүгээр.

Асуулт: *Баярлалаа.*

Их Багш: Зүгээр ээ. Бурханд талархъя!

Бүлэг 9
Гэрлэлт ба Сүнслэг хөгжил



Хэрвээ бид үнэхээр л “Хөршөө хайрла” гэсэн замналаар амьдрахыг хүсэж байвал хөршүүддээ амьтан найз нөхдөө багтаах ёстой, ялангуяа тэд бидэнд ямар ч хор хөнөөл учруулахгүй учраас Тэд бидний амьдралыг зөвхөн чимэглэдэг; тэд хайр татаж, бидний амьдралыг илүү амьд хөхиүн хөгжүүн, өнгөлөг бас сонирхолтой болгодог. Бид тэднийг хамгаалах, асрах, хайрлах бас тэдний байгааг таашаах хэрэгтэй. Бурхан үүнийг тодорхой болгосон; Тэр “Би бүх амьтдыг та нарын найз байг, та нарт туслаг гэж бүтээсэн.” хэмээн айлдсан.

~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Гэрлэсэн ч бай, үгүй ч бай өөрөөрөө л байгаарай

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Өмнөд Африкийн Кейп Таун хот, 1999 оны 12-р сарын 2 (Дүрс бичлэг №676)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Их Багш аа, сүнслэг хүмүүст гэрлэж амьдрахад саад болдог зүйл байгаа эсэхийг л би мэдэхийг хүссэн юм, учир нь миний мэдэхээр бол ихэнх сүнслэг хүмүүс, санваартнууд болон бусад олон хүн ганц бие байдаг.*

Их Багш: Өө, тиймээс номлогч нар сүнслэг байдаг гэж үү. Та үүнд итгэлтэй байна уу?

Асуулт: *Тэд шаашин шүтлэгтэй; би үүнийг хэлж чадна.*

Их Багш: За за. Хүсвэл ганц бие байж болно, хүсвэл гэрлэж болно. Энд ялгаа байхгүй. Гэхдээ ялгаа нь та үүнийг хэрхэн зохицуулдагт л байгаа юм. Гэрлэхээр Бурханыг олж чадахгүй гэсэн үг биш юм. Тийм байсан бол Бурхан эрэгтэй бас эмэгтэй хүнийг бүтээхгүй байсан, харин Бурхан эрэгтэй хүнийг ганцааранг нь, эсвэл эмэгтэй хүнийг ганцааранг нь бүтээх байсан. Ойлгож байна уу? Нэгт ийм байна.

Хоёрт гэвэл, үнэндээ та гэрлэсний дараа тэр амьдралдаа илүү их дасаж, хэсэг хугацааны дараа сүнслэг хөгжилд илүү их анхаарал хандуулдаг. Учир нь та ямар байдгийг нь нэгэнт мэддэг болж, үүнд шунахаа больдог, эхнэртэйгээ хэсэг амьдарсны дараа найзууд болчихдог. Ихэнхдээ ийм байдаг. Тэгэхлээр ганц бие эсвэл гэрлэсэн байх нь эцсийн дүндээ бараг адилхан. Гэвч ихэнх гэрлэсэн хүмүүс, анхаарлаа эхнэр, нөхөртөө дэндүү хандуулаад, Бурхан дээр төвлөрөх нь хэцүү байдаг. Энэ л асуудал байж магадгүй юм. Гэвч та харилцааны энергийг хэрхэн зохицуулахаа мэддэг бол энэ нь таны сүнслэг байдалд харин ч тусална, учир нь та бие махбодын хувьд ч жаргалтай, сэтгэл ч аз жаргалтай байдаг. Та хэн нэгнийг хайрлаж байхдаа биеэрээ, сэтгэл хөдлөлөөрөө, сэтгэл зүйгээрээ их жаргалтай байдаг. Тэгэхлээр таны сүнслэг амьдрал илүү хурдасдаг. Бурхан хайрыг дэмий зохиогоогүй.

Тэгээд л тэр. Биеийн хайр эсвэл гэрлэлтийн хайр бол Бурханы хайрын хэсэг; энэ нь Бурханы хайрын нэгэн хуулбар юм. Энэ нь танд аугаа их хайрыг олоход тусалдаг. Гэрлэлтэд харшилтай байх хэрэггүй. Зүгээр л хэвийн бай. Гэрлэмээр байвал гэрлэ, гэрлэ. Ганц бие баймаар шиг бол ганц биеэрээ л үлд.



Онч Үг

Гэрлэлтийн мөн чанар

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Сао Пауло, Бразил, 1989 оны 6-р сарын 15
(Дүрс бичлэг №82А) (Эх нь Хятад хэлээр)

Гэрлэлтэд муу юм ердөө байхгүй. Гагцхүү зарим хүн үүнийг бие махбодын таашаал авах хэрэгсэл болгон ашиглаж байвал л энэ сайн зүйл биш. Хосууд бие биедээ хүндэтгэлтэй хандаж, овог нэрээ авч явах үр хүүхэд төрүүлж, эв найртай зохицон амьдарч, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлж, эцэг эхээ асран халамжилж, нийгэмдээ үйлчилж чадвал гэрлэлт сайн. Энэ нь биднийг зоригжуулж, тогтвортой уур амьсгалд амьдрах боломж олгоно. Энэ нь бидэнд итгэл найдвар, халуун дулаан мэдрэмжийг төрүүлэхийн зэрэгцээ ажиллаж хөдөлмөрлөн, ирээдүйтэй нүүр тулах эр зориг, урам зориг өгдөг. Ийм гэрлэлт бол их сайн.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Камбож улсын Пном Пен хот, 1996 оны 7-р сарын 23, (Дүрс бичлэг №561)
(Эх нь Хятад хэлээр)

Энэ дэлхий дээр гэрлэлт, нөхөрлөл хоёр хоёулаа сайн талтай. Хамгийн аугаа давуу тал нь бид харилцан тусалж, өөрсдийн Мөн чанар, сүнслэг бясалгал дадлын чухлыг бие биедээ харилцан сануулах явдал юм. Хэрвээ бидэнд сүнслэг бясалгал болон дотоод Мөн Чанарыг маань үргэлж сануулж байдаг аливаа нөхцөл байдал буюу аливаа харилцаа байгаа бол энэ нь сэтгэл хөдлөл ба сэтгэлийн сайн холбоо бүхий сайн харилцаа мөн.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Коста Рика, 1990 оны 12-р сарын 16, (Дүрс бичлэг №141)
(Эх нь Англи хэлээр)

Гэрлэлт бол бие биеийнхээ амьдралыг сайжруулахыг хичээж, бие биеийнхээ үзэл санааг дэмжиж, амьдралаа илүү эрхэм ариун болгохыг хичээх нөхөрлөл юм.



Онч Үг

Амьдралын хамгийн сайн замыг сонгох

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Олон улсын дөрвөн өдрийн даяан, Вашингтон, АНУ, 1997 оны 12-р сарын 24
(Дүрс бичлэг №604) (Эх нь Англи хэлээр)

Ганц бие байхаар асуудал гардаг. Гэрлэсэн бол бас л асуудал гардаг. Гэхдээ ганц бие байх нь арай асуудал багатай, илүү эрх чөлөөтэй, магадгүй илүү ганцаардах байх гэж би хэлэх байна. Гэрлэсэн бол танд илүү зугаатай байдаг, гэхдээ бас л илүү төвөг бэрхшээлтэй байдаг. Та энэ амьдралдаа авахыг хүссэн бүхэндээ төлбөр төлдөг. Мөн та аль ч тохиолдолд бэлэн байх ёстой. Тиймээс та өөрийнхөө сонголтыг хийгээрэй. Хэрэв та гэрлэсэн бол Гэгээнтэн болж чадахгүй гэсэн үг биш юм.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Малайз улс, 1992 оны 2-р сарын 25 (Дүрс бичлэг №219)
(Эх нь Англи хэлээр)

Бурхан биднийг эхнэр нөхрөө дассан сурснаараа хайрлахыг хориглохоор тийм явцуу бодолтой нэгэн биш юм. Бурхан Өөртөө ирүүлэхийн тулд хайртай хосуудыг хагацуулах тийм харгис нэгэн ч биш. Бурханыг болон бусад төрөлтнүүдийг, түүний дотор өөрийн гэр бүлээ хайрлахын тулд бид зүрх сэтгэлээ уужим болгох хэрэгтэй. Бид өөрсдөөсөө харь холын төрөлтнүүдийг, мөн үл таних нэгнийг хайрлаж чадах юм бол яагаад гэр бүлийн гишүүд, ойр дотно хайртай хүмүүсээ хайрлаж чадахгүй гэж?

Зүрх сэтгэлийн асуудлаа зохицуулах нь

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Сингапур улс, 1993 оны 3-р сарын 9, (Дүрс бичлэг №328)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Эрхэм Их Багш аа, аз жаргалгүй гэрлэсэн эрэгтэй хүн дараа нь өөр гэрлэсэн бүсгүйд дурлавал хэрхэн даван туулах вэ?*

Их Багш: Та өөрийнхөө гэрлэлтийг шинжиж, аврагдах боломжгүй, засаж залруулах эсвэл сайжруулах огт боломжгүй болсон эсэхийг олж мэдэх хэрэгтэй. Эсвэл та өөртөө таашаал авах шалтаг болгож л өөр харилцаанаас хайр дурлал хайж байна уу гэдгээ хар. Учир нь ганц удаагийн гэрлэлт ч хэдийн хангалттай хүндрэлтэй байдаг. Тиймээс гэр бүлийн харилцаагаа анхаарч халамжилж чадаж байх нь илүү дээр. Энэ хэцүү гэдгийг би мэднэ; энэ дэлхий дээр бүх зүйл хэцүү байдаг. Гэхдээ энэ нь боломжгүй гэсэн үг биш.

Асуудал юунд байгааг эхнэртэйгээ ярилцаарай. Гэхдээ түүнд нууц амрагийн явдлаа хэлээд хэрэггүй л дээ. Хэрэв та энэ талаар хэлчихвэл өөр шийдэл байхгүй болно. Зүгээр ээ; та үүнийг алдаа байсан гэж бодож байвал үүнийг багасгах эсвэл орхихыг хичээж болно. Харин эхнэртэйгээ харилцаагаа хэрхэн сайжруулах талаар ярилцаарай: тэр юун дээр алдаж байна, та юун дээр алдаж байна, тэр юунд анхаарах эсвэл сайжруулах нь танд хэрэгтэй байна, эсвэл та түүнд юугаар туслалцаа үзүүлэх хэрэгтэй байна гээд ярилцаарай.

Хоорондоо ярилц. Түүнд шинэ бэлэг худалдаж ав; түүнд гоё хувцас худалдаж авч өг. Түүнийг гоё юмаар чим; түүнийг гоё болго. Өөр хүний эмэгтэйд цаг зав, эрч хүчээ зарцуулахын оронд гэргийгээ амьдралынхаа гоо үзэсгэлэн болго. Учир нь та нөгөө эмэгтэйд яагаад ч өөрийн болгохгүй. Бусдын эзэмшил дээр цаг зав, эрч хүчээ үрэхийн оронд өөрт байгаа зүйлдээ санаа тавих нь дээр. Хөршийнхөө машинд хэчнээн дуртай байсан ч та очоод алтаар шүршихгүй.

Өөрийнхөө машиныг шүрш! Та машинаа унаж байгаа, танд өдөр бүр хэрэгтэй байгаа тул өөрийн машинаа л анхаарч үзээрэй. Машин танд хэрэгцээтэй. Хөршийнхөө машиныг та чимээгүйхэн биширч болох ч түүн дээр алт шүрших хэрэггүй. Түүнийг хэт их алмайрч байгаад өөрийнхөө машиныг хайхрахгүй орхих хэрэггүй. Нэг л өдөр хөршийн машиныг жолооч нь унаад яваад өгнө, тэгэхэд та гэнэт унах унаагүй явахад хүрнэ. Таны машин гарааш дотроо, анхаараагүй болохоор эвдэрчихсэн, тэгээд та асуудалтай болсон байна.

Тиймээс та гэрлэлтээ үнэ цэнтэй гэж бодож байвал гэрлэлтийнхээ төлөө ажилла. Мөн үүнийхээ зэрэгцээ бусдын гэрлэлтийг хүндэтгэ. Хайртай зүйлээ орхиход сэтгэл шархална. Гэхдээ нөгөө эрэгтэйг бодоорой. Хэрвээ та түүний оронд байсан бол баяртай байх уу? Та эхнэрээ өөрт тань итгэлтэй, үнэнч байхыг илүү эрхэмлэхгүй гэж үү? Тиймээс эхнэрээ сайн эхнэр, өөрийгөө сайн нөхөр байлга. Хөршийнхөө эхнэрийг бас нөхрийнхээ сайн эхнэр нь байлга. Хэрвээ та илүү дээрийг олоогүй бол энэ хамгийн сайн шийдэл байх болно.

Гэр бүлийн хувийн асуудлаараа надад итгэж хандсанд баярлалаа. Гэхдээ энэ бас маш чухал сэдэв юм. Таны сэтгэл амар амгалан биш байвал хэдэн эхнэртэй байгаад ч ажил төрөл, бүх зүйл тань буруудна. Байгаа зүйлдээ сэтгэл хангалуун байж, түүнийгээ арчилж, үзэсгэлэнтэй болгох нь дээр. Түүнийг өөрийнхөө таашаалд нийцүүлэн улам үзэсгэлэнтэй болго. Ингэж яг өөрийн цэцэрлэгээ ургуулж, өөрийн сарнайгаа тарьж байгаа юм шиг л өөртөө байгаа зүйлээ өөрийнхөө төлөө гоё сайхан болго.



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Олон улсын 5 өдрийн даяан, Лонг Бийч, КА, АНУ
1996 оны 12-р сарын 28 (Дүрс бичлэг №573)
(Эх нь Англи хэлээр)

Хайр бол яг л мод, цэцэгтэй адил бөгөөд өдөр бүр, ядаж хуурай улиралд услах шаардлагатай байдаг. Тэгэхгүй бол үхнэ. Өө! Би чамд хайртай гээд хэлчихэд л энэ үүрдийнх байх болно гэж хүмүүс боддог. Үгүй, үгүй. Та хайр халамж, өдөр тутмын тордолт, бие биеийнхээ үнэ цэн ба нинжин сайхан сэтгэлийг үнэлэн сайшаах замаар үүнийгээ тэжээн тэтгэж, хайртай хүндээ дотоодынхоо хамгийн сайн чанарыг хөгжүүлэхэд нь туслах ёстой. Энэ бол жинхэнэ гэрлэлт. Энэ бол жинхэнэ түншлэл юм.

Гэрлэлтийн зөрчлийг шийдэх арга

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Малайз улс, 1992 оны 2-р сарын 25 (Дүрс бичлэг №219)
(Эх нь Англи хэлээр)

Зарим хүн урьд өмнө нь хэцүү гэрлэлтийг амссан туршлагаасаа үүдэн ухаалаг байдаг. Тиймээс тэд ахин гэрлэхээс зайлсхийдэг, магадгүй үүнээсээ болж лам хувраг болдог. Тэд магадгүй гэрлэлтийг хангалттай үзэж туулсан байх, тиймээс дахин ийм судалгаа, туршилт хийх хэрэгцээ тэдэнд байхгүй болсон. Тиймээс тэд энэ удаагийн амьдралдаа гэрлэхгүй. Тэд ганцаараа байгаадаа сэтгэл хангалуун байдаг.

Гэхдээ та хэдийн гэрлэсэн бол нэг ханьтайгаа л байхыг хичээ. Хэр хэцүү байх нь хамаагүй. Жишээ нь, Толстой маш хэцүү эхнэртэй байсан гэж би сонссон. Тэгээд нэг өдөр найзтайгаа ярилцаж байтал эхнэр нь маш муухай аашилж аяглажээ. Тэр түүнийг гутааж, найзынх нь нүүрэн дээр доромжилж байгаа мэт сэтгэгдэл төрүүлж байв.

Тэгэхээр нь найз нь “Чи тэрнээс том шүү дээ. Тэр гавихгүй жижиг амьтан. Чи тэр чөтгөрт ямар хүчтэйгээ харуулаад, нэг мөсөн шийдчихэд яадаг юм! Чи яаж энэ бүхэнтэй эвлэрч суудаг байна аа?” гэж хэлжээ. Толстой ингэж хариулжээ: “Чшш! Битгий их чанга ярь. Би наадахыг чинь урьд нь, өмнөх амьдралдаа туршиж үзсэн. Тийм ч учраас би одоо ‘давхар орлого’ -той байгаа юм! Дахиж тийм зүйл хийгээгүй нь дээр, тэгэхгүй бол дараагийн амьдралдаа гурав дахин орлоготой болчих гээд байна.” Тэрээр: “Би үүнтэй эвлэрэх хэрэгтэй. Учир нь би дахин давтвал, үүнээс хэзээ ч мултрахгүй.” гэж хэлжээ. Тэрээр орлого нь гурав дахин их болно, үргэлж улам л илүү байх болно гэдгийг мэджээ. Тиймээс тэр үүнтэй эвлэрч тэвчихийг хичээсэн.

Хэрвээ та аймшигтай гэмээр хань ижилтэй бол бас түүнийг танд хэрэгтэй гэж бодож байгаа бол энэ нь та хоёрын бие биетэйгээ амьдрах хамгийн сүүлчийн холбоо юм. Та үүнийг төлөх ёстой. Тиймээс өрийг хурдан төлөхийн тулд үүнийг тэвчиж, чадах бүхнээ хийж, тэр хүнийг сэтгэл хангалуун байлгахыг хичээ. Дайснаас ангижрах хамгийн сайн арга бол түүнийг найзаа болгох явдал юм. Аймшигтай эхнэрээс, эсвэл аймшигтай нөхрөөс ангижрах хамгийн сайн арга бол түүнд таалагдах, түүний бүх нэхэл шаардлагыг биелүүлэх юм. Тэгээд л тэр таны найз болно.



Онч Үг

Гэрлэлт бүтэмжтэй байх нь

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Олон улсын 5 өдрийн даяан, Лонг Бийч, КА, АНУ,
1996 оны 12-р сарын 28 (Дүрс бичлэг №573)
(Эх нь Англи хэлээр)

Гэрлэлт бол хараат байдал, боолчлол гэсэн утгатай биш. Гэрлэлт бол зүгээр л түншлэл нөхөрлөл юм. Нэг нь нөгөөгөө зоригжуулах ёстой. Зарим хүн буруугаар ойлгодог болохоор гэрлэлт бүтдэггүй. Гэхдээ та нэг л ойлголттой байж, тайлбарлахыг хичээх хэрэгтэй. Гагцхүү олон удаагийн сорилт, айдас түгшүүр болон үр дүнд хүрэхгүй байсны дараа л та өөрийнхөө сүнслэг хөгжил, аюулгүй байдлын төлөө ямар арга зам таньд бас түүнд ч тохирох талаар анхаарч бодож үзэж магадгүй.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Олон улсын 5 өдрийн даяан, Лонг Бийч, КА, АНУ, 1996 оны 12-р сарын 28
(Дүрс бичлэг № 573) (Эх нь Англи хэлээр)

Хүссэн зүйлээ авдаг нэгэн байхын оронд өөрийнхөө хүсэж буй хүн нь бай. Зүгээр л нэгэн бай. Та нөхрөө дэврүүн сайхан байгаагаас гээж хүсэж байгаа бол та өөрөө яагаад ийм байж болохгүй гэж? Тэгээд тэр сурна, хамтарч ажиллана. Эсвэл та эхнэрээ аятайхан бас дэврүүн сайхан байлгахыг хүсвэл, та түүнээс юу хүсэж байгаагаа, юунд дуртайгаа хэл, эсвэл өвөрмөц байдлаар битүүхэн цухуйлга. Харилцаан дээрээ ажиллаж, бие биенийхээ хамгийн сайн сайхныг гаргаж ир. Энэ бол хамгийн шилдэг нь.

Гэрлэлтээ хадгалахыг хамгийн сайнаар хичээ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Калифорнийн Их Сургууль, Ирвинс, КА, АНУ, 1998 оны 6-р сарын 2
(Дүрс бичлэг №623) (Эх нь Англи хэлээр)

Асуулт: *Гэр бүл салалтын талаар та юу гэж боддог вэ?*

Их Багш: Энэ муу хэрэг шүү; гэр бүл салалт бол хайрын харилцааны эцсийн шийдэл юм. Энэ огт тохиолдох ёсгүй зүйл. Гэхдээ эрэгтэй, эмэгтэй хүн маш их ялгаатай тул хоорондоо учраа олох маш хэцүү байдаг. Эрэгтэйчүүд илүү бүдүүн тойм, илүү шулуун, энгийн, харин эмэгтэйчүүд илүү мэдрэмжтэй, илүү дэврүүн сайхан сэтгэлтэй байдаг. Тиймээс дайчин эр ба гоо бүсгүй хоёр тэр бүр сайн зохицолдоод байдаггүй ч хоорондоо эвлэрэх олон арга бий. Гэрлэлтийн зөвлөгөө өгөх газар байдаг ба энэ тухай зөндөө ном бий. Мэдээж хэрэг, ялгааг эвлэрүүлэх олон бясалгал байдаг. Та хоёр хоёулаа өөрчлөгдөж, илүү хайрлаж, илүү ойлголцож, хүсэлт шаардлага багатай болж байгаагаа харна. Хэрвээ та хоёр бараг ижил дэс түвшинд байгаа бол ийм болно; үгүй бол зөрчилдсөн хэвээр байдаг. Гэхдээ та хоёр бие биенээ хайрласаар байх болно. Та дотоод амар амгаланг бясалгадаггүй бусад хүмүүс шиг салалтыг эцсийн шийдэл болгохгүй. Тийм хүмүүс салах нь их.

Би тэр үед гэгээрчихсэн байсан бол нөхрөөсөө салахгүй байх байсан. Би танд хэлье, тэр хамгийн сайн нөхөр байсан, одоо ч гэсэн. Гэхдээ тэр одоо өөр хэн нэгний хамгийн сайн нөхөр болсон. Гэгээрсний дараа та хань ижлээ илүү их үнэлж сурах болно. Эхнэр нөхөр хоёр хамтдаа бясалгал дадуулбал гэр бүлийн олон зөрчилдөөн авшиг хүртсэний дараа арилдаг.

Та хоёр хоёулаа Бурхан гэдгээ ойлгож ухаардаг учраас энэ нь үнэхээр тусалдаг. Таны дотоодоос хайр ундран гарч эр эм хүн хоорондын бүх ялгааг бүрхэн тэлэх болно. Бид бие биеэ хайрлаж, бие биенээ бүр Бурхан гэж хүндэлж сурах болно. Бие махбодын хайраас гадна өөр нэг ариун хайр байдаг нь та хоёрыг харилцан холбож, улам их хайр дүүрэн, илүү хариуцлагатай, бие биенийхээ дотоод мэдрэмж, хэрэгцээг илүү мэдэрдэг нэгэн болгодог.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Сингапур, 1993 оны 3-р сарын 10
(Дүрс бичлэг №329) (Эх нь Англи хэлээр)



*Хүний хувийн, гэр
бүлийн асуудлууд сүнслэг
талбарт хамаатай гэж
харагддаггүй. Гэвч
хамаатай байдаг. Таны
амьдрал зовлонтой,
ганцаардмал, таны нөхөр
бэрхшээлтэй, гэр бүлийн
хагарлаас таны хүүхдүүд
аз жаргалгүй байж байхад
танд бясалгахыг сургаж,
Гэгээнтэн болгох гэж
байгаа нь танд болон
надад сайн учраас л бус уу?
Мөн би та нарт тамыг
биш, Диваажинг авчрахыг
аль хэдийнээс хүссэн. Иймд
амьдралаа сайхан болгож,
орчноо гоёж, бататгаж,
гэр бүлээ нэгтгэн
бэхжүүлэхийн тулд энэ
дэлхийгээс ашиглаж болох бүхнийг
хэрэглэ, үүнд хүлэгдэж баригдалгүй,
зүгээр л ашиглаарай.*

Гэрлэлт болон Сүнслэг хөгжил

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Долоон өдрийн даяан, Шиху, Миаоли, Формоса, 1991 оны 5-р сарын 5-12
(Дүрс бичлэг №165) (Эх нь Хятад хэлээр)

Намайг гэрлэлт, хайр сэтгэлийн талаар ярихаар өөрт хамаатай зүйлээс хэтэрч байна гэж та нар битгий бодоорой. Тийм биш! Хэрэв та нарын гэрлэлт аз жаргалгүй, хань ижилтэйгээ сайхан харилцаатай биш байвал бясалгахдаа Самадид орж чаддаггүй учраас л би энэ тухай ярьдаг юм. Та нар дотроо шаналж, сэтгэл тань үймэрдэг. Бодол санаа тань энэ бүх зүйлсээр дүүрсэн байдаг. Самадид орох нь бүү хэл, Ариун Нэрсээ ч уншиж чаддаггүй. Ийм үед ижил хос тань танд Их Багшаас илүү чухал болсон байдаг. Гэсэн ч энэ бүхнээс зугатах аргагүй учраас би та нарыг буруутгахгүй. Ийм үед та нар бүр Нирваанд орохыг ч хүсдэггүй. Хүслээ ч аз жаргалгүй учраас та нар чадахгүй. Энэ бүхнийг би урьд нь туулж өнгөрүүлсэн учраас та нарт зааж хэлж чадна. Иймэрхүү нөхцөл байдлаас зайлсхийж, хянахад хэцүү.

Мэдээж хэрэг, бид сүнслэгээр дэвшсэнээр гэр бүлийн нандин харилцаагаа хэрхэн авч явахаа мэддэг. Гэсэн хэдий ч сэтгэлийн дарамтад орж, дотооддоо шаналж буй зарим нэг бясалгагч байна. Сүнслэг бясалгал дадалд тань ийм хамаатай учраас л би та нарт дэлхийн энэ хэрэг явдлын талаар ярих хэрэгтэй болж байна. Та нар аз жаргалтай байхдаа л Нирваанд байдаг. Хэн ч тань дээр ирсэн та аз жаргалтай байж, хэнийг ч хайрлаж, хэнийг ч уучилж, хэнд ч юуг ч өгч чаддаг. Харин та аз жаргалгүй байвал юу ч хийхийг, эсвэл ямар ч үүрэг хариуцлага үүрэхийг хүсдэггүй. Та хүссэн ч чадахгүй, учир нь ингэх урам зориггүй болсон байдаг.

Ийм үед та бүх зүйлээс залхаж бүхий л дэлхийг мартахыг хүсдэг. Ийм ч учраас “Дээдийн номын мөр хорвоогийн хэрэг явдалд оршдог.” гэсэн үг бий. Миний хэлж буй зөв үү? (Танхим: Тийм ээ) Тийм байна. Та нарт ийм юм тохиолдож байжээ.

Тиймээс сүнслэг зам мөрөөр цаашид саадгүй замнахыг хүсэж байвал өөрийн сэтгэл хөдлөл, мөн гэрлэлтээ хамгаалах хэрэгтэй гэж би та нарт олонтоо хэлдэг. Гэрлээгүй байгаа хүмүүс нь бие биедээ үнэхээр хайртай бол хайр сэтгэлээ хамгаалах хэрэгтэй. Нэгэнт салж холдсон хойноо алдаагаа засах гэвэл хэтэрхий оройтно шүү. Жаргалтай цаг мөч мөнх үргэлжилдэггүй. Нэгэнт түүнийгээ олсон бол халамжилж байх хэрэгтэй.

Үүнийг ялихгүй жижиг, хорвоогийн хэрэг явдал мэт бүү бод. Тийм биш шүү! Тийм биш! Хань ижилгүй үед хүн их ганцаарддаг. Зарим нь болоод байдаг ч ихэнх нь чаддаггүй. Танд энэ яавч хэрэгтэй бол түүнийгээ хамгаалах тал дээр анхаараарай.

Хайр сэтгэлийг байтугай, өчүүхэн сувдыг ч эрдэнэ мэт хамгаалж хайрладаг! Хайр танд тун тустай байж чадна. Түүнд хүлэгдэж хэрэггүй хэдий ч, тоохгүй орхиж бас болохгүй. Машин тантай адил хүн биш, эсвэл таны нэг хэсэг биш байж болох ч Шихүд очих гэвэл танд машин хэрэгтэй. Явган явж очих нь хэтэрхий тухгүй, цаг барсан хэрэг болно. “Би сүнслэгээр бясалгаж гэгээрэхийн тулд Шихү рүү явж байна. Надад машин ямар хэрэгтэй юм бэ? Ердөө л машин төдий шүү дээ. Замын хажууд хаячихъя!” гэж болохгүй. Тэгж болохгүй. Машин таныг энд, над дээр бүр богино хугацаанд түргэн хүргэж ирдэг. Ингэснээр та бясалгалдаа илүү их цаг гаргах болно. Мэдээж та явган явж ирж болох ч, хэдэн сар зарцуулан таныг энд ирэх үед Би явчихсан байж магадгүй.

Сайн хань ижил бай

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Флорида, АНУ, 1998 оны 10-р сарын 4
(Дүрс бичлэг №638)

Бид хань ижлээ ийм тийм байх, эсвэл энийг эсвэл тэрийг хийнэ гэж хүлээдэг. Тэгээд тэд хийхгүй бол бидний урам хугардаг. Тэд бидэнд таалагдахгүй бол бид урам хугарч, сэтгэл гонсойх ба энэ бүхнээс болж харилцаагаа тасалдаг. Гэвч энэ харилцаа нь таны хүссэнийг хийнэ гэж нөгөө хүнээсээ хүлээх зорилготой биш юм. Энэ нь та өөрөө хүссэн зүйлээ хийх, хэн байх, өөрийгөө ямар хүн бэ, хэр сайн, ямар байхыг хүсэж байгаагаа харуулах, энэ харилцаа, гэрлэлтийн явцад ямар хүн болохыг хүсэж байгаагаа харуулах явдал юм. Та сайн эхнэр, “дээд зэргийн-эхнэр”, тэвчээртэй эсвэл үнэнч нэгэн байхыг хүсэж магадгүй юм. Энэ бол та өөрийнхөө дүрд ямар байхыг хүсэж байгаа хэрэг болохоос биш үргэлж нөхрөөсөө ямар байх, танд хэрхэн хандах, тантай хэрхэн ярихыг нь хүлээх тухай биш юм.

Гэвч энэ бол гэрлэлтэд байдаг асуудал юм; та бүгдийг буруу ойлгосон байдаг. “За, одоо би түүнтэй уулзлаа, миний амьдрал өөрчлөгдсөн. Гайхалтай. Тэр намайг жаргалтай болгоно.” гэж та боддог. Энэ үнэн биш! Та энэ харилцаанд өөрийгөө аз жаргалтай байлгана, эсвэл үгүй. Гэтэл бид ихэнхдээ хамтрагчаасаа биднийг жаргалтай болгож, зурган дээрх бидэнд таалагддаг тэр хүн байх болно гэж горьдож хүлээдэг. Асуудал үүнд байна. Бид өөрөө хүссэнээрээ байхаа мартдаг. Бид өөртөө тохирох мөрийн хөтөлбөр гаргахаа мартдаг. Оронд нь бид хамтрагчдаа зориулсан нэгэн хөтөлбөр, хамтрагч талаа тааруулан нийцүүлэх дүр зураг эсвэл нэг төрлийн уулзалт зохиож гаргадаг. Тэгээд дараа нь аль аль тал нь ижил зүйлийг горьдож хүлээдэг, ингэж л бүх зүйл нурдаг.

Бид бүгдийг буруу ойлгосон байдаг. Ямар ч нөхцөлд бид зөвхөн өөрийгөө л шинжих хэрэгтэй. Энэ нөхцөл байдалд бид юу хийх гэж байна вэ? Бид юу болох вэ? Бид юу харуулахыг хүсэж байна вэ? Бид сайн сайхны аль хэсгийг хамтрагчдаа юмуу дэлхийд бэлэглэх гэж байна? Ямар нэг зүйл бэлэглэх ёстой хүн нь хань ижил чинь биш юм. Тэр юу бэлэглэхийг хүсэх нь түүний л асуудал. Бидний асуудал бол ердөө бид өөрсдөө л юм; үргэлж л бид байдаг. Гэтэл ихэнх хүн гэрлэсэн ч юмуу хамтрагчтай эсвэл найзтай бол бүх анхаарлаа нөгөө тал, нөгөө хагас руугаа хандуулчихаад л шиншилж шалгаад л, “Өө, тэр эрэгтэй буруу хийсэн. Тэр эмэгтэй муу хийчихлээ.” эсвэл “Тэр эмэгтэй сайн биш. Тэр эрэгтэй аятайхан биш.” гэдэг. Үүнийгээ март! Бид өөрсдийгөө л шинжин шалгавал зохино. Хамгийн чухал нь бид өөрсдөө. Ямар ч харилцаа, нөхцөл байдал бол бусад хүний биш, бидний өөрсдийн суралцах ёстой зүйл юм. Бусад хүн бол зөвхөн хурдасгагч, бидний өөрийн хүчээ, өөрийнхөө тухай төсөөллийг ашиглах шалтаг юм.

Энэ л асуудал юм. Тийм ч учраас гэрлэлт ихэнхдээ бүтдэггүй. Тиймээс өөрийнхөө гэрлэлтийг шалгаж үзээд засаарай. Энэ бол таны нөхөр эсвэл гэргийн тухай биш, харин та ямар хүн болохыг хүсэж байгаагаас, эсвэл та энэ харилцаанд юу харуулахыг хүсэж байгаагаас чинь хамаарна. Хэрвээ тэр үүнд сайнаар хариу үзүүлбэл зүгээр. Хэрэв сайнаар хариу үзүүлэхгүй бол та энэ талаар их юм хийж гавихгүй. Гэвч та зүгээр л өөрийгөө шалга, тэнцвэртэй байгаа эсэх, зөв зам жимээр явж байгаа эсэх, зүгээр байна уу үгүй юу гэдгээ шалгаарай. Тэр тантай үлдэх бол үлдэнэ, тэр явах бол явна. Та нэг их юм хийж чадахгүй. Та түүнд бүх анхаарлаа хандуулчихаад, өөрийгөө мартаж гээж болохгүй. Та түүнд анхаарал хандуулах тусам улам их алдаа гаргана. Тэгээд тэр улам л шүүмжилж, байдал бүр л дорддог!

Аз жаргалтай гэр бүлийг төлөвшүүлэх нь

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Камбож улсын Пномпен хот, 1996 оны 7-р сарын 23 (Дүрс бичлэг №563)
(Эх нь Англи хэлээр)

Ер нь хөршийн эхнэр үргэлж илүү сайхан харагддаг гэж хүмүүс ярьдаг. Харин би тэгж бодохгүй байна. Эрэгтэйчүүдийн 90% нь хэрэв боломжтой бол нэг эмэгтэйтэйгээ дахин гэрлэхийг хүсдэг гэсэн судалгаа байдаг. Тиймээс ойр хавиар сээтэгнэж гүйчихээд харамсаж, тэр 90%-ийн нэг нь болчих гээд байх хэрэггүй. Тэгээд л эртнээс аваад өнөөг хүртэл бүх Их Багш нар нэг ханьдаа л итгэлтэй, үнэнч байхыг зөвлөжээ. Учир нь таныг тэртээ тэргүй харамсана гэдгийг тэд мэдэж байдаг.

Нэг хүнтэй, танихгүй хүнтэй сайхан таарч нийцдэг болтлоо их хугацаа зарцуулдаг. Эмэгтэй ч бай эрэгтэй ч бай таны хайртай хүн таны хувьд танихгүй хүн. Та түүнийг өмнө нь хэзээ ч мэддэггүй байсан. Түүнийг та сургуулийн анд юмуу ямар нэг байдлаар таньдаг байсан байлаа ч яг хамт амьдрах хүртлээ таны мэдэхгүй байсан зүйл түүний дотор байж л байдаг.

Учир нь та найз залуу, найз охин, сүйт залуу гэх мэтээр үерхэж байхдаа ижил баяр баясгаланг хуваалцдаг ч ижил асуудалд санаа зовдоггүй. Та холдон явж, гэртээ харьж, хүн бүр өөрийнхөө асуудалд санаа зовж, өөрийн үүрэг хариуцлагад анхаардаг. Хамт байхдаа зөвхөн баяр хөөрөө л хуваалцдаг. Тиймээс бүх зүйл өөр, илүү гоёхон байдаг. Мөн аар саар муудалцсан ч гэсэн, зай холдсоноос, хамт байх зуршил юмуу хэрэгцээнээс болоод эргэж нийлээд түргэн уучилдаг. Харин нэгэнт хамт амьдрах болбол та ижил үүрэг хариуцлага, ижил зовнилыг хуваалцах ёстой болдог; ийнхүү юм өөрөөр эргэдэг.

Энэхүү хайрын харилцааг төлөвшүүлэх, бие биенийхээ зуршил болон нөгөө хүнийхээ дотоод сэтгэлийг гүнзгий таньж мэдэхэд удаан хугацаа шаардагдана.

Юмс цаг хугацааны явцад илэрдэг. Та түүний дутагдал, гэртээ “удаан ирдэг”, “хоцордог”, “эрт ирдэг” гэх мэт зүйлд дасдаг. Гэхдээ үүнд дасахад нэлээд хугацаа ордог. Нэгэнт бие биетэйгээ сайн харилцаа үүсгэж, ялгааг даван туулж, таарч тохирч чадсан л бол энэ таны өөрийн бүтээл шиг байх болно. Таны харилцаа бол таны л бүтээл, тиймээс танд сайхан санагдана. Яг л өөртөө байшин барьчихсан юм шиг. Энэ нь хөршийн байшин шиг сайхан биш ч юм уу, өөр харагдах ч юм уу, зарим хүнд тийм ч их таалагдахгүй байсан ч энэ бол таны байшин. Та үүнийг өөрийн гараар бүтээсэн тул түүнд хайртай байдаг. Та түүний нэг хэсэг гэдгээ мэдэрдэг. Тийм ч учраас удаан ханилсан эхнэр эсвэл нөхрөөсөө салж сарних юм бол та шаналдаг. Хэрвээ та өөр хүнтэй шинээр эхлэх хэрэгтэй бол ахиад л наанадаж арван жил шаардагдана.

Яахав, би энд Төв дээрээ бүх “эхнэр нөхрүүд” -тэйгээ харилцах гэж хичээсээр л байна. Би тэднийг хараахан таньж мэдэж амжаагүй байна. Би дандаа гайхширдаг; тэд надад үргэлж л гэнэтийн том бэлэг барьдаг. Би тэднийг бүгдийг нь дотор гадаргүй мэддэг эсэхээ хэзээ ч хэлж чадахгүй. Би тэдний зарим талыг нь мэддэг ч бүгдийг нь биш - тэдний хувийн зан чанарыг мэдэхгүй, дотоод Бурхан чанарыг биш. Би мөн туслахуудтай, гэхдээ заримдаа нэгийг нь солиход хамгийн найгүй нь байсан ч надад тун таагүй санагддаг. Би тэдэнд бүгдийг дахин зааж өгөх ёстой бөгөөд энэ маш их ядаргаатай. Сүүлчийн туслах маань муу байсан ч түүнд бас зарим сайн талууд байсан. Би түүний сайн, муу талуудтай зохицоод хэдийн дасчихсан байсан; би хэрхэн муу нэгэнтэй харьцаж, сайныг нь хүлээж авахаа мэддэг болсон. Гэтэл шинэ дутагдал, муу зуршлууд гарч ирж, би тэр цоо шинэ зүйлстэй дахин харьцах хэрэгтэй болж байна. Энэ нь сэтгэл догдлом ч бас ядаргаатай.

Энэ байдал эхнэр нөхөр хоёрын хувьд ч адилхан. Учир нь тэд анх нийлж байхдаа хамт байхаа тангараглаж, хамтдаа үүрээ барихыг чин сэтгэлээсээ хүсдэг. Тэд харилцаа холбоо, гэр орноо бүтээхэд бүх зүрх сэтгэл, оюун ухаанаа зориулах болно. Тэд их чин сэтгэлтэй. Ингээд тэд одоо бие биенийхээ нэг хэсэг мэт болдог. Үнэхээр тийм учраас бид тэднийг “хань ижил” эсвэл “нөгөө тал” юмуу “илүү сайн тал” минь гэхчлэн нэрлэдэг. Тиймээс тэд салчихаараа хагас болсон юм шиг; тавин хувь болж хоёр хуваагдсан мэт болдог. Ерөнхийдөө тэд ямар нэг зүйл дутагдаж байгааг мэдэрдэг. Өөр хамтрагчтай байшин барих нь адилхан байхгүй; өөр харилцааг бий болгоход ижил биш байх болно.

Хүн болгонд сайн ба муу тал бий; таны тааралдсан төрөлтөн бүрд ямар нэг зүйл дутагдаж байх болно. Тиймээс заримдаа та дараагийн хүн нь дээр, эсвэл нөгөө тал нь юмуу хөршийн эхнэр илүү дээр гэж өдрийн бодол болдог, гэвч тийм байх албагүй. Судалгаанаас харахад ихэнх эрчүүд нөгөө эмэгтэйтэйгээ дахин гэрлэх дуртай байдаг нь шашин, Библи, зарлигууд ямагт зөв байсан гэдгийг нотолж байна. Яагаад гэвэл тэртээ тэргүй хүн бүр Бурхан юм; энэ эмэгтэй Бурхан ч бай, тэр эмэгтэй Бурхан ч бай, Бурхан л байдаг. Тиймээс бид зүгээр л нэг Бурханд нь дасаж магадгүй юм. Тэд өөрийгөө арай ялгаатай болгох тус тусын өөр шинж чанартай. Тэгэхлээр, сүүлийн үед таны харилцаа муудаж, эсвэл гэр бүлд ямар нэг таагүй зүйл байгаа бол та энэ эмэгтэй эсвэл эрэгтэйгээсээ салахыг үнэхээр хүсэж байна уу, эсвэл та өөрөө алдаа гаргасан уу, тэр үнэхээр явчихвал юу болох талаар та дахин бодох хэрэгтэй. Тиймээс та үнэхээр сайн мэдэхгүй байгаа бол хэд хоног гэрээсээ явж, даяан бясалгал гэх мэтийг хийх хэрэгтэй.

Хүмүүс таныг ханьтайгаа адилхан байхын хэрээр сайн харилцаатай байдаг гэж хэлдэг. Энэ нь та хоёр бие биедээ маш их таалагдаж, бие биенийхээ чанарыг өөрөө ч мэдэхгүйгээр шингээн авч, нэг хүн шиг болдог гэсэн үг юм. Таны илэрхийлэл хүртэл өөрчлөгддөг.

Энэ нь яг нохой, муур болон тэдний халамжлагч хүн нь шиг, тэд муур, нохойтойгоо яг адилхан харагддаг. Учир нь тэд нохой, муураа маш их хайрладаг учраас тэдний илэрхийллийг дуурайдаг. Жишээ нь, тэд заандаа хайртай бол яг заан шиг урт хамартай болохын тулд хамраа сунгадаг. (Инээлдэв) Хайртай амьтантайгаа яг адилхан харагддаг олон хүнийг би харсан. Та ч үүнийг мэднэ; та бас тэднийг харсан. Хүмүүс гэрийн тэжээвэр амьтнаа дагуулан цэцэрлэгт хүрээлэнд явж байвал хэн нь хэнийхээ эзэн гэдгийг та зүгээр л хэлж чадахгүй! Тэд хоёулаа дэндүү адилхан. Тэгээд нохой, халамжлагч хүн хоёулаа хоорондоо сайн зохицдог.

Хүмүүсийн харилцаа үүнтэй ижил төстэй: та нар хэдий чинээ адилхан байна, харилцаа чинь төдий сайн байна гэсэн үг юм. Юуны өмнө, бие биедээ таалагддаг учраас та илүү адилхан харагддаг: илэрхийлэл, сэтгэхүй ижил байдаг тул таны гадаад төрх өөрчлөгддөг. Тийм ч учраас хүмүүс Арьяабалын Аргаар бясалгаснаар илүү гоо үзэсгэлэнтэй харагддаг. Аяндаа ийм байдаг. Та Бурхан болохыг хүсдэг, Бурхан бол үзэсгэлэнтэй. Мөн та илүү Бурхантай адил, сахиулсан тэнгэртэй адил чанар луу шилжиж байгаа. Тийм ч учраас таныг харсан хүмүүст хазгар доголлон, эрхтэн дутуу, халзан, бөгтөр байсан ч та зүгээр л үзэсгэлэнтэй санагддаг. Учир нь дотоод Бурхан чанар гэрэлтдэг; гэрэлтэж, гялалзаад л хүн бүрт тун таатай мэдрэмж төрүүлдэг. Учир нь та одоо Бурхан шиг харагдаж байгаа. Бурхан Бурханаа хайрладаг; ижил нь ижлээ татдаг шиг.

Тиймээс хэрэв хосууд хоорондоо маш адилхан харагддаг бол тэд өдөр бүр бие биенээ улам ихээр хайрлах болно. Учир нь үүнийг хүлээн зөвшөөрө: Бид өөртөө хамгийн хайртай байдаг. Тийм биш гэж үү? Бид толинд олон цагаар харж, үлдсэн хэдэн үсээ самнаж, хэдэн ширхэг сахал гэх мэтээ арчилдаг. Бид өөрсдийгөө хайрладаг, энэ нь зөв юм. Асуудал гагцхүү өөрийгөө үзэн ядах үед л үүсдэг. Энэ бол бидний хийж чадах хамгийн нүгэлтэй зүйл. Бид бол Бурхан. Бид л өөрийгөө хайрлахгүй юм бол өөр хэн ч чадахгүй. Хэрвээ бид өөрсдийгөө хайрладаггүй бол Бурханыг хайрладаггүй гэсэн үг юм. Хэрвээ бид өөрийгөө хайрлаж чадахгүй бол өөр хэнийг ч хайрлаж

чадахгүй. Өөрөөсөө түрүүлэн бусдыг хайрла, хөршөө хайрла гэх зэргээр хэн танд хэлэх нь хамаагүй. Эхлээд өөрийгөө хайрла, тэгвэл хөрш тань ч мөн адил байх болно.

Хэрэв та өөрийгөө хайрлахгүй бол бусдыг ч мөн адил хайрлаж чадахгүй. Та хайр гэж юу байдгийг мэдэхгүй. Өөрийгөө хайрлаж байж л өөртөө анхаарч сайн халамжилж чадна. Тэгээд та бусад хүнд юу таалагддагийг бас мэдэх болно - та өөрийгөө үнэхээр хайрлаж, өөртөө анхаарал тавихад ямар мэдрэмж төрдөг, танд юу тухтай байхыг мэднэ. Ингэвэл та мөн ижил зүйлийг дэргэдэх хүндээ хэрхэн санал болгохоо мэддэг, учир нь түүнд юу таатай байхыг та мэдэж байгаа. Би өөрийгөө яаж анхаарч халамжлахаа мэддэг учраас хүн бүр надад сайн ханддаг. Би надад юу сайн байхыг мэддэг. Мөн та харж байгаачлан би өөртөө хайртай. Тиймээс би хэн нэгэнд анхаарал тавихад тэр хүн мэл гайхдаг. Эсвэл тэр амьсгаа нь давчдаж, муужирдаг. Би өөрөө юунд дуртайгаа яг мэддэг учраас түүнд юу таалагдахыг тун сайн мэдэж байдаг.

Би юу ч өмссөн танд таалагдаж байгааг харж байгаа биз дээ? Учир нь би өөрийгөө сайхан харагдуулахын тулд юу өмсөхөө мэддэг. Би өөртөө хайртай. Энэ нь би өөрийгөө эрхлүүлж байгаа юм биш; би ямар ч хувцас өмссөн сайхан харагддаг ба миний хувцас үнэтэй учраас ч биш, таныхтай адилгүйдээ ч биш. Зүгээр л надад юу зохихыг би мэддэг. Би өөрт зохихыг сонгодог тул бараг юу ч өмссөн сайхан харагддаг. Би их үнэтэй зүйлс авдаг юм биш. Би ч гэсэн үнэтэй зүйл өмсдөг, гэхдээ энэ нь үнэтэй зүйл намайг сайхан харагдуулдаг гэсэн үг биш юм. Юу ч бай намайг сайхан харагдуулдаг. Мөн би дуртай өнгөө худалдаж авдаг тул бараг юу ч өмссөн бай сайхан харагддаг. Энэ нь надад сайхан зохино гэсэн мэдрэмж надад байдаг. Тийм ч учраас сайхан харагддаг. Би өөрийгөө сайхан харагдуулах дуртай. Нэгэнт л мөнгө зарцуулахаас хойш яагаад өөрийгөө муухай харагдуулах зүйл худалдаж авах ёстой гэж? Угаах, индүүдэх, өмсөхөд цаг зарцуулах гээд надад адилхан л төвөг болох байтал би яагаад намайг дордуулж харагдуулах зүйлд мөнгө төлөх ёстой гэж? Үүнд л зарчим нь байгаа юм.

Тэгэхлээр би хэрхэн сайхан харагдах, өөрийгөө арчлахыг мэддэг байх юм бол надад өөр хэн нэгнийг халамжлах хэрэг гарахад, тэгэх шаардлага байвал тэр хүнд таатай сайхан сэтгэгдэл төрөх ёстой. Сайхан мэдрэмж төрүүлэхээс өөр сонголт байхгүй. Би үүнийг хэтрүүлдэггүй. Миний хийдэг бүх зүйл яг таг таарсан бөгөөд хурдан байдаг. Мөн энэ нь сайхан, төгс харагдаж, сайхан мэдрэмж төрүүлдэг. Яагаад гэвэл надад хүмүүс хэрхэн хандвал дуртай байхыгаа би мэддэг. Би дэмий юм их ярих, их цаг авах, юмыг хэтрүүлж, хүмүүсийг бачууруулах дургүй. Зүгээр л гол зүйл рүүгээ чиглэнэ.

Тиймээс хэрэв та үнэхээр өөртөө анхаарал тавьж, өөрийгөө хайрлаж чадвал танд анхаарч халамжилж чадахгүй хүн гэж байхгүй болно, та тэдэнд анхаарал халамж тавихгүй байсан ч таны эргэн тойронд тав тухгүй хүн гэж байхгүй байх болно. Учир нь тэд таныг тийм байхсан гэж хүсдэг хүн нь, их амар хялбар, нямбай, энгийн бөгөөд хэзээ ч буруу юм хийдэггүй нэгэн гэж боддог.

Тиймээс өөрийгөө хайрла; өөрийгөө анхаарч халамжил. Гэхдээ их цаг зарцуулахгүйгээр. Нэг хүн надад, “Та үргэлж өөртөө сэтгэл хангалуун, аз жаргалтай харагддаг.” гэсэн. Би “Тийм ээ, би сайхан харагддаг, надад сайхан байдаг. Би сайн байдаг!” гэж хэлсэн. Би зүгээр л өөртөө итгэлтэй байдаг. Магадгүй би энэ дэлхийн шилдэг эмэгтэй шиг харагдахгүй ч би сайхан харагддаг. Тиймээс өөрийгөө сайхан мэдрэмжтэй байлга. Завгүй байсан ч хааяа өөрийгөө энхрийл. Мөн заримдаа өөртөө цаг гарга. Учир нь та энэ гараг дээрх хамгийн үнэ цэнтэй хүн юм. Хүн бүр тийм. Зөвхөн та л өөрийнхөө үнэ цэнийг анхаарч халамжлах ёстой; бусад хүмүүс мөн үнэ цэнтэй, гэхдээ энэ бол тэднийх. Тиймээс таны үнэ цэн танд хамгийн эрхэм юм. Та бол Бурхан учраас өөртөө анхаарал тавь. Сайн бай, сайн сайхан мэдрэмжтэй бай, эрхэм ариун бай. Мөн өөрийнхөө ямар болох тухай хүсэл зорилгодоо тэмүүл.

Хань ижлийн үүргээ биелүүлээрэй

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Шихү, Формоса, 1996 оны 1-р сарын 21 (Дүрс бичлэг №523)
(Эх нь Хятад хэлээр)

Хэдий би та нарт өөрийгөө арчилж тордох, гоо зүйгээ илэрхийлэхийн төлөө чадах бүхнээ хийвэл зохихыг сануулахын тулд гоо сайхны ур чадвар, ариун журмын талаар олон зүйл заадаг ч энэ нь таны гэрлэлт гарцаагүй аз жаргалтай, сэтгэл хангалуун байх баталгаа болохгүй. Учир нь үйлийн үр заримдаа бидний хүлээлтээс өөр нөхцөл байдлыг бий болгодог. Тиймээс, хэрэв бид чадах бүхнээ хийсэн ч гэрлэлт маань амжилтгүй байвал Бурханд биднийг чөлөөлсөнд нь талархах ёстой. Үүнд гомдоллох зүйл алга.

Хэрвээ бид гэрлэлтийн үүргээ биелүүлээгүй бол, гэрлэлт бүтэлгүйтэхэд зүрх сэтгэл тавгүйтэх болно. Энэ нь миний буруу байв уу, сайн хийгээгүй юм болов уу, хоол тааруу хийчихэв үү, эсвэл нөхөртөө таалагдахын тулд өөрийгөө гоёж гоодсонгүй юу гэхчлэн бид эргэцүүлдэг. Тиймээс бид бүх зүйлийг аль болох сайн хийх ёстой. Гэсэн ч энэ нь би бүх зүйлийг сайн хийчихвэл нөхөр маань намайг орхихгүй нь лавтай гэсэн үг биш юм. Ийм зүйлд хэн ч баталгаа өгч чадахгүй.

Үүнтэй адилаар хэрэв нөхөр нь төгс төгөлдөр, бас уян зөөлөн байвал эхнэр нь түүнийг орхихгүй гэсэн үг биш. Энэ дэлхий дэх учир шалтгаан, үйлийн үрийн саад тогторыг тодорхойлох нэн бэрх. Тиймээс үүрэг хариуцлагаа биелүүлэхийн тулд чадах бүхнээ хийх нь бидэнд сэтгэл амар тайван байх боломж өгдөг. Үнэхээр ямар нэг зүйл тохиолдлоо ч бидний ухамсар эвгүй байдалд орохгүй.

Бид хийх ёстой бүхнээ сайн хийсэн, үүргээ биелүүлсэн гэдгээ мэдэж байгаа учраас өөрийн ухамсартайгаа илэн далангүй нүүр тулж чадна.

Тиймээс би та нарт гоо сайхны ур чадвар, ариун журмын тухай зааж сургасны дараа та гэрлэлтдээ сэтгэл хангалуун байх болно гэсэн үг биш юм. Ийм зүйлд хэн ч баталгаа өгч чадахгүй. Энэ дэлхийн ихэнх зүйлс мөнх бус. Тиймээс бид аливаа зүйлийг хийхдээ гэр бүлээ хамгаалж байгаа үе шигээ л үүргээ биелүүлэхийн тулд чадах бүхнээ хийдэг. Дараа нь юу ч болсон үүнийг Бурхан, хувь тавилан зохицуулсан гэдгийг бид мэддэг. Бид цаашид юу ч хүлээх, хэн нэгнийг буруутгах, эвгүйцэх, гуниглах, ямар нэгэн зүйлд шунан хүлэгдэх шаардлагагүй болно. Бид бүх зүйлийг сайн хийсэн ч, бидний гэрлэлт бүтэлгүйтсэн ч бид сэтгэл хангалуун хүн хэвээр байх болно. Хамгийн чухал нь энэ юм.

Бүлэг 10

***Залуу үеийг Алтан Эринд
дагуулахуй***

Залуу бясалгагчдыг хэрхэн хөгжүүлэх нь

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Интернет видео конференц, 2002 оны 8-р сарын 11 (Дүрс бичлэг №745)
(Эх нь Англи хэлээр)

Асуулт: Бясалгадаг хүүхдүүдээ багаас нь материаллаг үзэлд автуулахгүй байхад нь бид хэзээнээс, хэрхэн туслах ёстой вэ?

Их Багш: За, та тэдэнд бүх зүйлийн түр зуурын мөн чанарын тухай ярьж өгч, номноос, бусдаас эсвэл байгалиас авсан зарим жишээг үзүүлж болно.

Асуулт: Хэрвээ бид хүүхдийн оюун ухааныг бохирдуулахгүй бол тэд аяндаа материаллаг зүйлээс хөндийрөх болов уу, эсвэл бид бас тэгж сургах ёстой юу?

Их Багш: Бид үүнийг сургаж чадна, тэгсэн ч тэд сургуульд явбал, гадагшаа явбал нийгмийн нөлөөнд автдаг. Гэхдээ тэд ядаж л сайн суурь мэдлэгтэй бол амьдрал, хамт олны зүгээс ирэх дарамт, гонсойлтыг давж гарах чадвартай байх болно. Тэд хамт олноос ирэх урам хугаралт, дарамт шахалт, ганцаардлыг амсахгүй гэсэн үг биш юм. Гэхдээ тэд үүнийг тэсвэрлэх чадвартай байх болно. Тэд эдгээр нөхцөл байдлаас үүдэлтэй харуусал, аз жаргалгүй байдлыг ойлгох эсвэл даван туулах хангалттай хүчтэй байх болно.

Асуулт: Зөвлөсөнд баярлалаа, Их Багш аа. (Алга ташив)

Их Багш: Зүгээр ээ.

Асуулт: Бидний олонх нь хүүхэдтэй, тэд авишигтан, хагас авишигтан бөгөөд тэднийг хэрхэн өсгөх талаар мэдэх нь бидэнд үргэлж их хэцүү байдаг. Бидэнд удирдамж маш тодорхой байдаг, гэвч хүүхэд өсгөх нь өөрийн бодлыг өөр хэн нэгэнд шилжүүлэх явдал юм. Энэ тун хэцүү, тиймээс зөвлөгөө өгсөнд баярлалаа.

Их Багш: Зүгээр дээ. Энэ бүтнэ гэж найдаж байна. Энэ дэлхийд хэзээ ч туйлын буюу 100% зүйл байдаггүй. Та зөвхөн чадах бүхнээ л хийж чадна, үүнийг хийж байгаадаа бахархаарай. Бусад бүх зүйл нь үйлийн үр, нийгэм, хамтын ухамсар, Бурханы таалал, цаг агаар, таны амьдарч буй улс орон, уламжлал, таны найз нөхөд, бусад бүх зүйлийн нөлөө юм. Та юм болгоныг хянаж чадахгүй. Тиймээс хамгийн сайн чадахаараа л хий. Мөн сайн эцэг эх байгаарай. Сайн хүн, нинжин сэтгэлтэй бай. Энэ хэдийн хангалттай сайн байна. Тэд та нар шиг сүнслэг, гэгээнтэн эцэг эхээс төрсөн тун их хувь заяатай хүүхдүүд юм.

Залуу үеийг Алтан Эринд дагуулаарай

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Австрали улсын Брисбейн хот, 1993 оны 3-р сарын 21 (Дүрс бичлэг №337)
(Эх нь Англи хэлээр)

***Асуулт:** Энэ үеийн зарим өсвөр насныхан эцэг эхээ үл хүндэтгэдэг. Бид сайн эцэг эх биш болохоор тэр үү?*

Их Багш: Үгүй ээ, би тэгж бодохгүй байна. Байдлаас шалтгаална. Би бүх эцэг эхийг сайн гэж хэлэхгүй, гэхдээ ихэнх нь сайн. Юу гэхээр, энэ үеийн өсвөр насныхан ёс суртахууны тал дээрээ, мөн эцэг эхээ дэлхий дээрх Бурханы төлөөлөгч, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, сургаж төлөвшүүлэхийн тулд Бурханы байр сууринд байгаа хүмүүс гэж харах хэмжээнд хангалттай төлөвшөөгүй байж магадгүй.

Хэрвээ хүүхдүүдээ Бурханыг ойлгож мэдэхийг хүсэх үед нь ямар нэгэн байдлаар саад болж, хааж боодог бол бид тэднийг их сайн эцэг эх биш гэж хэлж болно. Харин бусдаар бол "сайн биш" эцэг эх гэж байхгүй. Өнөөгийн өсвөр үеийнхэн маань муу мэдээ, харгис хэрцгий зураг, хүсүүштэй биш харилцааны олон хэрэгсэл, муу хамт олон, муу нөлөө, муу найз нөхдийн нөлөөллөөс болж өөр үзэл бодолтой байгаа байх. Өсвөр насныхан үүнээс болж өнөөдөр ийм байгаа юм.

Тиймээс шийдэл нь бид дахиад Алтан эрин лүү буцах явдал юм. Бид хүчирхийлэлгүй, хайрын замаар, гэгээрлийн замаар, Библид заасан шиг хэв маягаар амьдрах ёстой. Тэгвэл бид хүүхдүүдээ гэнэн цайлган, ёс зүйтэй амьдрах хэв маягт нь эргүүлж авчирч чадна. Хүүхдүүд ч бас гэгээрэлд хүрч чадна. Тэгвэл тэд өөрийгөө таньж чадна, амьдрах хэв маягаа өөрчилнө.

Тэгэхлээр бүх хүүхдүүд Үнэний зам мөрийг мэдвэл тэд түүнийг сонгох болно. Ингээд тэд өөрийнхөө доторх хайрыг нээх болно. Дараа нь тэд эцэг эхээ илүү хүндлэх болно. Тэгээд эргээд, эцэг эх нь илүү гэгээрвэл үр хүүхдээ хэрхэн өсгөн хүмүүжүүлэх талаар илүү тодорхой бөгөөд илүү сайн ойлголттой байх болно.

Залуу насны сатаарлыг даван туулах

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Хельсинк, Финлянд улс, 1999 оны 5-р сарын 30 (Дүрс бичлэг №663)
(Эх нь Англи хэлээр)

***Асуулт:** Би оюутан бөгөөд урам зориг, анхаарлаа төвлөрүүлэх чадвараа алдсан. Би үүнийг яаж буцааж авах вэ? Арьяабалын Аргын тусламжтайгаар болох уу? Би одоохондоо хичээлээ эхлүүлж чадахгүй, их шаналж байна. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Та л надад болон бусад оюутнуудад тусалж чадна.*

Их Багш: Та өсвөр насанд шилжиж өсөж эхлэхэд анхаарал сарниулах зүйл олон байх болно. Тийм учраас таньд анхаарлаа төвлөрүүлэхэд хэцүү байдаг. Гэхдээ та нар бага сагаар бясалгал дадуулж болно.

Хэрэв та Арьяабалын Аргыг хүсэж байвал сайн. Үгүй бол өөрт туслачих төвлөрөх энгийн аргыг хэрэглэж болно. Мөн анхаарал сарниулах олон кино үзэхгүй байхыг хичээгээрэй. Мөн эргэн тойрныхоо гоё хүүхнүүд, эсвэл царайлаг эрчүүд рүү нүд бэлчээхийг хичээх хэрэггүй.

Сургуулиа төгсчихөөрөө мэдээж хүссэн бүхнээ хийж болно. Таны сургалтын төлбөрийг төлөхийн тулд маш их хөдөлмөрлөсөн эцэг эх, буянтнаа бодож, үүргээ биелүүлэхийг хичээгээрэй. Учир нь таны амьдралын оюутан цаг бол чухамдаа хамгийн сайхан үе юм; тэгээд хожим та харамсах болно. Та эхлээд өөрийнхөө өмнө байгаа хичээл сургуулийг дуусгах ёстой, бусад бүх зүйл дараа нь ирнэ гэж өөртөө хэл. Дуусгана гэдэгтээ шийдэмгий байгаарай.

Сурч боловсрох соёлыг дээшлүүлэх

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Тайбэй хот, Формоса, 1988 оны 11-р сарын 17 (Дүрс бичлэг №19)
(Эх нь Хятад хэлээр)

Асуулт: Эрхэм Их Багш аа, би ахлах ангийн сурагч. Таны номуудыг уншаад бид сургуульд сурснаар амьдрал, үхлээс ангижрах аргыг сурдаггүй гэдгийг олж мэдсэн. Тэгэхлээр бид сургуульд боловсрол эзэмшихийн үнэ цэнийг үгүйсгэх ёстой юу?

Их Багш: Үгүй ээ, тэгэх ёсгүй. Би өмнө нь сургуульд сураагүй байсан бол өнөөдөр энд гадаад хэлээр ийм сайн ярьж чадахгүй байх байсан. Боловсрол олж авах нь тустай. Бидний боловсролын систем сүнслэг байдлын талаар сургалт явуулдаггүйд л гол нь байгаа юм. Тэд тийм ч ач тустай биш зүйл заадаг, харин хүүхдэд ёс суртахууны сайн хүмүүжил олгохгүй байна. Олон оронд, боловсрол нь зэрэг, дипломыг чухалчилдаг. Хүүхдүүд зөвхөн диплом авахын тулд сургуульд явдаг учраас маш их дарамтанд суралцдаг. Заримдаа тэд шөнөжингөө хичээлээ давтах шаардлагатай болдог. Тэд өдөржин сургууль дээрээ суудаг тул эцэг эхтэйгээ байх цаг бага үлддэг. Сургуулиа төгссөн хойноо сургуульд сурсан зүйлээсээ маш цөөхөн ашигладаг. Тиймээс хүүхдүүд үнэхээр өрөвдөлтэй. Гэвч манай дэлхий ийм л байна. Би үүнийг тийм ч их өөрчилж чадахгүй. Энэтхэгт боловсролын систем илүү сайн. Тэндхийн боловсрол илүү жам ёсны бөгөөд чөлөөтэй, хүүхдүүдийг хэрхэн сургах талаар сургуулиуд шийдэж болдог. Тухайлбал, Энэтхэгийн Арьяабалын сектийн гишүүд хүүхдүүдээ өөрсдөө сургадаг. Тэд математик, шинжлэх ухаан, хөгжим, ёс суртахуун, эртний ном судар, сүнслэг мэдлэг, эцэг эхдээ дуулгавартай байх, үнэнч байх гэх мэт хүүхдүүддээ хэрэгтэй хичээлүүд сонгодог.

Өсвөр үеийг сүнслэг хөгжилд чиглүүлэх

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Панам, 1991 оны 1-р сарын 27 (Дүрс бичлэг №145)
(Эх нь Англи хэлээр)

Жаахан өсөж том болоод, өсвөр насандаа ирэх үед бидэнд сургуулийн хичээл, ангийн хүүхдүүдийн өрсөлдөөн, найз охин, найз залуу эсвэл найз охин залуу хоёр болон гэр бүлийн гишүүдээс янз бүрийн дарамт шахалт ирдэг.

Заримдаа бид эцэг эхийнхээ дарамтыг, эсвэл ах эгч нарынхаа дарамтыг хэрэв тэд асуудалтай байвал хуваалцдаг. Тэд бидэнд хэлээгүй эсвэл цухуйлгасан байсан ч бид гэр бүлийн санхүүгийн байдал, эсвэл эцэг эхийн хоорондох гэр бүлийн уур амьсгал гэх мэтийг магадгүй мэдэж байдаг. Эдгээр бүх зүйл бидний сүнсэнд дарамт нэмнэ. Тиймээс заримдаа хүүхдүүдэд сэтгэл давчдах мэт санагддаг.

Тиймээс хүүхдүүд эм ууж, мансууруулах бодис хэрэглэж, амиа хөнөөж ч мэднэ. Эсвэл тэд гэрээсээ зугатах юмуу дарамтаас бултахын тулд элдэв муу хүмүүстэй очиж нийлж магад. Алдсан эсвэл олж чадахгүй байгаа аз жаргалаа эдгээр зүйлсээр орлуулна гэж тэд боддог.

Хүүхдүүдэд ирдэг дарамт заримдаа насанд хүрэгчдийнхээс илүү хүчтэй байдаг гэж би боддог. Учир нь бид насанд хүрсэн хойноо эдгээр бэрхшээлийг хүлээж авахад зохих бэлтгэлтэй, их бага хэмжээгээр хангалттай хүчтэй байдаг. Харин хүүхдүүд арай мэдрэмтгий, гэнэн цайлган, арга чаргагүй; тиймээс тэд хаашаа хандахаа мэддэггүй. Тэд өөрийгөө илэрхийлж мэддэггүй: тэд аймхай, бүрэг ичимхий гээд янз бүрийн зүйлс байна. Тиймээс хүүхэд байх, залуу байх нь хүмүүсийн зохиолд гардаг шиг тийм сайхан зүйл гэж би боддоггүй.

Тийм ч учраас хүүхэд буруу зүйл хийх нь бүхэлдээ түүний буруу биш юм. Энэ бол нөхцөл байдал, нийгмийн дарамт, орчин нөхцөл, гэр бүлийн байдал гээд энд олон зүйлс нийлсэн байдаг. Тиймээс сайн эцэг эхтэй, сайн гэр бүлтэй, гэр бүл дотроо аз жаргалтай, хайр мэдэрдэг хүүхдүүд азтай байдаг. Би багадаа үүнийг тийм ч их мэдэрдэггүй байсан. Харин Үнэний зам мөрд эцэг эхтэйгээ хамт бясалгадаг хүүхдүүд илүү дээр, хамаагүй дээр. Тэдэнд найдах дотоод тайтгарал бий. Энэ нь тэдэнд өсөж томрон, энэ дэлхийн дарамтыг даван туулахад шаардлагатай маш их хүч чадал, билиг ухааныг өгөх болно.

Заримдаа бидний эцэг эх, гэр бүлийн гишүүд дангаараа бидэнд хангалттай сэтгэл ханамж, амьдралыг туулах дотоод хүч чадлыг өгч чаддаггүй. Учир нь бидэнд эцэг эхтэйгээ ярилцаж чаддаггүй бас олон зүйл бий. Эцэг эхчүүдэд өөрийн асуудал, өөрт нь хамаарах дарамт байдаг. Хэдийгээр тэд хүүхдүүдээ илүү их хайрлах эсвэл хүүхдүүдийнхээ дарамтыг хуваалцахыг хүссэн ч жирийн хүний түвшний хүчин чармайлтаар үүнийг бүрэн дүүрэн хийж чаддаггүй.

Тиймээс бүх хүүхдүүд ирж, Арьяабалын Аргад суралцаж, ургамал хоол идэх хэрэгтэй гэж би бодож байна. Хэрэв тэдэнд асуудал гарвал надтай ярилцаж болно. Ингэх нь муу найзууд дээрээ очиж ярилцсанаас дээр! Би тэдний аав, ээж, найз, хайртай хүн, багш эсвэл юу ч байж чадна, ингэснээр тэд залуу насны цаг үеэ даван туулах болно. Тэгээд тэд өсөж том болохоороо өөрөө юмсыг хийж чадна.



Бясалгал бол нэгэн төрлийн боловсрол

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Сао Пауло, Бразил, 1989 оны 11-р сарын 11 (Дүрс бичлэг №103)
(Эх нь Англи хэлээр)

Бясалгал бол нэг төрлийн боловсрол, нэг төрлийн суралцах үйл явц юм. Та яг коллежид сурч байгаатай адил, зарим юмыг профессор юмуу багшаасаа асуучихаад, чимээгүйхэн сууж, түүний сургаал, билиг ухааныг нь сонсох хэрэгтэй байдаг. Оюутан зүгээр л коллежид явж, профессороос ямар нэг юм асуугаад, шууд гараад өөр зүйл хийгээд явчихдаг бол тэр хэзээ нэгэн цагт мэргэн ухаантай болно гэж үү? Тиймээс профессор урд нь зогсож байлаа ч гэсэн тэр юу ч хүртдэггүй, учир нь түүнд ярих боломж олгодоггүй.

Бясалгал бол бидний амьдрал дахь бусад шинжлэх ухааны нэгэн адил юм. Бид суралцах ёстой. Бидэнд өгөгдөх билиг ухааныг хүлээн авах хүсэл эрмэлзэлтэй, бэлэн байх ёстой. Бусад шинжлэх ухаан, судалгааны нэгэн адил бид сонсон хүлээж авч, дадлага хийснээр суралцдаг. Бид чимээгүйд нам гүмхэн суувал бидний оршихуйд маш их мэдээлэл, адислал, хайр, эрч хүч урсах болно. Бясалгалын дараа бидэнд өөр мэдрэмж төрнө. Бид бясалгах хугацаа урт, урт бясалгах тусам илүү ухаалаг, амар амгалан болдог. Дэлхий ингэж л амар амгалан болох юм.

Боловсрол гэр бүлээс эхэлдэг

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Пиндун, Формоса, 1988 оны 12-р сарын 1 (Дүрс бичлэг №21)
(Эх нь Хятад хэлээр)

Асуулт: *Эрхэм Их Багш аа, бага, ахлах ангийн хүүхдүүдэд эелдэг зөөлөн байж, эцэг эхийнхээ хайрыг эргэлзэхгүйгээр ойлгоход нь хэрхэн туслах вэ?*

Их Багш: Энэ нь эцэг эх, үр хүүхдийн үйлийн үрээс хамаарна. Ер нь хүүхдүүд зүрх сэтгэлдээ сайн байдаг ч гаднах нийгмийн нөлөөнд автдаг. Хүчирхийллийн кино, садар самууныг харуулсан зурагт хуудас хаа сайгүй тархаж, бидний хүүхдүүдэд нөлөөлж байгаа учраас нийгмийн орчин хүүхдэд тийм ч таатай биш байна. Одоогоор сургуулийн сургалтын хөтөлбөрт ёс суртахууны хичээл ороогүй байна. Ирээдүйд энэ өөрчлөгдөж магадгүй юм; засгийн газрууд эдгээр хичээлүүдийг боловсролын системд оруулах байх. Хүүхдүүдэд ёс суртахууны үлгэр уншуулж, эсвэл өдөр бүр гучин минут бясалгуул. Тэгвэл хүүхдүүд сайжирна. (Алга ташив.)

Энэтхэг улс үүнийг боловсролын системдээ аль хэдийн оруулсан. Одоо барууны зарим их сургууль энэ хичээлийг бас нэмээд байх шиг байна. Тэдний оюутнууд өдөр бүр хагас цаг бясалгадаг. Энэ оюутнууд илүү ухаалаг, зүрх сэтгэл нь илүү тогтвортой болж, багш нартаа илүү сайн хандаж байгааг тэд олж мэдсэн. Тэгэхээр бид хүүхдээ өөрчилье гэвэл гаднаас нь биш дотроос нь засах хэрэгтэй. Нийгэмд байгаа бүх хүмүүс хамтран ажиллаж, хүн бүр өөрийнхөө хувийн зан чанарыг анхаарч үзэх хэрэгтэй. Эцэг эхчүүд ч бас хариуцлагатай байх хэрэгтэй. Тэд зөвхөн хүүхдээ л өөрчлөгдөхийг гуйх биш юм; тэд өөрсдөө ч өөрчлөгдөх ёстой.

Арьяабалын Аргаар бясалгадаг байсан нэгэн талийгаач Их Багш хүүтэй байжээ. Тэр хүү их багшдаа өөрийнхөө зарим түүхийг ярьжээ. Тэр багаасаа буюу дөнгөж гурав, дөрөвхөн настай байхаасаа эцэг эх нь өдөр бүр эртлэн босож бясалгал хийж байхыг хардаг байжээ.

Тухайн үед тэр яаж бясалгахыг мэдэхгүй байсан ч тэдэнтэй хамт суудаг байв. Тиймээс тэрээр балчир байхдаа л бясалгалд суралцаад яваад байжээ, тэр өдөр бүр эрт босоод эцэг эхтэйгээ хамт бясалгаж байв. Тэрээр, ёс суртахуунтай олон хүн эцэг эх дээр нь ирж, олон бясалгагчид тэдэнтэй хамт бясалгахыг мөн харж байжээ. Ээж аав нь хамт нийтийн бясалгал хийхээр ирсэн хүмүүсийг хайрлан халамжилдаг байв. Орой бүр эсвэл Ням гарагт эцэг эх нь гэр бүлдээ зарим судар, ёс суртахууны тухай зүйлс, сайн үлгэр түүх уншиж өгдөг байв. Заримдаа тэд хамт бясалгахын өмнө дуу бичлэг сонсдог байсан. Ийм л орчинд тэр хүмүүжсэн. Тэрээр том болоод Энэтхэгтээ алдартай их багш болсон нь гайхах зүйл биш юм. Тэр одоо ч олон улсад маш алдартай.

Тиймээс хүүхдүүдийг битгий буруутгаарай, томчууд бид ч гэсэн заримдаа алдаа гаргадаг. Жишээ нь, бидний өмсөж буй хувцас хангалттай хүндэтгэлтэй биш, бидний зан чанар хангалттай эрхэм ариун биш, эсвэл бидний ёс суртахуун хангалттай гүн биш байж болно. Бид хүүхдүүдээ сургуулиас биш, гэр бүлээсээ хүмүүжүүлж эхэлдэг, учир нь эцэг эх нь хамгийн аугаа, хамгийн үндсэн, хамгийн чухал багш нар юм. Та юу гэж бодож байна? (Алга ташив.)



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Сингапур улс, 1992 оны 3-р сарын 3 (Дүрс бичлэг №223)
(Эх нь Англи хэлээр)

Мод газарт сайн үндэстэй байдаг шиг хүүхэд бага наснаасаа ёс зүйн суурь үндэс сайтай өсөж торнивол том болсон хойноо тийм ч амархан унадаггүй. Харин мод газарт сайн үндэслээгүй байвал жаахан ургаад ирмэгцээ салхи, байгалийн бусад хүчний нөлөөгөөр хугарч унадаг.

Гэр бүл бүхэн сүнслэг бясалгал дадуулж, хүн бүр гэгээнтэн шиг байх

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Нарита нисэх онгоцны буудал, Япон, 1993 оны 10-р сарын 18
(Дүрс бичлэг №382) (Эх нь Хятад хэлээр)

Үнэндээ, ихэнх муу хүүхэд тийм ч муу биш; хүн амины хэрэг, дээрэм хийдэг хүмүүсийн ихэнх бас тийм ч муу биш. Хэн ч тэдэнд сайн зүйл заагаагүй учраас л тэд муу болдог бөгөөд тэд зөвхөн муу зүйл сургадаг хүмүүст өртдөг. Ёс зүйн болон ёс суртахууны хэм хэмжээг сургуульд бараг заадаггүй. Хүүхдүүдэд ердөө л математик, түүх болон бусад хичээлүүд дээр баримт цээжлэхийг, сургуулиа хурдан төгсөөд ажил олж, мөнгө олохыг л заадаг. Тэдний гэр бүлээсээ авдаг ганц сэдэл нь: "Чи сайн сурахгүй бол том болоод мөнгө олж чадахгүй, мөнгөгүй бол сайн эхнэр авч чадахгүй." гэх мэт зүйлс байдаг. Ихэнх сургууль үүнийг онцолж байна. Ихэнх хүмүүс ердөө мөнгө, албан тушаал, алдар нэрийн төлөө хоорондоо өрсөлдөж, хүүхдэд ёс суртахуун, хариуцлага, нийгэмд хувь нэмэр оруулах тухай ойлголтыг сургадаггүй; тиймээс ирээдүй хойч үе маш өрөвдөлтэй байдалд орж магадгүй юм!

Дараагийн удаа та дээрэмчнийг буруутгах эсвэл хүүхдийг муу байна гэж зэмлэхээсээ өмнө өөрөөсөө "Эцэг эх, ахмадууд бид үүрэг хариуцлагаа үнэхээр биелүүлсэн үү?" гэж асуугаарай. Магадгүй бид өөрөөсөө ичвэл зохино! Гэсэн хэдий ч ахмад үе маань ч бидэнд илүү сайн зүйл заагаагүй учраас бид буруугүй. Тиймээс бид өөрсдийн цаг үеийнхнээсээ эхлэх ёстой бөгөөд цаашид хойшлуулах ёсгүй; бид хүүхдүүдээ болон өөрсдөдөө сайн зүйлийг хурдан сургах ёстой. Бид өөр арга зам хайх ёстой, эс тэгвээс бидний хүүхдүүд доройтох болно. Муу хүүхэд муугаараа төрдөггүй; төрсөн цагаасаа л муу хүүхэд гэж байдаггүй.

АНУ-д хүн амины хэрэг, дээрмийн гэмт хэрэг үйлдсэн залуу хоригдлуудад зориулсан тусгай хорих анги байдаг. Мэдээж хэрэг, АНУ-д ийм олон хорих газар байдаг, гэхдээ энэ хорих газар боловсролд илүү их анхаарал хандуулдгаараа онцгой юм. Хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн хүмүүс торны цаана суусан ч суллагдсаныхаа дараа алдаагаа давтдаг нь судалгаагаар тогтоогджээ. Гэсэн хэдий ч энэ өвөрмөц хорих анги нь залуу хоригдлуудад боловсрол олгох, тэдэнд хариуцлага ба ичгүүрийг мэдрүүлэх, яагаад ийм үйлдэл хийхээ болих ёстойг ойлгуулахын тулд янз бүрийн систем ашигладаг. Хүн амины хэргээр ял эдлээд, энэ хорих ангиас суллагдсан 160 залуугаас зөвхөн ганц нь л тэр гамшигт замыг дахин давтсан гэсэн статистик судалгаа гарчээ!

Хоригдлуудад боловсрол олгож, тэдний хэнэггүй хүйтэн өнгөц багийг нь хуулж, алдаагаа үгүйсгэдэг байдлыг арилгахад тэд өөрсдийн ухамсартайгаа нүүр тулдаг. Аяндаа тэд ийм зүйл хийх нь муу гэдгийг ухаарч ойлгодог. Өөрийн амьдралыг хариуцдаг шигээ бусдын амь насыг ч хариуцах ёстойг хоригдлууд ухаардаг. Хоригдлууд мөн хохирогчийн дүрд тоглож, түүний зовлон, үүнээс үүдсэн хамаатан садан, үр хүүхэд, найз нөхдийнх нь шаналал зовлонг мэдэрдэг. Хоригдлуудын нулимс нь сад тавьж, чин сэтгэлээсээ наманчлах хүртэл нь ийм боловсрол олгодог, ингээд тэд суллагдсаныхаа дараа дахин гэмт хэрэг үйлдэхгүй.

Хоригдлууд алдаагаа хүлээн зөвшөөрөхгүй, ухамсартайгаа нүүр тулахгүй, дотоод мэдрэмжээ үл тоон, хэнэггүй хүйтэн багаа зүүсээр байвал суллагдсан хойноо дахин гэмт хэрэг үйлдэж, хүн хөнөөх зуршилтай болно. Тэд хүний амь нас маш үнэ цэнтэй гэдгийг ухаарахаа байж, хүнийг эд зүйл мэт үзэж харьцах болно. Тэд хохирогсод эсвэл тэдний хамаатан садан, найз нөхдийн сэтгэл санааг огт тоохгүй. Тиймээс хоригдлуудыг хүмүүжүүлэх энэ арга нь маш үр дүнтэй байдаг.

Тэр хүүхдүүд эсвэл хоригдлууд үнэндээ тийм ч муу хүмүүс биш. Тэдний зан авир нь ихэвчлэн ар гэрийн золгүй нөхцөл байдалтай нь холбоотой байдаг. Тухайлбал, ээж нь хар тамхи хэрэглэдэг, хойд аав нь мөрийтэй тоглоом, архинд донтсон, тэднийг байнга зоддог байсан байж магадгүй. Ар гэрийн ийм нөхцөл байдал нь хүүхэд уур бухимдлаа бусад хүнд гарган, гэмт хэрэг үйлдэх хүчин зүйл болсон байдаг. Тиймээс энэ хорих ангийн боловсролын системд хоригдлууд ч ийм нөхцөл байдалтай тулгардаг. Хоригдлуудад өөртэй нь адил өрөвдөлтэй, мөн тийм төрлийн гэр бүлээс гаралтай байж болох, гэм зэмгүй хүмүүст дайсагналаа гаргахгүй байхыг зөвлөдөг.

Янз бүрийн гэр бүлээс гаралтай хоригдлуудыг сурган хүмүүжүүлэхийн тулд өөр өөр аргыг хэрэглэдэг бөгөөд боловсролын үр нөлөө өндөр болохыг үр дүн нь нотлон харуулжээ. Энэ хорих ангиас суллагдсан нийт 160 гаруй хоригдлын нэг нь л дахин өөр гэмт хэрэг үйлджээ. Гэвч хорих анги жил бүр энэ хөтөлбөртөө ердөө 24 хоригдлыг хүлээн авах боломжтой, учир нь энэ бол цаг хугацаа, тэвчээр шаарддаг ажил юм.

Тиймээс хүүхдүүдээ бага балчраас нь л сайн харж хандах нь сайн; тэгээд ч бидэнд харж хандах хэдхэн л хүүхэд бий шүү дээ. Тэднийг том болоод нийгэмдээ хүнд ачаа тээр болтол нь бүү хүлээ.

Ёс зүй, ёс суртахууны үндэс суурийг бага насанд нь тавьж өгснөөр хүүхэд өсөж том болоод бүх зүйлийг шийдэмгий, зөв, алдаагүй хийж чадна. Тиймээс та нар өөрсдөө сүнслэг бясалгал дадуулахаас гадна хүүхдүүддээ анхаарал тавьж, тэднийг сургаж, сүнслэг бясалгалын ач тусыг тэдэнд ойлгуулах хэрэгтэй. Энэ нь эцэг эхийн үүрэг төдий зүйл биш юм. Энэ бас улс үндэстний иргэн бүрийн үүрэг, мөн энэ дэлхий дээрх номын ах, эгч нарын үүрэг юм. Хорин нэгдүгээр зуун бол гэр бүл бүхэн сүнслэг бясалгал хийдэг, хүн бүр нь гэгээнтэн байдаг гайхамшигтай эрин байх болно гэж бид найдаж байна. Энэ зорилгыг биелүүлэхэд бүх хүний хүчин чармайлт шаардагдана. (Алга ташив)

Ёс зүйн ойлголт ухамсрыг бага наснаас нь төлөвшүүлэх

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Шихү төв, Формоса, 1995 оны 11-р сарын 3 (Дүрс бичлэг №511)
(Эх нь Англи хэлээр)

Хүүхдүүддээ сайн үлгэр дуурайл үзүүлэх замаар тэдэнд найдаж, зааж сургацгаая. Тэднийг зоригтой, илэн далангүй, шударга байхыг дэмж. Энэ бол таны үүрэг; та тэдэнд сайн үлгэр дуурайл үзүүлэх ёстой.

Хүүхдүүд их хурдан сурдаг, бас сургууль дээрээ маш олон муу зүйл сурдаг. Учир нь тэнд ёс зүйн хувьд зөв зүйл төдий л заадаггүй багш нар байдаг, бидний хүүхдүүдэд үргэлж сайн үлгэр дуурайл үзүүлж чаддаггүй ангийн нөхөд нь байдаг. Эндхийн зарим хүүхдийг би сургуульд явуулсан. Гэхдээ сургуульд явахынхаа өмнө тэд илүү эелдэг, илүү сайн, тайван, дуулгавартай байсан. Хэдэн жил сургуульд сурсны дараа тэд өөр болсон. Тэд өмнөх шигээ эцэг эхдээ дуулгавартай байхаа больсон байв. Заримдаа үгээр, заримдаа дохио зангаагаар маш ширүүн эсэргүүцдэг байв. Үүнийг мэдэхээр маш их цочирддог.

Өсөлтийн насны асуудал

Гэхдээ би тэднийг сургуульд явахыг нь зогсоож чадахгүй. Хэрвээ тэгвэл намайг хүүхдээ сургуульд явуулахгүй байна гэж хүмүүс хэлж, бид бүгд илүү асуудалд орно. Гэвч тэднийг сургуульд явуулчихвал, бид ердөө ганцаараа үлддэг, тэд өдөржин сургууль дээрээ байдаг. Тэгээд гэртээ ирэхээрээ гэрийн даалгавраа хийгээд завгүй байж байгаад л унтчихдаг.

Тиймээс эцэг эхтэйгээ хамт байх цаг нь ангийнхантайгаа байхаас цөөн байдаг. Энэ бол өнөөгийн хүүхдүүдэд тулгардаг асуудал юм. Нэг хүүхэд буруу зүйл сурахад бусад нь бүгд дуурайдаг. Тэд үнэхээр зоригтой, ухаалаг сэргэлэн биш бол түүнийг дуурайхгүй байх хэцүү. Хэрэв тэд бусад хүүхдүүдээ дагаж дуурайхгүй бол сургуулийн танхайчууд тэднийг дагуулахын тулд дээрэлхдэг. Эсвэл заримдаа тэд буруу зүйлд дагуулах гэж тэднийг ичээдэг. Учир нь тэд ингэж хэлдэг: “Чи шалихгүй банди байна. Өөрийгөө хараач ‘Сайн хүү’. Чи юу ч мэддэггүй! Чи охидыг мэддэггүй, мансууруулах бодис ч мэддэггүй, бас тамхи ч мэдэхгүй. Чи юу ч мэдэхгүй. Бид бүгдийг мэддэг. Алив ээ, чамд ямар ч зориг алга. Чи бол.....” Тэд тийм хүүхдүүдийг “туулай”, “дэгдээхэй” гэх мэтээр дуудна. Ингээд жаахан хүүгийн бардам занг хөндөж, тэр эрт орой хэзээ нэг цагт үүнд нэгддэг.

